

С. Амарсанаа, О.Батсайхан, З.Лонжид  
Д.Нансалмаа, О.Оюунтунгалаг, Б.Пунсалдулам, У.Туяа

# ТҮҮХ IX

Ерөнхий боловсролын 12 жилийн  
сургуулийн 9 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны  
зөвшөөрлөөр хэвлэв.

Хоёр дахь хэвлэл

Улаанбаатар хот  
2019 он

DDC  
371.32  
T-826

Түүх IX: Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн 9 дүгээр анги  
(Туяа У., ба бус., Ред. Пүрэв О., УБ. 2015. - 160х)

Азийн Хөгжлийн Банкны “Эдийн засгийн хүндрэлийн үед боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах төсөл”-ийн хүрээнд хэвлүүлэв.

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр, бүтнээр эсхүл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ [textbook@mecs.gov.mn](mailto:textbook@mecs.gov.mn) хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN: 978-99962-74-42-8

## ТҮҮХЭЭ БҮТЭЭЦГЭЭ

“Эрдэмтэн сайд угаа үл умартмуй”,  
“Монгол тоотон бүгдээр уг үндэс ба язгуур удмаа мэдтүгэй”  
их эрдэмтэн Инжаннашийн сургаалаас

Бидний монголчуудын хэдэн мянган жил тасралтгүй үргэлжилсэн эх түүхийн нэгэн онцгой үе 1911 оноос эхэлдэг билээ. Өвөг дээдэс маань төрийн тусгаар тогтнолоо сэргээн тунхагласнаар гараагаа авсан тэрхүү түүхт өдрийг 1911-1936 онд жил бүр тэмдэглэж байсан юм. Харин 1937-2010 онд ингэж тэмдэглэхээ азнасныг 2011 онд Монгол Улсын их хурлын шийдвэрээр жил бүр үндэсний баяр болгон тэмдэглэдэг боллоо.

1911 оноос эдүгээ хүртэлх хугацаанд манай улсад олон үйл явдал болсныг энэхүү сурах бичигт хураангуй өгүүлээ. Тухайлбал, 1911 оны 12 сарын 29-ний өдөр Монгол төр улс, тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан, 1919 оны эцсээр Монгол Улсын хувь заяанд эгзэгтэй байдал тохиосон, 1921 онд Монгол Улс хоёр засгийн газартай болсон, 1924-1990 онд Зөвлөлтийн нөлөөнд автсан, 1924-1992 онд дөрвөн удаа Үндсэн хууль баталсан, 1945 оны намар тусгаар тогтнолоо баталгаажуулах бүх ард түмний санал хураалт болсон, 1961 онд НҮБ-д элссэн, 1990 оны цагаан морин жилийн ардчилсан хувьсгал гарсан зэрэг гол гол үйл явдлыг дэлхийн түүхийн онцлог үйл явдалтай холбон энэхүү сурах бичигт тусгалаа. Сурагч та бүхэн эх түүхийнхээ жимээр аялж, оюун ухаандаа тунгаагаарай.

Өнөөгийн бидэнд өвөг дээдсийнхээ түүхийг шүүх эрх байхгүй ч түүх та бүхэнд эргэцүүлэл, сургамжийг хайрлах болно. Хүүхдүүд та бүхэнд эх түүхийн бахархам үйлсийг үргэлжлүүлэх түүхэн үүрэг ногдсон шүү гэдгээ ухамсарлан ойлгоорой.

Өндөр уулын хөтөл зорь Хол хэмээн бүү цөх, явбал хүрью  
Өргөн далайн олом зорь Хүнд хэмээн бүү цөх, өргөвөөс дааюу... хэмээн  
сод богд эзэн Чингисийнхээ айлдсан сургаалийг ёсчлон хэрэгжүүлээрэй.

Эх түүхээсээ суралцаж байгаа эрхэм охид,  
хөвгүүд та нарын оюуны ам нээгдэх болтугай.

Зохиогчид

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

ГОЛ САНАА

ТҮЛХҮҮР ҮГ

ТОЛЬ

Тухайн сэдэв монголын болон дэлхийн түүхэнд тодорхой нөлөө үзүүлсэн талаар, энэ сэдвийг судлахад анхаарч үзэх гол санааг тэмдэглэсэн. Түлхүүр үгсийг гол зүйлээ тайлбарлахад, цахим орчноос нэмэлт мэдээлэл хайхдаа ашиглаарай.

Сэдэвт буй товчилсон үг болон зарим ойлголтын тайлбарыг эндээс хараарай.



АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

Түүхийн тухайн үйл явдлын талаар танд ямар асуулт байна вэ? Энэ сэдвийн хүрээнд ямар асуудал байна гэж та үзэж байна вэ? Энэ үеийн улс орон, хүмүүсийн аж байдлыг төсөөлнө үү.



УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

Эх, зураг, бүдүүвч, хүснэгт зэрэг хэлбэрээр буй мэдээллийг уншиж, тэдгээрийн агуулгыг ойлгож аваарай. Энэ нь та бүхэнд шинжилгээ хийж, дүгнэлт гаргахад тустай.



ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

Төрөл бүрийн эх сурвалжаас авсан мэдээлэл, ойлголтоо тодорхой арга хэрэгслийн тусламжтайгаар шинжлэн дүгнээрэй.

ҮНЭЛЭЭРЭЙ

МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ЧИГ  
БАРИМЖАА БА ЗХУ-ЫН НӨЛӨӨ

Тухайн сэдвийн хүрээнд юуг сурч мэдсэн, цаашид юуг хэрхэн судлах төлөвлөгөөтэй байгаагаа эргэн хараарай.

## ГАРЧИГ:

### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ТҮҮХИЙГ ОЙЛГОХ НЬ



1. Орчин үеийн монголын түүхийг хэрхэн судлах вэ? \_\_\_\_\_ 5
2. Орчин үеийн түүхээр юу судлах вэ? \_\_\_\_\_ 9

### ХОЁРДУГААР БҮЛЭГ: МОНГОЛЫН ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ БА ДЭЛХИЙ ДАХИН (1911-1924)



*Орчин үеийн  
Монголын  
түүхийн  
үнэт зүйлсээ  
шимтэн  
судлаарай.*

1. 1911 оны Монголын үндэсний хувьсгал \_\_\_\_\_ 12
2. Тусгаар тогтносон Монгол улс \_\_\_\_\_ 18
3. Монгол улсын нийгэм, эдийн засаг, соёл \_\_\_\_\_ 23
4. Монголчуудаа нэгтгэхийн төлөө тэмцэлд \_\_\_\_\_ 28
5. Дэлхийн I дайн ба Монгол улс \_\_\_\_\_ 31
6. Орос улс дахь Октябрийн эргэлт \_\_\_\_\_ 35
7. Монголын нөхцөл байдал (1919-1921) \_\_\_\_\_ 39
8. 1921 оны Монголын хувьсгал \_\_\_\_\_ 45
9. Ардын засгийн анхны арга хэмжээ \_\_\_\_\_ 48
- Бүлгийн дүгнэлт \_\_\_\_\_ 52


### ГУРАВДУГААР БҮЛЭГ: СОЦИАЛИЗМЫН ҮЕИЙН МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙ ДАХИН (1924-1990)



*Монголын  
түүхийн  
ээдрээтэй  
зурвас үеийг  
цэгнэж үзээрэй.*

1. Монголын хөгжлийн чиг баримжаа ба ЗХУ-ын нөлөө \_\_\_\_\_ 54
2. Монгол улс бүгд найрамдах засаглалд шилжсэн нь \_\_\_\_\_ 58
3. БНМАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх бодлого \_\_\_\_\_ 63
4. БНМАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх бодлогод өөрчлөлт гарсан нь \_\_\_\_\_ 68
5. БНМАУ-ын боловсролын хөгжил \_\_\_\_\_ 75
6. БНМАУ-ын соёлын хөгжил \_\_\_\_\_ 81
7. БНМАУ-ын эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөгжил \_\_\_\_\_ 88
8. Бурхны шашин ба социализм \_\_\_\_\_ 93
9. Лам нарын “эсэргүү бослого” \_\_\_\_\_ 98
10. Монголын түүхэн дэх хар толбо \_\_\_\_\_ 102
11. Дэлхийн II дайн (1939-1945) \_\_\_\_\_ 108
12. БНМАУ дэлхийн II дайнд оролцсон нь \_\_\_\_\_ 114
13. Хүйтэн дайн (1946-1991) \_\_\_\_\_ 119
14. НҮБ ба Монгол улс \_\_\_\_\_ 123
- Бүлгийн дүгнэлт \_\_\_\_\_ 127


### ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: АРДЧИЛСАН МОНГОЛ УЛС БА ӨНӨӨГИЙН ДЭЛХИЙ ДАХИН (1990 ОНООС ӨНӨӨ ҮЕ)



*1990-ээд оноос  
хойш Монгол  
улс хэрхэн  
өөрчлөгдөв?*

1. Социалист систем задран унасан нь \_\_\_\_\_ 129
2. Монгол улсад ардчилсан хувьсгал эхэлсэн нь \_\_\_\_\_ 134
3. Ардчилсан хувьсгалын өрнөл \_\_\_\_\_ 138
4. Ардчилсан сонгууль, шинэ Үндсэн хууль \_\_\_\_\_ 143
5. Монгол улсын эдийн засгийн өөрчлөлт \_\_\_\_\_ 146
6. Монголчуудын оюун санаа, нийгмийн амьдралд гарсан өөрчлөлт \_\_\_\_\_ 150
7. Монгол улсын гадаад бодлогын өөрчлөлт \_\_\_\_\_ 155
- Бүлгийн дүгнэлт \_\_\_\_\_ 158
- Ном зүй \_\_\_\_\_ 160





### 1

## ОРЧИН ҮЕИЙН МОНГОЛЫН ТҮҮХИЙГ ХЭРХЭН СУДЛАХ ВЭ?

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Түүх бол аж төрөх ухаан, үндэсний бахархал, уламжлал, тэргүүтнийг өвлүүлэгч тул та бидний орших, хөгжихийн дархлаа мөн болно.

### ГОЛ САНАА

Орчин үеийн Монголын түүх 1911 оноос эхэлнэ. Эл үеийн түүхийг 1911-1924, 1924-1990, 1990 оноос эдүгээ хүртэл хэмээн 3 үед хувааж авч үзэв.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Түүх
- Түүхийн эх сурвалж
- Орчин үеийн Монголын түүх



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ


1. Он тооллын шугамыг гүйцээж түүхийн үечлэлийг хийнэ үү.



2. Түүхийн эх сурвалжийг бүдүүвчээр харуулна уу.
3. Түүхэн зүтгэлтний намтраас сонгож бичнэ үү.
4. Орчин үеийн түүхээр юуг, хэрхэн судлах талаар өөр, өөрийн таамаглал, төсөөллөө танилцуулна уу.

Орчин үеийн түүхийг судлах баялаг эх сурвалж та бүгдийн өмнө байна. Эх сурвалж арвин их тул тэдгээрийг ангилан авч үзсэнээр тухайн үеийн түүхийг судлахад хялбар болно.

Бүдүүвч 1.1. Эх сурвалжийн ангилал



Түүхийн эх сурвалжууд Монгол улсын Үндэсний төв архив, Монгол улсын зэвсэгт хүчний архив, намуудын архив, Засгийн газрын архив, Гадаад харилцааны архив, Тагнуулын ерөнхий газрын архив, орон нутгийн (аймаг, сум зэрэг) архивт хадгалагдаж байна. Орчин үеийн Монголын түүхэнд холбогдох архивт хадгалагдаж буй сурвалжийг удаа дараа хэвлэн нийтлүүлж олны хүртээл болгосоор байна. Хэвлэн нийтлэгдсэн томоохон эх сурвалж, баримт бичгүүдээс дурдвал: “Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл” баримт бичгийн эмхтгэл (1900-1911 он), УБ., “Монголын автономит үеийн сургууль” (1911-1920), УБ., 1966, “Автономит Монгол улсын үеийн онцлог баримт бичгүүд” УБ., 2003, “БНМАУ-ын Их, бага хурлын тогтоол, Үндсэн хууль, тунхагууд” УБ., 1956, “Монгол улсын нутаг дэвсгэр, хил хязгаар” УБ., 2011, “Монголын төр, эрх зүйн түүх”. 6 дэвтэр, (Дээж бичиг) УБ., 2010, “Коминтерн ба Монгол” баримт бичгийн эмхтгэл. УБ., 1996, “Монголын тухай БХК (б)Н-ын баримт бичигт” (1920-1952) баримтын эмхтгэл. УБ., 2005 зэрэг олон эмхтгэл гарчээ.

Монголын тогтмол хэвлэлүүд тухайн цаг үеийн түүхийг тодруулахад өргөн боломж олгодог. Ялангуяа, үндэсний дэвшилт ардчилсан сонин “Шинэ толь хэмээх бичиг” (1913 оны 6 сарын 6-1914

оны 8 сарын 21), “Нийслэл Хүрээний сонин бичиг” (1915 оны 9 сарын 1- 1920 оны 1 сарын 23), “Монголын үнэн” (1920 оны 9 сараас) зэрэг хэвлэл орчин үеийн монголын түүхийн эх сурвалж болно.

Түүхэн үйл явдалд оролцож явсан хүмүүсийн дуртгал, дурсамж түүх судлалд үнэтэй тус нэмэр болдог. Сүүлийн үед хүмүүсийн дуртгалыг олноор хэвлүүлэх болсон. Тухайлбал, “Монгол ардын журамт цэргийн дуртгалууд” I, II дэвтэр УБ., 1961. 1971, Ц.Дамбадорж. “Толбо нуур” УБ., 1928, Ж.Самбуу “Амьдралын замналаас” (Дуртгал I, II дэвтэр) УБ., 1965. 1970, Ж.Лхагвасүрэн. “Сэтгэлд шингэсэн он жилүүд” УБ., 1984 гэх мэт олон бүтээл гарчээ.

XX зууны эхний хагасын бүтээлүүдийг ахмад түүхчид уламжлалт ёсыг баримтлан Монголын ард түмний эрх чөлөө, тусгаар тогтнолын үнэлэмж, зарчмыг эрхэмлэн бичсэн байдаг тул өнөөдөр чухал эх сурвалж болж байна.

Энэ үеийн түүхийн бүтээлүүдийг 2015 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын захиалгаар нэр бүхий түүхчид эрхлэн “Монголын эх түүх” 7 дэвтрээр гаргажээ. Үүнд: А.Амарын “Монголын товч түүх”, “Б.Ишдоржийн “Монгол улсын хураангуй түүх”, Л.Дэндэвийн “Дундад үеийн Монголын түүх”, Б.Буянчуулганы “Манж, Монгол холбогдсон түүхт байдал”,

Н.Магсаржавын “Монгол улсын шинэ түүх”, Л.Дэндэвийн “Монголын товч түүх”, Х.Чойбалсан, Д.Лосол, Г.Дэмид нарын “Монгол ардын үндэсний хувьсгалын анх үүсэж байгуулагдсан товч түүх” бүтээлүүд гар бичмэлийн хамт эмхтгэсэн байна.

Түүхийн баримтыг сонгох, боловсруулах, үнэлэхэд мэргэжлийн онцгой хариуцлага шаардана. Баримтыг олж сонгох нь эцсийн зорилго биш, түүнийг тайлбарлах, задлан шинжилгээ хийх, нэгтгэн дүгнэх, гол зүй тогтлыг олж тогтоох нь чухал. Баримтыг хэт шүтэх, эсвэл хэт үл ойшоохын аль аль нь учир дутагдалтай. Түүхэн үйл явдал, үзэгдэл юмс, олон янз, бөгөөд бид бүхний үнэлэмжээс үл хамааран оршиж ирсэн. Бичигч түүхэн үеийн аль нэг үйл явдал, үзэгдэл, үнэлэмжтэй харьцуулан дүгнэж, тайлбарлаж иржээ. Ингэж үнэлж, тайлбарлах нь хэн нэгэн хүний дур зоргын асуудал биш, түүнийг түүхийн бодит баримтад тулгуурлахыг гол шалгуур болгох ёстой. Гэвч баримт бүр бодит агуулгатай байж тэр бүр чаддаггүй, заримдаа болсон үйл явдлын зорилго, утга агуулга, үйл явцыг

мушгин гуйвуулсан, тодорхой хэсэг бүлэг хүмүүсийн эрх ашиг, үзэл бодолд нийцүүлэхийг оролдсон зохиомжтой байх тохиолдол байдаг. Тиймээс баримтыг сайтар нягтлан, сонгох хэрэгтэй.

Сурагч та бүхэн орчин үеийн түүхийг судалснаар дараах чадварыг эзэмшиж хөгжүүлнэ. Үүнд:

- Орчин үеийн түүхийн эх сурвалжуудыг нэрлэх, энэ үеийн түүхийг бусад үеийнхээс ялгах, тайлбарлах;
- Баримт, мэдээллийг ялгаж ангилах, үнэлэх;
- Түүхийн баримт, эх сурвалжийг өөр, өөрөөр тайлбарлаж байгаагийн учир шалтгааныг эргэцүүлэх, өөрийн тайлбар хийх;
- Түүхэн баримт, эх сурвалжийг ашиглан түүхэн үйл явдлыг сэргээн дүрслэх, төсөөлөх, асуудал, таамаглал дэвшүүлэх;
- Хүмүүсийн намтар түүхийн эх сурвалж болохыг нотлох, ялгаатай бичсэн намтруудыг судлах, өөрийн үнэлэлт, дүгнэлт өгөх зэрэг болно.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Эхээс мэдэж авсан зүйлсээ гол ба гол бусаар нь ангилна уу. Яагаад гол гэж үзсэнээ танилцуулна уу.
2. Дараах ойлголтыг тайлбарлаарай. а) эх сурвалж, б) судалгаа
3. Орчин үеийн түүхийн эх сурвалж нь өмнөх үеийн түүхийн эх сурвалжуудаас ямар онцлог ялгаатай вэ? Энэхүү ялгааны учир юу вэ? Дараах хүснэгтийг ашиглан хариулна уу.

№	Түүхийн үеүд	Эх сурвалжийн төрөл	Тайлбар
	Эртний үе		
	Дундад зууны үе		
	Шинэ үе		
	Орчин үе		

4. Дараах хоёр баримт дээр ажиллана уу.

Баримт	Баримт
<p>Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрийн зорилго нь сурагч бүрийг сурах арга барил, амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар, бие даан бүтээлчээр суралцах чадвар эзэмших, үндэсний хэл, түүх, соёлоо дээдлэн хөгжүүлэх, ардчилсан, хүмүүнлэг үзэлтэй иргэн төлөвших боломж олгоход оршино.</p> <p>Эх сурвалж: Монгол улсын “Суурь боловсролын сургалтын цөм хөтөлбөрөөс авав, 2015 оны 7-р сар</p>	<p>Байгалийн ухааны хичээлийг үзэж судлахад, .... Бүтээх арга нь ... хамгийн үр дүнтэй арга... Энэ арга нь шинжлэх ухааны болон байгалийн ухааны холбогдох хуулийг өөрийн биеэр мэдэрч судалж мэдэх... Судлагдахууны агуулга болон өдөр тутмын амьдрал болон нийгмийн амьдралын уялдаа холбоог илрүүлэх, мэдлэгээ ашиглаж сурахад хамгийн үр дүнтэй арга юм.</p> <p>Эх сурвалж: Япон улсын “Дунд сургуулийн Байгалийн ухааны сургалтын хөтөлбөрийн зөвлөмжөөс (3-р бүлгийн 1-ээс) товчлон авав, Хэйсэй 20 оны 9-р сар</p>

- а) Баримтууд ямар эх сурвалжид хамаарах вэ?
  - б) Баримтууд дахь цаг хугацааг харьцуулна уу. Үүнийг тооцоолоход та бүхэнд түүхийн ямар мэдлэг хэрэг болох вэ?
  - в) Баримт бүрийн агуулга нь та бүхэнд ямар, ямар улсын, ямар салбарын, аль үед хамаарах, ямар мэдээллийг өгч байна вэ?
  - г) Түүхийн эх сурвалж, баримтыг задлан шинжлэх, нэгтгэн дүгнэхийн учир холбогдлыг хэрхэн ойлгож байна вэ?
5. Та бүхэн орчин үеийн түүхийг судлахын тулд ямар, ямар эх сурвалжуудыг ашиглаж болох вэ? Энэхүү асуултад хариулахын тулд:
- а) Сургууль болон гэрийнхээ номын санд буй түүхийн холбогдолтой номын жагсаалтыг гаргаарай.
  - б) Гаргасан жагсаалтаа сэдэв, агуулгаар нь ангилаарай.
  - в) Гаргасан жагсаалтаасаа нэг номыг сонгон уншиж, тэмдэглэл хийгээрэй.

**ТҮҮХИЙГ СУДЛАХДАА АНХААРНА УУ**

**Интернетийг ашиглах арга:** Интернет ашиглахдаа түлхүүр үг оруулахад л богино хугацаанд их мэдээлэл олж авах боломжтой.

**Хэрэглэх үед анхаарах зүйл:** Интернетийн мэдээлэл нь ашиглахад хялбар боловч тайлбар нэг тийш хэт хэлбийсэн, хувь хүний үзлээр бичигдсэн зүйл байдаг учраас анхаарах шаардлагатай. Агуулгыг тэр чигт нь хуулж бичвэл зохиогчийн эрхийн хуулийг зөрчсөн болох тал бий. Тиймээс олж үзсэн мэдээллийг тэр чигт нь хэрэглэх биш харин зөв сонгон боловсруулах хэрэгтэй юм.

**Санамж:** Баримтыг сонгохдоо уг эх сурвалжийн гарал үүсэл, хаана бичигдсэн, ямар нөхцөлд бүтээгдсэн, зохиогч нь хэн болох, баримтын нэр, он сар, үйл явдалд оролцсон хүмүүсийн нэрс зэргийг сайн нягтлан сонгох хэрэгтэй. Сонгосон баримт, эх сурвалжийн дотоод мөн чанарыг сайн нягтлан унших, мэдээнүүдийг нэгтгэн дүгнэх, бусад сурвалжтай зэрэгцүүлэн авч үзэх хэрэгтэй. Ямар ч үнэтэй эх сурвалж өөрөө үгээ хэлдэггүй. Харин тэр үгийг хэлүүлдэг. Тиймээс баримтыг тайлбарлахдаа хувийн үзэл эсвэл улс төрийн үзэлд тулгаж, тохируулж, тайлбарлаж болохгүй.

## 2

ОРЧИН ҮЕИЙН ТҮҮХЭЭР  
ЮУ СУДЛАХ ВЭ?СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Түүх бол болж өнгөрсөн үйл явдал мөн. Гэхдээ үйл явдал бүр түүх болдоггүй бөгөөд хамгийн чухал нь, бидний амьдралыг өөрчилж, бас бидэнд сургаамж өгсөн нь түүх юм.

## ГОЛ САНАА

Орчин үеийн Монголын түүхээр та бидний өнөөгийн амьдралын эх үндсийг тавьсан гол, гол үйл явдлыг судлан хэлэлцэнэ.

## ТҮЛХҮҮР ҮГ

- Түүхэн сургаамж
- Түүхийн хар толбо
- Туйлшрал



## АСУУГААРЫЙ, ТААМАГЛААРЫЙ

1. Дараах хүснэгтийг гүйцээж нөхөх замаар түүхийн үеүдэд юуг, хэрхэн судалсан талаараа сэргээн ярилцана уу.

Түүхийн үеүд	Хамрах он цаг	Түүхэн үйл явдал	Түүхэн зүтгэлтэн	Түүхэн сургаамж
Монгол ба эртний дэлхий: Нэн эртнээс Чингисийн өмнөх үе хүртэл				
Монгол ба дундад зуун: Чингисийн өмнөх үеэс ХҮ зуун				
Монголын эзэнт гүрний дараах Монгол ба шинэ үеийн дэлхий				

2. Та бүхэн түүхийг судлахдаа ямар арга, аргачлал ашигладаг вэ?

Болж өнгөрсөн үйл явдал бүхэн түүх болдоггүй. Хамгийн чухал, гол үйл явдал л түүх болон үлддэг. XX зууны Монголын түүхийн хамгийн гол асуудал буюу сэдэв юу вэ? гэдэг дээр ихэнх судлаачид санал нэгтэй байдаг. Жишээ нь, 1911 оны Үндэсний эрх чөлөөний хувьсгал бол тусгаар тогтнолынхоо төлөө монголчуудын олон зуун жилийн (1690-ээд оноос 1911 он) шургуу тэмцлийн үр дүн байв. Иймээс сурагч бүр энэ түүхэн үйл явдлыг заавал судалж мэдсэн байх хэрэгтэй. Мөн 1921 оны 2 сард Оросын цагаантны цэргийн генерал Ф.Унгерн Богд Жавзандамбын зөвшөөрсний дагуу хятадын цэргийг Нийслэл хүрээнээс хөөн зайлуулсан нь Монголын тусгаар тогтнол дахин сэргэх боломж бүрдүүлсэн билээ. Иймээс энэ бол түүхийн гол үйл явдал мөн гэдгийг үгүйсгэх учиргүй. Ер нь 1921, 1990 онд Монголд улс төрийн том үйл явдал болж өнгөрснийг Монголын түүхэнд заавал авч үзэх ёстой.

1921-1924 онд Монголын удирдагчид улс орноо дэлхийн жишгээр хөгжүүлж хоёр хөрш улс болон бусад улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын найрсаг

харилцаатай байхыг хичээж байлаа. Гэтэл 1924 оны 8 сард хуралдсан МАН-ын III их хурал, мөн оны 11 сард хуралдсан Улсын I их хурлын шийдвэрүүдэд Монгол Улсын хөгжлийн чиглэлийг огт өөрөөр тодорхойлсон нь XX зууны Монголын түүхийн тойрч өнгөрөх аргагүй чухал сэдэв юм. Яагаад гэвэл Монгол улс 1924 оноос 1990 он хүртэлх хугацаанд үндсэндээ хойд хөршөөсөө хараат улс байсныг судалж, түүхэн сургамж авах учиртай.

Энэ үеийн түүхийн чухал үйл явдлууд “баруунтан, зүүнтэн”-ий үед болсон байдаг. Баруунтны бодлого 1921-1924 онд нилээд амжилттай хэрэгжиж байв. Тэд улс орноо хүн төрөлхтний хөгжлийн жам ёсоор буюу дэлхийн жишгийг үлгэр загвар болгохыг хичээж байв. Гэтэл 1924-1928 онд тэднийг буруутгаж, удирдах албан тушаалаас нь хөөн зайлуулжээ. Түүгээр ч зогсохгүй заримыг нь цаазалж, заримыг нь ЗХУ-д нутаг заан цөлснөөр баруунтны бодлого бүр мөсөн тасалдсан юм. Зүүнтэн бол ЗХУ-ын удирдагчдын зааврыг туйлын үнэн хэмээн итгэж, Монгол Улсаа хөгжүүлэхийн тулд ЗХУ-аас өөр ямар ч улс оронтой харилцахгүй, хувийн өмчийг ямагт хязгаарлаж яваандаа устгаж нийгмийн өмчтэй болно гэж үздэг хүмүүс байлаа. Тэд “шашин бол хар тамхи мэт хортой, лам хувраг ялангуяа, эрдэм мэдлэгтэй, зэрэг хэргэмтэй хутагт хувилгаад бол хувьсгалын дайсан” хэмээн үзэж байв. Энэ гашуун үнэнийг мэдсэнээр түүнийг дахин давтахгүй байх, түүнээс ухаарал сургамж авахад тустай.

1929 оноос эхлэн дэлхий дахины эдийн засаг, улс төр ихээхэн хямарсан юм. Ялангуяа, дорно дахинд Япон ихээхэн хүчирхэгжиж, Хятадын зах хязгаар нутгаас булаан авч Манж Го улс байгуулсан нь манай улстай хил залган орших болов. Үүнийг ЗХУ ихээр сэжиглэн 1932-1940 онд лам нар, төрийн

албан хаагчид, эгэл ардыг Манж Го улсад хандаж болзошгүй хэмээн хардаж сэжиглэн тэднийг хувьсгалын эсэргүү хэмээн оргүй хилс хэрэгт олноор нь хэлмэгдүүлсэн билээ. 1922 оноос анх эхэлсэн энэ хийрхэл 1937 онд оргилдоо хүрч 1939 оноос бага зэрэг саарч 1950-аад оноос 1990 он хүртэл янз бүрийн нэр хаягтайгаар үргэлжилсэн. Энэ бол XX зууны Монголын түүхэнд тохиосон гүн эмгэнэл байсан юм. Монгол төрийн эрх мэдэл харийнхны мэдэлд орж, үндэсний соёл, хууль ёсыг эс хэрэгсвэл ямар их аюултайг сургамж болгохын тулд энэ тухай заавал мэдэх, ойлгох хэрэгтэй.

Дэлхийн II дайн эхэлсэн, төгссөн талаар тун анхаарч судлах шаардлагатай. Учир нь энэ дайн Халх голын дайнтай холбогддог бөгөөд энэ дайн манай түүхийн чухал асуудал мөн билээ. 1941-1945 онд БНМАУ-ын түүхэнд олон гол үйл явдал болсноос хамгийн гол нь 1945 оны 10 сарын 20-нд болсон бүх ард түмний санал хураалт гэдгийг онцлох хэрэгтэй. Мөн 1961 оны 10 сарын 27-нд манай улс НҮБ-д элссэн нь Монголын түүхийн онцгой чухал үйл явдал юм. Бас XX зуунд Монгол Улсын боловсрол гэгээрэл, соёл шинжлэх ухааны салбарт олсон амжилтыг судлан таньж, үнэлэн бахархах учиртай.

1990 он буюу цагаан морин жилийн хувьсгал бол Монголыг дэлхийд таниулж ард иргэддээ эрх, эрх чөлөөг бодитойгоор эдлэх бүх боломжийг олгосноороо, Монголын түүхэн дэх үндсэн эргэлтийн эхлэлийг тавьснаараа үл мартагдах түүхэн үйл явдал билээ. Энэ хувьсгалыг манай бүх иргэд хэний ч албадлагагүйгээр дэмжсэн учраас маш тайван замаар улс орноо зөв замд оруулж чадсан юм.

Ер нь аливаа үйл явдал өргөн олны сэтгэлд нийцсэн бол заавал тэдний дэмжлэг хүлээж зорилгодоо хүрч чаддагийг Монгол болон дэлхийн



бусад оронд болсон үйл явдлууд нотолсон билээ. 1911 оноос эдүгээ хүртэлх үеийн Монголын түүхэнд тохиосон олон үйл явдлаас ард иргэдийн сэтгэлд нийцэж дэмжлэг олсон ба эс нийцэж дургүйцэл төрүүлсэн ямар ямар үйл явдал байсныг энэ сурах бичгээс та нар ойлгож авах болно. Монголын түүхэнд тодорсон Чингис, Хубилай, Батмөнх, Лигдэн, Занабазар, VIII Богд Жавзандамба, Ханддорж, Цэрэнчимэд, Хайсан, Намнансүрэн, Бодоо, Данзан, Сүхбаатар, Цэрэндорж, Амар, Дамбадорж, Чойбалсан, Цэдэнбал, Зориг нарыг манай Монгол ба дэлхийн олон орны ард түмэн мэднэ. Түүхэн зүтгэлтнүүд бол улс орныхоо сайн сайхны төлөө тууштай тэмцэгчид байдаг.



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Эхээс мэдсэн, ойлгосон зүйлсээ бүдүүвчлэн тэмдэглэж, танилцуулна уу.
2. Орчин үеийн монголын түүхийн гол, гол үйл явдлын талаар өөрийн мэдлэг, ойлголтоо бусадтайгаа хуваалцана уу.
3. Дараах үг тус бүрээр 3-5 өгүүлбэр зохионо уу.
  - Түүхийн сургамж
  - Түйлшрал
  - Түүхийн хар толбо
  - Морин жил
4. Түүхийн сургамж гэж юу вэ? Түүхээс хэн, хэрхэн сургамж авах ёстой вэ?

### ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Түүх
- Түүхийн эх сурвалж
- Түүхийн сургамж

1. Түүх судлахын тулд та бүхэнд ямар бэлтгэл хэрэгтэй талаар ярилцаж, жагсаалт гаргана уу. Тухайлбал,

- а) Орчин үеийн монголын болон дэлхий дахины түүхийг судлахын тулд ямар мэдлэг хэрэгтэйг
- б) Мөн ямар чадвар шаардлагатай болохыг гэх мэт

2. Орчин үеийн Монголын түүхийг судласнаар ямар сургамж авч болохыг хэлэлцээрэй.

3. Та 9 дүгээр ангид түүхийг хэрхэн судлах төлөвлөгөөгөө гаргаарай.



# II БҮЛЭГ

## МОНГОЛ ТӨРИЙН СЭРГЭН МАНДАЛТ БА ДЭЛХИЙ ДАХИН (1911-1924)

### 1

## 1911 ОНЫ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУВЬСГАЛ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Монголын Үндэсний хувьсгал нь эзэн Чингисийн байгуулсан Монгол төрийг сэргээн, орчин үеийн монголын түүхийн эхлэлийг тавьсан юм.

### ГОЛ САНАА

1911 онд монголчууд тусгаар тогтнол, төр улсаа сэргээн, дэлхий дахинаа тунхаглав.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Үндэсний хувьсгал
- Тусгаар тогтнол
- Үндэсний бахархал
- Богд Жавзандамба хутагт
- Монгол улс
- Монгол овогтон
- Монгол үндэстэн



## АСУУГААРЫЙ, ТААМАГЛААРЫЙ



Зураг 2.1. Манжийн Бадаргуулт Төрийн 362 (1907) оны 5 сарын 15-нд үйлдсэн газар зүйн зургаас авав. ҮТ Архив, Газар зүйн зургийн цуглуулга № 33

Эрдэмтэн Хук цагаан хэрмээс хойших Монголын газар нутаг руу давшлан орж буй хятадуудыг “Говь цөл рүү мөлхөж буй могой адил” хэмээн зүйрлэсэн байдаг.

“Хятад хүн, монгол газарт тариа хагалж болохгүй, монгол эм охиныг гэргий болгон авч болохгүй”

“Зарлигаар тогтоосон Гадаад Монголын төрийг засах явдлын яамны хууль зүйлийн бичиг”-ээс

Манжийн төр монголын талаар баримталж байсан бодлогоо өөрчилж, XIX зууны сүүлчээс Шинэ засгийн бодлого (ШЗБ) явуулж эхлэв. Энэ бодлогоор хятад иргэд олноор Монголд суурьших, тариалан эрхлэх, монгол эхнэр авах эрхтэй болов. “Хятад иргэдийг Монголд нүүлгэх товчоог” 1906 онд Бээжинд байгуулж, дараах бодлогыг хэрэгжүүлжээ. Үүнд:

- Монголын нутгийн тариалж болох бүх газрын 50 хувийг өртгөөр нь худалдан авах;
- Монголын эдийн засаг, ашигт малтмал, ажиллах хүч зэргийг 14 зүйлээр байцаан бүртгэх;



## ТОДРУУЛГА

1900 он: Улиастайд Манжийн эсрэг Монгол цэргийн бослого гарав.  
 1900 он: Богд гэгээн шадар туслахуудаа Орос улсад нууцаар илгээв.  
 1910 он: Хүрээний лам нар болон хятадуудын хооронд зодоон болов.

- Эх сурвалж болон мэдээлэл тус бүрийн агуулгыг шүүн хэлэлцэнэ үү.
  - Та бүхэнд аль үеийн түүхийн талаар, ямар мэдээлэл өгч байна вэ?
  - Дээрх эх сурвалжуудыг хаанаас авсан бол...?
- XIX зууны сүүл XX зууны эхээр монголчууд, монгол орон ямар байдалтай байсныг төсөөлнө үү.
- Монголчууд хятадчилах бодлогоос хэрхэн ангижирсан талаар асуулт гаргаж, хэн, ямар зүйлийг, хэрхэн хийж байсан талаар өөрсдийн мэдлэг, мэдээллээ харилцан солилцоорой.
- Та бүхний гаргасан асуултад хариулах, мэдлэгээ өргөтгөхөд ямар эх сурвалж болон мэдээлэл хэрэгтэй талаар ярилцаарай.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

## 1911 ОНЫ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУВЬСГАЛЫН ӨМНӨХ БАЙДАЛ

1911 онд Монгол тусгаар тогтнол, төр улсаа сэргээсэн билээ. Үүний өмнө монгол орны байдал ямар байсан талаар авч үзье.

Оросууд 1861 онд Хүрээнд Консулын газраа нээж, улмаар Монголд худалдаа арилжаа өрнүүлж, хятад худалдаачидтай өрсөлдөхийг санаархаж байлаа. Тэд “Монгол бол хятадтай бус эрх баригчидтай нь холбоотой байсан. Тэд эрх барихаа болихоор эл холбоо тасарч монгол урьдын адил тусгаар орших учиртай, бид үүнд нь туслах болно” гэх болов. 1907 онд Орос, Япон хоёр нууц гэрээ байгуулжээ. Тус гэрээгээр Японы эзэн хааны засгийн газар Орос улсын Гадаад Монгол дахь тусгай сонирхлыг хвлээн зөвшөөрчээ.

XX зууны эхээр Манжийн эрх баригчдыг унагах гэсэн хятадын Синьхайн хувьсгал гарч Манж Чин гүрний эзэн хааны засаглалыг сандаргав. Тухайн нөхцөл байдлыг VIII Богд Жавзандамба хутагт болон монгол ноёд “дотоод газар цаг самуун болсон нь манай Монголд завшаан болж” байна хэмээн үйл ажиллагаагаа идэвхжүүлжээ.

1910 оны 3 сард Хүрээний лам нар хятадуудтай хийсэн зодооныг монголчууд дэмжиж хятад пүүсийг шатаажээ. Уг хэргийг зохицуулахаар хүрээний амбан Сандо өөрийн биеэр очсон боловч уурссан монголчууд чулуугаар нүүлгэн буцаав. Манжийн амбан сайд Сандо зодооныг толгойлж, удирдсан Жавзандамба хутагтын туслах, шанзав нарыг баривчлах гэсэн боловч Богд гэгээнтэн тавьж өгөөгүйгээр үл барам ордондоо нуужээ. Энэ нь зөвхөн хэдэн лам танхайрсан хэрэг төдий бус монголчуудын дургүйцэл хэчнээн хурцадсныг харуулсан хэрэг байлаа. 1911 оны эхээр Манжийн эрх баригчид Хүрээний амбангийн мэдэлд байдаг хойд хилийн монгол харуулуудыг хятад цэргүүдээр сольсон нь монголчуудын дургүйцлийг бүр ч их хүргэв.

## УРЬД

1636 онд Өмнөд Монгол,  
 1691 онд Халх Монгол,  
 1755 онд Ойрад Монгол тус тус Манжийн эрхшээлд оржээ.

**НОЁДЫН НУУЦ ЗӨВЛӨЛГӨӨН БА МОНГОЛД ТҮР ЗАСГИЙН ГАЗАР БАЙГУУЛСАН НЬ**

1911 оны зун Богд Жавзандамба хутагтын зарлигаар дөрвөн аймгийн хан, ван, ноёдын зөвлөлгөөн Их Хүрээнээ болов. Түүнд Хамба номунхан Пунцаг, гүн Содномдорж, да лам Цэрэнчимэд, чин ван Ханддорж, Сайн ноён Намнансүрэн, дархан ван Пунцагцэрэн, түшээт гүн Чагдаржав, далай ван Гомбосүрэн, далай чойнхор ван Цэдэнсоном, ван Намсрай, гүн Хайсан нарын зэрэг хүмүүс оролцжээ. Тэд Монголын тусгаар тогтнолыг хэрхэн сэргээх тухай хэлэлцсэн байна. Улмаар Халхын Хүрээний газрын бүгд хэргийг түр ерөнхийлэн захиран шийтгэх газар буюу Түр засгийн газрыг нууцаар байгуулжээ.

Хүснэгт 2.1. Үндэсний хувьсгалын үйл явц

1900 он	1907 он	1908 он	1909 он	1911 он
Богд гэгээн Шанзудба Бадамдорж, зайсан Цэрэн-Осор нарыг Орос улсаас мөнгө зээлэх нэрийн дор тусламж гуйхаар илгээв.	Өвөр Монголын харчин гүн Хайсан, Алмас-Очир нар Их Хүрээнд сэм ирж, Богд гэгээнтэн, монгол ноёдтой зөвлөлджээ.	Богд гэгээнтэнд бат оршил өргөсний дараа монгол ноёд зөвлөлдөв.	Монгол тусгаар тогтнох “тэнгэрийн цаг болов” хэмээн Богд гэгээн зарлиг буулгажээ.	Монгол тусгаар тогтнол, төр улсаа сэргээн дэлхий дахинд тунхаглаж, Богдыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөв.

Их Хүрээ, Богд ууланд нууцаар хуралдсан ноёдын зөвлөлгөөнөөс Орос улсаас тусламж эрэх шийд гарсан байна. Богд Жавзандамба хутагт Халхын Түшээт хан Дашням, Сэцэн хан Навааннэрэн, Сайн ноён Намнансүрэн, Засагт хан Содномравдан нар нэр хамтран Оросын эзэн хаанд захидал бичиж, Чин ван Ханддорж тэргүүтэй Да лам Цэрэнчимэд, Гүн Хайсан нарын элч төлөөлөгчдийг нууцаар илгээжээ.

- Монгол төрийг сэргээн мандуулах тухай ухуулан зарлах тунхаг бичиг гаргав.
- Сандо амбаныг хүрээнээс хөөсөн бичиг хүргүүлэв.

Манж амбан Сандо Хүрээнээс хөөгдөн гарав.

Ня	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя
					1	2
3	4	5	6	7	8	9
10	11	12	13	14	15	16
17	18	19	20	21	22	23
24	25	26	27	28	29	30
31						

1911 оны 12 сарын 29-ний өдөр Монгол Улс тусгаар тогтнолоо сэргээн тунхагласан тул энэ өдрийг 2011 оноос эхлэн Монгол Улсын Их хурлын шийдвэрээр үндэсний баярын өдөр хэмээн тэмдэглэж байна.



Зураг 2.2.

**VIII Богд Жавзандамба** хутагт 1869 онд Төвөдэд төржээ. 1874 оноос Халх монголын бурхны шашны тэргүүн, 1911 оноос Монгол улсын төр, шашныг хослон баригч эзэн хаан, 1921-1924 онд хэмжээт цаазат хаан сууж байгаад 1924 оны 5 сарын 20-нд таалал төгсчээ.

**Улсын эх дагина Дондогдулам** Сэцэн хан аймгийн Хөвчийн жонон бэйс Цанлигдоржийн хошууны нутагт Цэндийн гэр бүлд мэндэлжээ. 1896 оноос Богдтой ханилж, 1902 оноос Цагаан Дара, Эрдэнэ сэцэн, 1911 оноос улсын Эх дагинаар тус тус өргөмжлөгджээ.

## ТӨРИЙН ИХ ЁСЛОЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА

“Монголын цагагчин гахай жилийн 11 сарын шинийн 9 бөгөөд Европын 1911 оны 12 сарын 29-ний өдөр Богд Жавзандамба хутагт ламыг Монгол Улсын хаанд өргөмжлөх явдлыг гуйн айлгаж мөн өдрийн 11 цагт эрдэнийн ширээнд залж суулгаад басхүү шавь охин эрдэнэ сэцэн Цагаан Дара Дондогдуламыг улсын эхэд өргөмжлөн хамтаар ёслох учир хааны эрдэнэ, хасын тамга, алтан үсэгт өргөмжлөл ба Монголын газраас гарсан ёсны юм есөн цагаан билгийн цагаан тэмээ, мөнгөн буйл, булган мулцагт нэжгээд цагаан морь, булган мулцагт наймаад хадаг сэлтийг бэлэглэн өргөхдөө төрийн ордноо хуралдсан хүн бүгдээр хичээнгүйлэн Богд хаан, Улсын эхэд тус тус гурвантаа сөгдөж, есөнтөө толгой дохиж” мөргөжээ.

*Н.Магсаржав Монгол Улсын шинэ түүхээс. УБ, 1994*

Мөнөөхөн өвлийн дунд сарын шинийн есөн болж ирэв. Мөнхүү өглөө чуулганы даргын жасааны түшмэл, бичээч нарын хамт залан Дашдондов, Анваан нар малгай, хүрэм болон Их Хүрээний төвийн шар ордны тэнд очиж, мориноос буугаад их хаалганы өмнө хүрэхэд олон хүн хуралдаж, үнэхээр нүд алдам их байв. Отго жинс хүрэм эрээн дээлтэй ноёд, түшмэд, хутагт хувилгаад, лам нар жагсан хүлээж байна...

.... Богд, эх дагина хоёр хар үнэг гэдэг үнэт үстэй малгайд очир жинс хадаж, эрээн дээл, булган цоохор хүрэм өмсөж, явганаар шадар ноёд, сойвон, донир нарыг дагалдуулан хойноо шар торгон баалтан саалуу хээт шүхэр хоёр тогосны өдөн шүхэр нэг, ийм гурван шүхрийг бариулж, өмнө нь донир ба улаан хуйт сэлэм зүүсэн хар ноён хоёр хүн удирдан, мөнөөхөн бэлтгэсэн шар торгон зам дээгүүр алгуурхнаар алхуулан явахад нь шадар ноёд дөрвөн хүн Богд, эх дагины хоёр талаас нь түшиж хүндэтгэн явна....

*Г.Навааннамжил Өвгөн бичээчийн өгүүллээс. УБ, 1956*



Зураг 2.3. Богд хааны мөнгөн тамга

Улсын цол МОНГОЛ хэмээн тэмдэглэжээ. Энэ бол нийт монгол овогтон угсаатанд хамаатай нэр, энэ нь угсаа гарлын болон түүхийн хувьд монгол нэг юм гэдгийг илтгэсэн аж. Оны цолыг ОЛНОО ӨРГӨГДСӨН хэмээн нэрлэж, 1911 оныг Олноо өргөгдсний тэргүүн он болгов. Улсын нийслэлийг НИЙСЛЭЛ ХҮРЭЭ хэмээн өргөмжлөв.



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Уншиж, ойлгосноо хүснэгтийн дагуу шинжлээрэй.

Мэдлэг, мэдээллийг			
Хаанаас авав?	Юу мэдэв?	Юу чухал байв? яагаад?	Юуг, яагаад лавшруулан судлахыг хүсэв?
Эхээс			
Баримтаас			
Хүснэгтээс			
Зургаас			
Хуанлиас			

- 1911 оны Монголын үндэсний хувьсгалын түүхийн он цагийн хэлхээсийг хийнэ үү. Хувьсгалын оргил үе хэдийд байв? Яагаад оргил үе гэж үзэв?
- Энэ хувьсгалын түүхэн зүтгэлтнүүдийг нэрлэнэ үү. Хэн, ямар үүрэг гүйцэтгэснийг ярилцаарай.
- 200 жил тасарсан монгол төрийг сэргээн тогтоосон их ёслолыг дүрслэн харуулна уу. Энэ их ёслолын тухай бага ангийн сурагчдад зориулсан мэдээлэл бэлтгэнэ үү.

1911 оны Үндэсний хувьсгал монголчуудад тусгаар тогтнол, үндэсний бахархлыг нь эргүүлэн авчирсан юм. Дэлхийн түүхийн бүхэл бүтэн хоёр зууныг тодорхойлж байсан монголчууд уруудан доройтож, 200-аад жил бусдын эрхшээлд байсан билээ. ХХ зууны эхээр Манжийн эрхшээлээс гарч, үндэсний тусгаар тогтнол, төр улсаа сэргээж, Монгол Улсын эзэн хаанаар бурхны шашны тэргүүн Богдыг өргөмжилсөн нь монгол хүн бүрийн сэтгэлийг сэргээсэн юм. 1911 оны үндэсний хувьсгал амжилтад хүрсэн нэг гол учир утга нь бүх монгол овогтон үндэсний үзлээрээ нэгдэж, нэгдмэл нэг зорилгын төлөө бурхны шашныхаа тэргүүнийг хүрээлж, түүхэн амжилтад хүрсэн явдал билээ. 1911 оны үндэсний хувьсгал нь монгол төрийн гал голомтыг сэргээж, монгол үндэстний цаашид оршин байх үндсийг тавьж, үндэсний уламжлал, зан заншил, соёлыг бадраах үндэс болсноороо монголчуудын түүхэнд хүндтэй байр суурь эзэлдэг.

ҮНЭЛЭЭРЭЙ

1911 ОНЫ МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ХУВЬСГАЛ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Үндэсний хувьсгал
- Тусгаар тогтнол, үндэсний бахархал, үнэт зүйлс
- Богд хаан, Сайн ноён хан Намнансүрэн, Чин ван Ханддорж, Чин ван Чагдаржав, Далам Цэрэнчимэд, Хайсан гүн

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Монголын үндэсний хувьсгал хэрхэн өрнөснийг дүрслэн гаргаарай. <ul style="list-style-type: none"> <li>• Удирдагчид, оролцогчид</li> <li>• Гол, гол үйл явдал өрнөсөн арга зам</li> <li>• Он цаг, хугацаа (эхэлсэн, төгссөн)</li> <li>• Хүмүүсийн сэтгэл санаа</li> </ul>	2. 1911 оны үндэсний хувьсгалын ач холбогдлыг “тусгаар тогтнол, үндэсний бахархал” гэсэн ойлголтуудтай холбон тодорхойлоорой.	3. 200 жил тасарсан монгол төрийг сэргээн тогтоосон их ёслолын тухай бага ангийн сурагчдад зориулсан мэдээлэл хийхэд бэлтгээрэй. 4. Үндэсний хувьсгалын түүхэн зүтгэлтнүүдийн цомог хийгээрэй. <i>Ашиглах зүйл: Монголчууд XX зууны эхэнд, зурагт түүх. (УБ., 2011.) болон бусад эх сурвалж</i>

ТОЛЬ

Шинэ засгийн бодлого	Манж Чин улсаас Монголд хэрэгжүүлсэн бодлого
Улсын цол	Монгол
Оны цол	Олноо өргөгдсөн
Нийслэл хот	Нийслэл Хүрээ



Зураг 2.4. Хаан төрийн долоон эрдэнэ



2

ТУСГААР ТОГТНОСОН МОНГОЛ УЛС

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Үндэсний тусгаар тогтнолоо бэхжүүлж, монгол овогтноо нэгтгэн, дэлхийн улс гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө тэмцэв.

ГОЛ САНАА

Монгол Улсын хаан Богд Жавзандамба засгийн газраа эмхлэн байгуулж, төр улсаа төвхнүүлэв.

ТҮЛХҮҮР ҮГ

- Монголын Засгийн газар
- Богд хаан
- Чин ван Ханддорж
- Сайн ноён хан Намнансүрэн
- Да лам Цэрэнчимэд



АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

Зураг 2.5. Монгол улсын Засгийн газрын сайдууд



Ерөнхий сайд Т.Намнансүрэн

Дотоод хэргийн яам Г.Цэрэнчимэд

Гадаад хэргийн яам М.Ханддорж

Цэргийн яам С.Гомбосүрэн

Сангийн яам Г.Чагдаржав

Шүүх яам Э.Намсрай

ЦАХИЛГААН МЭДЭЭ


Дундад Иргэн Улсын их ерөнхийлөгч Юан Ши Кайгаас	Монгол Улсын эзэн хаан Богд Жавзандамбаас
<p>“Монгол газар хэдий уудам боловч хүний тоо даанч цөөн”, “Олон монголчууд хятад лугаа зах нийлэн сууж харилцан түшилцвээс харин улс төр дор тустай бөгөөд нийлэлцвээс хоёр этгээдэд ашиг буй. Салалцваас хоёр этгээдэд хохирол буй” гэх зэргээр сургаж, Богд хааныг «хэрхэвч бээр бүү гажуу үгс дор баширлагдан, Гадаад Монголд мохош үгүй гэмшлийг хоцроотугай»</p>	<p>“Ноднин өвөл Гадаад Монгол дан гагц цагийн байдал маш түгшүүртэй учир гагцаар тогтнохыг зарлан ухуулаад Жавзандамба лам намайг бүгдээр өргөмжлөн Монгол Улсын хаан эзэн болгох тухай дор хүчлэн маргавчаар болсон үгүй... Гадаад Монгол энэ удаа журмыг үүсгэсэн нь язгуураас үндсээ батлан шашнаа баталж харьяат газраа бүрэн бүтэн болгон батлахын санаа болой. Ер өөр горилох зүйл бүхий нь бус. Үнэхээрийн харгис засаг дор зовж зүдэрсний учир болой” ...</p> <p>“Байцаавал нэг. Ин улс (Англи улс) Мэй улс (АНУ)-ыг дагуулан нэгэн хааны захиргааны хүн болжээ. Хойно Мэй улсын хүн дангаараа тусгаар улс болж, харилцан гэрээ бичиг байгуулж, эдүгээ хүртэл тасраагүй тус тусдаа улс болсонд харшлалтай болсонгүй”</p>

“Улс хэмээгч олон хүн нар нийлж нэгэн газар оршин, өөртөө захирагдаж, бусдын эрхийг үл дагах, дотоод, гадаад их, бага хэргийг цөм өөртөө эзэрхэж, тусгаар тогтносны нэр. Газар оронгүй бөгөөс улс үгүй. Улс мөхвөөс улсын газар орон гэж үгүй болно. Улсын газар орон хэмээгч өөртөө эзэрхэж, өөртөө тогтносон улсын магад нэгэн бэлгэ тэмдэг мөн”

Жамсрангийн Цэвээн., “Улсын эрх”, 1915 он

1. Нэр бүхий түүхэн зүтгэлтнүүдийн тухай мэдээллээ хуваалцана уу. Монголын түүхэнд ямар гавьяа байгуулсан бэ?
2. Богд эзэн хаан болон Юан Ши Кай нарын солилцсон цахилгаан мэдээний агуулгыг шүүн хэлэлцэнэ үү. Тэдний хэн нь, ямар бодлого баримталж байсныг тодорхойлно уу.

**Бүдүүвч 2.1. Богд хааны Засгийн газрын бодлого**



Шинэ тутам тусгаар тогтнолоо зарласан Монгол Улс юуны өмнө төр засгаа төвхнүүлэх нь чухал байлаа. Тиймээс Засгийн газрын бүтэц, бодлого, үйл ажиллагаа, улсын сан, хил, гааль, татвар, засаг захиргааны талаар зарлиг буулгаж, төр засгийн бүтэц, засаг захиргааны хуваарь, эдийн засаг, эрх зүйн үндсийг тавьсан байна.

1912 онд Богд хааны зарлигаар Нийслэл Хүрээ, Улиастай, Хиагт хотуудад гаалийн хороо байгуулж, Монгол Улсын хилээр орж буй (импортын) архинаас бусад бүх бараанаас 5 хувь, архинаас 10 хувийн татвар, хилээр гарч буй (экспортын) хөлөөр гаргах мал, түүхий эдээс 5 хувийн гаалийн татвар хурааж эхэлсэн байна. 1912 оноос эхлэн хятад худалдаачдын малаас бэлчээрийн татвар авах болжээ. Тухайлбал, тэмээ нэг бүрээс 1 лан, адуу бүрээс 0.5 лан, хонь, ямаа нэг бүрээс 0.1 лан, ботго бүрээс 0.3 лан, унага, тугал бүрээс 0.2 лан, хурга, ишиг бүрээс 5 пун мөнгө жил бүр хураан авч байжээ.

**ТОДРУУЛГА**

Дараах цахим хуудаснаас тоо баримт, мэдээллийг дэлгэрүүлж үзээрэй.


[www.mof.gov.mn](http://www.mof.gov.mn) Сангийн яам.

[www.mfa.gov.mn](http://www.mfa.gov.mn) Гадаад Яам.

[www.moj.gov.mn](http://www.moj.gov.mn) Хууль зүйн яам

[www.mod.gov.mn](http://www.mod.gov.mn) Батлан хамгаалах яам

**Бүдүүвч 2.2. Монгол Улсын засгийн газрын бүтэц**



Монгол Улсаа төвхнүүлэхдээ дэлхийн хөгжилтэй орнуудын дэвшилтэт туршлагыг тусгахыг хичээж байв. Үүний тод илрэл нь тулгамдсан асуудлыг хэлэлцэж, бодлого боловсруулах, зөвлөх эрхтэй дээд, доод хоёр танхим бүхий Улсын хурлыг Богд хааны зарлигаар 1914 оны хавар байгуулсан явдал мөн.

Хүснэгт 2.2. Улсын хурал

Улсын хурал	Эрх хэмжээ	Эрх бүхий албан тушаал	Хурлыг удирдах албан тушаалтан
Дээд хурал	Улс төрийн чухал хэрэгт баримтлах бодлого боловсруулан хаанд айлтгах	Яамдын тэргүүн, дэд сайд, ван, бэйл, бэйс, гүн, засгууд, Их шавь, Хөлөнбуйр, Дарьганга, Цахарын зэрэг бүгдийн дарга	Ерөнхий сайд
Доод хурал	Улсын аливаа хэрэгт тустай санаа сэдэж, зөвлөн хэлэлцээд дээд хуралд оруулах	Яамдын дэс түшмэл, эх зохиогч түшмэл, Эрдэнэшанзудбын яам, дөрвөн аймгийн жанжин, суурин жасааны нэг түшмэл г.м.	Ерөнхий сайдаас томилсон албан тушаалтан

Тусгаар улс, түүний төр захиргаанаас хийсэн эхний ажлуудын нэг нь Монгол улсын хууль тогтоомжийг боловсруулах, хэрэгжүүлэх ажил байлаа. Богд хааны зарлигаар Монголын эрдэмтэн мэргэд, төрийн түшээд 1913-1918 онд Монгол улсын хууль зүйлийн бичиг 65 дэвтрийг боловсруулжээ. Монгол Улсын төрийн тогтолцоог шинэчлэн бий болгох, хууль цааз боловсруулах, гадаад улстай гэрээ хэлэлцээ байгуулахдаа уламжлалт хууль цаазаас гадна гадаад улсуудын төр эрх зүйн



Зураг 2.6. Монгол цэргүүд

баримт бичгүүдээс хөрвүүлэн ашиглаж байв. Тухайлбал, Америкийн хуульч, дипломат Хенри Вьютоны “Elements of International Law” зохиолыг “Түмэн улсын ердийн цааз” нэрээр хөрвүүлэн ашигласан байдаг. Хууль тогтоомжуудыг Улсын дээд, доод хурлаар хэлэлцүүлж, Богд хааны зарлигаар батлуулж байжээ.

Монгол Улсын Засгийн газар улс орныхоо аюулгүй

байдлыг хангах байнгын армитай байх нь зүйтэй гэж үзлээ. Энэ зорилгоор дараах ажлыг хийсэн байна. Үүнд:

- 1912 онд Хужирбуланд цэргийн сургууль нээсэн.
- 1913 онд “Монгол цэрэг бэлтгэн сургах тухай Монгол -Оросын цэргийн гэрээ”-г байгуулсан. Энэ гэрээгээр 1900 хүнтэй морин цэргийн бригад байгуулахаар заасан. Мөн Оросын 49 сургагч ажиллуулах цэргийн хэрэгт зориулж зээл олгох болсон байна.

Тусгаар тогтносон улсын нэг чухал шинж бол бусад улс орнуудад хүлээн зөвшөөрөгдөх, тэдэнтэй харилцах явдал юм. Үүний тул Богдын Засгийн газар юуны



өмнө манж Чин улсын Засгийн газарт цахилгаан илгээжээ. Гэвч Манж Чин улс шинэ тулгар Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн хариу өгсөнгүй. Манж Чин улсын ноёрхол эцэс болсны дараа суурин дээр нь тогтсон Дундад Иргэн улс (ДИУ) манжийн төрийн бодлогыг үргэлжлүүлэхийг санаархаж байлаа.

Оросын эзэнт гүрний Засгийн газар Монгол Улсын тусгаар тогтнолыг шууд дэмжээгүй мэт боловч Монголын асуудалд анхаарал тавьж, мэдэгдэл гаргаж байв.

Монголын Засгийн газраас 1912 онд Монгол Улсыг байгуулсан учрыг мэдэгдэн дэлхийн 9 улсад нот бичиг илгээсэн байна.

**ТОДРУУЛГА**

Нот бичгийн агуулга: «эдүгээ манай Монгол Улс нийт бүхнээр эртнээс тогтносоор ирсэн өөрийн газар орон ба шажин суртаал ёс журмыг алдагдах үгүйгээр сахих учир нэгэнт Чин улсаас салаад өөртөө тогтнож өөрөө эзэрхэх улс төр байгуулан халх монголын шарын шашны эзэн Жавзандамба лам юугаа Монгол Улсын хаан эзэнд өргөмжлөн шашин төрийг хослон бариулаад Олноо өргөгдсний тэргүүн он хэмээн халсан зэрэг явдлыг» эрхэм улсын Гадаад явдлын яамнаа мэдэгдэж, цаашид улс хоорондоо гэрээ байгуулан худалдаа нэвтрүүлэн харилцаа тогтоох санал дэвшүүлсэн байна.

*Хүснэгт 2.3. Богд хаант Монгол Улсын гадаад харилцааны он цаг*

1912 он		1912-13 он		1913 оны эхээр	1913-14 он	1915 он
11 сар: Орос Монголын гэрээ	Франц, Бельги, Англи, Япон, Их Герман, Америк, Дани, Голланд, Орос улсад нот бичиг илгээв.	12 сар: Монгол Төвөдийн гэрээ	Гадаад яамны сайд Ханддорж тэргүүтэй төлөөлөгчдийн Орос улсад хийсэн айлчлал	Дотоод яамны сайд Да лам Цэрэнчимэд тэргүүтэй төлөөлөгчид Япон улсыг зорив.	Ерөнхий сайд Т.Намансүрэн тэргүүтэй төлөөлөгчид Орос улсад айлчлав.	Хятад, Орос, Монгол гурван улсын Хиагтын гэрээ
Монгол Улс тусгаар тогтносноо мэдэгдсэн. Харилцаа тогтоож, хамтран ажиллахыг эрмэлзэв.		Зэвсэг ба санхүүгийн тусламж авах, Бусад улсын элчин сайд лугаа уулзах Англи, Франц зэрэг улстай харилцаа тогтоохыг зорив.		Тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх Өвөр Монгол, Баргыг хамгаалуулах хүсэлт гаргав.	Орос, Хятадын 1913 оны тунхаглалыг үл зөвшөөрөхөө мэдэгдэх Өвөр Монголыг нэгтгэхэд дэмжлэг авахыг хүссэн.	Орос, Хятад хоёр хуйвалдан, Монголын хил хязгаарыг Халх дөрвөн аймаг, Ховдын хязгаарын нутгаар хязгаарлав. Өвөр Монгол, Баргыг Монголоос тусгаарлав.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Шинэ тутам тусгаар тогтносон Монгол улсын төр засгийн зохион байгуулалтыг тайлбарлана уу. Манай улсын анхны яамдыг нэрлэж, тэдгээр яамд ямар үйл ажиллагаа явуулж байсан талаар мэдээлэл солилцоно уу.
2. Богдын Засгийн газрын хамгийн түрүүнд хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийн талаар юу мэдэв? Яагаад эдгээр арга хэмжээг нэн тэргүүнд хэрэгжүүлэх болсон тухай эргэцүүлээрэй.

Монголын цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн 9 буюу Европын 1911 оны 12 сарын 29-ний өдөр монголчууд манжаас салж, тусгаар тогтнол, төр улсаа сэргээн тунхаглав. Шашны тэргүүн VIII Богд Жавзандамба хутагтыг Монгол Улсын эзэн хаанаар өргөмжлөөд, улсын цолыг Монгол, оны цолыг Олноо өргөгдсөн, Их Хүрээг Нийслэл Хүрээ хэмээн нэрийдэж, Монгол Улсын сэргэн мандлын шинэ түүх эхэлжээ.

Монгол Улсын Засгийн газар сэргээн тунхагласан төр улс, тусгаар тогтнолоо бэхжүүлэх, дэлхийн улс гүрнүүдээр хүлээн зөвшөөрүүлэхийн төлөө хүчин чармайлт гаргаж байв. Монгол овогтноо нэгтгэхийн төлөө тэмцэв.

### ТУСГААР ТОГТНОСОН МОНГОЛ УЛС

### ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Монгол Улсын Засгийн газар
- Түшээт ван Г.Чагдаржав
- Чин ван М.Ханддорж
- Богд хаан
- Да лам Г. Цэрэнчимэд
- Сайн ноён хан Т. Намнансүрэн

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.			Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Монгол Улсын Засгийн газрын хамгийн түрүүнд авсан арга хэмжээг дараах хүснэгтэд тэмдэглэнэ үү.			2. “Бүрэн эрхт тусгаар тогтносон улс”-ын талаар эргэцүүлэн бичнэ үү (18 талын эх сурвалжийг ашиглаарай).	3. “Улсынхаа тусгаар тогтнолыг хайрлах, хамгаалах, бэхжүүлэх учиртай.” Бодомжийг үндэслэгээ, нотолгоонд тулгуурлан дэлгэрүүлж бичээрэй. Үүний тулд: <ul style="list-style-type: none"> <li>• Эргэцүүлээрэй.</li> <li>• Хэлэлцээрэй.</li> <li>• Бичээрэй.</li> <li>• Танилцуулаарай.</li> </ul> 4. Та Монгол Улсын тусгаар тогтнолд ямар хувь нэмэр оруулж чадах вэ?
Ямар?	Хэзээ?	Үр дүн		

### ТОЛЬ

Автономи	Аль нэгэн улсаас хараат буюу өөртөө эзэрхэх эрх
Тусгаар тогтнол	Тухайн улсын бие даасан, тусгаар тогтносон, бүрэн эрхт байдал
ДИУ	Дундад иргэн улс буюу БНХУ (1911-1949)

3

МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Монгол улс 1911 онд тусгаар тогтнол, төр улсаа сэргээн тунхагласнаар үндэсний эдийн засаг, соёлоо шинэчлэн хөгжүүлэх боломж бүрдсэн.

ГОЛ САНАА

Монгол Улсын Засгийн газар эдийн засаг, соёл, боловсролыг хөгжүүлэх бодлого хэрэгжүүлж эхлэв.

ТҮЛХҮҮР ҮГ

- Эдийн засаг
- Мал аж ахуй
- Татвар
- Иргэний сургууль



АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ



Зураг 2.7. Орос, Монгол, Хятад худалдаачид Нийслэл Хүрээнд



Монголын мал сүрэг нь а) төрийн мэдлийн, б) хамтын буюу дундын өмчид, в) хувийн өмчид байлаа. Тахилгатай уулын сэтэртэн сүрэг, цэргийн агт, хүнсний мал тоогоор цөөн боловч төрийн мэдэлд байв. Хүрээ, хийдийн аж ахуй буюу жасын мал бол дундын буюу хамтын өмч юм. Сүсэгтэн өглөгийн эздээс өргөсөн мал, бусад зүйлийг өсгөн арвижуулж хувраг санваартнуудын хурал номын бэлтгэл гүйцээх, лам хувраг шавь нарын зэд (цалин), пог (хүнс)-ийг жасууд бэлтгэдэг байв.

Долдугаар зүйл. Бага сургуулийн танхимын хөвгүүд дор заан сургах зүйл ану: *Нэгдүгээр*: монгол үсгийн бичиг шастир, *Хоёрдугаар*: энгийн тоо бодох сургууль, *Гуравдугаар*: монгол ба бусад олон газрын байдал төлөв, *Дөрөвдүгээр*: аж төрөхийг сайжруулах ёс, *Тавдугаар*: монголын хураангуй түүх, *Зургадугаар*: биеийн судал тамирыг сайжруулан боловсруулах зэрэг зүйлийг гол болгомой.

Есдүгээр зүйл. Нийслэл Хүрээ, Маймаа хотын бага сургуулийн танхимын сургуулийн хөвгүүдийг өдөр бүр могой цагийн эхэнд зарлан хуруулж, бичиг үсэг заан сургаад бичин цагийн эхэнд тарааж, өөр өөрийн гэр дор буцааваас зохимой.

1915 оны зун Богд хааны зарлигаар батлагдсан “Бага сургуулийн дүрэм”-ийн зарим заалтаас

1. Зураг болон диаграмм та бүхэнд ямар мэдээлэл өгөв? Тэр үеийн Монголын мал сүргийн өмчлөлийн талаар танд ямар бодол төрөв?
3. “Бага сургуулийн дүрэм”-ийн тухай асуулт гаргаарай. Тухайлбал, судалж байсан хичээл, хичээл эхлэх, дуусах цагийн талаар...
4. Та бүхэн тусгаар тогтнол, төр улсаа сэргээсний дараах Монгол Улсын эдийн засаг, шинэ соёлын талаар ямар төсөөлөл байна вэ?

## МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН БАЙДАЛ

XX зууны эхэнд монголчууд уламжлалт нүүдлийн мал аж ахуйгаа эрхэлж байв. Богдын Засгийн газар тусгаар тогтнолоо бэхжүүлэхийн зэрэгцээ хүн амын аж байдлыг дээшлүүлэх, аж ахуйгаа хөгжүүлэх бодлого, үйл ажиллагааг хэрэгжүүлжээ. Үүний тулд:

- Мал сүргийн тоо толгойг өсгөх, үүлдэр угсааг сайжруулах, малыг зуд турхан, хулгай дээрмээс хамгаалах;
- Худалдаа болон газар тариаланг сэргээх;
- Байгалийн баялаг, ашигт малтмалыг олборлох;
- Санхүүгийн төлбөр, тооцооны хэрэгслийг цэгцлэх ажлыг хийж байв.

Монголчууд өөр өөрийн өмч, малтай бөгөөд малын толгойн хувьд ерөнхийдөө баян чинээлэг, дундаж, ядуучууд гэсэн гурван бүлэгт хуваагдаж байв. Монголчууд мал аж ахуйгаас гарах бүтээгдэхүүнээ худалдан борлуулж, малчдын дотроос хөрөнгөлөг аж ахуйтан төрж байжээ. Мал аж ахуйгаа эрхлэн хөтлөх арга ухаанд дэвшил гарч хашаа саравч барих, өвс хадлан бэлтгэх болж, ашиг шимийг нь бүрэн боловсруулан авахыг эрхэмлэх болжээ. Мал эмчлэхэд орос эмч нар оролцох болов.

### ТОДРУУЛГА

Монгол  
Улсын  
төсвийн  
эх үүсвэр

Татвар: Татварын ихэнхийг гадаадын байгууллага, харьяатаас авч байжээ.

Түрээс: Дотоод, гадаадын байгууллага, харьяатуудад түрээслүүлнэ.

Банкны хураамж, хувь хүний өргөл хандив.

Төсвийг хаан ба төрийн албан хаагчдын цалин, цэргийн зардал, гадаадын зээлийн хүү, сул ван гүнгүүдийн пүнлүү, сургууль, албан байгууллагын зардалд зарцуулж байв. Тухайлбал, 1914 онд төсөв зарцуулалтын хуваарь: Төрийн албан хаагчдын цалин, бичиг хэрэг, түлш, албан байр, цэрэг, гяндан, гадаад сургагч багш нарын цалин хангамжид 130598 лан мөнгө, төрийн бус ажилтан, ажилчид 10381 хүн.

Засгийн газраас Хөвсгөл, Буйр нуур, Халх голд загас агнах зөвшөөрлийг 5-10 жилийн хугацаатай олгож байв. 1913 оны “Алт мөнгөний зэрэг уурхай нээх дүрэм”-д зааснаар олзворлосон цагаан алт, очир алмас, эрдэнийн бусад чулуунаас 20-50 хувь, чулуун нүүрснээс 5-10 хувь, алтнаас 16,5 хувь, хилээр гаргахад 5 хувийн татвар авч байв. 1912 онд Богд хааны зарлигаар Нийслэл Хүрээ, Улиастай, Хиагт хотуудад гаалийн хороо байгуулж, Монгол Улсын хилээр орж, гарч буй бараанаас гаалийн татвар тус тус хурааж эхэлсэн байна. Тухайлбал,

- Экспортын татвар: байгалийн баялаг болон хөлөөр гаргах мал, түүхий эдээс 5 хувь,
- Импортын татвар: архинаас бусад бараанаас 5 хувь, архинаас 10 хувь байв.

Монгол Улс Орос улсаас 1912 онд 100.0 мянган рублийг 10 жилийн хугацаатай, 1913 онд 2 сая рубль 20 жилийн хугацаатай зээлээр авсан байна. Хүрээнд хятад, орос банкууд ажиллаж байсан боловч монголын эдийн засагт дорвитой хувь нэмэр оруулаагүй юм.

Хүрээнд 20 гаруй пүүс, 100 гаруй жижиг дэлгүүр мухлаг ажиллаж байв. Худалдааны гол түнш нь Орос, Хятад улс байв. Герман, Англи, Америкийн худалдааны пүүсүүд гол төлөв хятад бараа борлуулсан, малын арьс, шир, ноос бусад түүхий эд, эмийн ургамал зэргийг худалдан авч гадагш гаргадаг байжээ. 1914-1919 онд Монголын зах зээлд худалдсан ноосны 75 хувийг америк, англи руу экспортолсон байна. 1918 онд түшмэл Цэдэвсүрэн, лам Чагдаржав тэргүүтэй нийслэл хүрээний 18 худалдаачин хувь хөрөнгө нийлүүлж “Монголын харилцан туслах хоршоо”-г байгуулахаар зэхэж байв. Тэд түүхий эд болон гаднаас авах барааг бусдаар дамжуулахгүй шууд борлуулж ашигтай ажиллахыг зорьж байжээ.



Зураг 2.8. Нийслэл Хүрээ. 1911 он.

Монгол Улсын Засгийн газар улсын орлогыг нэмэгдүүлэхийн тулд 1913 оноос улсын албан тариаланг дахин сэргээжээ. Сангийн тариалан эрхлэгчдэд улсаас анжис, борной, тарих үр олгоод, хурааж авсан ургацын 30 хувийг улсын санд, 30 хувийг дараа жил тарих үр болгон нөөцөлж, 20 хувийг нь тариалсан хүнд, 20 хувийг хошууны хэрэгцээнд зориулдаг байв. Гэвч сангийн тариалан нь улсад ашиггүй байсан учир 1918 онд Богдын зарлигаар зогсоосон байна.

Монгол Улсын төсвийн зарлага нь орлогоосоо хэтэрч байв. Тухайлбал, 1912 онд хоёр яам шинээр байгуулснаас цалин хангамжийн зардал эрс өсчээ. 1912 оны сүүлчээс 1914 оны эх хүртэл өвөр монголд дайтсан цэргийн зардалд үлэмж хөрөнгө зарцуулсан байна.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1. Энэ үеийн Монгол Улсын эдийн засгийн талаар ямар төсөөлөлтэй болов? Тухайлбал:
  - Эдийн засгийн ямар салбарууд байв, тэдгээрийг хэрхэн ангилж болохоор байна вэ?
  - Төсвийн орлогын эх үүсвэр, төсвийн зарцуулалтын талаар
  - Төлбөр, тооцооны нэгжийн талаар гэх мэт.
2. Монгол Улсын Засгийн газраас улсынхаа эдийн засгийн талаар ямар арга хэмжээнүүд хэрэгжүүлэв, тэдгээрийн үр дүн, ач холбогдлыг тодорхойлно уу.
3. Мэдээлэл болон бусад эх сурвалжид үндэслэн Монголын Засгийн газрын эдийн засгийн бодлогыг өөрийн ойлголтоор тодорхойлно уу.



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ, СОЁЛ

Тусгаар тогтносон Монгол Улс ард түмнийхээ боловсрол, соёлыг дээшлүүлэх талаар цөөнгүй арга хэмжээ авав. Үүний дотор сургууль байгуулж, хэвлэлийн эхийг тавьсан нь томоохон байр суурь эзэлдэг.

Хүснэгт 2.4. Монгол Улсын сургуулиуд

Иргэний сургууль	Цэргийн сургууль	Шашны сургууль	Орос хэл бичгийн сургууль
1912 онд 47 хүүхэдтэйгээр нээгдсэн. Тэр үед аймаг, хошуудад нийтдээ 60 гаруй сургууль байв. Сургууль нь сургалтын төлөвлөгөө, дүрэм, заах зүйлийн хөтөлбөр, ном, сургах бичигтэй болж байлаа. Иргэний сургууль нь хүүхдийг ялгаварлалгүйгээр суралцуулах болсноороо онцлогтой. 1912-1917 онд 10 гаруй хөвгүүдийг Орос улсын сургуулиудад сургажээ.	1912 онд байгуулагдсан. Залуучуудыг цэргийн зохион байгуулалтад сургах, зэр зэвсэг эзэмшүүлэхэд цэргийн сургууль их үүрэг гүйцэтгэсэн.	Энэ бол манай уламжлалт сургууль. Сүм хийдэд сургуулийн насны хүүхэд 25-30 хувийг эзэлж, 18000-20000 хүүхэд шавилан сууж байсан тооцоо байдаг. Шашны сургуулиудад шашны гүн ухаан, хэл, яруу найргийн онол, хүн эмнэлэг, одон орон, зурхай, түүх, урлаг, биеийн тамирын хичээлийг судалдаг байжээ. Томоохон хүрээ, хийдэд Чойрын дацан (онолын), зурхай, мамба дацан (эмнэлгийн) гэх зэрэг төрөлжсөн сургууль, ангитай байв.	Орчуулагч, хэлмэрчдийг бэлтгэх энэ сургууль 1914 онд 46 сурагчтай байв. Сургууль монгол, хятад, орос, манж дөрвөн хэлний ангитай, хүүхдүүд сонирхлынхоо дагуу дуртай ангидаа суралцдаг. Орос улсаас мэргэжилтэн багш урьж, хичээл заалгаж байсан.

Хожим

Их хэлмэгдүүлэлтээр 17 мянга гаруй лам амь насаа алдаж, 700 гаруй сүм хийд, хэдэн мянган бурхан, суврагыг устгасны дунд Жанрайсиг бурхан өртсөн байна. Дэлхийн II дайны үед бурхныг буулгаж, алт, мөнгө, эрдэнэсэн чимэглэлийг тонон, их биеийг Орос цэргүүд буулган авчээ. Соёлын сангийн санаачлага, Монгол Улсын Засгийн газрын дэмжлэгтэйгээр 1996 онд сэргээн бүтээв.

Монголын Засгийн газар олон түмнээ соён гэгээрүүлэх, шинэ цагийн эрдэм боловсролд сургахыг чухалчлан ном зохиол хэвлэх, сонин хэвлэл гаргах ажил хийсэн. Мөн үндэсний ухамсрыг сэргээх, үндэсний соёл, шашнаа дээдлэх зорилгоор сүм хийдээ засаж сэлбэх, шүтээнээ залах болсны хамгийн том нь 80 тохой Мигжэд Жанрайсиг бурхныг бүтээн залсан явдал юм. Монголын ард түмэн мөнгө болон зэсэн аяга, шанаганд Богд уулын хойд голоос дэнж хүртэл цуван зогсч, аяга, шанагаа газарт хүргэлгүйгээр ус зөөж, бурхны суурийг тавихад гар бие оролцож байсан түүх буй. Архивын эх сурвалжид бичсэнээр их шүтээнийг бүхэлд нь зэсээр бүтээж, 230000 лан мөнгө, их бурхныг алтдаж чимэглэхэд 1200 лан (45 кг) алт, 1500 лан (56 кг) мөнгө зарцуулсан байна. Мөн 400 гаруй эрдэнийн чулуун шигтгээгээр чимжээ.

Энэ үед дараах ном, хэвлэлүүд гарчээ. Үүнд:

- 1915 онд түүхч Ч.Бат-Очир “Мандах нарны туяа хэмээх сургаалын бичиг”, “Ер байдлын анги” хэмээх сургаал шүлэг
- 1913-1915 оны үеэс эрдэмтэн Ч.Дандаа “Бурхны номын журам бадруулсан Эрдэнэт толь хэмээх шастир”, “Шинэ засгийн зүйл”
- 1913 онд “Шинэ толь” сэтгүүл
- 1915 онд “Нийслэл хүрээний сонин бичиг”

- 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол улсын хууль зүйлийн бичиг” – 65 дэвтэр хууль
- 1918 онд “Зарлигаар тогтоосон Монгол улсын шастир” – 11 дэвтэр түүх тус тус болно.

1910-аад оны үед Нийслэл хүрээнд Богд хааны ордон, Оросын хорооны “Биржа” дэн буудал, хятад иргэдийн амьдардаг гудамж дахь “Ший Янзан” зэрэг газар кино гардаг байжээ. Энэ үед Монгол улсын соёлын нэрт төлөөлөгчид болох зураач Жүгдэр, Б.Шарав, хуурч Лувсан, Парчин нар уран бүтээлээ туурвиж байв. Жишээ нь, Б.Шарав 1911-1912 онд Богд хааны хүсэлтээр “Монголын нэг өдөр”, “Үрс гарч байгаа нь” гэдэг алдарт зургуудаа зурсан бөгөөд тэр нь Богд гэгээнд ихэд таалагдаж Шаравт “марзан” хэмээх хоч өгсөн тухай ном зохиолд бичжээ.



## УНШААРЙ, ОЙЛГООРИЙ

1. Монгол Улсын Засгийн газраас боловсрол, соёлын талаар ямар арга хэмжээнүүд хэрэгжүүлэв, тэдгээрийн үр дүн, ач холбогдлыг тодорхойлно уу.
2. Үндэсний соёл урлагийн талаар бие даан судалж, танилцуулаарай.

1911-1919 онд Монгол улс нөөц бололцоогоо дээд зэргээр ашиглах, уул уурхайн орлогоос төсвөө бүрдүүлэхийг хичээж байв. Энэ үед ялангуяа, иргэний сургууль байгуулах зэргээр шинэ цагийн, боловсрол, соёлыг нэвтрүүлэх эхлэлийг тавьсан нь цаашид улам хөгжсөн билээ.

## МОНГОЛ УЛСЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, СОЁЛ

### ҮНЭЛЭЭРЭЙ

Үе бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Эдийн засаг
- Татвар
- Мал аж ахуй
- Иргэний сургууль

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.			Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Монгол Улсын Засгийн газраас авсан арга хэмжээ			2. Монголчуудын эрхлэх гол аж ахуй юу вэ? 3. Засгийн газар шинээр юу хийв?	4. Тэр үед Засгийн газрын хэрэгжүүлсэн бодлого, үйл ажиллагаанаас аль нь өнөөг хүртэл үргэлжилж байгаа талаар хэлэлцэнэ үү.
Эдийн засгийн	Боловсролын	Соёлын		

### ТОЛЬ

Жас	Сүм хийдэд сүсэгтний өргөсөн зүйлээр байгуулсан аж ахуй
Лан	37.2 граммтай тэнцэх хүндийн нэгж
Пүн	3.7 граммтай тэнцэх хүндийн нэгж
Цэн	0.37 граммтай тэнцэх хүндийн нэгж
Иргэний сургууль	Иргэний түүх, байгалийн ухааны чиглэлээр мэдлэг олгодог сургууль
Сэтэртэн сүрэг	Богд хаан, Хан хэнтий, Отгон тэнгэр, Дарьгангын Алтан овоог тахихад сүсэгтнүүдээс өргөсөн мал сүрэг

4

МОНГОЛЧУУДАА НЭГТГЭХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

*Нэг соёл уламжлалтай тархан суурьшсан монгол овогтон бие биеэ таних, ойртох хүсэл эрмэлзэл өнөөг хүртэл байдаг.*

ГОЛ САНАА

*Монголын Засгийн газрын монгол овогтноо нэгтгэх оролдлого түүнд учирсан саад бэрхшээл*

ТҮЛХҮҮР ҮГ

- Тусгаар тогтнол
- 3 улсын гэрээ
- Монгол овогтон
- 5 замын цэрэг



Зураг 2.9. Манлайбаатар Дамдинсүрэн

Монголын Засгийн газраас улс орныхоо амгалан тайван байдлыг хангахаар өмнө зүгийн буухиа өртөө байгуулав. Мөн умар хязгаарын Хиагтад суусан хятад заргач нарыг тусгай түшмэл цэрэг гаргаж хөөн явуулаад Хиагтын харьяат худалдааны иргэдийн хэргийг захирах монгол түшмэлийг томилон илгээжээ. Үүний зэрэгцээ Богд хаан Баруун хязгаарыг илбэн тохинуулах сайдаар Жалханз хутагт Дамдинбазарыг, дэд сайдаар гүн Хайсанг томилж, барга гүн Дамдинсүрэн, халхын гүн Магсаржав нарт Ховдыг чөлөөлөх үүрэг өгчээ. Монгол цэргүүд Ховдыг олноо өргөгдсөний 2 дугаар оны 8 сарын эхээр чөлөөлсөн байна. Үүний учир Богд хааны зарлигаар Дамдинсүрэнд Манлайбаатар жанжин цол, засаг төрийн бэйлийн хэргэм, Магсаржавт Хатанбаатар цол, бэйсийн хэргэм бас бус дагалдан явсан түшмэл цэргүүдийн гавьяа зүтгэлийг үнэлж дэс дараалан жинс зэрэг цол шагнах зэргээр хөхиүлэн урамшуулжээ.

МОНГОЛ ОВОГТНОО НЭГТГЭХИЙН ТӨЛӨӨХ БОГДЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА



Зураг 2.10. Монгол овогтны нэгдмэл байдлын төлөө Хятадын эсрэг цэрэг элсүүлэн тэмцэж байсан шударга баатар харчин гүн Бавуужав

Энэ үеэр Өвөр Монголд хятадуудын дарлалыг эсэргүүцсэн, монгол овогтон эвлэлдэн нэгдэхийн төлөө тэмцэл газар сайгүй өрнөж байлаа. Өвөр Монголын 49 хошуунаас 36 нь Монгол Улсад дагаар орох саналаа илэрхийлэв. Богд хааны зарлигаар Манлайбаатар Дамдинсүрэнгээр удирдуулсан нэг түмэн хүнтэй 5 замын их цэрэг Өвөр Монголыг хятадын хар цэргээс чөлөөлөхийн төлөө тэмцэж байв. Тэд 1913 оны намар Шилийн гол, Цахарын нутгийг чөлөөлсөн бөгөөд зарим газар цагаан хэрэмд тулж очжээ.

Гэвч энэ үйл ажиллагаа Орос, Хятад, Японы ашиг сонирхлоос үүдэлтэйгээр зогссон байна. Орос Япон хоёр 1907 онд байгуулсан гэрээгээ 1912 онд сунгаж, нэмэлт оруулжээ. Энэ гэрээгээр гадаад Монгол Оросын, Өвөр Монгол Японы ашиг сонирхлын бүс болохыг зааж, үүнийгээ зөрчихгүй байх үүрэг хүлээжээ.

Харин тулгар Монгол улсын Засгийн газраас Барга, Өвөр Монгол зэрэг олон монгол овогтноо нэгтгэхийн төлөө бүх л боломж, хүчээ дайчилж байлаа. Монгол Улсын Ерөнхий сайд Сайн ноён хан Намнансүрэн тэргүүтэй төлөөлөгчид Орос улсад айлчилж, эл асуудлаар дэмжлэг



эрэхийн зэрэгцээ Япон зэрэг улсын тэргүүнд хүртэл хандаж байв.

Хиагтад 1914-1915 онд Хятад, Орос, Монгол гурван улс хэлэлцээр хийж, гэрээ байгуулав. Хэлэлцээрт оролцсон монголын төлөөлөгчид тусгаар тогтнол, улсын цол, хааны цол зэргээ хамгаалсан байр сууриа ягштал баримталсаар 9 сарын турш хэлэлцэж, мэтгэлцсэн боловч аргагүй байдалд автсан юм. Уг гэрээгээр Монгол Улсыг Ар, Өвөр Монгол болгон хувааж, газар нутгийн хувьд Өвөр Монголыг Монгол Улсаас хуульчлан тусгаарласан юм. Ингэснээр Монголынхоо тусгаар тогтнолын төлөө монгол овогтны нэгдмэл эрмэлзлэл, зорилгоор явуулсан тэмцлийг зогсоож, монгол овогтон саланги тусгаар байх болжээ.



Зураг 2.11. Гурван улсын хэлэлцээрт оролцогчид

Хиагтын гэрээгээр Өөртөө зээрхсэн Монголын нутаг дэвсгэрийг “урьдах Хүрээний сайд, Улиастайн жанжин, Ховдын сайдын захиргаанд байсан газрууд бөгөөд

ДИУ лугаа нийлсэн хил болбоос Зүүн зүг Хөлөн буйрын хязгаар, Өмнө зүг Дотоод Монгол, Баруун өмнө зүг Шинэ хязгаар, Баруун зүг Алтайн хязгаар лугаа зах нийлсэн халхын 4 аймаг ба Ховдын хязгаарын олон хошуудын хилээр баймой” хэмээн зааглан тогтоосон нь Монголыг Хятадаас туурга тусгаар олон улсын эрх зүйн этгээд мөн болохыг хүлээн зөвшөөрсний тод нотолгоо мөн.

1917 оны Октябрийн эргэлтээр Гурван улсын гэрээ байгуулсан нэг улс болох Орос гүрэн үгүй болсныг далимдуулан 1919 онд ДИУ Монголын тусгаар тогтнолыг түр хязгаарласан юм.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1. Монгол овогтон нэгдэхийн төлөөх үйл явдлын он цаг, түүхэн зүтгэлтнүүдийн талаар ярилцана уу.
2. 1915 оны гурван улсын гэрээ Монгол улсад ямар нөлөө үзүүлэв?
3. Тусгаар тогтнолын тухай эргэцүүлэн ярилцана уу. Дараах асуултыг ашиглаарай:
  - Тусгаар тогтнол гэдэг үгийг төлөөлөх бусад үгсийг хэлнэ үү.
  - Яагаад түүхийн бүхий л үеийн турш тусгаар тогтнол, эрх чөлөөний тухай авч үздэг юм бол...?



ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

- 1911-1919 онд Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбоотой ямар түүхэн үйл явдлууд болов?
- 1911-1919 оны Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын талаар ярилцана уу. Тухайлбал,
  - Улсын тусгаар тогтнол, бүрэн бүтэн байдал
  - Хөрш улсуудын ашиг сонирхол
- 1915 оны гурван улсын хэлэлцээрт оролцсон болон 1919 онд тусгаар тогтнолоо түр хязгаарлуулах үеийн монголын удирдагчдын түүх, намтартай танилцаж, тэдний тухайн үеийн үзэл бодлыг судлаарай.

МОНГОЛЧУУДАА НЭГТГЭХИЙН ТӨЛӨӨ ТЭМЦЭЛД

ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Тусгаар тогтнол
- 3 улсын гэрээ
- 5 замын цэрэг

<i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i>		<i>Гол санаагаа ойлгов уу?</i>	<i>Бүтээлчээр сэтгээрэй.</i>
1. Бахархан дууриах, хэзээ ч үл мартах түүхэн зүтгэлтнүүдийн тухай ярилцана уу. 2. Монгол улсын тусгаар тогтнолтой холбоотой чухал он цаг, үйл явдлыг тэмдэглэнэ үү.		3. Монгол Услын засгийн газар монгол овогтноо нэгтгэхийн төлөө тэмцсэний учир юу вэ?	4. Тусгаар тогтнолтой холбоотой сэдвээр ямар хичээл дээр, юу хийсэн, юуг ойлгож мэдэж авсан талаараа цогц зураглал хийнэ үү. 5. “Тусгаар тогтнол ба түүхэн зүтгэлтэн” сэдвээр эсээ бичээрэй.
Хэзээ?	Юу?		

## 5

## ДЭЛХИЙН I ДАЙН БА МОНГОЛ УЛС

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Дэлхийн том гүрнүүдийн эрх ашгийн төлөөх зөрчлөөс үүсч олон сая хүний амь насыг сүйтгэсэн.

## ГОЛ САНАА

- Дайны сургаамжийг бид мартаж учиргүй
- Дэлхийн I дайны үед шинэ зэвсэг, шинэ технологи гарсан.

## ТҮЛХҮҮР ҮГ

- Холбоотнууд
- Баруун, зүүн фронт
- Нуувчны тулаан
- Дэлхийн дайн



## АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

**1. Нуувчны тулаан.** 1915 оны эхэн гэхэд талууд галаас нуугдах хэдэн зуун км нуувч барьсан. Нуувчаа уртасгах, өргөсгөх хэдхэн метр газар хожихын төлөө цэргүүдийнхээ амийг хэдэн зуугаар нь золиосолж байв. “Нуувч зэрлэг оготноор дүүрэн, хоол унд үгүй, унтаж амрах газаргүй тэсэхийн аргагүй” ... “Цэргүүд шаварт унтаж, шавраар гар нүүрээ угааж, шавар идэж байлаа” “Бууны сумнууд нуувчинд унана. Бөмбөгдөлтөд шороо босон амьсгалахын аргагүй болж ухсан нуувч маань шороонд булагдана. Сохорсон, шархадсан, мөлхсөн, ёолсон цэргүүд бороо шиг орж бидэн рүү цусаа үсчүүлэн амь тавина. Амьдын там л гэсэн үг” гэж нэгэн франц цэрэг ярьжээ.

**2. Дайны шинэ зэвсгүүд: Хорт хий:** Анх Герман, дараа нь дайнд оролцогч талууд бүгд хэрэглэсэн. Хорт хий нь хараагүй болгодог, арьсанд харшил үзүүлж цэврүү үүсгэдэг, амьсгал боож үхэлд хүргэдэг аюултай. **Автомат буу:** Сумаа автоматаар цэнэглэдэг буу нь дайралт хийх боломж олгодоггүй, 1-р дайны үед маш боловсронгуй болсон. **Танк:** 1916 оны Сомын тулаанд Британичууд анх хэрэглэсэн. Танк нь бүрэн тоноглогдсон тээврийн хэрэгсэл бөгөөд гинжин дугуйтай тул ямар ч гадаргуу дээр саадгүй явна. **Шумбагч онгоц:** 1914 онд Германчууд анх хэрэглэсэн, шумбагч онгоцны гол зэвсэг нь усан доороос бууддаг тэсрэх бөмбөг.

Зураг 2.12. Шведийн зохион бүтээгч Альфред Нобель (1833-1896) өөрийн бүтээл динамитийг цэргийн зориулалтаар ашиглах болсонд харамсаж энхийг тогтооход онцгой хувь нэмэр оруулсан хүмүүст зориулан “Нобелийн энх тайвны шагнал” бий болгон, шагналыг жил бүр гардуулахыг гэрээсэлжээ.



1. Дээрх эх сурвалжууд ямар үйл явдалд хамаарахыг тогтоож, юуг өгүүлж буй талаар дэлгэрүүлэн ярилцана уу.
2. Өнөө үед болж буй дайн тулааны талаар та бүхэнд ямар мэдээлэл байна вэ? Дайн болж буй улсын хүн ард, хүүхдүүдийн амьдралыг төсөөлнө үү.
3. Дайны тухай ярилцаарай:
  - Улс орнууд яагаад өөр хоорондоо дайтдаг тухай;
  - Дайны хор уршиг, үр дагаврын талаар;
  - Дайнгүй, энх тайван амьдралын талаар гэх мэт.

4. Хүснэгтэд дэлхийн I дайны талаар нөхөж бичээрэй.

Мэддэг зүйл	Мэдэхгүй зүйл	Мэдэхийг хүсэж буй зүйл


Дэлхийн I дайн 1914-1918 онд болж, дэлхийн 1,5 тэрбум хүн ам бүхий 38 улс оролцсон юм. Энэ дайны шалтаг нь 1914 оны 6 сарын 28-нд Славяны националист байгууллагын гишүүн Австри-Унгарын хунтайж Фрэнсис Фердинандыг буудан хороосон хэрэг байсан бол гол шалтгаан нь өөр зүйл байв. Дэлхийн I дайнд оролцогч орнуудын нийтлэг зорилго нь дэлхийн колонийн системд тэдний эзлэж буй байр суурь, бүс нутаг дахь нөлөөний төлөө өрсөлдөөн, аж үйлдвэрийн бүтээгдэхүүний үр ашиг бүхий зах зээл, түүхий эдийн эх сурвалжийн төлөө өрсөлдөөнөөр тодорхойлогдоно.

Хүснэгт 2.5. Европын хуваагдал

1914 он гэхэд Европ хоёр том хүчинд хуваагдсан байв. Үүнд:

Антантын эвслийн орнууд (Холбоотнууд)	Гурвын холбоо буюу төвийн хүчин
<ul style="list-style-type: none"> <li>Их Британи</li> <li>Франц</li> <li>Орос</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Герман</li> <li>Австри-Унгар</li> <li>Итали</li> </ul>

Бүдүүвч 2.3.



ДАЙНЫ ЯВЦ

ТОДРУУЛГА

Дэлхийн I дайны тухай судлаарай.

“www.youtube.com/khanacademy.mongolia”

Дайны нэг талд Герман болон Австри-Унгар байсан бөгөөд тэдний байрлал нь Европын төвд байсан тул төвийн хүчнүүд гэж нэрлэж байлаа. Алдсан газар нутгаа эргүүлэн авах зорилготойгоор Болгар болон Оттоманы Их гүрэн сүүлд төвийн хүчинд нэгдэн дайтсан. Дайны нөгөө талд Их Британи, Франц, Орос байх бөгөөд Антантын эвслийн орнууд буюу холбоотнууд гэж нэрлэж байв. Дайны дундуур Япон, Итали улсууд нэгдэв. Итали улс Герман, Австри-Унгарын 3-ын холбоонд байсан боловч шударга бусаар дайн эхэлсэн хэмээн тэднийг буруутган Холбоотны хүчинд нэгдсэн байлаа.

Францын хойд нутгаар үргэлжлэх тулааны талбар нь баруун фронт бөгөөд энэ нь хойд тэнгисээс Швейцарийн хил хүртэл бараг 800 км газар нутгийг хамарч байв. Зүүн фронтод Орос, Серби улсууд Герман, Австри-Унгар хоёрын эсрэг Орос



Германы хил дагуу тулалдаж байв. Герман Улс Шлифений төлөвлөгөө гэх дайны стратеги боловсруулан хэрэгжүүлэхийг зорьж байв. Уг стратегийн гол санаа нь Францыг эрчимтэй дайрч, ялаад дараа нь Оростой дайтахаар зүүн зүг рүү фронтоо шилжүүлэх байлаа. Гэвч үр дүн нь Вердунд германчууд 6 км, Сомд британчууд 8 км газар ахисан явдал байлаа.

- Антантын холбооны улсууд
- Герман, түүний холбоотон улсууд
- Төвийг сахисан улсууд

4.VIII.1914 Дайн эхэлсэн өдөр

- Герман, түүний холбоотны цэргүүд
- Антантын холбооны цэргүүд

1914-1917 оны Фронтын шугам

Усан доорх байлдааны үндсэн үйл ажиллагаа

1916-1918 Тэнгисийн томоохон тулаан болсон газрууд

Дорнод, өрнөт фронтын нэмэлт хүч бусад фронтоос татсан цэргүүд

1915 оны сүүлээр Сербийн цэргийн ухралт

1916 онд Баруун, өмнөд фронтод оросын цэргүүд довтолгоо

1917.10 сард орос цэрээ татсан нь

1918.11.9-нд Комльенийн найрамдлын үеийн Итали Балканы баруун фронтын шугам

1918.11.11 Комльенийн найрамдлын гэрээ байгуулсан

Зураг 2.13. Европ дахь дэлхийн I дайн



Дайны удирдагчид хорт хий, зэвсэглэсэн танк зэрэг шинэ зэвсгүүд нь дайныг түргэн шийдэхэд гол хүч болно гэж тооцоолсон боловч цэргүүдийг хоморголон устгахаас өөр үр дүнд хүрсэнгүй. Энэ дайнд нийтдээ 40 гаруй сая хүн амь нас аалджээ. Үйлдвэр, зам гүүр, төмөр зам цөм дайны хөлд нурж, ажилчид нь цэргийн албанд явсан тул зарим бизнес хаагдаж, олон үйлдвэр, фирм байлдааны эд, хэрэгсэл хийхээр өөрчлөгдөв. Европын улс орнууд бүх хөрөнгө хүчээ дайнд зориулаад, дайн дуусахад цөм туйлдаж ядарцагасан байв. Дайны дараа эзэнт гүрнүүд задарч, Австри, Унгар, Чехословакийн бүгд найрамдах улсууд бий болов. Балтийн орнууд тухайлбал, Эстони, Латви, Литва улсууд Оросоос салж тусгаар тогтнолоо тунхагласан байна. Дэлхийн I дайн нийгэм, хүмүүст асар их хохирол учруулж, бас өөрчлөлт авчирчээ. Сая сая хүмүүс орон гэргүй болж, дүрвэн зайлжээ. Тариачид хөдөө фермдээ буцалгүй хотуудад суурьшиж, хот суурин газрууд хүрээгээ эрчимтэй тэлж байв. Нийгэм урьд өмнөхөөс илүү ардчилсан шинжтэй болж, дэлхий нийт хүний эрхийг хамгаалах хэрэгтэйг ойлгож эхэллээ.

## ДЭЛХИЙН I ДАЙНЫ ҮЕИЙН МОНГОЛ УЛС

- 1914 оны 8 сарын 26-нд Орос Монголын хилийн жижиг хот Хиагтад эхэлсэн Хятад, Орос, Монгол гурван этгээдийн хэлэлцээр бүтэн 9 сар үргэлжилжээ.
- 1915 оны Монгол, Орос, Хятад гурван этгээдийн Хиагтын бага хуралд Монгол улс тусгаар улс байх үзлийг илэрхийлж, Монголыг Хятадын эзэн эрх бүхий улс байхыг эсэргүүцэв.
- 1916 онд Орос улстай гэрээ байгуулж монгол залуучуудыг цэргийн эрдэмд сургахаар тохиров.
- 1919 оны 8 сард хятадын цэрэг Монголыг “улааны аюулаас хамгаална” гэсэн шалтгаар Нийслэл Хүрээнд орж ирэв.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1. Газар зүйн зургийг (33 т) уншиж, дэлхийн I дайны түүхийн тухай 5 асуулт гаргаарай.
2. Дайны дараа европын улс төрийн газрын зурагт ямар өөрчлөлт гарсан бэ? Шинээр байгуулагдсан болон тусгаар тогтносон улсуудыг газар зүйн зурагт заана уу.
3. Дэлхийн I дайн ямар үр дагавар үлдээсэн бэ? Бид ямар сургамж авч болох вэ?
4. Дэлхийн I дайны үеийн Монгол улс ямар байдалтай байсныг төсөөлөөрэй. Дайнд оролцогч орнуудаас ямар орны нөлөө Монголд их байв? Яагаад?

## ДЭЛХИЙН I ДАЙН БА МОНГОЛ

## ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Холбоотнууд
- Нуувчны тулаан
- Баруун, зүүн фронт

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.		Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй, бичээрэй.
1. Дайн дэлхийн түүхэнд ямар нөлөө үзүүлснийг тэмдэглээрэй		2. Дэлхийн I дайны үед шинэ зэвсэг, зэвсгийн шинэ технологи яагаад гарах болсон талаар, энэ нь эерэг, сөрөг ямар үр дагаварт хүргэсэн талаар ярилцаарай.	3. Дэлхийн I дайны тухай баримтат кино, холбогдолтой эх сурвалж, баримт мэдээлэл цуглуулж, танилцуулаарай. 4. “Дайны тухай хүмүүсийн үзэл бодол” сэдвээр эсээ бичээрэй. Холбогдох эх сурвалжаас ишлэл аваарай.
Үзүүлэлт	Үзүүлсэн нөлөө		
Эдийн засагт			
Улс төрд			
Нийгэмд			

6

ОРОС УЛС ДАХЬ ОКТЯБРИЙН ЭРГЭЛТ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Октябрийн эргэлт нь дэлхийн анхны коммунист улс байгуулах болон дэлхий хоёр системд хуваагдах эхлэлийг тавьсан.

ГОЛ САНАА

- 1917 оны 10 сард Орос оронд Октябрийн эргэлт гарч, коммунист нийгэм байгуулах эхлэлийг тавив.
- Октябрийн эргэлтээр тогтсон коммунист дэглэм Монголд 70 жилийн турш нөлөөлсөн.

ТҮЛХҮҮР ҮГ

- Большевик
- Марксизм
- В.И.Ленин
- Октябрийн эргэлт
- “Октябрийн хувьсгал”



Зураг 2.14. ЗСБНХУ-ын газар зүйн зураг



Зураг 2.15. ОХУ-ын газар зүйн зураг

- 882 он: Киевийн Орос үүссэн.
- 1547 он: Оросын эзэнт улс тогтсон.
- 1917 он: ЗСБНХОУ байгуулагдсан.
- 1922 он: ЗСБНХУ
- 1991 он: ЗХУ задарч, ОХУ байгуулагдсан.

**Орос** буюу **Оросын Холбооны Улс (ОХУ)** нь Евразид оршдог. Орос нь өргөн уудам нутагтай. Баруунаас зүүн тийш Норвеги, Финлянд, Эстон, Латви, Литва, Польш, Беларусь, Украин, Гүрж, Азербайжан, Казахстан, Хятад, Монгол, Хойд Солонгос зэрэг олон улстай хил залгана. Мөн усаар зааглагдаж, АНУ-ын Аляска муж, Швед, Дани, Турк, Япон улстай ойр оршдог. Эстон, Латви, Литва, Беларусь, Украин, Гүрж, Азербайжан, Казахстан, Киргиз, Тажикистан, Туркменистан, Узбекистан, Армени, Молдав зэрэг улсууд өмнө нь ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан.



АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

1. Зураг 2.14, 2.15-ыг харьцуулан ярилцаарай.
2. Орос улсад түүхийн аль үед, ямар улсууд байгуулагдсан бэ?
3. Бидний хойд хөрш Оросын холбооны улсын тухай мэдээллээ хуваалцаарай.

## 1917 ОНЫ 2 САРЫН ХУВЬСГАЛ

Дэлхийн I дайнд Оросын арми туйлдаж байлаа. Европын орнуудтай харьцуулахад Орос улс үйлдвэржээгүй байсан тул армид хоол хүнс, буу сум, гутал, хувцас байнга дутагдаж байв. Улс орных нь эдийн засаг хямарч, нийгэм үймээн самуунд автаж, хаант засгийн нэр хүнд, нөлөө урьд байгаагүйгээр буурсан байв. Хаант Оросын бүрэлдэхүүнд багтдаг орос бус ард түмэн үндэсний хөдөлгөөн өрнүүлж, юуны өмнө автономит эрхтэй улс болох, алсдаа төвлөрсөн засгаас хамааралгүй бие даасан улс болохын төлөө тэмцэж байв. Ийм байдал нь 1917 оны 2 сард хөрөнгөтний ардчилсан хувьсгал гарахад хүргэв. 1917 оны 2 сарын 26-нд хувьсгал эхэлж маргааш нь хаант засгийн хэд хэдэн хороо цэрэг ажилчдын талд нэгджээ. 1917 оны 3 сарын 2-нд II Николай хаан огцорч, хаант засаглалыг халж бүгд найрамдах засаглалд шилжив. 2 сарын хувьсгалын дараа Керинский тэргүүтэй хөрөнгөтний түр засгийн газар тогтож, Ленин тэргүүтэй большевикууд нууц байдалд оров.



Зураг 2.16. **В.И Ленин** (1870-1924) “Оросын коммунист намыг үндэслэгч.

Социализмын жилүүдэд “Октябрийн хувьсгал” -ын эцэг хэмээн тахин шүтэгдэж ЗХУ-ын бүх хотуудад түүний хөшөөг босгосон байв.

1917 оны хаврын эхэн сараас Орос улс өлсгөлөнд нэрвэгдэн, Санкт-Петербургт ажилчид ажил хаяж, эмэгтэйчүүд гудамжид гарч “Талх, талх” гэсэн уриа лоозон барин сүрт жагсаал хийх болов. Большевикууд нууц байдалд орсон боловч үйл ажиллагаагаа идэвхжүүлж “Энх тайван”, “Газар”, Засгийн эрхийг ард түмэнд” гэсэн олон түмэнд ойлгомжтой энгийн лоозон дэвшүүлэв. Цэргүүд жагсагчдын эсрэг гал нээхээс татгалзсанаар Түр Засгийн газар мухардав. Энэ үед Орос орныг дэлхийн дайнаас гаргах, улс орон даяар газрыг дахин хуваарилах, үндэсний асуудлыг шийдвэрлэх, хүн амын

амьжиргааны түвшинг дээшлүүлэх асуудал юу юунаас чухал болов.

### ТОДРУУЛГА

Октябрийн эргэлтийн тухай судлаарай.

[www.youtube.com  
“khan academy.  
mongolia”](http://www.youtube.com/khan_academy_mongolia)

### БОЛЬШЕВИКУУДЫН БОСЛОГО БУЮУ ОКТЯБРИЙН ЭРГЭЛТ

Хөрөнгөтний түр засгийн газар улс орноо хямралаас гаргаж чадахгүй байсан энэ үед Ленинээр удирдуулсан оросын большевикууд 1917 оны 10 сарын 24-26 (11 сарын 6-8)-нд тухайн үеийн Петроградад бослого гаргав. Босогчид 10 сарын 24-25-нд шилжих шөнө өвлийн ордонг эзэлж, оросын иргэдэд хандаж “түр засгийн газар огцорсон, төр засаг Петроградын ажилчин цэргийн депутатуудын зөвлөлд шилжсэн”-ийг зарлав. Түүний дараа В.И Ленин үг хэлж “ажилчин тариачны хувьсгалыг большевикууд хэрэгжүүллээ” гэж мэдэгдэв.

Октябрийн эргэлтийн дүнд Оросын ажилчин тариачны төр засгийн газар байгуулж, тэргүүнээр нь В.И Ленинийг томилов. 1917 оны 11 сарын дундуур Москва большевикуудын нийслэл хот болж, Кремль Оросын засаг захиргааны төв болжээ. Большевикууд Оросын бусад хотуудад асар богино хугацаанд засгийн эрхийг

### ТОДРУУЛГА

1917 оны энэ үйл явдлыг 1930-аад он хүртэл Октябрийн эргэлт, 1990 он хүртэл “Октябрийн Социалист аугаа их хувьсгал” гэж албан ёсны түүхэнд нэрлэж байв. Большевикууд өөрсдөө энэ үйл явдлыг “хувьсгал” хэмээн нэрлэсэн. Харин сүүлийн үед судлаачид “октябрийн эргэлт”, “10 сарын хувьсгалт эргэлт” гэж үзэх болжээ.



гартаа оруулав. Тухайлбал, Беларусь, Украин, Эстони, Латви, Крым, Умард Кавказ, Дундад Азид зөвлөлт засгийг тогтоов. Большевикууд газрыг хувийн өмч байхыг хориглож, тариачдад эзэмшүүлэн, ажилчдад уурхай, үйлдвэрийг шилжүүлэв.

Тус хувьсгалаар дэлхийг капиталист, социалист хоёр системд хуваах эхлэл тавигдсан юм. Оросын ард түмний нэг хэсэг нь шинэ төрийг дэмжиж байсан боловч нөгөө хэсэг нь хаант засаг нэгдмэл Орос улсын төлөө тэмцэх болсноор иргэний дайн дэгдэж 1922 он хүртэл үргэлжилсэн юм.

## ОКТЯБРИЙН ЭРГЭЛТ БА МОНГОЛ УЛС

Орост гарсан Октябрийн эргэлтийн тухай мэдээ, үзэл санаа нь хөрш Монголд дараах арга замуудаар түгж байв.

- Зөвлөлүүд, большевикууд намын уриа тунхаг, ялангуяа, 1919 оны зун ЗОУ-аас Автономит Монголын Засгийн газарт хандсан уриа;
- Монгол оронд тархсан оросын хувьсгалт хэвлэл, ном зохиол, сонин сэтгүүл;
- Монголын хувьсгалчидтай холбоо тогтоосон Нийслэл Хүрээн дэх оросын харьяатуудын хувьсгалт байгууллагын үйл ажиллагаа;
- Монголд амьдарч байсан жирийн орос иргэдийн өдөр тутмын яриа хөөрөө;
- Хил орчмын орос, монгол хүмүүсийн харилцаа, хэлхээ холбоо зэрэг болно.

Шинээр тогтсон Зөвлөлийн Засагт Орос Улс (ЗЗОУ)-ын Засгийн газар 1918 оны 2 сард Монголын Засгийн газарт цахилгаан утас ирүүлж, хаант Орос улсаас Монгол улстай байгуулсан бүх гэрээ хэлэлцээр, урьдын өр зээлийг хүчингүй болгож, эрх тэгш харилцаа тогтооход бэлэн байгаагаа мэдэгдэв.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Бүдүүвчийн дагуу 1917 оны Октябрийн эргэлтийн үйл явцыг задлан шинжилж өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлээрэй.
2. Октябрийн эргэлтийн он цаг хоёр янзаар тоологдож буйн учрыг олно уу.



3. Октябрийн эргэлтийн талаарх ялгаатай үзэл бодлыг харьцуулан, өөрийн үзэл бодол, байр суурийг танилцуулна уу.

Үзэл бодол 1:	Үзэл бодол 2:
1980-аад оны дунд үе хүртэл социалист системийн улс орнуудын нийгэм судлаачдын олонх нь Октябрийн хувьсгал бол хүн төрөлхтний хөгжлийн шинэ эхлэлийг тавьсан аугаа их үйл явдал хэмээн бичиж байлаа. Марксист номлолыг эсэргүүцдэг судлаачид 1917 оноос эхэлсэн Оросын хувьсгал бол дэлхийг 2 ертөнцөд хуваах эхлэл коммунист туршилтын гараа болж их сүйрэл хямрал дагуулсан “хар үйл явдал” гэсэн санааг илэрхийлж байв.	Монголчууд Оросын 1917 оны үйл явдлын талаар ямар үзэл бодолтой байсныг судлаачид дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд: “1990 оноос өмнөх марксист түүх бичлэгт 1917 оны оросын хөрөнгөтний хувьсгал болон 10 сарын октябрийн эргэлт аль аль нь монголчууд автономит эрхээ сэргээх, тусгаар тогтнолын төлөө тэмцлийг улам зоригжуулсан.” Үүний зэрэгцээ “монголчууд октябрийн эргэлтийн дараа большевикуудыг эзэн хаанаа огцруулсан үл бүтэх этгээд хэмээн үзэж байсан” гэж оросын түүхч бичиж байлаа.

4. В.И Лениний тухай мэдээлэл цуглуулж, хуваалцана уу.

5. Октябрийн эргэлт Монгол Улсад хэрхэн нөлөөлснийг баримтаар батлан ярилцаарай.

## ОРОС УЛС ДАХЬ ОКЯБРИЙН ЭРГЭЛТ

## ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Большевик
- Марксизм
- В.И Ленин

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй, бичээрэй.
1. Дараах хүснэгтэд Октябрийн эргэлт Монголын болон дэлхийн түүхэнд ямар нөлөө үзүүлснийг нөхөж бичээрэй.	2. Октябрийн эргэлтээр тогтсон коммунист дэглэм Монголд 70 жилийн турш нөлөөлсний эерэг, сөрөг үр дагаврыг тодорхойлоорой.	3. Октябрийн эргэлт дэлхийг хоёр систем болон хуваагдах эхлэлийг тавьсан гэж үздэгийн учир шалтгааныг тайлбарлаарай.
Монгол Улсын түүхэнд	Дэлхийн түүхэнд	

## ТОЛЬ

Большевик нам	1917 оны 10 сараас Оросын төрийн эрх барьсан нам. ОК(б)Н, ЗХУКН нэртэй байв.
ОК(б)Н	Оросын Коммунист Большевикуудын нам
БХК(б)Н	Бүх холбоотын коммунист Большевикуудын нам
ЗХУКН	Зөвлөлт Холбоот Улсын коммунист нам
ЗСБНХУ	Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс
ЗХУ	Зөвлөлт Холбоот Улс
ХЦХ	Хувьсгалт Цэргийн Хороо
БОТГХ	Бүх Оросын Төвийн Гүйцэтгэх Хороо

## 7

## МОНГОЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (1919-1921)

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Бүх монголчууд төр шашнаа сэргээхийн төлөө хэсэг бүлгээрээ эвлэлдэн тууштай тэмцэж байв.

## ГОЛ САНАА

Монгол улс өөртөө эзэрхэх эрхээ алдсан боловч 1921 оны 2 болон 7 сард тусгаар тогтнолоо сэргээн тунхаглав.

## ТҮЛХҮҮР ҮГ

- Нууц бүлэг
- МАН
- Зөвлөлийн Засагт Орос улс
- Гамин, цагаантан
- Барон Унгерн



## АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ

Зураг 2.17. Ардын хувьсгалын зүтгэлтнүүд



Ардын засгийн газрын анхны ерөнхий сайд Д.Бодоо



Монгол ардын намын анхны дарга С.Данзан



Бүх цэргийн жанжин бөгөөд Цэргийн яамны сайд Д.Сүхбаатар

1. Нэр бүхий түүхэн зүтгэлтнүүдийн тухай мэдээллээ хуваалцана уу. Тэд Монголын түүхэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бол... ?
2. Өмнөх сэдэв болон өөрсдийн мэдлэгт үндэслэн “1920-иод оны Монгол орон”-ы дотоод, гадаад байдлыг дүрслэн ярилцана уу.
3. Монголд яагаад дахин хувьсгал гарах болов? Энэ талаар асуулт гаргаарай.

Өөртөө эзэрхэх эрхээ алдсан монголчууд зохион байгуулалтад орж, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэх болов. Тэрхүү тэмцлийн гол зорилго нь юуны өмнө тусгаар тогтнолоо сэргээхэд чиглэж байлаа. Тэмцэл хурцадсаар 1918 оноос зохион байгуулалттай болов. Бүрэлдэхүүний хувьд ихэс дээдсүүд, бага албан тушаал бүхий бичгийн хүмүүсээс бүрдсэн хоёр бүлэг байлаа. Хоёр бүлэгт оролцогчид бүгдээрээ улс үндсээ болон төр шашнаа аврахын төлөө нэгдмэл зорилготой боловч тус тусдаа ажиллаж үйлсийн төлөө янз бүрийн аргаар тэмцэж байв. Тэд юуны өмнө гадаад улс орнуудтай холбоо тогтоохыг эрмэлзэж байв. Тухайлбал, Орос, Америк,

## ТОДРУУЛГА

Коминтерн  
- Коммунист  
интернационал  
Энэ бол дэлхийн  
хувьсгал хийх  
зорилгоор байгуулсан  
олон улсын  
байгууллага юм.  
Коминтерн 1919-1943  
онд оршиж байв.

Япон улсаас дэмжлэг эрж, холбоо тогтоохыг оролдсон байдаг. Гэвч тухайн үеийн дэлхий дахины байдлаас болж монголчуудын хүсэлтийг хүлээж аваагүй юм. Энэ үед дэлхийн I дайн дөнгөж дууссан, өмнөд хөршид ДИУ шинэ тутам төвхнөж, хойд хөршид Октябрийн эргэлтийн дараа дотооддоо иргэний

дайн хийж байлаа.


Ихэс дээдсийн бүлгийг Богд Жавзандамба хутагт, бага албан тушаалтны бүлгийг С.Данзан, Д.Бодоо нар удирдаж байв. Д.Бодоогийн тэргүүлсэн Консулын дэнжийн бүлгийнхэн Хүрээнд ажиллаж байсан, хувьсгалч үзэлтэй М.И.Кучеренко, Я.В.Гембаржевский нартай ажил хэргээ зөвлөх болов. Тэд хаант засаглалыг эсэргүүцдэг большевикуудыг тууштай дэмжигчид байв. Тиймээс ЗЗОУ-д хандаж тусламж гуйвал бүтнэ хэмээн Консулын бүлгийнхнийг ятгаж байсны сацуу бусад бүлгүүдийн тухай большевикуудад мэдээлж, Хүрээнд төлөөлөгч ирүүлэхийг уламжилж байв. Эдгээр бүлгийн аль аль нь ЗЗОУ ба дэлхий дахины улс төрийн байдлыг сонирхож янз бүрийн шугамаар мэдээлэл авч байв. Энэ үед ЗЗОУ тунхаг гаргаж дарлагдсан улс үндэстний тусгаар тогтнол, эрх чөлөөний тэмцэлд туслахаа мэдэгдэв.

## ТОДРУУЛГА

АНУ-ын ерөнхийлөгч Вудро Вильсон 1918 оны эхээр 14 зүйл бүхий тунхаг нийтэлж улс үндэстнүүд өөрийнхөө асуудлыг өөрсдөө шийдвэрлэх эрхтэйг анхааруулав.

1919 оны 11 сарын 17-нд Зүүн хүрээ (С.Данзан), Консулын дэнж (Д.Бодоо)-ийн хоёр бүлэг хамтран

хуралдаж, Оросын консул Орловоор дамжуулан, улсын хурлын нэрээр Орос улсаас тусламж гуйх бичиг өгөхөөр шийдвэрлэж, үүнийгээ Богдоор зөвшөөрүүлэх гэсэнд үл зөвшөөрчээ. Үүний дараа хоёр бүлгийнхэн Нийслэл хүрээнд дэх Оросын хуучин консултай уулзсанд тэрбээр, “Танай улсын хурал бол хэрэг хэлэлцэх эрхтэй байгууллага биш. Харин Богдын тамгатай бичиг байвал би Засгийн газартаа уламжилъя” гэжээ. Нууц бүлгийнхэн ийм хариу сонсоод дахин Богдод хандсан боловч мөн зөвшөөрөөгүй аж. Богд ийнхүү хоёр удаа татгалзсан нь зохих шалтгаантай. Тухайлбал, ЗЗОУ-д иргэний дайн үргэлжилж большевикууд төрийн эрхэнд байх эсэх нь тун эгзэгтэй байв. Омскийн Засгийн газар (1918-1-18-1920-1-5) улаантны довтолгоонд байнга өртөж байсан юм. Иймээс Орост итгэх аргагүйг Богд ухаарч тусламж гуйхаа азнаж байжээ.



Зураг 2.18. “Монголын үнэн” сонин.  
1920 оны 10 сар

1920 оны зун ЗЗОУ ба Коминтерний томилолтоор И.Сороковиков, С.Борисов, Д.Цэдэн-Иш нар Монголд ирж, нууц бүлгийн төлөөлөгчдийг Орост илгээх болов. Үүний сацуу С.Данзан, Х.Чойбалсан нар эхний удаад, Д.Бодоо, Д.Чагдаржав нар дараа нь Орост очив. Гэтэл оросууд тэдний тусламж гуйж байгааг Богд хутагт зөвшөөрсөн баталгаа авчир гэж шаардав. Иймээс нууц бүлгийн төлөөлөгчдийн сүүлчийн хэсэг Д.Сүхбаатар, Д.Догсом, Л.Лосол нар Богдын тамгатай бичгийг авч тэдний араас одов. Орост очсон нууц бүлгийн төлөөлөгчдөөс С.Данзан, Д.Чагдаржав нар Москва орж, ЗЗОУ-ын удирдагчидтай уулзаж тусламж авахаар тохиролцжээ.

### ТОДРУУЛГА



Зураг 2.19. Барон Унгерн

Нийслэл хүрээнд хятад цэргийн дарангуйлал нэн хэцүү болсон үед Барон Унгерний захирсан орос цэрэг Монголын зүүн хязгаараар хил нэвтрэв. Тэд Богдод захидал хүргүүлж, Монголыг хятад цэргээс чөлөөлөх зорилготойгоо мэдэгджээ. Богд хутагт үүнийг дуртай зөвшөөрсөн байна.

Энэ дагуу 1920 оны 10 сарын 26-нд Унгерний цэрэг Хүрээ рүү довтолсон боловч амжилт ололгүй ухарчээ. Үүний дараа Унгерний цэрэг Хэрлэн голын савд түр хуарагнан байлдааны бэлтгэлээ хангаад дахин Нийслэл хүрээг довтолов. Тэд 1921 оны 2 сарын 4-нд хятад цэргийг бүрмөсөн зайлуулав. Хятад цэргийн нэг хэсэг нь Хиагтыг чиглэн зугтаж Маймаачинд очиж хуарагнав. Үлдсэн хэсэг нь Хятад руу зугтаж одов. Ийнхүү хятад цэргийг хөөсний дараа Богд гэгээнийг хаан ширээнд эргүүлэн залж, улмаар Монголын тусгаар тогтнолыг тунхаглаж Засгийн газрыг 5 яамтайгаар сэргээн байгуулав. Засгийн газрын тэргүүнээр нь С.Дамдинбазарыг томилжээ.



Зураг 2.20. Ерөнхий сайд Жалханз хутагт Дамдинбазар

### МАН БАЙГУУЛАГДАВ

Монголын тусгаар тогтнол сэргэсний дараа улаантнууд ихэд тэвдэж, Унгерн Монголд суурьшиж, ЗЗОУ-д довтолох нь зайлшгүй хэмээн үзэж сөрөг арга хэмжээ авсан юм. Тэдгээр арга хэмжээний нэг нь цагаантантай дайтах төв болох МАН, АТЗГ байгуулахаар нэн шуурхайлан зохих бэлтгэл хангажээ. Чингээд 1921 оны 3 сарын 1-3-нд АДБНУ-ын Троицкосавск тосгонд С.Борисов, О.Макстеник, Ж.Цэвээн зэрэг Оросын харьяат нарын оролцоотойгоор нууц бүлгийн төлөөлөгч С.Данзан, Д.Сүхбаатар, Д.Лосол нар, мөн тэр хавийн 18 монгол иргэн, Оросын харьяат хэдэн буриад хуралдаж Монголын улс төрийн байдлыг хэлэлцэв. С.Данзан тус хурал дээр үг хэлэхдээ “Монголын түгшүүртэй байдлыг намжаах, шашин суртал, нутаг үндсээ хамгаалж

### Хожим

Монгол улс олон намын тогтолцоотой бөгөөд 2015 оны байдлаар Дээд шүүхэд бүртгэлтэй 24 нам байна.



тусгаар улс болж оршин тогтнох” -ыг онцлон тэмдэглэв. Мөн зарим хүн цагаантны цэргийг ЗЗОУ-ын тусламжтайгаар Монголоос хөөн зайлуулах тухай ярьжээ. Тус хурлаас МАН байгуулагдлаа хэмээн албан ёсоор тунхаглан зарлав. Элсүүлсэн цэргийг МАН-ын цэрэг гэж нэрлээд цэргийн жанжнаар Д.Сүхбаатарыг томиллов. Үүнээс гадна С.Данзанг МАН-ын ТХ-ны даргаар, гишүүдэд Ц.Дамбадорж, Д.Лосол нарыг сонгожээ. Бас Коминтерний төлөөлөгчийг МАН-д суулгахаар шийдвэрлэв. Тус намаас “Түмэнд тунхаглан зарлах бичгийн оршил”, “Гадаад Монголын түмэнд зарлах бичиг” хэмээх нэртэй хоёр баримтыг Ж.Цэвээн боловсруулсныг батлав. Эдгээр бичигт МАН-ын гол зорилго нь ард түмнийг зовлонгоос ангижруулж, алсдаа бүх монголчууд нэгдэж нэг улс болохын тулд Монголын төрийг дахин сэргээх явдал гэж заав.

### АРДЫН ТҮР ЗАСГИЙН ГАЗАР БАЙГУУЛАГДАВ

МАН байгуулснаас 10 хоногийн дараа Ц.Дамбадоржийн удирдлагаар 19 хүн хуралдаж АТЗГ-ыг байгуулж Д.Чагдаржавыг Засгийн газрын ерөнхий сайдаар, Д.Сүхбаатар, Н.Билэгсайхан, Л.Сумьяа, Д.Бодоо, Х.Чойбалсан нарыг түшмэлээр томилжээ. Ингэж Богдын тэргүүлсэн Засгийн газраас гадна АТЗГ байгуулагдснаар Монгол улс хоёр засгийн газартай болжээ.

Хүснэгт 2.6. Хоёр засгийн газрын үйл ажиллагаанаас

Ардын Түр Засгийн газрын үйл ажиллагаа	Богдын тэргүүлсэн Засгийн газрын үйл ажиллагаа
МАН, Түр засгийн төлөөний түшмэлийг хошуу, шавьд томилон суулгахаар шийдсэн. Төлөөний түшмэл нь ухуулга сурталчилгаа хийх, цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах, нэр нөлөө бүхий ихэс дээдэстэй холбоо тогтоох, АЖЦ-ийг өргөтгөх, хүч нөлөөгөө нэмэгдүүлэх, шашин, лам нарын хүч нөлөөг ашиглах үүрэгтэй.	АТЗГ-тай сөргөлдөж байсан тул яваандаа зэвсэгт мөргөлдөөнд зайлшгүй хүрнэ хэмээн бэлтгэлээ хангаж байв. Тухайлбал цэргийн насны эрчүүдийг албадан дайчлах, эсвэл хөлсний цэрэг элсүүлэх, цэргийн хүнс, уналга, сууц бэлтгэхэд хөрөнгө санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэхийг хичээх болов.
Цагаантны цэргийг хөөн зайлуулахын тулд улаан цэргийн ангиудыг Монголд оруулах хүсэлтийг ЗЗОУ-д тавьсан.	Гадаад бодлогодоо анхаарч Монгол, ДИУ-ын хооронд АНУ-аар зуучлуулах, Америкийн консулыг Монголд суулгах хүсэлт гаргав.
ЗЗОУ-аас АТЗГ-т өгдөг санхүүгийн дэмжлэгээ нэмсэн.	“Бага болзоот” хэмээх цаасан мөнгө гүйлгээнд гаргасан.

1921 оны 2-7 сард Богд хааны засгийн газар болон АТЗГ-ын аль аль нь цэрэг дайны аюулаас сэрэмжлэх, хил хязгаарыг батлан хамгаалах, хөрөнгө санхүүгийн эх үүсвэртэй болоход чиглэсэн бодлого хэрэгжүүлж байв.



## УНШААРЫ, ОЙЛГООРОЙ

1. Дараах асуултын дагуу ярилцаарай. Үүнд:
  - а) 1920-иод оны үед Монгол орны байдал ямар байв?
  - б) Энэ үеийн монголчуудын хүсэл, зорилго юу байв?
  - в) Зорилгодоо хүрэхийн тулд ямар үйл ажиллагаа явуулж байв?
  - г) ЗОУ-тай холбоо тогтоох болсны учир холбогдол юу вэ?
2. Эх сурвалжийг уншаад гүйцэтгээрэй.

“Ардын намын зорилт нь шашин, үндсэнд харшлах, харгис дайсныг цэвэрлэж, алдагдсан эрхийг эргүүлэн аваад, төр шашныг үнэн сэтгэлээр бататган мандуулж, үндэс язгуурыг алдахгүй сахих ба дотоод засгийг үнэн сэтгэлээр сайжруулан засамжилж, ядуу доорд ард түмний тусыг туйлаар бодох ба өөрийн дотоод эрхийг өнө үүрд сахиж, дарлах дарлагдахын зовлонгүй аж төрөхийг чухал болгоно”.

*Тангаргийн бичгийн 1-р зүйлээс*

“Монгол олон аймгийн ард олны эрх мэдлийг мандуулан дарлал, боолчлолын зүйлүүдийг устган, түмэн ардын гашуун зовлонг арилгаад, энх төвшнөөр аж төрөн, бусад олон үндсэн улсын адил аливаа эр чадал, эрдэм билиг юүгээн бадруулан гэгээрүүлж, улам улам боловсрон хэн тэгш жаргацгаахыг хүснэ”.

*“МАН-аас Гадаад Монголын түмэнд тунхаглан зарлах бичиг”-ээс*

- а) Ямар эх сурвалж болохыг тайлбарлаарай. Дараах загварыг ажиглаж болно.
- б) Гол, чухал санааг ялгаарай. Яагаад гол гэж үзсэнээ тайлбарлана уу?

<i>Тангаргийн бичгийн 1-р зүйлээс</i>	<i>МАН-аас гадаад Монголын түмэнд тунхаглан зарлах бичиг</i>
- Шашин, Монгол үндэстэн, төрөө мандуулах	- дарлал боолчлолыг устгах
- ядуу доорд олон түмний тусыг илүү бодох	- аливаа улсын адил гэгээрэн хөгжих
- .....	- .....

3. МАН-ын зорилго, бодлогыг тодорхойлно уу? Үүний тулд дараах асуултаас ашиглаарай. Үүнд:
  - а) МАН-ын үндсэн зорилго юу вэ? Тэд хувьсгалыг хийснээр улс орны байдал ямар болно гэж бодсон бэ?
  - б) Тэд яагаад ядуу доорд олон түмнийг илүүд үзсэн бэ? Энд ямар нэгэн ялгаварлал байгаа гэж үзэх үндэслэл байгаа юу?
  - в) МАН шашны талаар ямар бодлоготой байсан бэ?
  - г) Яагаад МАН-д коминтерний төлөөлөгчийг суулгахаар шийдэв?

4. Монгол улс яагаад хоёр Засгийн газартай болов? Эдгээрийн бодлого, үйл ажиллагааны талаар эргэцүүлж дүгнэж ярилцаарай.

1919 оны сүүлчээс өөртөө эзэрхэх эрхээ алдсан монголчууд улс үндэснийхээ язгуур эрх ашиг, эрх чөлөө, тусгаар тогтнолынхоо төлөө тэмцэж эхлэв. 1921 оны 2 сард Оросын цагаантны цэргийн генерал Ф.Унгерн Богд Жавзандамбын зөвшөөрсний дагуу хятадын цэргийг Нийслэл Хүрэннээс хөөн зайлуулсан нь Монголын тусгаар тогтнол дахин сэргэх боломж бүрдүүлсэн билээ.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### МОНГОЛЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ (1919-1921)

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Нууц бүлэг, нам
- Зөвлөлийн Засагт Орос улс
- Гамин, цагаантан
- Барон Унгерн

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.			Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. XX зууны эхэн үеийн Монгол Улс монголчуудын байдлыг жишээгээр тайлбарлаарай. 2. Тусгаар тогтнолоо сэргээхийн төлөө тэмцэл хэрхэн эхэлснийг хүснэгтээр харуулна уу. 3. Эх сурвалжуудыг ашиглан АТЗГ, МАН-ын зорилго, зорилтыг тодорхойлоорой.			4. МАН-ын ЗЗОУ-тай тогтоосон холбоо Монголын цаашдын түүхэнд хэрхэн нөлөөлснийг ярилцаарай.	5. 1921 оны хувьсгалын удирдагчдаас сонгон танилцуулга бичээрэй. 6. Түүхийг өөр өөрөөр тайлбарладгийг эргэцүүлээрэй.
Гол үйл явдлууд	Он цаг	Үр дүн		

## ТОЛЬ

- ЗЗОУ Зөвлөлийн засагт орос улс  
 АТЗГ Ардын түр засгийн газар  
 МАН Монгол ардын нам  
 АЖЦ Ардын журамт цэрэг  
 АДБНУ Алс дорнодын бүгд найрамдах улс

## 8

## 1921 ОНЫ МОНГОЛЫН ХУВЬСГАЛ

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

1921 оны Монголын хувьсгалын тухай зөв ойлголттой болсноор өнгөрсөн түүхээ танин мэдэх ач холбогдолтой.

## ГОЛ САНАА

1921 оны 3-7 сард Монголд болсон үйл явдлаар хувьсгал эхэлсэн гэж үздэг байлаа. Тэр үеэс эхлэн Монгол улс хойд хөршийн шууд хараат болж 70 жилийн турш большевикуудын заавраар замнав.

## ТҮЛХҮҮР ҮГ

- МАН
- Ардын журамт цэрэг
- Ардын засгийн газар
- Д.Бодоо
- С.Данзан
- Д.Сүхбаатар

1921 оны хавар Нийслэл хүрээнээс хөөгдсөн 2000 шахам цэрэгтэй, 12 пулемет, 7 их буу бүхий гамин цэргийн хүч Хиагтад байрлаж байв. МАН, АТЗГ тэрхүү хятад цэргийг үлдэн хөөх бэлтгэл хангасны дараа 1921 оны 3 сарын 18-нд улаан цэрэг, ардын журамт цэрэг (АЖЦ)-ийн хамт Хиагтыг чөлөөлжээ. Хятад цэргийн нэг хэсэг нь АДБНУ-ын нутаг руу, нэг хэсэг нь Нийслэл хүрээний баруун чиглэлээр Хятадыг зүглэн тус тус зугтаж, үлдсэн хэсэг нь Монголын умард хэсгээр сарнин тархаж, нутгийн ард олныг дээрэмдэж байв. Хиагтыг чөлөөлсний маргааш АТЗГ, МАН-ын ТХ дээд Шивээнээс Хиагтад шилжин байрлаж, цагаантны эсрэг тэмцэлд бэлтгэж эхлэв. Юуны түрүүнд АТЗГ-ыг 3 яамтай болгон зохион байгуулав.

Барон Унгерн дараагийн алхмаа хийж 1921 оны 5 сард цэргээ авч Нийслэл Хүрээнээс гарчээ. Тэрээр Хиагт орчмыг эзэлж, улмаар АДБНУ-ын нутаг руу орохоор төлөвлөж, хэд хэдэн удаа довтолсон боловч амжилт олоогүй юм.

ЗЗОУ 1921 оны зун Монголд цэргээ оруулахаар шийдснээр Монголын АЖЦ-тэй хүч хамсран байлдааны ажиллагааг эхлэх боломжтой болов.

Цагаантны цэрэг Нийслэл Хүрээнээс бараг бүгд гарахад зөвхөн Богд хааны



Зураг 2.21. Ардын нам засгийнхан. 1921 он

торгон цэрэг үлдэв. Тэр үед ЗЗОУ-ын сургагч нарын шийдвэрээр АТЗГ, МАН-ын ТХ Орос, Монгол цэргийн ангиудын хамт 1921 оны 6 сарын сүүлчээр Хиагтаас Нийслэл Хүрээ рүү хөдөлж, мөн оны 7 сарын 6-8-нд Нийслэл Хүрээнд ирэв. Ирмэгц Богд хаанд бараалхаж, Түр засгийн газрын ерөнхий сайд Д.Бодоо “Бидний ардын төлөөлөгчид Богд хаан болон олон лам, ноёд Та бүхний даалгасан ёсоор их Орос улсаас тусламжийг олж, гадаадын харгисыг сөнөөж, газар орноо бүрэн бүтэн болгож авав” хэмээн айлтгажээ. Мөн Богд хааныг хэмжээт эрхт эзэн хаанд өргөмжлөхөөр төлөвлөснөө танилцуулахад тэрбээр эсэргүүцээгүй ажээ. Ингээд мөн сарын 10-нд Монгол улсын Ардын засгийн газрыг (АЗГ)


**Хожим**

Жил бүрийн 7 сарын 11-нийг үндэсний их баяр наадам хэмээн тэмдэглэж ирэв.

байгуулжээ.

Нийслэл Хүрээнд ирсний дараа АЗГ-аас авч хэрэгжүүлсэн эхний алхам нь цагаантны үлдэгдлийг нутгаасаа бүрэн гаргахад чиглэсэн байна. 1921 оны 4 сард АТЗГ-аас аймаг, хошуудад төлөөний түшмэл илгээсэн. Тэд МАН-ын бодлогыг сурталчилж, цагаантны цэрэгт хүчин зүтгэж байсан монголчуудыг талдаа татах, цэрэг элсүүлэх, орон нутгийн нэр нөлөө бүхий ихэс дээдэстэй холбоо тогтоох, орон нутгийг төвхнүүлэх зэрэг ажлыг хийж байв.


Бүдүүвч 2.4. Ардын засгийн газрын бүтэц



Монголын АЖЦ, ЗЗОУ-ын улаан армийн хамт 1921 оны 8 сард Монгол орны төв хэсгийг, 1922 оны эх гэхэд цагаантан ба хятадын цэргээс бүрэн чөлөөлөв. Харин 1925 оны эх хүртэл ЗЗОУ-ын цэрэг монголд байрлаж байв.

Ардын засаг өмнөд хөрш ДИУ-ын заналхийллийг зогсоох, бусад улс оронд тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэхээр 1921 оны 9 сард ЗЗОУ, АНУ зэрэг улс оронд нот бичиг илгээв. Гэвч ЗЗОУ-аас бусад улс хариу ирүүлээгүй бөгөөд Ардын засгийн газар ЗЗОУ, Коминтернд түшиглэн тусгаар тогтнолоо бэхжүүлэх улс орноо төвхнүүлэх өөр сонголтгүй болов. 1921 оны намар С.Данзан тэргүүтэй

Зураг 2.22. Монгол орныг цагаантнаас чөлөөлөв





Ардын засгийн төлөөлөгчид ЗОУ-д айлчлан хэлэлцээр хийж, «Монгол, Орос улсын хооронд найрамдлын барилдлага байгуулах тухай» гэрээнд 11 сарын 5-нд гарын үсэг зурсан байна.

1918-1919 оны зааг үеэс эхэлсэн Монголын үндэсний эх орончдын тэмцэл 1921 онд оргилдоо хүрч улс орныхоо тусгаар тогтнолыг сэргээн тунхаглав. Энэ бол XX зууны Монголын түүхийн онцгой тэмдэглэлт үйл явдал мөн.



## УНШААРЙ, ОЙЛГООРОЙ

- 1921 оны хувьсгалын явцыг дүрсэлнэ үү. (зургаар, он тооллын шугамаар, бичгээр...)
- Хувьсгалын ялалт Хиагтаас эхэлсний учир холбогдол юу болохыг тунгаан ярилцаарай.
- Монголчуудын хувьсгал хийхдээ ашигласан арга, хэлбэрүүдийг жагсаан бичиж ярилцаарай.
- Эх орноо цагаантан ба хятадын цэргээс чөлөөлсөн үйл явц болон түүхэн зүтгэлтнүүдийн талаар ярилцаарай.

### 1921 ОНЫ МОНГОЛЫН ХУВЬСГАЛ

### ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- МАН
- Ардын журамт цэрэг
- Ардын засгийн газар
- Д.Бодоо
- С.Данзан
- Д.Сүхбаатар

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай			Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. 1920 оны үеийн Монгол орны түүхэн нөхцөл байдал:			5. Хувьсгал хийхэд ЗЗОУ-ын тусламжид түшиглэсний учир шалтгааныг тайлбарлан ярилцаарай.	7. Орон нутагтаа буй хувьсгалын үйл хэрэгт хүчин зүтгэж явсан хүмүүсийн талаар болон хувьсгалын түүхтэй холбоотой газар нутгийн талаар мэдээлэл цуглуулж, солилцоно уу.
Монголчуудын зорилго	Цагаан цэргийн зорилго	Гамин цэргийн зорилго		
2. Зорилгоо хэрэгжүүлэхийн тулд МАН-аас авч хэрэгжүүлсэн гол алхмуудыг он дарааллаар нь тоочин бичээрэй.			6. Хувьсгалын үйл явцтай холбоотой газар нутгууд хаана байдгийг эрж олон, газрын зурагт тэмдэглээрэй.	
3. Эдгээр үйл явдлын аль нь хувьсгалын эхлэл, төгсгөл, ялалтад хамаарч байгааг ялгаж, үр дагаврыг тодорхойлоорой.				
1921 оны хувьсгалын үйл явц				
Эхлэл		Өрнөл		

9

## АРДЫН ЗАСГИЙН АНХНЫ АРГА ХЭМЖЭЭ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Монголын удирдагчид үндэсний уламжлалаа түлхүү анхаарч, улс орноо дэлхийн жишгээр хөгжүүлэх бодлого боловсруулж эхэлсэн юм.

### ГОЛ САНАА

Монголын удирдагчид 1924 он хүртэл улс төр, эдийн засаг, соёлын хэд хэдэн чухал арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Хэмжээт эрхт хаант төр
- Улсын түр цагийн хурал
- Хамжлагат ёс
- Засаг захиргаа



### АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ

“Эрдмээр илүү нь эрхбиш тэргүүлдэг учиртайг... олон улс ухамсарлан мэдэж эрдэмд боловсруулахыг засгийн бодлогын манлай болгожээ. Улс эрдэм мөхөс болбаас ажил, үйлдвэр нь бүдүүлэг, эд хөрөнгө ба сүр хүчин буурай. Хэрэв эрдэм дэлгэрсэн болбаас элдэв зүйлийн боловсон арга хэрэглэж эд хөрөнгө зузаан, сүр хүчин их болно”

*Эдийн засгийн үндсэн бодлогоос. 1923 он*

1. Дээрх эх сурвалжаас харахад монголчууд юунд зорьж байв?
2. Тэдний зорилго хэрэгжсэн эсэх талаарх та бүхний төсөөлөл...?

### ТОДРУУЛГА

...одоо манай ардын засгийн газраас, ер Дундад улс лугаа өшөө хорслыг агуулан байлдаж дайлах хэргийг явуулах саналгүй боловч Хятадын сюзеренитетийг дахин хүлээж хэрхэвч чадахгүй...


*“Дэлхийн олон улсад хандаж тунхаглан нийтэлсэн бичиг”-ээс*

Ардын засгийн газар дараах чиглэлээр эхний арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлжээ. Үүнд:

- Хууль цаазыг шинэчлэх;
- Улсын түр цагийн хурал байгуулах;
- Богд хааны эрх хэмжээг тодорхойлох;
- Орон нутгийн засаг захиргааг өөрчлөх;
- Хамжлагат ёсыг халах;
- Албан татварыг тэгшитгэх;
- Сургууль байгуулах зэрэг болно.

Хятад, цагаантны цэргийн үлдэгдлийг хөөн зайлуулсныхаа дараа 1921 оны 7 сарын 23-нд төрийн бүх эрх мэдлийг өөртөө төвлөрүүлснээ Засгийн газар зарлан мэдэгдэв. Мөн оны 8 сард Улсын Түр Цагийн Хурал (УТЦХ) байгуулах шийдвэр гарч УИХ байгуулах хүртэл засгийн газар зөвлөх эрхтэй ажиллуулахаар заав. Үүний дараа 9 сарын 21-нд УТЦХ-ын дүрмийг баталжээ. Уул дүрэмд зааснаар аймаг, шавь тус бүрээс зургаан хүнийг УТЦХ-д сонгоно. Тэгэхдээ зөвхөн нэг нь ноёдоос, тав нь заавал эгэл ард хүн байхаар заав. Энэ нь Монгол улсад иргэдээ нийгмийн байдлаар нь ялгаварлах эхлэл байлаа.

УТЦХ-ын гол үүрэг нь Монголын төрийн үйл ажиллагааг тодорхой хууль дүрэмд захируулж дэлхийн олон улсын жишигт нийцүүлж байх явдал байв. Мөн оны 11 сарын 5-нд Богд хаан ба Засгийн газрын хооронд “Тангаргийн гэрээ” байгуулж Богд хаан зөвхөн шашны бүх хэргийг хязгааргүй эрхлэх, засгийн газрын шийдвэртэй танилцах эрхтэй боловч зөвхөн нэг удаа татгалзах эрхтэй болов.



Зураг 2.23. Ардыг гэгээрүүлэх яамны сайд Эрдэнэбатхааны захиалгаар Герман улсад 1923 онд хэвлэсэн Монгол улсын газар зүйн зураг

1923 оны эхээр хамжлагат ёсыг халав. “Монгол Улсын засаг ба засаг бус ван гүнгүүдийн эрх хэмжээний дүрэм”, “Монгол Улсын нутгийн захиргааны дүрэм” батлан гаргаж ван гүнгүүдийн эрхийг хязгаарлав. Нутгийн захиргааны удирдлагыг сонгон байгуулах болов. 1924 онд УИХ байгуулагдсанаар бүгд найрамдах засагтай улс болов.

1922 оноос нутгийн захиргаадыг шинэчлэх ажил эхэлж, 1923 онд 4 аймаг, бүх хошууг урьдын адил засаг ноёдын нэрээр нэрлэхийг зогсоож, ард олны сайн мэдэх томоохон уул, газар усны нэрээр нэрлэх болжээ.

## ТОЛЬ

Сюзеренитет	эзэн эрх
Хамжлага	Язгууртнуудын шууд мэдлийн албат иргэд. 1923 оноос өмнө Монголын язгууртнууд хамжлага эзэмших эрхтэй байв.
УТЦХ	Улсын түр цагийн хурал
Янчиан	Хятадын мөнгөн тэмдэгт

## Хожим

1931 онд орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалтыг өөрчилжээ.

1938 онд Булган аймаг байгуулагдав. 1940 онд Баян-Өлгий аймаг байгуулагджээ. 1942 онд Баянхонгор, Дундговь, Сүхбаатар аймаг байгуулагдаж, нийт 18 аймагтай болов. 1994 онд Дархан уул, Орхон, Говь-Сүмбэр аймаг нэмэгдэж, 21 аймагтай болжээ.

Шинэ тутам монгол улсын эдийн засгийг бэхжүүлэх талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

*Хүснэгт 2.7. Эдийн засгийн зарим арга хэмжээ*

<i>Мал сүрээ</i>	<ul style="list-style-type: none"> <li>• 1921-1924 онд 50 хүртэл толгой малтай өрхийг татвараас чөлөөлсөн</li> <li>• 1924 оноос 100-500 малтай бол 5%, 501-1000-д 15%, 1000-аас дээш малтай бол 20%-ийн татвар ногдуулах болсон.</li> </ul>
<i>Тариалан</i>	<ul style="list-style-type: none"> <li>• 1922-1924 онд Ховд, Зүүнхараад төрийн өмчийн тариалангийн газар-САА байгуулав.</li> <li>• Гадаадынхны орлогоос 10%-ийн татвар хурааж, түүний 6%-ийг улсын санд, 4%-ийг тухайн орон нутгийн төсөвт зарцуулж байв.</li> </ul>
<i>Төсөө, санхүү</i>	<ul style="list-style-type: none"> <li>• 1924 онд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн “Худалдаа аж үйлдвэрийн банк” байгуулсан. 1954 онд уг банкийг БНМАУ-ын өмчид өгсөн.</li> <li>• 1925 онд үндэсний мөнгөн тэмдэгттэй болсон</li> <li>• 1921-1924 онд улсын хэмжээнд 24 гаалийн хороо ажиллаж, гаалийн татварын орлого 1,5-2,5 сая лан мөнгө болсон.</li> </ul>
<i>Худалдаа</i>	<ul style="list-style-type: none"> <li>• 1921 оны эцсээр Монгол ардын харилцан туслалцах хоршоог анх 70 гишүүн, 15 мянга орчим янчианы хөрөнгөтэй байгуулжээ.</li> <li>• 1922 оны сүүлчээс эхлэн ЗХУ, Коминтерний заавраар хувийн худалдааг хавчиж, хоршооллын ба улсын худалдааг төрөөс дэмжих болов.</li> </ul>
<i>Үйлдвэр</i>	<ul style="list-style-type: none"> <li>• 1921-1924 онд зарим үйлдвэрийн салбарууд бий болсон. Жишээ нь: Цэргийн хувцас, агтны тоноглол, зэвсэг засварын цех ажиллах болов.</li> <li>• Хэвлэлийн газар, малын эм бэлтгэх газар, Налайхын уурхай, мод бэлтгэх газар, шохой тоосгоны үйлдвэр, Алтанбулагийн булигаарын үйлдвэр зэргийг улсын мэдэлд авсан.</li> <li>• Ноос угаах, өлөн гэдэс, лаа, саван боловсруулах газрыг өргөтгөжээ.</li> </ul>

Ардын засгийн газраас шинэ цагийн боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэхэд анхаарч 1921 оны намраас Нийслэл хүрээнд анхны бага сургууль байгуулж улмаар хөдөөд бага сургуулиуд хичээллэх болсон нь орчин үеийн сургууль боловсролын эхлэл болов. Монголын төр иргэдээ боловсролтой болгох нь улс орон тогтвортой хөгжих баталгаа хэмээн үзэж байлаа. Тиймээс 1921-1923 онд Засгийн газрын шийдвэрээр С.Жамьян Ж.Цэвээн тэргүүтэй хэсэг эрдэмтдийн боловсруулж батлуулсан “Эдийн засгийн үндсэн бодлого” хэмээх хөтөлбөрт эрдэм боловсролын талаар чухалчлан тэмдэглэжээ. 1922-1923 онд Багш нарыг бэлтгэх ба давтан сургах сургууль байгуулсан нь монголын анхны үндэсний мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх эхлэл байв. 1923 оноос хүүхдүүд дунд сургуульд суралцах болжээ.

1921 оны 11 сард Монгол улсын шинжлэх ухааны анхны байгууллага Судар бичгийн хүрээлэнг байгуулав. Судар бичгийн хүрээлэнд С.Жамъян, Ж.Цэвээн, Ш.Дамдин, Ч.Дэмчигдорж, Б.Буянчуулган, Л.Дэндэв, Ц.Ширнэндамдин нарын монголын урдаа барьдаг эрдэмтэн мэргэд ажиллаж байв. Тус хүрээлэн эхэн үедээ түүхийн дурсгалт зүйлсийг олж цуглуулах, хадгалах, шинжлэх ухааны суртал нэвтрүүлэг түгээх, гадаад хэлээрх зохиолыг монголчлох болон түүх, монгол хэл, газар зүйн судалгаа хийж байв.

1923 оноос ЗХУ-ын эрдэмтэн П.К. Козловын шинжилгээний анги Ноён ууланд малтлага хийж Хүннүгийн үеийн булшаар шинэ нээлт хийжээ. АНУ-ын судлаач Р.Эндрюсийн палеонтологийн анхны экспедиц засгийн газрын зөвшөөрлөөр 1922 онд Бага Богд, Арц Богд, Гурван сайхан, Онгийн голд, хоёр дахь экспедиц нь 1923 онд Онгийн гол, Шаварт, Баянзаг зэрэг газруудаар хайгуул хийж, Монголын говиос үлэг гүрвэлийн бүтэн яс, өндөг, бусад үнэт зүйл олжээ.



ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Хүснэгтийн дагуу ажиллаж Ардын засгаас хэрэгжүүлсэн арга хэмжээ түүний үр дүнг тодорхойлоорой.

Улс төрийн арга хэмжээ	Эдийн засгийн арга хэмжээ	Нийгмийн арга хэмжээ	Соёл, боловсролын арга хэмжээ

2. Анхны арга хэмжээнүүдээс үзэхэд 1921-1924 онд Засгийн газар ямар бодлого баримталж байв?

3. Дараах загварыг ашиглан өөрийн аймаг, сумын засаг захиргааны хуваарь хэрхэн өөрчлөгдөж ирснийг судлан тогтоогоорой, танилцуулаарай.

1921-1924 онд Монголын удирдагчид улс орноо дэлхийн жишгээр хөгжүүлж хоёр хөрш улс болон бусад улс орнуудтай улс төр, эдийн засаг, соёлын найрсаг харилцаатай байхыг хичээж байлаа.

Гэтэл 1924 оны 8 сард хуралдсан МАН-ын III их хурал, мөн оны 11 сард хуралдсан Улсын I их хурлын шийдвэрүүдэд Монгол улсын хөгжлийн чиглэлийг огт өөрөөр тодорхойлсон. Энэ үеэс хойд хөршөөсөө хараат байх эхлэл тавигдсан юм.

- Одоогийн нэр:** Баянхонгор аймгийн Жаргалант сум
- Манжийн эрхшээлийн үед:** Сайн ноён аймаг 1725 онд Түшээт хан аймгаас тасарч байгуулсан. 1725-1911 онд 24 хошуу, 8 тамгатай хутагтын шавьтай байв. Халхын хойд замын баруун гарын этгээдийн хойдох хошуу (1691-1911)
- Богд хаант Монгол улсын үед:** (1911-1923 онд) Сайн ноён хан аймгийн Эрдэнэ засгийн хошуу нэртэй байв. Сайн ноён хан Намнансүрэн Монгол Улсын анхны ерөнхий сайдаар 1912-1919 онд ажиллаж байв.
- Ардын засгийн үед:**
  - 1923-1931 онд Цэцэрлэг Мандал уулын аймгийн Богд хайрхан уулын хошуу гэж нэрлэж байв.
  - 1931 оноос Өвөрхангай аймгийн Заг сум.
  - 1942 оноос Баянхонгор аймаг, Жаргалант сум байгуулав.

АРДЫН ЗАСГИЙН АНХНЫ АРГА ХЭМЖЭЭ

ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийн утгыг 2-3 өгүүлбэрээр илэрхийлэн тайлбарлаарай.

- Хэмжээт эрхт хаант төр
- Улсын түр цагийн хурал
- Хамжлагат ёс

Мэдээлэл, тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр хийгээрэй.	
1. 1921-1924 онд Монгол улсын эдийн засаг, соёлд гарсан ололтыг жагсаан хэлэлцээрэй. 2. Холбогдох түүхийн дурсгалт газруудыг зурагт тэмдэглээрэй.	3. Ардын засгийн газраас авч хэрэгжүүлсэн гол арга хэмжээг хүснэгтээр үзүүлээрэй.	4. Шинэ тутам Монгол улсын эдийн засаг, боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх чиглэлээр авсан арга хэмжээг илтгэн харуулахуйц бүтээл хийж танилцуулаарай.	
			Авсан арга хэмжээ
	Хууль цаазыг шинэчлэх		
	Богдын эрх хэмжааг тогтоох		
	Орон нутгийн засаг захиргааг өөрчлөх		



## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүүхдүүдээ, Та бүхэн “Монгол төрийн сэргэн мандалт ба дэлхий дахин” сэдэвт хоёрдугаар бүлгийг судалж дууслаа. Энэ бүлгээр ХХ зууны монголын түүхэнд гарсан хоёр хувьсгалыг судаллаа. Мөн дэлхийн түүхийн томоохон үйл явдал болон I дайн болон Орос улс дахь Октябрийн эргэлтийг монголын түүхтэйгээ холбон судлан мэдсэн гэдэгт итгэж байна.

1. Бүлэгт гарсан хүмүүсийн нэрсийг жагсааж бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.
  - а) Хүмүүсийн нэрсээс монголын болон дэлхийн түүхэнд тодорхой үүрэг гүйцэтгэсэн гэж үзэж буй 3-5 хүний нэрийг сонгоно уу.
  - б) Яагаад та эдгээр хүмүүсийн нэрсийг сонгосноо тайлбарлаж, бусад хүүхдүүдийн сонголттой харьцуулна уу.
2. Хүснэгтийг нөхөж гүйцээгээрэй.


	Хувьсгал гарах үеийн		Түүхэн хүмүүс	Гол үйл явдал	Үр дүн	Сургамж
	гадаад байдал	дотоод байдал				
1911 оны хувьсгал						
1921 оны хувьсгал						

3. Зөв тохируулаарай.

1.	1910 он	а)	Сурагчид	i.	Монгол төрийн тусгаар тогтнолыг сэргээн тунхаглав.
2.	1911 оны зун	б)	Түүхчид	ii.	Газар оронгүй бөгөөс улс үгүй.
3.	1911 оны 12 сарын 29	в)	Монгол ноёд	iii.	Зарлигаар тогтоосон Монголд улсын шашдир
4.	1912	г)	Богд хаан	iv.	... могой цагийн эхэнд хурж, бичин цагийн эхэнд тарна.
5.	1915 он	д)	Т.Намнансүрэн	v.	Хүрээний лам нарын зодоон болов.
6.	1911 он	е)	Ж.Цэвээн	vi.	Ерөнхий сайд
7.	1915 он	ё)	Дамдинсүрэн	vii.	Ноёдын нууц зөвлөлгөөн болов.
8.	1918 он	ж)	Сандо	viii.	...зарим газар цагаан хэрэмд тулж очив.

4. Дараах бүлэглэсэн түлхүүр үгсийг ашиглан 3-5 өгүүлбэр зохионо уу.
  - а) Тусгаар тогтнол, үндэсний бахархал, өөртөө эзэрхэх эрх
  - б) Хувьсгал, дайн, эргэлт
  - в) МАН, ардын засгийн газар, хэмжээт эрхт хаант төр, хамжлагат ёс
  - г) Ардын журамт цэрэг, улаантан, цагаантан
  - д) Эдийн засаг, соёл, боловсрол

5. Дараах бүдүүвчийг гүйцээнэ үү.



6. Бүлгийг судлахад ашигласан эх сурвалжуудаа жагсаан бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

а) Эх сурвалжуудыг ашиглан түүхийн тодорхой асуудлыг судлахын тулд шинжлэн судлах үйл ажиллагааны ямар дараалал баримталснаа тэмдэглэнэ үү.



б) Жагсаасан эх сурвалжуудаасаа хоёрыг сонгон дараах хүснэгтийн загварыг ашиглаж эх сурвалжаа тайлбарлаарай.

	Гарал	Төрөл
Эх сурвалж 1:	Анхдагч эх сурвалж Учир нь..... -Хоёрдогч эх сурвалж Учир нь.....	-Эх сурвалж Яагаад гэвэл..... -Судалгааны бүтээл Яагаад гэвэл.....

7. Бүлэгт гарсан улсууд болон газар орны нэрийг бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

а) Жагсаасан улс болон газар нутгаа монголын болон дэлхийн газрын зурагт заана уу.

б) Газрын зурагт зааж чадаж буй эсэхээ дараах хүснэгтийн дагуу тэмдэглэж, өөрийгөө үнэлээрэй.

№	Улс, газар нутаг	шууд зааж чадсан	Өөрийн үнэлгээ		Өөртөө өгөх зөвлөгөө
			нэмэлт мэдээлэл уншиж байж заасан	зааж чадахгүй байсан	
1.					

8. Дараах он цагийг шилжүүлнэ үү.

а) Монгол цэргүүд олноо өргөгдсний 2 дугаар оны 8 сарын эхээр Ховдыг чөлөөлжээ.

б) Босогчид георгийн тооллын 1917 оны 10 сарын 24-25-нд шилжих шөнө өвлийн ордонг эзлэв.

9. Дараах сэдвүүдээс сонгож хэлэлцүүлэг хийнэ үү.

а) Монголын тусгаар тогтнол ба монгол хүн

б) Дайн ба хүмүүсийн амьдрал

в) Түүхийн талаарх ялгаатай үзэл бодол



# СОЦИАЛИЗМЫН ҮЕИЙН МОНГОЛ УЛС БА ДЭЛХИЙ ДАХИН (1924-1990)

## 1

### МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА БА ЗХУ-ЫН НӨЛӨӨ

#### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

- Өнгөрсөн түүхээсээ сургамж авдаг нь хүн төрөлхтний нийтлэг жишиг.
- ЗЗОУ (ЗСБНХУ) ДИУ хоёр Монгол улсын хувь заяаг шийдвэрлэж байсан түүхэн үнэний бодит сургамжийг ухаарах

#### ГОЛ САНАА

- Монголын төр түүхэн хөгжлийн замаа тодорхойлсон ч ЗХУ 1924 оноос Монголын дотоод хэрэгт шууд оролцох болов.

#### ТҮЛХҮҮР ҮГ

- Капиталист бус хөгжлийн зам
- Социализм
- Эдийн засгийн үндсэн бодлого
- Коминтерн
- Нийгэм журам (коммунизм)



### АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ



Зураг 3.1. Д.Амгалан “Капитализмыг алгасач”

Улс орны хөгжлийн чиг шугамыг тодорхойлохдоо “нэг хоёр хүний боловсорсон, мэдсэн цэцэн хурцаар тогтоод журамлан явахуйяа бэрх”. Харин “бүгдээр найрамдах буюу зөвлөлдөх мэтсийн олон зэрэг дэс байр байх бөгөөд үлгэрлэвээс авирах гишгүүрт нэгээс үүсгэн дэвших ба усанд гүехнээс гүнд орохын адил буй. Үүний зэрэг дэс солигдвоос үл болох буюу”.

1922 оны 4 сарын 17-нд С.Данзангаас МАН-ын Төв Хороонд өргөсөн саналаас

1. Зураг 3.1-ийг ажиглаж түүхийн хичээлтэй холбон асуулт гаргана уу.
2. Социализмын тухай өмнөх мэдлэгээ сэргээн санаж ярилцаарай.
3. Монголчууд яагаад социализмын замыг сонгох болсон талаар өөрийн таамаглалыг хэлнэ үү.

1921-1924 оны намар хүртэлх хугацаанд Монголын удирдагчид улс орноо хөгжүүлэх бодлогын эхний хэсгийг боловсруулан хэрэгжүүлж эхэлсэн юм. Уул бодлогын агуулга нь:

- монголчууд үндэсний эрх ашгаа дээдлэн хадгалах
- эдийн засгийн хувьд аль нэг хүчирхэг гүрний хараат байдалд орохоос сэрэмжлэхэд чиглэж байв.

Энэ үед улс төр, нийгэм, эдийн засгийн бодлогыг боловсруулах, төлөвлөх, хэрэгжүүлэхэд Д.Бодоо, С.Данзан, С.Дамдинбазар, Б.Цэрэндорж, А.Амар нар тэргүүлэх байр суурьтай байв. Тэд “Үндэсний онцлогоо чанд хадгална. Хувийн болон хоршооллын өмчийг төрөөс тууштай дэмжинэ. Хүн төрөлхтний нийтлэг жам ёсны дагуу улс орноо хөгжүүлнэ. Английг толь болгож Монголд тохирох зүйлээс нь шилж сонгон хэрэглэнэ. Ард иргэдээ баян чинээлэг амьжиргаатай болгоно. Дэлхийн аль ч улс оронтой харилцан ашигтай, хамтран ажиллана” гэж хөгжлийн баримжаагаа тодорхойлж байв.

Харин ЗХУ-ын удирдагчид “Монгол улс хөрөнгөтөн баячуудгүй, хувийн өмчгүй байх ёстой. Монголын хөгжлийн гол зорилго бол нийгэм журам байгуулахад чиглэх ёстой” гэж үзэж байв.

Монголын удирдагчид 1921 оны 9, 10 сард Монгол улсын хөгжлийн чиг баримжааг тодорхойлсон хоёр баримт бичиг боловсруулж сонинд нийтлүүлсэн юм. Энэ хоёр баримт бичиг бол Монголын төр улс орноо нийтийн жам ёсны дагуу хөгжүүлэх зорилгоор боловсруулсан анхны хөтөлбөр байлаа.

Хүснэгт 3.1.

Баримт бичиг		Агуулга
1921 оны 9 сарын 14-ний “Уриа” сонинд	“Нам засгаас ойрын үед гүйцэтгэх бодлогууд”	<p>Төр засгийн эрх мэдэл, үйл ажиллагааны үндсэн агуулгыг тодорхойлов. Тухайлбал,</p> <ul style="list-style-type: none"> <li>• Богд хаан Засгийн газрын шийдвэрийг цуцлах эрхгүй.</li> <li>• Дайтах, найрамдах, улсын төсөв батлах эсэхийг Засгийн газар, Улсын хурал хамтран шийдвэрлэнэ</li> <li>• Хуралд данстай ламаас бусад цэргийн насны эрчүүд цэргийн алба хаана.</li> <li>• Бүх хүн хуулийн өмнө адил эрхтэй байна.</li> </ul>
1921 оны 10 сарын 2	“МАН-ын зорилтыг ухуулан тайлбарласан бичиг” (10 зүйл бүхий)	<ul style="list-style-type: none"> <li>• Улс орноо хөгжүүлэхэд эрдэм мэдлэг тэргүүлэх үүрэгтэй. Тиймээс боловсон багш нарыг урьж түүхий эд боловсруулах машины сургууль байгуулж, хүүхэд залуусаа сургана.</li> <li>• Худалдааны хоршоо байгуулж түүхий эдээ экспортолж, чанартай эд бараа авчирч борлуулан ард иргэдийнхээ амь зуулга, ашиг орлогыг дээшлүүлнэ.</li> <li>• Ард түмнээс хураадаг албан татварыг багасгана.</li> <li>• Үйлдвэрлэх, бүтээх, арвилан хэмнэхийг чухал болгоно.</li> </ul>

1923 оны 4 сард баталсан “Эдийн засгийн үндсэн бодлого” бол дээрх хоёр баримт бичгээс нилээд өргөн агуулгатай юм. Тухайлбал, эдийн засаг, гадаад худалдаа, сургууль, боловсрол, гадаад түншлэлээ зөв сонгоход ихээхэн анхаарчээ. Тухайлбал, “Хүн ам нь эрүүл чийрэг, боловсрол мэдлэгтэй, тооны хувьд олон бол аль ч улс түргэн хөгжих боломжтой. Иргэд эрүүл чийрэг байхын тулд хүн бүр цэвэр орчинд байж, ариун цэврийг чанд сахих хэрэгтэй... Мөн харьд буй монголчуудаа урьж ирүүлбэл хүн амын тоо олширч, эд хөрөнгө элбэг зузаан болно” гэжээ.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Эх сурвалжуудаас үзвэл Монгол улс хөгжлийн шинэ чиг баримжаагаа хэрхэн тодорхойлж байсныг дараах чиглэлийн дагуу ярилцаарай
  - Боловсрол
  - Эрүүл мэнд
  - Худалдаа

1. Монгол улсын гадаад худалдааны учир, байцаавал олон их, бага улс дотроос зарим нь эзэрхэг шунахай бөгөөд бага буурайг дарламтгай ба залгимтгай, зарим нь хурц эрдэмтэй, зарим нь бүдүүлэг байх...учир, зүй нь харилцан худалдаа ашиг, эрдэм соёлын тухай гэрээ, болзоо тогтоон нэвтрэлцэхэд хүрвэл эрхбиш хэдэн давхар эргэцүүлэн хянаж тогтоовол зохино. Герман, Англи, Орос, Америк, Хятад, Япон хэмээн шилэн сонгоход хүрвээс аль ч талаар Герман, Орос, Америк хэмээх мэтээр тэд дараалан ормой.

*Эдийн засгийн үндсэн бодлого.  
17-р зүйл*

2. Улс эрдэм мөхөс болвоос ажил үйлдвэр нь бүдүүлэг, эд хөрөнгө ба сүр хүчин буурай, хэрэв эрдэм дэлгэрсэн болвоос элдэв зүйлийн боловсон арга хэрэглэж, эд хөрөнгө зузаан, сүр хүчин их болно. Герман улсын ард түмэн нэгэн түмэн эр, эм хүн дотроос дөрөвхөн нь бичиг үл мэдэх, Английн улсын дотор нэгэн түмэн хүний арваад хүн бичиг үл мэдэх бус, Оросын түмэн хүн дотор долоон мянга нь бичиг үл мэдэх, Рибин (Япон) улсын түмэн хүн дотор нэг зуун хүн бичиг үл таних мэт үлгэртэй бөгөөд эрдэм соёлоор баялаг нь эд хөрөнгө, чадал хүчнээр аяндаа баялаг ажгуу.

*Эдийн засгийн үндсэн бодлого 18-р зүйл*

2. ЗХУ болон Коминтерний зүгээс Монгол улсын хөгжлийн чиг баримжааны асуудлаар ялгаатай байр суурь баримталж байсныг баримтад үндэслэн тайлбарлаарай.
3. Коминтерн гэж ямар байгууллага вэ? Тэд монголчуудын хувь заяанд хэрхэн нөлөөлсөн бэ?



Монголын удирдагчид хөгжлийн чиг баримжаагаа тодорхойлон хэрэгжүүлж эхлээд байсан үед МАН-ын II их хурал 1923 оны зун хуралдаж анхаарал татахуйц хоёр шийдвэр гаргасан юм. Үүнд:

1. “Манай хоёр улсын эв найрамдлыг эвдэхийг бодож үйлдэгч харгис этгээдийг шууд устгавал зохино” хэмээн ЗХУ-аас Монголын талаар хэрэгжүүлж буй бодлогод шүүмжлэлтэй ханддаг хүмүүсийг залхаан цээрлүүлж байх тухай

2. “Манай нам бөгөөс жинхэнэ улсыг удирдах нам мөн” гэсэн Монгол улсын төрийн дээд байгууллага нь Монгол улсын Засгийн газар бус, МАН гэж тунхагласан заалт юм.

Энэ хоёр шийдвэр нь хоорондоо нягт уялдаатай бөгөөд төр улсын дээд эрх барих МАН-ыг ЗХУ өөрийн хүссэнээр залж чиглүүлэх бүрэн эрхтэй болов. Мөн тус хурлаас Монгол улс капиталист бус замаар хөгжих болно хэмээн онцлон заав. ЗХУ-ын нөлөөгөөр 1924 онд МАН-ын III, Улсын анхдугаар их хурлаас гаргасан дээрх шийдвэрийн уршгаар 1921-1923 онд Монголын төрөөс боловсруулсан бодлогыг 1928 оны сүүлч гэхэд зугуухнаар цуцалсан байв.

ҮНЭЛЭЭРЭЙ

МОНГОЛЫН ХӨГЖЛИЙН ЧИГ БАРИМЖАА БА ЗХУ-ЫН НӨЛӨӨ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Капиталист бус хөгжлийн зам
- Социализм
- Коминтерн
- Эдийн засгийн үндсэн бодлого

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.								
<p>1. Монголын удирдагчид улсынхаа хөгжлийн чиг хандлагыг тодорхойлсон байдал:</p> <table border="1" data-bbox="146 1233 494 1372"> <tr> <td>Салбар</td> <td>Шийдвэрлэх арга зам</td> </tr> <tr> <td>Эрүүл мэнд</td> <td></td> </tr> <tr> <td>Боловсрол</td> <td></td> </tr> <tr> <td>Худалдаа</td> <td></td> </tr> </table> <p>2. Монголын удирдагчдын бодлого хэрхэн хэрэгжив? Түүнд юу саад болов?</p>	Салбар	Шийдвэрлэх арга зам	Эрүүл мэнд		Боловсрол		Худалдаа		<p>3. Улс орны хөгжлийн цаашдын хувь заяаны асуудлаарх дэвшүүлсэн таамаглал батлагдав уу? Үндэслэлээ баримтаар нотлон танилцуулаарай.</p>	<p>4. “Коминтерн ба Монголын хөгжлийн чиг баримжаа” сэдвээр эсээ бичээрэй.</p>
Салбар	Шийдвэрлэх арга зам									
Эрүүл мэнд										
Боловсрол										
Худалдаа										

ТОЛЬ

Капиталист бус хөгжлийн зам  
Капитал

Капиталист нийгмийг алгасан шууд социализмд шилжих хэмээсэн большевикуудын үзэл баримтлал  
Хөрөнгө, хөрөнгөтөн

## 2

## МОНГОЛ УЛС БҮГД НАЙРАМДАХ ЗАСАГЛАЛД ШИЛЖСЭН НЬ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Эх түүхийн сайн нь ч миний  
багш, саар нь ч бас миний  
багш

*Мэргэдийн сургаал*

### ГОЛ САНАА

Хаант засгийг устгаж  
Монголд Бүгд найрамдах  
засаглал тогтсон.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Бүгд найрамдах засаг
- Үндсэн хууль
- Жинхэнэ ард
- Жинхэнэ бус ард
- ЗХУ



### АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ

1921 оны 7 сард Монгол улс тусгаар тогтнолоо сэргээж хэмжээт эрхт хаант засаглалаа тунхагласныг ЗЗОУ хүлээн зөвшөөрөхгүй байлаа. Тиймээс ч большевикууд тэр үеэс эхлэн Монголыг Бүгд найрамдах засаглалд шилжүүлэх төлөвлөгөө боловсруулсан боловч түүнийг хүлээн авахад ард түмнийг бэлтгэх нь бүр илүү чухал байсан бас “эзэн хаан нэртэйгээс цаашгүй Богд гэгээнийг нас барах хүртэл” бүгд найрамдах засгийг хойшлуулсан юм гэж ЗХУ-аас Монголд сууж байсан бүрэн эрхт төлөөлөгч 1924 оны зун Москвад мэдээлсэн байдаг.

*Монголын тухай БХК/Б/Н-ын баримт бичиг 1920-1952/ I боть 1920-1932.  
Эмхэтгэгчид С.Дамдинсүрэн, А.С.Железняков ба бусад УБ 2002. Т-149*



Зураг 3.2. БНМАУ-ын төрийн далбаа 1924 он



Зураг 3.3. 1924 оны Үндсэн хуулиар баталсан БНМАУ-ын УИХ-ын тамганы дардас

1. 1921 оны хувьсгалын үр дүнд байгуулсан Ардын засгийн газар болон Богд хааны эрх хэмжээний талаар өмнөх мэдлэгтээ тулгуурлан ярилцаарай.
2. 1921-1924 оны хооронд ЗЗОУ Монголын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрөхгүй байсан учир шалтгааныг эргэцүүлэн ярилцана уу.
3. 1924 оны далбаа болон тамганы бичээсийг уншина уу. Та бүхэнд ямар мэдээлэл өгч байна вэ?

ЗЗОУ 1921 оноос эхлэн ДИУ-тай гэрээ байгуулж тусгаар тогтнолоо зөвшөөрүүлэхээр хичээсэн боловч нааштай үр дүнд хүрэхгүй байсаар 1924 онтой золгов. Үүний гол шалтгаан нь Монголын тусгаар тогтнол байв. Тиймээс Дундад иргэн улс “ЗСБНХУ-ыг Хятад улс хүлээн зөвшөөрөх нэг гол болзол” бол “ЗСБНХУ Монголын бие даасан байдлыг дэмжихээ бүрмөсөн болих шаардлага тавьсан байна”. Большевикууд үүнийг зөвшөөрч 1924 оны 5 сарын 31-нд “Хятад Зөвлөлтийн хоорондын маргаантай асуудлыг шийдвэрлэх хөтөлбөрийн тухай хэлэлцээр” байгуулж “Зөвлөлт Засгийн газар Гадаад Монгол нь ДИУ-ын нэг хэсэг мөн болохыг хүлээн зөвшөөрч уг нутаг дэвсгэрт хятадын бүрэн эрхийг хүндэтгэнэ” хэмээн тохиролцож Монголын тусгаар тогтнолыг үл зөвшөөрөхөө мэдэгдсэн юм.

Монголын тусгаар тогтнолыг ЗХУ, ДИУ хоёр хуйвалдан цуцлахаар хэлэлцэж буйг Монголын эрх баригчид сайн мэдэж эсэргүүцэж байлаа. Гэвч хүчтэний дэргэд хүчгүй нь буруутан болоод өнгөрчээ. Урьд нь 1913 оны 11 сарын 5-нд Орос, Хятад хоёр хуйвалдаж Гадаад Монголын газар нутаг Хятадын нутаг дэвсгэрийн нэг хэсэг мөн болохыг Орос улс хүлээн зөвшөөрнө хэмээн тохиролцож Монголыг ДИУ-д найрсгаар бэлэглэсэнээ 10 жил 2 сар, 26 хоногийн дараа ийнхүү дахин давтсан юм. Хоёр хөрш маань яагаад Богд хаантныг сэрүүн тунгалаг байхад ийм шийдвэр гаргаагүй нь “үхсэн буурны толгойноос амьд ат айна” гэгчээр эмээж байсных юм. Тодруулбал, 1890-ээд оноос эхлэн Монголын тусгаар тогтнолын төлөө тууштай тэмцэж, 1911 оноос Монгол улсын эзэн хаан суусан Богдоос эмээж байсан хэрэг юм.

Богд хаан 1924 онд төрөл арилжмагц мөн оны 6 сарын 3, 7-нд МАН-ын Төв Хороо 2 удаа хуралдаж бүгд найрамдах засаглалд шилжихээр шийдвэрлэсэн юм. Ийнхүү Монгол улс хэмжээт эрхт хаант засаглалаас Бүгд найрамдах засаглалд шилжих шийдвэр гаргаж большевикуудын даалгаврыг биелүүлэв.

Монголын төр дэлхий дахины жишгийг дагаж Үндсэн хуультай болох бэлтгэл ажлыг 1921 оны зунаас эхлүүлж, Ерөнхий сайд Д.Бодоо, эрдэмтэн Ж.Цэвээн нар тус бүр нэг төсөл боловсруулсан байв. Гэвч 1922 оны эхээр Д.Бодоог улс төрийн хэрэгт буруутган огцруулсан тул түүний боловсруулсан төсөл хэрэггүй болсон юм. Үүний дараа 1922 оны 5 сарын 19-нд Шүүх яамны сайд Н.Магсаржав, эрдэмтэн Ж.Цэвээн, түшмэл Ч.Бат-Очир нарын бүрэлдэхүүнтэй комисс байгуулж “Англи мэт улсын хуулиас товчлон авч эдүгээгийн явуулан буй засгийн байдалд нийлүүлэн” Үндсэн хуулийн төсөл боловсруулахыг даалгав. Тус комисс Засгийн газрын тогтоолын дагуу Английн Магна харта буюу Эрх чөлөөний их харта, АНУ, Японы Үндсэн хуулийг бүтнээр нь, Норвегийн Үндсэн хуулиас хурлуудын тухай заалтуудыг орчуулж төсөл бэлтгэж байв.

### Тодруулга

“Жинхэнэ ардын гол зорилго нь “хөрөнгөтний байдлыг үндсээр устгаж, нийгэм журамт ба эв хамтын ёс журмыг эрмэлзэн хөгжүүлэхэд оршино” гэж заав.

*БНМАУ-ын анхдугаар  
Үндсэн хуулиас*

### Тодруулга

Аливаа улс орны бүрэн эрхт байдлын илэрхийлэл бол Үндсэн хууль байдаг. Манай өмнөд хөрш ДИУ 1912, 1914 онд, ЗЗОУ 1918 онд, Алс Дорнодын Бүгд найрамдах улс 1921 оны хавар тус бүрдээ Үндсэн хуулиа баталсан байлаа.

### Тодруулга

“Монгол улсыг үүнээс хойш Бүгд найрамдах бүрэн эрхтэй ард улс гэж, улсын дээд эрхийг жинхэнэ ардад эзлүүлэн улсын аливаа хэргийг УИХ ба мөн хурлаар сонгогдсон Засгийн газраас гүйцэтгэн шийтгүүлэх явдлыг нийтээр сүслэн дагавал зохино”

*БНМАУ-ын анхны  
Үндсэн хуулиас*

### Тодруулга

Улс төрийн эрхээ хасуулсан хүмүүс:

- бусдыг хөлслөн аж ахуй эрхлэгчид
- урьдын хаад ноёд, хутагт хувилгаад
- хүрээ хийдэд байнга сууж хурал ном хурдаг лам нар



Зураг 3.4. 1924 оны  
Үндсэн хууль

Гэтэл большевикууд 1924 оны хавар хуульч Всесвятскийг Монголд ирүүлж Үндсэн хуулийн комиссыг шинэчилж ЗОУ-ын 1918 оны Үндсэн хуулийг монголоор орчуулж түүний олон заалтыг бараг хэвээр нь хуулбарлаж шинэ төсөл боловсруулжээ. Уул төслийг 1924 оны 11 сарын 25-26-нд Улсын анхдугаар их хурлаар хэлэлцээд БНМАУ-ын Үндсэн хууль хэмээн батлав.

Монгол улс гэдэг нэрийг БНМАУ хэмээн шинэчлэв. Мөн улсын нийслэлийг Улаанбаатар гэж нэрлэжээ. Үндсэн хуулиар Монгол улсын төрийн байгууллын тогтолцоог хуульчлан батлав. Монгол улсад ард түмэн өөрсдөө төрийн эрх барих тогтолцоо бий болгов хэмээн тунхаглав. Үндсэн хуульд төрийн байгууламжаас гадна олон асуудлыг хуульчилсан юм. Тухайлбал, иргэдийн эрх, эрх чөлөөтэй холбоотой заалтыг оруулжээ. Мөн хувийн өмчийг хязгаарлаж, хөрөнгөжиж баяжихыг хориглов. Мөн жинхэнэ ардын эрх чөлөө, үйл ажиллагааг дээдлэх ёстой хэмээн зарим хүмүүсийн улс төрийн эрхийг хассан юм.

Үндсэн хуулиар төрийн байгууламжийг тогтоож, улсын дээд эрхийг УИХ барина. УИХ-ын чөлөөт цагт УБХ төрийн хэргийг эрхэлж, УБХ нь Засгийн газрын бүрэлдэхүүнийг томилж байх болов. Улсын анхдугаар их хурлаас Улсын Бага хурлын Тэргүүлэгчдийн даргаар П.Гэндэнг сонгожээ. УБХ-ын гишүүнээр 30 хүн сонгосны дотор Э.Ринчино, М.Амагаев зэрэг ЗХУ-ын харьяат хоёр хүн байв. Их хурал Үндсэн хууль баталсны ач холбогдлыг “бидний монгол язгууртанд хэдэн зуун оноос янагш үзэгдсэнгүй гайхамшигт хэрэг боллоо” гэж дүгнэжээ.

Монгол улс анхны үндсэн хуулиа баталснаас 15 жилийн дараа хоёр дахь үндсэн хуулиа батласан юм. Уг хуулийн төслийг ЗХУ-ын удирдагчид уншиж танилцаад засч сайжруулах 21 санал өгснийг бүрэн тусган 1940 оны 6 сарын 30-нд баталж “Чойбалсангийн үндсэн хууль” гэж нэрлэсэн юм.

1940 оны Үндсэн хуульд хууль тогтоох, гүйцэтгэх засаглалын эрх үүргийг 1924 оны Үндсэн хуульд зааснаас илүү тодорхой болгож, шүүх засаглалын тухай нэмж зааж өгчээ.

Сонгох, сонгогдох эрхийн тухай үндсэндээ ижил боловч 1924 оны үндсэн хуульд сонгуулийн эрхгүй хүмүүсийн тухай заасныг улам чангатгав. Тухайлбал 1921 оноос өмнө хамжлагатай байсан тайж нар, бөө удган, цагаантны цэрэгт явж байсан хувьсгалын эсэргүү бослогод оролцогсдын эрхийг хасчээ. 1944 оны 9 сард БНМАУ-ын Үндсэн хуульд өөрчлөлт оруулж, сонгуулийн насны бүх хүнд сонгох, сонгогдох эрх олгов.

1960 оны үндсэн хуульд “... төр нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон МАХН мөн” гэсэн заалт оруулжээ.



Зураг 3.5. Төрийн сүлд, далбаа  
1960 он



Зураг 3.6. Төрийн сүлд, далбаа  
1992 он



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Дараах асуултын дагуу ярилцаж эх сурвалж, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй.
  - а) ЗСБНХУ, ДИУ хоёр Монгол улсын хувь заяаг хэрхэн шийдвэрлэж байв?
  - б) Богд хааны нэр хүнд, байр суурийн талаар хэрхэн дүгнэж болох вэ?
2. Монгол улс хэмжээт эрхт хаант засаглалаас бүгд найрамдах засаглалд шилжсэний эерэг болон сөрөг талыг тодорхойлоорой.
3. Монголчууд Үндсэн хуулийн төслөө боловсруулах комиссыг ажиллуулсаар байтал Всесвятскийн төслөөр батлуулсныг хэрхэн тайлбарлаж болох вэ?
4. Үндсэн хууль яагаад өөрчлөгддөг, Үндсэн хууль яагаад чухал болох талаар санал бодлоо солилцоорой.
5. Монгол улсын төрийн хэргийг эрхэлж байсан УБХ-д яагаад ЗХУ-ын харьяат орос хүмүүсийн төлөөллийг сонгосон бэ?
6. 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудын адил төсөөтэй ба ялгаатай зүйлсийг тодорхойлоорой.



Тодруулга

“... хуучин түшмэд ба лам нарын . . . этгээдүүдэд хөдөлмөрчин ардын нэгэн адил улс төрийн эрхийг олговоос инээдэмтэй бөгөөд тэнэг хэрэг болмой”

Улсын VIII их хурал дээр Х.Чойбалсангийн хэлсэн үгээс

Монгол улсад бүгд найрамдах засаглал тогтож улсын нэрийг өөрчилсөн нь шинэ улс байгуулсан буюу улс тунхагласан явдал огт бус. Харин улсын нэрийг өөрчилж, хаант засаглалыг халж бүгд найрамдах засаглалд шилжсэнийг тус хуулиар баталгаажуулжээ. Монгол улс түүхэндээ анх удаа Үндсэн хуультай болсон нь тэмдэглүүштэй чухал зүйл билээ. Гэвч тус хууль ард түмнээ жинхэнэ ба жинхэнэ бус буюу итгэж болох, үл болох хэмээн хоёр хувааж МАН-ын III их хурлын шийдвэрийг хуульчлан баталгаажуулав. Монголчууд үүнд дүргүйцэж байсан боловч цаашдаа байдал хэрхэн өөрчлөгдөхийг азнан хүлээж байлаа. Гэвч олны сэтгэлд нийцэхүйц ахиц гаргаагүйгээр үл барам Үндсэн хуулиар зөвшөөрсөн өргөн олны шүтэх бишрэх эрхийг шууд хязгаарлаж, өмч хөрөнгийг нь хүчээр хураасны уршгаар 1929-1932 онд ардын бослого дэгдсэн юм.

МОНГОЛ УЛС БҮГД НАЙРАМДАХ ЗАСАГЛАЛД ШИЛЖСЭН НЬ

ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Бүгд найрамдах засаглал
- Үндсэн хууль
- Жинхэнэ ард

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Монгол улсад хэмжээт эрхт хаант засаглалаас бүгд найрамдах засаглалд шилжих үйл явц хэрхэн явагдав?	4. Монгол улсын тусгаар тогтнол болон цаашдын хувь заяаны асуудалд яагаад хоёр хөрш улс нөлөөлөв?	6. “Үхсэн буурны толгойноос амьд ат айна” хэлцийн утгыг тайлбарлаж бичээрэй.
2. Бүгд найрамдах засаглалд шилжсэний ач холбогдол юунд орших вэ?	5. Монголчууд яагаад өөрсдийнхөө хувь заяаг шийдвэрлэж чадахгүй байв. Үүнд юу нөлөөлөв?	7. Тухайн үеийн түүхэн хүмүүсийн талаар сурвалжлан мэдээлэл цуглуулж танилцуулга бэлтгээрэй.
3. Төрийн сүлд, далбаануудыг ажиглаад ялгааг олж тайлбарлаарай.		

ТОЛЬ

Жинхэнэ ард Угсаа сурвалжгүй, хөрөнгө чинээгүй эгэл хүнийг 1924-1944 онд ингэж нэрлэж байв.  
 МАХН 1925 оны 3 сараас МАН-ыг ийнхүү нэрлэх болсон.  
 УБХ Монгол улсын хууль тогтоох дээд байгууллага (1924-1951)  
 УИХ 1951 оноос хойших Монгол улсын хууль тогтоох дээд байгууллага  
 МАХН-ын ТХ Монгол Ардын Хувьсгалт Намын Төв хороо  
 БНМАУ Бүгд Найрамдах Монгол Ард улс (1924-1992 онд Монгол улсыг ийнхүү нэрлэж байв).

3

**БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО**

**СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ**

Түүхэн чухал үеүдэд улс орныг удирдах хэрэгт алдаа, оноо гарч байсан түүхэн үнэнийг таньж судлах нь ирээдүйд сургамжтай.

**ГОЛ САНАА**

1921-1928 онд Монголын төр үндэсний уламжлалд тулгуурласан өвөрмөц эдийн засгийн бодлого хэрэгжүүлсэн. Харин 1928-1932 онд ЗХУ, Коминтерний зааварт хэт дулдуйдсан, ард олны сэтгэлд үл нийцсэн бодлогод шилжив.

**ТҮЛХҮҮР ҮГ**

- Баруунтан
- Зүүнтэн
- Өмчийн хэлбэр
- Баяжигтун
- Нармай монгол



Ерөнхий сайд  
Б.Цэрэндорж



Засгийн газрын  
жинхэнэ орлогч  
А.Амар



МАХН-ын  
ТХ-ны дарга  
Ц.Дамбадорж



МАХН-ын ТХ-  
ны дэд дарга  
Н.Жадамба



Судар бичгийн  
хүрээлэнгийн  
эрдэмтэн нарийн  
бичгийн дарга  
Ж.Цэвээн


Зураг 3.7. БНМАУ-ын 1921-1928 оны нам төрийн удирдагчид



**АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ**

МАН-ын эцсийн зорилго бол эв хамтын ёс мөн бөгөөд капитал, хөрөнгөтний шатыг алгасан энэ зорилгод хүрэх ёстой. Энэ зорилгодоо хүрэхийн тулд нам төр, зөвхөн ядуу доод ангийг буюу дунд хоосон, үгээгүй, угсаа сурвалжгүй хүмүүст түшиглэж хувийн хөрөнгийг хязгаарлан баян чинээлэг ард иргэдийг хяхан хавчих шаардлагатай.

МАН-ын III их хурлын шийдвэрээс



1. Нэр бүхий түүхэн зүтгэлтнүүдийн талаар юу мэдэх вэ? Тэд Монгол улсын түүхэнд ямар үүрэг гүйцэтгэснийг хэлэлцээрэй.
2. 1921-1924 оны үеийн Монгол улсын байдлыг төсөөлөн эргэцүүлээрэй. Байгуулагдсан хамтрал, коммуны тоо өсөхөд мал сүргийн тоо хэрхэн өөрчлөгдсөнийг харьцуулан дүгнэлт хийгээрэй.
3. МАН-ын III их хурлын шийдвэрээс юу мэдэв? Энэ шийдвэр улс орны цаашдын хөгжилд хэрхэн нөлөөлсөн бэ?

Большевикууд Б.Цэрэндорж, А.Амар, Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ж.Цэвээн зэрэг Монголын удирдагчдыг 1925 оны орчмоос баруунтан гэж нэрлэсэн юм. Тэднийг улс орныг удирдаж байх үед монголын төр өмчийн бүх хэвшлийн үйл ажиллагааг зөвшөөрч байсан нь тухайн цаг үеийн бодит байдлыг харгалзсны илрэл юм.

Гэвч үүнийг өөрчилсөн шалтгаан нь МАН-ын III их хурал, Улсын I их хурлуудын шийдвэрт хөрөнгө чинээтэй баячуудыг жинхэнэ бус ард, итгэлгүй хүмүүс хэмээн ангичлан ялгаварласан явдалд оршино. Энэ нь “жинхэнэ ард буюу угсаа сурвалжгүй ядуус байх ёстой” хэмээсэн заалтыг ажил хэрэг болгохын эхлэл байлаа.

### Тодруулга

Баруунтныг буруутгасан зүйл нь:

- 1 ЗХУ-ыг эсэргүүцдэг;
- 2 Хуучны язгууртан баячуудыг дэмжиж хөрөнгөтний эрх ашгийг хамгаалдаг;
- 3 Шашныг ариунаар мандуулах эрмэлзэлтэй;
- 4 Капиталист орнуудтай харилцаа тогтоохыг хичээдэг;
- 5 Нармай монгол үзэлтэй;

МАН-ын II, III их хурал, Улсын I их хурлын шийдвэрт большевикуудын тулгасан шаардлагыг нилээд тодорхой тусгасан боловч баруунтнууд буюу улсаа хөгжүүлбэ хэмээсэн зөв бодлоготнууд үзэл бодлоосоо төдий л ухраагүй юм. Большевикууд үүнийг таслан зогсоохын тулд 1928 оны намар Коминтерноос Б.Шмераль тэргүүтэй тусгай комиссыг Улаанбаатарт ирүүлж МАХН-ын ТХ-ны III бүгд хурал, МАХН-ын VII их хурлыг дараалан хуралдуулж, нам төрийн удирдлагуудыг өөрчлөв. Тэд баян чинээлэг, язгуур угсаатай бүх хүний хөрөнгийг хураах шийдвэр гаргасан юм. Б.Цэрэндоржийг Ерөнхий сайдын албан тушаалаас огцруулахаар бэлтгэж байх үед тэрбээр нас баржээ. Үүний дараа 1928 оны эцсээр

Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ж.Цэвээн нарыг төр засгийн удирдлагаас зайлуулж, 1930 он хүртэл А. Амарыг уул албанд нь түр үлдээсэн юм. 1927 оноос эхлэн Ж.Гэлэгсэнгэ, С.Довчин, Н.Хаянхярваа, С.Буяннэмэх, Б.Буянчуулган нарыг баруунтны жагсаалтад хамруулав.



Зураг 3.8. МАХН-ын VII их хурлын дараа зүүнтний удирдагчид төрийн эрхэнд гараад буй нь

Зөвлөлтийн заавраар Монголын чадварлаг удирдагчдыг албан тушаалаас нь өөрчилж, тухайн үед ЗХУ-д сургууль төгссөн, Коминтерний заавар, зөвлөгөөг хэт шүтэгч З.Шижээ, Ө.Бадрах, Л.Лааган, Цэндсүрэн зэрэг хүмүүсийг өндөр албан тушаалд томилсон юм. Тэд улс орондоо хар буруу санаагүй боловч удирдан зохион байгуулах чадвар мөхсийн уршгаар Зөвлөлтийнхний хэлсэн үг бүрийг туйлын үнэн хэмээн үнэмшиж,

Тодруулга

1930-аад оны үед малын үнэ дундажаар нэг тэмээ 50 төгрөг, адуу, үхэр тус бүр 30 төгрөг, хонь 6 төгрөг, ямааны үнэ тодорхой бус байв.

тэдний заавар зөвлөгөөг үг дуугүй даган биелүүлж байв. Тэд “Монголд нийгэм журам байгуулна. Үүний тулд хуучны ноёд, угсаа сурвалжтай, баян чинээлэг хүний мал хөрөнгийг хурааж хамтын аж ахуй байгуулна” хэмээн итгэж, 1929-1932 оны зун хүртэл улс орныг ихээхэн үймүүлсэн юм. Тэднийг зүүнтэн гэж тухайн үед нэрлэсэн нь түүхэнд үлджээ.

Хүснэгт 3.2.

Зүүнтнүүдийн хэрэгжүүлсэн эдийн засгийн бодлого, түүний үр дагавар

Гол чиглэл	Үйл ажиллагаа	Үр дүн
Мал сүрэг	Тэд ард түмний хэдэн үеэрээ уламжлан өсгөж үржүүлсэн мал сүргийг хурааж хамтрал, нөхөрлөл, коммуна, артель, нэгдэл хэмээх дундын өмчтэй хоршоолол хэдэн зууг байгуулжээ.	Хамтралжуулснаар хамралд ажиллаж хөлс авах хүмүүсийн сонирхол нэмэгдсэн, газар тариалангийн ажил эхэлсэн зэрэг давуу тал байсан боловч өмч эзэнгүйдэж, мал сүрэг эрс хорогдсон юм.
Өмч хөрөнгө	Намын VII их хурлын шийдвэрийн дагуу 1929 оны 9 сард феодалын хөрөнгө хураах төв комиссыг Х.Чойбалсангаар удирдуулан байгуулав. 1929 оны намраас эхлэн 1932 оны 4 сар хүртэл хоёр үе шаттайгаар 1300-аад язгууртан, лам нараас 10 сая гаруй төгрөгийн хөрөнгө хурааж 1,7 сая төгрөгийн үнэ бүхий зүйлийг ядуучуудад өгчээ. Хураасан малын олонхийг хамтрал, нөхөрлөлд, үлдсэнийг нь ядуучуудад өгчээ.	Лам нар, хутагт хувилгаад, урьдын түшмэдээс хураасан малын олонх нь үрэн таран алга болов. Иргэдийн хувийн өмчид ноцтойгоор халдаж, хүний эрхийг зөрчсөнөөр олон түмний дургүйцлийг хүргэжээ.
Худалдаа	Төрөөс худалдааны салбарт тавих хяналтыг хүчтэй болгох нэрийдлээр дөнгөж үүсч байсан хувийн худалдаачдыг хавчих, түүнчлэн гадаадын капиталыг ухаалгаар ашиглахын оронд харин тэдэн рүү шууд довтолсон.	1928 оны эцэс болоход Монголд ажиллаж байсан хятад худалдаачдын 80 хүртэл хувь нь нутагтаа буцжээ. Эдгээр нь улс орны эдийн засагт сөрөг нөлөө үзүүлсэн юм.
Шүтлэг, бишрэл	Үндсэн хуулиар ард иргэдэд олгосон шүтэх, бишрэх эрх чөлөөг хаан боогдуулж, шашныг устгах замд оруулжээ. Шашныг устгахын тулд ухуулга хийхээс гадна эдийн засгийн арга хэрэглэжээ. Тухайлбал, 1929 оноос эхлэн сүм хийдийн хөрөнгө, барилга, жасын бүх хөрөнгөд ногдуулдаг татварыг өсгөн нэмэгдүүлсэн бөгөөд жасын малыг баян чинээлэг аж ахуйтнаар маллуулахыг хориглож, зөвхөн ядуу дунд аж ахуйтан, хамтралд өгч маллуулах жасын кампани гэгчийг хэрэгжүүлсэн.	Жасын кампани зохион байгуулснаар жасын мал 1928 онд 3 сая 460000 байсан бол 1932 онд 392300 болтлоо цөөрчээ.

### Тодруулга

“... ийм бүдүүлэг оронд үзүүлэх манай болон ЗХУ, олон улсын хувьсгалт хөдөлгөөний нөлөөллөөс үүдэн практик туршлага хийж болох бололцоо бүхий өвөрмөц орон, энэ нь юуны өмнө коммунист үзэл бодлын үүднээс бидэнд хэрэгтэй юм. ... ЗХУ-ын талаас томоохон стратегийн ач холбогдолтой юм. Монгол нь бидний хувьд түүхий эдийн талаар томоохон ач холбогдолтой юм.....” гэжээ.

*Коминтерний төлөөлөгч Б.Шмераль 1928, 1934 онуудад Монголд ирж, зүүнтнүүдийн болчимгүй үйл хэргийн талаар илтгэж хэлсэн үгээс*



Зураг 3.9. Хөрөнгө хураалт. 1929 он

Үндсэн хуулиар олгосон шүтэх, бишрэх эрхээ эдлэх боломжгүй болж, өмч хөрөнгөө хураалгасан иргэд нам, төрийн буруу бодлогод дургүйцэж байв. Мөн большевикууд монголын дотоод хэрэгт хэтэрхий хутгалдан оролцож, монголд социализм байгуулж болох эсэхийг туршиж буйг эсэргүүцэж байв. Энэ бүхэн нь 1932 онд ард олны бослого гарахад нөлөөлсөн юм. Бослогод лам нар сүсэгтэн олноос гадна төр засагт өмч хөрөнгөө хураалгасан баян чинээлэг ардууд, хуучны түшмэд тайж нар, төрийн зарим албан хаагчид, сургуулийн зарим багш нар, Улсын бага хурал ба нам, эвлэлийн зарим гишүүд оролцжээ.

### АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

1. Удирдагчдын үзэл бодлын зөрүүтэй байдлыг тухайн үеийн нөхцөл байдалтай уялдуулан хэлэлцээрэй.
2. Монголын удирдагчдыг бодлогоо хэрэгжүүлэхэд нь ЗХУ, Коминтерний зүгээс улайран саад болж байсны цаад учир юунд орших вэ? Коминтерн заавал Монгол улсыг сонгож, социализм байгуулах туршилт явуулах болсныг хэрхэн тайлбарлах вэ?
3. 1921-1924 онд Монголын удирдагчдын идэвхтэй явуулж байсан бодлого өнөө хүртэл тасалдахгүй үргэлжилсэн бол.....эргэцүүлээрэй.
4. Тухайн үеийн нам, засгийн удирдагчдын буруу бодлогын уршиг юунд хүргэснийг эргэцүүлэн ярилцаарай.



1921-1928 онд төрийн эрх барьж байсан Б.Цэрэндорж, А.Амар, Ц.Дамбадорж, Н.Жадамба, Ж.Цэвээн нар бол Д.Бодоо, С.Данзан нартай сэтгэл, гар нийлсэн алба хашиж, үзэл баримтлалыг нь зөв хэмээн ухаарсан залгамжлагч нь байлаа. Тэд улс орныхоо нийгэм, эдийн засаг, соёлыг хөгжүүлэхдээ үндэсний уламжлалаасаа аль дэвшилттэйг нь тухайн үеийн дэлхий дахины дэвшилтэй зөв хослуулахыг хичээж байв. Баруунтнууд хэмээн нэрлэгдэж байсан эдгээр хүмүүс өмчийн бүх хэлбэрийг дэмжиж, ард иргэдээ хөрөнгөлөг, баян чинээлэг болохыг дэмжиж байсан юм. Тэдний явуулж байсан бодлого 1921-1924 онд идэвхтэй хэрэгжсэн боловч 1924-1928 онд энэ бодлогыг ЗХУ, Коминтерний нөлөөгөөр өөрчилсөн юм.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГО

Үе бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Баруунтан
- Зүүнтэн
- Өмчийн хэлбэр
- Баяжигтун
- Нармай монгол

<i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i>	<i>Гол санаагаа ойлгов уу?</i>	<i>Бүтээлчээр сэтгээрэй.</i>
<p>1. 1921-1924 онд Монголын удирдагчид БНМАУ-ын эдийн засгийг хөгжүүлэх талаар ямар үйл ажиллагааг явуулж байсныг жагсаан бичээрэй. Эдгээр нь 1928-1932 онд явуулж байсан “зүүнтний” бодлогоос ямар ялгаатай байгааг танилцуулаарай.</p> <p>2. “Нармай монгол үзэл”-ийн талаар өөрийнхөө ойлгосноор тайлбарлаарай</p>	<p>3. Тухайн үед дэлхий дахины дэвшилтэй зөв хослуулан нийгэм, эдийн засаг, соёлоо хөгжүүлэх манай үндэсний уламжлалт зүйл юу байж болох вэ?</p> <p>4. Хөрөнгө хураасан үйл явцыг төсөөлнө үү.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Энэ үед хүмүүсийн санаа сэтгэл ямар байсан бол...</li> <li>• Хүмүүсийн хөрөнгийг яагаад хураах болов...</li> </ul>	<p>5. Тухайн үеийн түүхт хүмүүсийн талаар баримт мэдээлэл цуглуулж тэднээр хэрхэн бахархаж буйгаа харуулсан бүтээл хийгээрэй.</p>

## ТОЛЬ

Баруунтан	Монголын онцлог байдлыг тууштай баримтлагчид
Зүүнтэн	Большевикуудын заавар зөвлөгөөнийг шүтэн дээдлэгчид
Нармай монгол	Бүх монгол үндэстнийг нэгтгэх үзэл
Өмчийн хэлбэр	Төрийн буюу улсын, хувийн, хамтын буюу дундын өмч, нийгмийн өмч

4

**БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ  
БОДЛОГОД ӨӨРЧЛӨЛТ ГАРСАН НЬ**

**СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ**

*Улс орныг удирдах хэрэгт алдаа, оноо гарч байсан түүхэн үнэнийг судлах нь ирээдүйд сургамжтай.*

**ГОЛ САНАА**

*1928 онд үндэсний уламжлалынхаа аль дэвшилттэйг дэлхийн жишигтэй хослуулан улс орноо хөгжүүлэх бодлого хэрэгжиж байв. Гэвч 1929 оноос большевикуудын тулгалтаар Монгол Улсад нийгэм журам байгуулах туршилт хийгдсэн юм. Энэ үед ЗХУ-ын нөлөө давамгайлж байв.*

**ТҮЛХҮҮР ҮГ**

- Шинэ эргэлтийн бодлого
- Социализмын материал техникийн бааз
- Атрын аян
- Аж үйлдвэр, дэд бүтэц



**АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ**

Дорнод аймгийн Жаргалан сумын харьяат Юндэнсамбуугийн Гонгор гэгч хохь тайж, гамин, бароныг хөөх хэрэгт оролцсон төдийгүй цаашид цэрэгт долоон жил алба хаагаад халагдаж, нутагтаа ирж сумын галч хийж байтал феодал гаралтай хэмээн сонгуулийн эрхийг нь хасч ажлаас нь хөөжээ. Цэрэгт шагнуулсан буугаараа зээр гөрөөс агнан амьдралаа залгуултал бууг нь хурааж аваад нүүхийг хориглон нэгэн аманд нутаг заажээ. Үүгээр барахгүй хоёр морийг нь өртөөнд хэрэглэжээ. Нэг морио цахиур буугаар солин тарвагачилтал “феодал ан авлах эрхгүй” гээд бууг нь хураажээ. Гэдэс тэжээхийн эрхэнд хамтралын хонины ноос хяргалцъя гэтэл “ардад 10 мөнгөний, тайжид 3 мөнгөний хөлс өгнө” гэжээ. Тэрийг нь зөвшөөрөөд ажиллалал “феодалд хяргуулах бузар хонь байхгүй” гээд дээрээс болиулсан байна. Гонгорт феодалын татвар хэмээн 60 төгрөг ногдуулав. Татвараа хугацаанд нь төлөхгүй бол шоронд хийх гээд байсан тул ганц шараа маханд өгтөл “ардынхыг 70-аар авна, тайжийнхыг 50-аар авна” гэсэн тул 10 төгрөгт нь үлдсэн ганц морио өгчээ. Зээр агнах компани тус суманд өрнөхөд анд явалцаад шанд нь зээрийн мах авъя гэж гуйхад “тайж феодалд алуулах бузар зээр манай оронд байхгүй” гэсэн ангич үг сонсов.

*Шинэ эргэлтийн бодлогын үед “Үнэн” сонинд нийтлэгдсэн эх сурвалж*

Элдэв-Очирын эхнэр Туваансүрэнг эвлэлээс хөөж, нөхөр Элдэв-Очирыг түүнээс салахыг шаардсан. Гэтэл Элдэв-Очир эхнэрээ өмөөрч... намайг эхнэрээс салахыг шаардах эрх та нарт байхгүй гэж хэгжүүрхсэн. ....Сургуульд хүүхдийг авахдаа ангийн шугамыг баримтлахгүй байна. Тухайлбал, С.Данзангийн охиныг сургуульд авчээ.

*МХЗЭ-ийн VIII их  
хурал дээр төлөөлөгч  
Батнягтын  
шүүмжилсэн нь*

1. 1930-аад оны үеийн Монгол улсын байдлыг төсөөлж, дээрх эх сурвалжуудыг уншаад төрсөн сэтгэгдлээ хуваалцаарай.
2. Өмнөх сэдвүүдээр судалсан нам төрийн удирдагчдын гаргасан шийдвэрийг санаж зүүнтний алдаатай бодлогын хор уршгийн талаар ярилцаарай. Хэрэв ийм байдал удаан үргэлжилсэн бол юунд хүргэж болох вэ?
3. Монгол улсад бий болсон нөхцөл байдлыг хэрхэн өөрчилсөн бол, зүүнтний уршгаар бий болсон хүнд хямралыг даван туулахын тулд юу хийсэн бол, социализмын үед эдийн засаг хэрхэн хөгжиж байсан бол гэдэг талаар таамаглан ярилцаарай.

## ШИНЭ ЭРГЭЛТИЙН БОДЛОГО

Зүүнтний учруулсан хор уршгийг арилгахын тулд 1932 оны зунаас эхлэн баруунтны бодлогыг сэргээж хэрэгжүүлсэн юм. Үүнийг түүхэнд шинэ эргэлтийн бодлого (ШЭБ) гэж нэрлэжээ. ШЭБ-ын эхэн үед большевикууд Монголын дотоод хэрэгт шууд оролцохоо хэсэг зуур азнаж, хөндлөнгөөс хянан ажиглаж байлаа.

Монголын төр энэ завшааныг ашиглаж мал сүргийнхээ тоог өсгөхийн тулд зээл, албан татварын оновчтой бодлого хэрэгжүүлсний үрээр 1932-1945 онд мал сүрэг 16,2 саяас 27,5 сая хүрсэн нь 1992 он хүртэл давтагдаагүй юм.

Зөвлөлтийн удирдагчид Монголд буруу бодлого тулган хэрэгжүүлснээ ухаарч 1932 оны зунаас эхлэн ШЭБ хэрэгжүүлсэн юм. Энэхүү ШЭБ бол цоо шинэ зүйл огт бус. 1921-1928 онд баруунтны боловсруулсан бодлого байлаа.

ШЭБ-ын үр дүнд :

- Нам, төрөөс шуурхай арга хэмжээ авсны үр дүнд зэвсэгт бослого зогсов.
- Нам, төрийн үүрэг, заагийг тогтоож төр, засаг харьцангуй бие даасан байдалтай болжээ.
- Монголын төр ард түмний шүтэх, бишрэх эрх чөлөөг сэргээж, лам нарыг албадан хар болгохоо зогсоосноор 1932-1934 онд 2700 гаруй лам хүрээ хийддээ дахин шавилжээ.
- Албадан байгуулсан хамтрал, артель, коммуны талаар 1932 оны 8 сард Засгийн газрын тогтоол гарснаар, зүүнтний үед байгуулсан 800 гаруй хамтын аж ахуй бараг цөм таржээ. Харин хамтралын гишүүд хүч хөдөлмөрөө нэгтгэн хамтын үйлдвэрлэл эрхлэх нөхөрлөл, нэгдэл байгуулахыг зөвшөөрчээ.
- Мал сүргийг өсгөх уян хатан бодлогын үр дүнд ганцхан жилийн дотор малын тоо 3,3 саяар өсчээ.
- Хувийн худалдааг дэмжсэнээр тэдний тоо түргэн өсч хөдөөгийн хүн ардыг өргөн хэрэгцээт бараагаар хангах болжээ.

### Тодруулга

... Намын Төв Хороо ба орон нутгийн намын байгуулалтууд нь үнэн хэрэг дээрээ элдэв зүйлийг таслан шийдвэрлэж, тус орны нийт байдлыг удирдаж байсан байна. Ийм бодлогыг явуулсны улмаас ард түмэн нь засаг хэмээн мэдэхгүй болж, улсын засаг нь ард түмний өмнө гутсан ба нэр хүндгүй болсон байна.

*МАХН-ын Төв Хорооны онц III бүгд хурлын тогтоолоос, 1932 он*

**Тодруулга**

1. Өвс хадлан бэлтгэх
2. Жасын ба хувийн мал хариулах
3. Жин тээх
4. Малын хашаа саравч барих
5. Ан агнах
6. Тариалан эрхлэхийг зөвшөөрөх

*Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрмээс*

**УААА, соёлыг хөгжүүлэх таван жилийн төлөвлөгөө:**

1.	1948-1952 он	I 5 жил
2.	1952-1957 он	II 5 жил
3.	1958-1960 он	3 жил
4.	1961-1965 он	III 5 жил
5.	1966-1970 он	IV 5 жил
6.	1971-1975 он	V 5 жил
7.	1976-1980 он	VI 5 жил
8.	1981-1985 он	VII 5 жил
9.	1986-1990 он	VIII 5 жил



*Зураг 3.10. Нэгдэлжих хөдөлгөөн*

сэр байгуулагдсаар 1950-аад оны дунд үе хүртэл нэлээд олширчээ. Гэвч АҮН-ийн мал төдийлөн өсөхгүй байв. Үүнийг төр засаг үл хайхран 1958-1959 онд малын 90 гаруй хувийг нэгдэлд хамруулсан нь мал хорогдох нэг шалтгаан болсон юм.

ШЭБ-ын үед буюу 1932-1940 онд хувийн худалдаа, үйлдвэр эрхлэгчдийг төр засаг тууштай дэмжиж байсны үрээр тэднээс хураах татвар хураамжийн хэмжээ багассан ба банкнаас зээл авах эрх олгов. Тэд зарж борлуулах зүйлээ хоршооноос бөөний үнээр авах, цуглуулсан түүхий эдээ хоршоонд тушаах эрхтэй байв. Гэвч тэднийг 1959 онд үйлдвэрийн хоршоололд албадан элсүүлсэн байна.

**НЭГДЭЛЖИХ ХӨДӨЛГӨӨН**

ШЭБ хэрэгжиж байх үед Герман ЗХУ-д довтолсны дараа манай ЗХУ-аас импортолдог хүнсний зүйл, гурил будааны хэмжээ багасч махны хэрэглээ эрс өсөв. Мөн 1941 оноос ноос дараа нь мал, мах, өөхөн тос, сүү улсад албан журмаар бэлтгэх болов. Тэгэхдээ иргэд эдгээр бэлтгэлийн зүйлийг бэлэн байгаа малынхаа тоонд бус урьд жил нь тоолуулсан малын тоогоор бодож төлөх ёстой байлаа. Хэрэв бэлтгэлийн зүйлийг заасан хугацаанд эс нийлүүлбэл хуулийн хариуцлага хүлээлгэж байв. Энэ нь зуданд малаа хорогдуулсан олон айл өрхийн тэргүүн шоронд орох болзошгүй байсан тул малчид мал сүргээ хямд үнээр зарж борлуулах бусдад бэлэглэх нь нэмэгдсэн байна. Үүний улмаас малын тоо хорогдох болжээ.

Мөн түүнчлэн 1958-1959 онд малчдыг эдийн засгийн албадлагаар нэгдэлжүүлэх болсон нь мал хорогдоход нөлөөлжээ. Жишээлбэл, нэгдэлжүүлсний дараа 1959-1961 онд улсын бүх мал 23,8 саяас 20,3 сая болж 14,8% цөөрч 1989 он дуустал малын өсөлт тогтворгүй байв. Харин 1992 онд мал хувьчилснаас хойш бараг жил дараалан өссөөр 2014 оны эцэст 51 сая толгойд хүрэв. 2018 онд 66.5 сая болов.

Зүүнтний үед хүчээр хамтралжуулсны уршгаар малын тоо ихээр хорогдсныг ШЭБ-ыг боловсруулагчид соргогоор мэдэрч мал сүргийг дундын өмч болгохоос татгалзсан юм. Тиймээс 1932 оны 10 сард батлагдсан “Ардын үйлдвэрлэлийн нэгдлийн дүрэм”-д нэгдлүүд өөрийн малтай байхыг зөвшөөрөөгүй, зөвхөн 6 төрлийн ажил эрхлэхийг тодорхой зааж өгчээ. 1933 оноос эхлэн мал бүхий нэгдлүүд мэр



## АТАР ГАЗРЫГ ЭЗЭМШСЭН НЬ

1959 оны эхээр хуралдсан МАХН-ын ТХ-ны III бүгд хурлаас 1959-1961 онд 300 мянган га атар эзэмших зорилт дэвшүүлжээ. ЗХУ-ын техник, эдийн засаг, мэргэжилтний туслалцаатайгаар атар эзэмших хөдөлгөөн өрнөв. ЗХУ-аас 1959 онд 3000 автомашин, 2500 трактор, 500 комбайн зэрэг хөдөө аж ахуйн бусад техникийг зээлээр авч хэрэглэв. Атар эзэмшсэн эхний жилүүдэд өндөр ургац авч байсан. Гэвч газар тариаланг хөгжүүлэхдээ хагалбарлах талбайг нэмэгдүүлэх замаар газрыг сорчлон хагалж, өмнөхийг орхиж байсан



Зураг 3.11. Атрын анхны шан татаж буй

нь газрын үржил шимийг барагдуулж яваандаа хөрсний эвдрэлд оруулж байв. Атрыг эзэмшихдээ аль үржил шимтэй газрыг хагалж байсан нь малын бэлчээрийг хомсдуулж байв. Газар тариалангийн үйлдвэрлэл нь зээлийн хөрөнгө техникт түшиглэсэн, бусад салбараас илүү ажиллах хүч хэрэглэж, алдагдлаа улсын татаасаар нөхдөг ашиг орлого багатай үрэлгэн байдалтай байв. 1976 оноос атрын II аян, 2008 оноос атрын III аяныг өрнүүлжээ.

## АЖ ҮЙЛДВЭР, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖИЛ

1961 онд хуралдсан МАХН-ын XIV их хурал “БНМАУ-ын өөрийн хөгжлийн шинэ үе шат-социализмыг байгуулж дуусгах шатандаа орлоо” хэмээн үзэж, энэ үеийн үндсэн зорилго, шинжийг тодорхойлох шийдвэр гаргасан билээ. Үндсэн зорилтыг хэрэгжүүлэх гол арга замын нэг нь социализмын материал техникийн бааз байгуулах явдал байв. Энэ учраас улс орныг үйлдвэржүүлэх нь уг баазыг байгуулах гол зангилаа асуудал гэж үзэж байлаа. Гэвч өгүүлэн буй үед манай аж



Зураг 3.12. Аж үйлдвэрийн комбинат. 1934 он

үйлдвэр, дэд бүтцийн салбарт үйлдвэрлэл, үйлчилгээний үр ашгийг бус, төлөвлөгөөг биелүүлэхийг хамгийн гол зорилт болгодог байсны сацуу техник, технологи үлэмж хоцрогдсон байлаа. Энэ нь үйлдвэрлэл үйлчилгээний зардал ихээхэн өсч, ашиг буурахад хүргэж байв. Ашиггүй ажилласан үйлдвэрийн газрын алдагдлыг төсвөөс болон ЗХУ, социалист орнуудын зээл, тусламжаар нөхдөг байлаа.




Эдийн засгийн гол салбар	Он	Бүтээн байгуулалт, ололт амжилт
Аж үйлдвэр	1965-1990	Улаанбаатар, Эрдэнэт, Чойбалсан, Хөтөл зэрэг аж үйлдвэрийн шинэ төвүүд бий болсон.
	1973-1981	Зэс молибдений хүдэр баяжуулах “Эрдэнэт” үйлдвэрийг байгуулах тухай БНМАУ, ЗХУ-ын Засгийн газар хоорондын гэрээнд гарын үсэг зурж бүрэн хэмжээгээр ашиглалтад оруулсан нь манай орны эдийн засагт чухал хувь нэмэр оруулж байна. Ямааны ноолуур, тэмээний ноос боловсруулах “Говь” комбинат одоо ноос боловсруулах дэлхийн таван том үйлдвэрийн нэг болжээ.
Эрчим хүч	1966-1976	Төвийн эрчим хүчний системийг байгуулж, ЗХУ-ын Дорнод Сибирийн эрчим хүчний системтэй холбосон нь цахилгаан эрчим хүчний 80%-ийг үйлдвэрлэх болов. I, III цахилгаан станцыг өргөтгөн, IV цахилгаан станцыг барьж ашиглалтад оруулав.
Барилга,	1970-с	Улаанбаатар хотод байшин үйлдвэрлэх комбинат, Дарханд цемент, цагаан тоосгоны үйлдвэр, Тосонцэнгэлд мод боловсруулах комбинат, хэд хэдэн аймгуудад барилгын зарим материалын үйлдвэр, мод боловсруулах үйлдвэр байгуулагдсан.

### Тодруулга

Энэ үед БНМАУ-д байгуулагдсан үйлдвэрүүд нь ЗХУ болон Чехословак, Унгар, Болгар, БНАГУ, Румын, Польш зэрэг социалист улсуудын зээл, тусламжаар баригдсан байна. Говь комбинатыг Япон улсын хөрөнгө оруулалтаар баригдсан юм.

Бүдүүвч 3.1. БНМАУ-ын гадаад худалдааны эргэлт 1980-аад он.



Зураг 3.14. Эрдэнэт уулын баяжуулах үйлдвэр, Эрдэнэт хот

1932 оны зун эхэлсэн ШЭБ богинохон хугацаанд үр дүнгээ өгч манай орны эдийн засаг, аж ахуй, соёлын салбарт багагүй ахиц гарчээ. Гэвч олон улсын байдал хурцдаж, улс төрийн егүүтгэл газар авснаас болж ШЭБ тасалдсан байна. 1934 оноос лам нарыг хүрээ хийдээс холдуулах, аажмаар шашныг хориглон устгах бодлого дахин сэргэж эхэлжээ.

Цаашид социализмын материал техникийн бааз байгуулахтай холбоотой аж үйлдвэр, дэд бүтцийг хөгжүүлэхэд анхаарч байсан боловч үр ашиг муутай, алдагдал ихтэй байсныг ЗХУ болон социалист орнуудын зээл тусламжаар төлдөг байсан нь алсдаа мухардалд орсон юм.

1960-аад оны эх гэхэд атар эзэмших аяныг зохион байгуулснаар манай орны хөдөө аж ахуй нь мал аж ахуй, газар тариалан гэсэн хоёр үндсэн салбараас бүрдэх боллоо. Мал аж ахуйн үйлдвэрлэлд нэгдэл, газар тариалангийн үйлдвэрлэлд сангийн аж ахуй гол үүрэг гүйцэтгэж байлаа.



Зураг 3.13. Ю.Цэдэнбал (1916-1991) 1940-1984 онд МАХН-ын ТХ-ны Ерөнхий нарийн бичгийн дарга, Сайд нарын Зөвлөлийн дарга, БНМАУ-ын Ардын их хурлын тэргүүлэгчдийн дарга зэрэг албыг хашиж байв. Улсын маршал



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. ЗХУ, Коминтерний зүгээс баруунтнуудыг буруутгаж байсан зүйлсийг санацгаая. Эдгээр нь ШЭБ-той хэрхэн хамаарч байгааг эргэцүүлж хүснэгтийн дагуу ажиллаарай.

Баруунтнуудыг буруутгасан зүйл	Зүүнтний үйл ажиллагаа	Шинэ эргэлтийн бодлогоор залруулсан нь
ЗХУ-ыг эсэргүүцдэг		
Хуучны язгууртан баячуудыг дэмжиж хөрөнгөтний эрх ашгийг хамгаалдаг		
Шашныг ариунаар мандуулах эрмэлзэлтэй		
Капиталист орнуудтай харилцаа тогтоохыг эрмэлздэг		

2. ШЭБ-ын үед болон нэгдэлжих хөдөлгөөний үед малын тоо хорогдсныг зүүнтний үед малын тоо хорогдсонтой харьцуулж, юугаараа ялгаатайг ярилцаарай.
3. “Социализмын үед үйлдвэрлэл нь хэрэглэгчиддээ бус, харин хэрэглэгч нь үйлдвэрлэгчиддээ захирагдаж байлаа” Үүний үр дагавар нь юунд орших вэ?
4. Тухайн үед том оврын үйлдвэрүүд хэр ашигтай байв? Жижиг дунд үйлдвэрүүдийг хөгжүүлэх боломж байсан уу?

ҮНЭЛЭЭРЭЙ

БНМАУ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГОД ӨӨРЧЛӨЛТ ГАРСАН НЬ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Шинэ эргэлтийн бодлого
- Аж үйлдвэрийн нэгдэл
- Социализмын материал техникийн бааз

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгоё уу?	Бүтээлчээр сэтгээрэй.										
<p>1. 1932 оноос Монголд хэрэгжүүлсэн ШЭБ-ын мөн чанар юунд орших талаар ярилцаарай.</p> <p>2. ШЭБ-ын гол арга хэмжээнүүдийг хүснэгтээр илэрхийлээрэй.</p> <table border="1" data-bbox="172 744 523 925"> <tr> <td></td> <td>Авсан арга хэмжээ</td> </tr> <tr> <td>Мал сүрэг</td> <td></td> </tr> <tr> <td>Худалдаа</td> <td></td> </tr> <tr> <td>Үйлдвэр</td> <td></td> </tr> <tr> <td>Бусад</td> <td></td> </tr> </table> <p>3. Социализмын үед нам, төрөөс хөрөнгө хүч их зарцуулж эдийн засгийн хөгжилд ихээхэн анхаарч байсан ч дорвитой үр дүнд хүрэхгүй байсны учир шалтгааныг юутай холбон тайлбарлах вэ?</p>		Авсан арга хэмжээ	Мал сүрэг		Худалдаа		Үйлдвэр		Бусад		<p>4. Зүүнтний алдаа завхралыг засч ард иргэдийн амьжиргаагаа дээшлүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх сонирхлыг дээшлүүлэхийн тулд нам, төрөөс зохион байгуулсан ажлуудын талаар багаараа ярилцаарай.</p> <p>5. ШЭБ удаан үргэлжлээгүй шалтгааныг дэлгэрүүлэн ярилцаарай.</p>	<p>6. Улс орныг зөв удирдан чиглүүлж шинэ бодлого явуулсан тухайн үеийн түүхэн зүтгэлтнүүд хэн бэ? Тэдний тухай мэдээлэл цуглуулж танилцуулаарай.</p> <p>7. Мал нийгэмчлэх үеийн уран сайхны кино үзээрэй. (Жишээ нь, Тунгалаг тамир, Морьтой ч болоосой)</p> <p>8. Монголын эдийн засаг, нийгмийн хөгжилд “Эрдэнэт” үйлдвэрийн оруулж буй хувь нэмрийг илэрхийлсэн мэдээлэл олж судлаарай.</p>
	Авсан арга хэмжээ											
Мал сүрэг												
Худалдаа												
Үйлдвэр												
Бусад												

ТОЛЬ

Шинэ эргэлтийн бодлого  
Жас  
Жасын кампани  
Тайж  
Хохь тайж  
Социализмын материал техникийн бааз

Баруунтны бодлогыг 1932 онд сэргээснийг ШЭБ гэдэг Сүсэгтнүүдийн өргөлөөр байгуулагдсан дундын аж ахуй  
Жасын малыг хамтралаар маллуулахаар гаргасан шийдвэр  
Чингис, Чингисийн эрэгтэй дүү нарын хөвгүүдэд олгодог тусгай хүндэтгэл нэр  
Хамжлагагүй, хөрөнгө ядуу тайж  
Машинт том аж үйлдвэр, социалист ёсоор хоршоолсон хөдөө аж ахуй, эрүүл чийрэг бие бялдартай, цэвэр ариун ёс суртахуунтай ирэгэнийг төлөвшүүлэх явдал хэмээн үзэж байв.

5

**БНМАУ-ЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ**

**СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ**

XX зуунд монголчуудын олсон гол амжилтын нэг нь боловсрол, шинжлэх ухааны ололт байв.

**ГОЛ САНАА**

- Боловсрол, шинжлэх ухааны салбарын үүсэл, хөгжил, дэвшил
- Монголчуудын оюун санааны амьдралд гарсан өөрчлөлт

**ТҮЛХҮҮР ҮГ**


- Бага, дунд, тусгай, дээд сургууль
- Боловсролын тогтолцоо
- Судар бичгийн хүрээлэн, ШУХ, ШУА



**АСУУГААРЙ, ТААМАГЛААРЙ**


“...1931 оны зун Хэнтий аймагт соёлын довтолгооноор очиж, аймгийн төвд цуглуулсан эмэгтэйчүүдэд латин үсэг, хуучин монгол бичиг зааж зуслаа. Бас Галшир суманд ариун цэврийн довтолгооноор очив. Намар нь Гэгээрлийн яамнаас соёлын довтолгооны ажлыг дүгнэж, намайг хоёрдугаар байрт оруулж, савхин цамц, үнэмлэхээр шагнав. 1932 онд хавар Гэгээрлийн яам Сүхбаатарын талбайгаас үдэж, 40 оюутан мориор, 150 оюутныг үхэр тэргээр хөдөлгөсөн юм”

Соёлын довтолгооны үед шинэ үсгийн багшаар ажиллаж байсан Ц.Цэдэнжав дурсамжаас




Зураг 3.15. Анхны цэцэрлэг, сургууль байгуулагдсан аймгууд

Бүдүүвч 3.2. ЕБС, сурагчид, багш нарын тоо, мян.хүн



Бүдүүвч 3.3. 1930-1940 онд ажиллаж байсан цэцэрлэг болон хүүхдийн тоо





1. Зураглал болон график та бүхэнд юу өгүүлж байна вэ? Хэдийн үеийн үйл явдлыг дүрслэн харуулж байгаа талаар ярилцаарай.
2. Соёлын довтолгооны үед ажиллаж байсан багшийн дурсамж та бүхэнд юу хэлж байна вэ?
3. Тухайн онуудад цэцэрлэг, сургуулийн тоо хэрхэн өөрчлөгдснийг тооцоолоорой. Бүх шатны сургуулийн тоо өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар таамаглал дэвшүүлэн ярилцаарай.

## БОЛОВСРОЛЫН ГАДААД ХАМТЫН АЖИЛЛАГАА

1926 оны байдлаар гадаадад 250 орчим монгол залуучууд суралцаж байсны 20 гаруй хувийг Герман, Францад суралцагсад эзэлж байв. 1929 онд Коминтерн, ОК(б) Н-ын тулгалт шахалт, зүүнтний алдаатай бодлогын уршгаар Герман, Францад суралцагчдыг эргүүлэн татаж, өрнө дахины тэргүүний хөгжилтэй улсуудад үндэсний боловсон хүчнийг бэлтгэх зорилт тасарчээ. 1933 оноос Монголын дунд, дээд, тусгай мэргэжлийн боловсон хүчнийг Троицкосавск, Дээд-Үд, Эрхүү, Москва хотноо сургаж эхэлжээ. 1950 оноос БНХАУ, 1960-аад оноос БНАГУ, Франц, Болгар, Чехословак, Унгар, Югослав, Польш, Румын, БНКУ, Вьетнам зэрэг улсуудтай боловсролын салбарт хамтран ажиллаж ирэв. 1962 онд ЮНЕСКО-д элссэнээс хойш манай улсын боловсролын гадаад хамтын ажиллагаа улам өргөжив. Энэ үед Энэтхэг, Англи, Япон зэрэг улстай багш, судлаач, оюутан солилцож байжээ. 1970-1990 онуудад ЗХУ-ын дээд сургуулиудад 1300, ТМС-д 200, европын социалист гэгдэж байсан орнуудад 200 орчим хүнийг жил бүр сургаж байв. 1988 оны байдлаар гадаадын 13 улсад монголын 14000 орчим хүн сурч байлаа.

### Тодруулга

№ 6

БНМАУ-ын бичгийг монгол үсгээс орос үсэгт шилжүүлэх тухай БХК(б)-ын Төв Хорооны Улс төрийн Товчооны хуралдааны 31 дүгээр протоколоос

1941 оны дөрөвдүгээр сарын 26 УТГ-ны 41. IV. 25-ны шийдвэр<sup>1</sup>

246. БНМАУ-ын бичгийг монгол үсгээс орос үсэгт шилжүүлэх тухай МАХН-ын Төв хорооны сургагч н. Д.И.Сидровын<sup>2</sup> бичиг(ЗБТ 41. IV. 23-ны хуралдааны пр. № 76, зүйл 546-гс). БНМАУ-ын бичгийг монгол үсгээс орос үсэгт шилжүүлэхэд татгалзах зүйлгүй байна.

РГАСПИ. Ф.17. Оп.З.Д.1038.Л.69. Хуулбар. МУУТА. Х.445. Д.5. ХН.88. Тал 1. Ксеро хуулбар. Монгол-Зөвлөлтийн соёл шинжлэх ухааны, техникийн хамтын ажиллагаа(1921-1960). Баримт бичгийн эмхтгэл 1-р боть, -УБ.2000.х.332.

### БИЧИГ ҮСЭГТ СУРГАХ


Ардын засгаас авч явуулсан бодлогын үр дүнд бичиг үсэг үл мэдэх байдлыг арилгаж, сургуулийн анхан шатны шатлалаас орчин үеийн боловсролын тогтолцоог бүрэлдүүлжээ.

1930-аад оны үед БНМАУ-д бичиг үсгийн шинэчлэл хийж, бүх нийтийг латин бичиг үсэгт сургах ажил өрнөжээ. Энэхүү латинчлах аян 1931 оны соёлын довтолгооны нэгэн зорилт болж, орон даяар бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгах уриан дор өрнөжээ. 1931-1932 онд 20000 хүн бичиг үсэгт тайлагдав. Латин үсгийн Зөвлөлөөс эрхлэн цагаан толгой, бичиг үсгийн дүрэм, тогтмол хэвлэл, сонин гаргажээ. 1941 оноос кирилл үсэгт шилжих шийдвэр гарч “Шинэ үсгээр үг холбох тухай” анхны түр дүрэм нийтлэгдэж, 1946 оны 1 сарын 1-ээс эхлэн албан хэргийг шинэ үсгээр явуулахаар болжээ. Гэвч бичиг үсгийн боловсрол хангалтгүй байна гэж үзээд МАХН-ын Улс төрийн товчоо 1959 оны 7 сарын 13-нд “Бүх орон даяар соёлын довтолгоон явуулах” тогтоол гаргав.



1969 оны хүн амын бүртгэлийн мэдээгээр нийт хүн амын 82.4% нь, үүнээс эрэгтэйчүүдийн 88.7%, эмэгтэйчүүдийн 76.6% нь кирилл бичигтэн болсон байна. Монголчуудын бичиг үсгийн мэдлэгийн дээшлэлт 1963 онд 71,5%, 1969 онд 82.4%, 1979 онд 93,3%, 1989 онд 97% нь бичигтэн болж, 1969-1989 онуудад бичиг үсэг мэдэгчийн тоо 15%-иар өсөж, 1970 онд Н.К.Крупскаягийн нэрэмжит ЮНЕСКО-гийн олон улсын шагналыг Монгол улсад олгожээ.

Уг тогтоолд "...ойрын ирээдүйд бүх насанд хүрэгчдийг анхан шатны боловсролтой болгох хэмжээнд хүрсэн байхаар бичиг үсгийн мэдлэгийг сайжруулахаар", хүн бүрийн боловсролыг нэг шат ахиулахаар заажээ. Хүн бүр боловсролын талаар шат ахих явдал бол 1959 онд эхэлсэн соёлын довтолгооны үндсэн гурван лоозонгийн нэг байв. Соёлын довтолгооны жилд бичиг үсгийн гурван сарын аян зохиож, бичиг үсгийн бүлгэмд 1600 гаруй багш, 800 гаруй оюутан багшилж байжээ.



Зураг 3.16. Н.К.Крупскаягийн нэрэмжит шагнал

## БАГА, ДУНД БОЛОВСРОЛ

1921 онд Дотоод яамны бүтцэд сургууль хариуцсан хэлтэс, 1924 онд сургууль боловсрол хариуцсан яам байгуулагджээ. 1923 оноос Нийслэл Хүрээнд анхны бүрэн бус дунд сургууль байгуулагджээ. 1924 онд Алтанбулагт, 1925 оноос Улаанбаатар хотод анх цэцэрлэг байгуулж, 30 гаруй хүүхэд, 4 багштайгаар үйл ажиллагаа эхлүүлж байжээ.

1948-1949 оноос “Бүх нийтээр заавал сургах зарчим”-ыг тогтоон, хөдөөд 4-р ангийн, хотод 7 жилийн боловсролтой болгох зорилт хэрэгжжээ. 1960 оны эхээр сургуулийн насны бүх хүүхдийг нийтээр нь заавал, бүрэн бус дунд боловсролтой болгох бэлтгэл ажил дуусаж, 1970 онд энэ зорилт үндсэндээ биелжээ. 1963-1964 оны хичээлийн жилээс эхлэн ерөнхий боловсролын 7, 10 жилийн дунд сургуулийг ерөнхий боловсрол-хөдөлмөр политехникийн 8, 11 жилийн дунд сургууль болгож өөрчилсөн байна. Бүх нийтийг 8 жилийн боловсролтой болгох явцад сургуулийн бүтэц өөрчлөгдөн бага сургууль цөөрч, бүрэн, бүрэн бус дунд сургуулийн тоо нэмэгджээ.

1924-1990 оны БНМАУ-ын боловсролын зорилгыг дараах байдлаар ангилж болно. Үүнд:

1924-1960 он

- Орчин цагийн иргэний боловсролыг бүх нийтэд түгээх;
- Нийгмийн оюун санааг шашин шүтлэгээс чөлөөлөх;
- Боловсролын тогтолцооны эх суурийг тавих;
- Сургалтыг шаталсан системтэй явуулах;

1961-1990 он

- Боловсролын системийг боловсронгуй болгож сургууль, амьдралын холбоог бэхжүүлэх;
- Сургуулийн насны хүүхдийг бүрэн дунд боловсролтой болгох;
- Сургалтыг үйлдвэрлэлтэй холбох үндсэн дээр сургуулийн тогтолцоог өөрчлөн шинэчлэх;

## ДЭЭД БОЛОВСРОЛ



Зураг 3.17. Монгол Улсын Их сургууль 1942 онд байгуулагдсан.

Шинжлэх ухаан, техникийн хувьсгал 1950-иад оноос эхэлжээ. Үүний дотор дээд боловсрол нь дэлхийн II дайнаас хойш нийтийг хамарч бүх нийтийн хэрэгцээ, сонирхол, үнэт зүйлийн салшгүй нэг хэсэг болов. Дээд боловсрол бол чадал зүтгэл нь тэнцсэн хэн бүхэнд нээлттэй байвал зохино гэж Хүний эрхийн түгээмэл тунхаглал (1948)-ын 26-р зүйлд заажээ. Өгүүлэн буй үед МУИС, Политехникийн дээд сургууль, Улсын багшийн дээд сургууль, Анагаах ухааны дээд сургууль, Хөдөө аж ахуйн дээд сургууль, Эдийн засгийн дээд сургууль, Орос хэлний багшийн дээд сургууль, Ховдын багшийн дээд сургууль, Намын дээд сургууль, Цэргийн ерөнхий дээд сургууль, Нийгмийн аюулаас хамгаалах яамны дээд сургууль, Удирдах ажилтны мэргэжил дээшлүүлэх институт зэрэг иргэний болон цэргийн 12 их, дээд сургууль дээд боловсролыг эзэмшүүлж байв. 1985 онд иргэний 7 дээд сургууль сурган хүмүүжүүлэх, анагаах ухаан, үйлдвэр, хөдөө аж ахуй, эдийн засаг, техникийн чиглэлийн 84 мэргэжлээр боловсон хүчин бэлтгэж байснаас МУИС 20, УБДС ба Ховдын багшийн дээд 14, ОБДС 1, АУДС 5, ХААДС 12, ПДС 32 мэргэжлээр дээд боловсролтой мэргэжилтэн бэлтгэж байжээ.

### ХӨДӨЛМӨРЧДИЙН БОЛОВСРОЛ

Үйлдвэрийн ажилчин, малчдад ерөнхий боловсролыг 3 жилд багтаан олгож байв. Хөдөлмөрчдийн ерөнхий боловсролыг дээшлүүлэх ажлыг

- а) бичиг үсгийн дугуйлан, суурийн сургууль;
- б) бага сургуулийн боловсрол олгох түр сургууль;
- в) бүрэн бус дунд боловсрол олгох улирлын сургууль;
- г) ерөнхий боловсролын оройн (ээлжийн) дунд сургууль;
- д) эчнээ сургалт (бие дааж сурах) гэсэн үндсэн хэлбэрүүдээр хэрэгжүүлэх болжээ.

### ТУСГАЙ МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ

1924 оноос нягтлан бодогч, хууль цаазны мэргэжилтэн бэлтгэх нэг жилийн хугацаатай сургууль, Эд хэрэглэгчдийн харилцан туслалцах түр сургууль, мал эмнэлэг, сувилагчийн түр сургууль, 1929 онд хүн эмнэлгийн техникум, 1938 онд үйлдвэрийн тусгай мэргэжлийн сургууль тус тус байгуулагджээ. 1960 онд тусгай мэргэжлийн дунд сургууль 15 байсанд 8.8 мянган хүн суралцаж, 10000 хүн тутмаас 92 хүн тусгай мэргэжлийн дунд сургуульд суралцаж байв. Энэ тоо 1985 онд 40, 1987 онд 43 болж, 115 мэргэжлээр 28 мянга гаруй сурагч суралцаж байжээ.


### НИЙГМИЙН УХААНЫ САЛБАРТ ОЛСОН АМЖИЛТ

Манай эрдэмтэн, судлаачид улс орныхоо түүх, нийгмийн асуудалд анхаарал хандуулж, дорвитой бүтээлүүд туурвисан байна. “БНМАУ-ын түүх” (3 боть. 1966-1969), “БНМАУ-ын түүх” (боть. 1984), “БНМАУ-ын соёлын түүх”, “БНМАУ-ын ардын аж ахуйн бүтэц” (1978), “Монгол бичгийн хэлний зүй” I, II, III, IV боть, “Монголын уран зохиолын түүх” I, II боть, “Монгол бичгийн хэлний зүй” (4 боть. 1964, 1966, 1967), “Монгол хэлний товч ТОЛЬ” (1966), “Монголын уран зохиолын тойм” (3 боть. 1957, 1972, 1976), “Орос-Монгол нэр томъёоны толь” (I-III боть “Монгол хэлний товч ТОЛЬ” (1966), “Монгол бичгийн хэлний зүй” (1964-1967), “Орчин цагийн монгол хэлний бүтэц” (1967-1968) зэрэг томхон бүтээлийг онцлон дурдаж болно.

## ШУА БАЙГУУЛАГДСАН НЬ

БНМАУ-ын АИХ-ын тэргүүлэгчид 1961 оны 5 сарын 16-нд ШУА байгуулах тухай зарлиг гаргасан. ШУА-ийн Ерөнхийлөгчөөр профессор Базарын Ширэндэв, дэд ерөнхийлөгчөөр Батын Дашжамц, эрдэмтэн нарийн бичгийн даргаар Чимэдийн Сэрээтэрийг сонгожээ. ШУА-ийн дүрмийг баталж, харьяанд нь ажиллах эрдэм шинжилгээний хүрээлэн, газруудыг тогтоож өгсөн байна.

1961 онд ШУА-ийг байгуулахад Түүх, Хэл зохиол, Хөдөө аж ахуй, Анагаах ухаан, Байгалийн ухааны хүрээлэнтэйгээр байгуулжээ. Улмаар 1962 онд Философи, социологи, эрхийн хүрээлэн, 1973 онд Байгалийн нэгдлийн хүрээлэн, 1974 онд Физик, техникийн, Математик, Ботаникийн хүрээлэн, 1976 онд Дорно дахины, Үйлдвэрлэх хүчний хөгжлийн хүрээлэнгүүд байгуулагджээ. ШУА-ийн харьяанд улсын төв номын сан, төв музей, Эрдэнэ зуу хийд музей, архив гэрэл зургийн лаборатори, инфоматикийн төв, шинжлэх ухаан мэдээллийн хэлтэс гэсэн салбар төвүүд ажиллаж байв.



Зураг 3.18.  
Бямбын Ринчен (1905-1977) Шинжлэх ухааны академийн жинхэнэ гишүүн, хэлбичгийн ухааны доктор

## БАЙГАЛИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАР

Монголын судлаачид үр тарианы “Орхон”, “Халхгол”, “Дархан”, “Сэлэнгэ” улаан буудайн сорт, арвайн “Алаг Эрдэнэ” зэрэг сортуудыг гарган авч тариалах болжээ. Мөн мал сүрэгт элбэг тохиолдож байсан халдварт өвчнүүдийг оношлоход ихэд анхааран, урьдчилан сэргийлэх өндөр үр ашигтай вакциныг 1976 онд зохион бүтээжээ. Зохиогч Д.Дашдаваа Монгол улсын төрийн шагнал хүртжээ.



Зураг 3.19. 1961 он нарийвтар ноост Орхон үүлдэр



Зураг 3.20. 1971 он ноолуурын Говь гурван сайхан үүлдэр



Зураг 3.21. 1984 он махны чиглэлийн Сэлэнгэ үүлдэр

1924-1960 онд Монгол улс нийтээрээ бичигтэн болж боловсролын тогтолцоо бүрэлдэн тогтжээ. Мөн орчин цагийн шинжлэх ухаан үүсэн төлөвшив.

1961-1990 онд техник мэргэжлийн болон дээд боловсролын систем бүрэлдэн боловсролын салбарын гадаад харилцаа өргөжжээ. Шинжлэх ухааны олон салбар хөгжиж суурь судалгааны хүрээ өргөжив.

Зураг 3.22.  
1981 оны 3 сарын 22-нд БНМАУ-ын иргэн Ж.Гүррагчаа сансарт нисэв.





### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

Дээрх мэдээллүүдийг эргэцүүлж дараах асуултуудын дагуу хамтран ажиллаж задлан шинжлээрэй. Үүнд:

1. 1924-1960, 1961-1990 онд Боловсрол, шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар дэвшүүлсэн зорилгын ижил ба ялгаатай талыг задлан дүгнээрэй.
2. Ард олныг бичиг үсэгтэн болгох явцад ямар бэрхшээл тулгарч байсан бол?
3. Монголд шинжлэх ухааны олон салбар үүсч хөгжиж байсныг илтгэх баримт мэдээлэл олж харилцан солилцоорой.
4. Боловсрол шинжлэх ухааныг хөгжүүлэх талаар авсан арга хэмжээний үр дүн өнөөгийн Монголын боловсролын салбарт ямар өөрчлөлт, дэвшлийг авчирсан талаар дүгнэлт гаргаарай.

### ҮНЭЛЭЭРЭЙ

### БНМАУ-ЫН БОЛОВСРОЛЫН ХӨГЖИЛ

<p><i>Үг бүрийг 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Бага, дунд, тусгай мэргэжлийн сургууль</li> <li>• Дээд боловсролын тогтолцоо</li> <li>• Хөдөлмөрдийн боловсрол</li> </ul>																			
Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.		Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.																
<p>1. БНМАУ-ын Засгийн Газраас боловсрол шинжлэх ухааныг хөгжүүлэх чиглэлээр ..</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Дэвшүүлсэн зорлого</th> <th>Авсан арга хэмжээ</th> <th>Хүрсэн үр дүн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>2</td> <td></td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>3</td> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>		№	Дэвшүүлсэн зорлого	Авсан арга хэмжээ	Хүрсэн үр дүн	1				2				3				<p>3. Дараах 2 даалгаврын аль нэгийг сонгон хийгээрэй.</p> <p>а) Өнөөгийн боловсрол, шинжлэх ухааны хөгжлийн суурийг хэрхэн тавив?</p> <p>б) Боловсрол шинжлэх ухааны хөгжлийг харуулсан хронологийн хүснэгт зохиогоорой.</p>	<p>4. “Зураг түүх өгүүлнэ” сэдвээр судалсан агуулгыг илэрхийлсэн зурган бүтээл хийгээрэй</p> <p>5. “Боловсролын салбарын үүсэл, хөгжлийн түүхэн жимээр” эсээ бичээрэй.</p> <p>6. “Шинэ үсгийн багш” уран сайхны киноны үйл явдлыг түүхэн талаас нь шинжлээрэй.</p>
№	Дэвшүүлсэн зорлого	Авсан арга хэмжээ	Хүрсэн үр дүн																
1																			
2																			
3																			
<p>2. Социализмын үед бичиг үсэг үл мэдэгчдийн тоо хэрхэн өөрчлөгдсөнг бүдүүвчээр илэрхийлээрэй.</p>																			

### ТОЛЬ

МХЗЭ  
ШУХ  
ШУА  
ЮНЕСКО

Монголын хувьсгалт залуучуудын эвлэл  
Шинжлэх Ухааны Хүрээлэн  
Шинжлэх Ухааны Академи  
НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын асуудал эрхэлсэн төрөлжсөн байгууллага



## 6

## БНМАУ-ЫН СОЁЛЫН ХӨГЖИЛ

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Өнгөрсөн үеийн урлаг, соёлын хөгжлийн ололт, амжилт, сургамжийг судлах нь ирээдүйн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлоход тусална.

## ГОЛ САНАА

Монголд үндэсний соёл, урлагийн байгууллага, мэргэжилтэй боловсон хүчин бэлтгэгдэж, дэлхийн соёл, урлагтай танилцав.

## ТҮЛХҮҮР ҮГ

- Ахуй үйлчилгээ
- Соёлжилт
- Урлаг соёл

## МАЛЧДЫН АХУЙ АМЬДРАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

1921 онд хувьсгал ялж, малчдын ахуй амьдралд шинэ өөрчлөлтүүд гарч эхэлсэн. 1932 оноос коммун хамтрал, анхны нөхөрлөл, нэгдэл, сангийн аж ахуй, өвс хадах машинт станцууд, аж үйлдвэрийн комбинат зэрэг олон газрууд шинээр байгуулагдаж, нүүдэлчдийн уламжлалт амьдралд өөрчлөлт оров. Нэгдлийн төвд сүү, тосны завод, төмөр ба модны дархны газар, малын зохиомол хээлтүүлгийн газар, сургууль, халуун ус, гуанз, дэлгүүр, зочид буудал, хүн, мал эмнэлгийн салбар, улаан булан бий болж амьдралын шинэ хэв маяг үүсч, мал маллагааны уламжлалт арга ажиллагаанд дэвшилт өөрчлөлт гарав. Мөн ахуй амьдрал, гэр орноо тохижуулах, хувцаслах, хооллох, чөлөөт цагаа өнгөрүүлэх хэв маяг өөрчлөгдөж эхэлжээ.

## СОЁЛ ГЭГЭЭРЛИЙН БАЙГУУЛЛАГА

Нийгмийн оюун санааны хоцрогдлыг арилгах, тэргүүний дэвшилтэд үзэл санааг түгээх, соёл-гэгээрлийн ажлыг зохиох цэнгэлдэх хүрээлэн, клуб, улаан гэр байгуулах шийдвэр гарав. Хүн ам төвлөрсөн Улаанбаатар, Улиастай, Алтанбулаг хотод бүжиг наадам, жүжиг, сүүдэр ший үзүүлэн ард олны таашаалыг хүлээж байв. Мөн ном хэвлэлээр үйлчлэх номын сан, уншлагын газруудыг байгуулах, явуулын уншлагын номын сан ажиллуулах, номыг үнэ төлбөргүй тавьж олгох ажлуудыг хийж байв.

Цаашид урлаг, уран сайхны газруудыг шинээр байгуулахад анхаарч эхний ээлжинд 1924 онд Улиастай хотын орон нутгийг судлах музей байгуулжээ. 1934 онд хувьсгалын музей байгуулж, 1938 онд Чойжин ламын сүмийг шашнийг эсэргүүцэх музей болгожээ. Соёл, гэгээрлийн ажилд нэн тустай радио нэвтүүлгийг 1931 оны 5 сард ЗХУ-ын хүч хөрөнгөөр бага хүчний зангилаа байгуулж, радио цэгийн тоог нэмэгдүүлсээр иржээ.



**СОНИН ХЭВЛЭЛ**

1921 онд “Уриа”, 1924 онд “Ардын эрх” сонин, 1925 онд “Үнэн” сонин гарчээ. “Ардын цэрэг” сонин (1924-1927 он), “Хувьсгалт улаан цэргийн соёлын зам” (1927-1930 он хүртэл), 1930 оноос “Улаан од” зэрэг сонин хэвлэгдэж байв. “Манай зам” (тус сэтгүүлийг 1925 оноос “Хувьсгалт залуучуудын эвлэл”), “Хураангуй сэтгүүл” (1922-1923 он) зэрэг сэтгүүл хэвлэгдэн гарч байв. Гучаад оноос эхлэн “Ажилчны зам”, “Хөдөлмөр”, “Залуучуудын үнэн” зэрэг сонингууд хэвлэгдэж эхлэв.

1950 онд нийт 24 нэр бүхий сонин жилд 25876,2 мянган ширхэгээр хэвлэгдэж байсан бол 1960 онд 29 нэр бүхий сонин жилд 53858,8 мянган ширхэг хэвлэгдэх болов. 1950 онд сэтгүүлийн тоо 12 байсан нь 975,5 мянган ширхэгээр, 1960 онд 16 нэр төрлийн сэтгүүл 2394,5 мянган ширхэгээр хэвлэгдсэн байна.



*Зураг 3.23. 1920-иод оны үеийн монгол айл*



*Зураг 3.24. 1950-иад оны үеийн монгол айл*



## АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ

1. Малчдын амьдралд өөрчлөлт гарахад юу нөлөөлсөн талаар асуулт гаргаарай.
2. 82-р талын зураг дээр ажиллаж, монголчуудын ахуй амьдралд ямар өөрчлөлт гарсныг тодорхойлоорой. Монгол гэрт буй эд хэрэгслийг нэрлэж, зориулалтыг ярилцаарай.
3. Оюун санааны хоцрогдлыг арилгахад чиглэсэн ямар ямар арга хэмжээ авч хэрэгжүүлж байв? Тэдгээрийн үр дүнг тодорхойлоорой.
4. Энэ үед гарч байсан сонин хэвлэлүүдийн зорилго юунд чиглэж байсан тухай таамаглал дэвшүүлж, сонин хэвлэлийн нэрийн талаар санал бодлоо хуваалцаарай.

## МОНГОЛД ӨРНӨСӨН СОЁЛЫН ДОВТОЛГООН

Хөдөлмөрчдийн ухамсрыг дээшлүүлэх соёлын довтолгоог XX зууны дунд үед хоёр үе шаттай, тун эрчимтэй улс даяар өрнүүлжээ. Шат бүр нь өмнөө дэвшүүлсэн зорилготой, хэрэгжүүлэх арга хэлбэрийн хувьд ялгаатай үйл явц байв. 1959 оноос эхэлсэн соёлын довтолгоог аймаг, хотын намын хороод удирдан зохион байгуулж байв. Харин үйл ажиллагааг тэргүүлэн гүйцэтгэгчид нь сэхээтнүүд, эмэгтэйчүүд, залуучууд, эмэгтэйчүүдийн байгууллага, МХЗЭ болон бүх сонин хэвлэлүүд (бүх сонин хэвлэл энэ ажиллагаанд зориулсан тусгай булантай байжээ) сум, нэгдэл, бригад, үйлдвэрийн соёлын довтолгооны ажлыг хариуцсан комиссууд байв.

Соёлын довтолгооны эхний жилүүдэд хот хөдөөд бичиг үсэг үл мэдэгчдэд зориулсан сургалтыг зохион байгуулж 8500 гаруй хүнийг бичиг үсэг сайн мэдэгчээр тайлсан. Тухайлбал Булган, Өмнөговьд бүлгэм байгуулагдаж 57000 хүнийг бага мэдэгчээр, Ховд, Сэлэнгэ зэрэг аймгууд 13-45 насны бүх иргэдээ бичигтэн болгожээ. Гэр ахуйн соёлжилт мэдэгдэхүйц ахиж хөдөлмөрчдийн ахуй амьдралд шинэ дэвшилт дадал заншил нэвтэрч байв. Хот, хөдөөд 56000 хүн ариун цэврийн анхан шатны мэдлэг авчээ.

Соёлын довтолгоог хүн бүрийн идэвх санаачлагын үндсэн дээр сурталчилгааны аргатай хослуулан явуулсны дүнд ард олны эрүүл мэнд, бичиг үсэг, соёл, техникийн мэдлэг, хамтач сэтгэлгээ, гэр ахуйн соёлжилт мэдэгдэхүйц дээшилсэн байна. Соёлын довтолгооны дараагийн шатны үйл ажиллагаа нь шинжлэх ухааны үндэстэй сургалт, сургууль, үйлдвэр, практикт түшиглэн явуулж зохих үр дүнд хүрсэн үйл явц байв. Энэ үед үндэсний соёл урлагийн мэргэжилтэй боловсон хүчин бий болсон.



Зураг 3.25. Соёлын довтолгооны үеийн жагсаал



Зураг 3.26. “Бөмбөгөр ногоон” Ардын цэнгэлдэх хүрээлэн буюу “Бөмбөгөр ногоон” хэмээн нийтэд алдаршсан барилгыг 1927 онд төр засгийн удирдагч, өргөн олон түмэн ёслол төгөлдөр нээн мялаалга үйлджээ.

УТГА ЗОХИОЛ, УРЛАГИЙН ХӨГЖИЛ

Нийгмийн өмчид тулгуурласан хамтач үзэл, зан үйл бүрэлдэн төлөвшиж байв. Ардын засгийн газраас урлаг, утга зохиолыг хөгжүүлэх талаар их анхаарал тавьж байв. Энэ үед ард түмний эрх ашигт нийцсэн агуулгатай, үндэсний хэлбэртэй урлаг соёлыг хөгжүүлэх, дэлхий дахины сонгодог урлагийн дэвшилтэт өвөөс бүтээлчээр суралцах зорилтыг дэвшүүлж ажилласнаар монголын орчин үеийн урлагийн түүхийн шинэ хуудас нээгджээ.

1920-1940 оны тогтмол хэвлэл, урлаг, утга зохиол, уран бүтээлийн нийтлэг зорилго нь олон түмнийг шинэ амьдралд уриалсан, сайн сайханд тэмүүлсэн утга агуулгатай нийтлэл, бүтээл гаргахад чиглэж байв. 1950-иад оноос соёл урлагт социалист бүтээн байгуулалт, ах дүүгийн найрамдлыг магтан дуулах, сурталчилах чиглэл давамгайлж байв. Мөн энэ үеэс Монголын түүхэн туульс, уламжлалт зан заншлыг дэлгэрүүлэх, хөгжүүлэх үйл ажиллагаа саарч иржээ.

Урлагийн байгууллагын удирдах ажилтан, мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх талаар анхаарч байжээ. 1945-1946 онд Улсын цирк 20 хүний орон тоотой циркийн сургуулийг Зураг урлалын газрын дэргэд уран зураач, уран барималчийн Дүрслэх урлагийн сургууль, Улсын төв театрын дэргэд уран сайхны сургуулийг тус тус байгуулжээ. Төв театрт найрал дууны болон бүжгийн

ангийг шинээр байгуулж, симфони найрал хөгжимтэй дуулж бүжих болов.

1931 онд Улсын төв театр байгуулагдаж, 1950 оны 12 сард Улсын хөгжимт драмын театр зориулалтын шинэ барилгатай болов. Ингэснээр тайз техникийн нөхцөл эрс сайжирчээ. 1950 онд театрын дэргэд Хүүхдийн төв театр, 1948 онд Дорнод аймагт, 1950 онд Ховд аймагт театр байгуулагджээ. 1963 онд Улсын Хөгжимт драмын театрыг Улсын Драмын театр, Улсын Дуурь Бүжгийн театр болгон зохион байгуулжээ.

Улсын төв театрт С.Буяннэмэхийн “Шөнийн буг”, “Харанхуй засаг”, Ши.Аюушийн “Говийн хүүхэн Гүндэгмаа”, Э.Оюуны орчуулгаар Н.Гоголийн “Байцаагч түшмэл”, Шекспирийн “Отелло” зэрэг дотоод, гадаадын олон жүжиг тоглож байжээ. Түүхэн хөгжлийн явцад Монголын урлагийн тайзнаа дэлхийн сонгодог 100 гаруй жүжгийг эх хэл дээрээ орчуулан нийтийн хүртээл болгожээ. 1933 оны 5 сард сайн дурын хувьсгалт театрын олон улсын олимпиад Москвад болов. Түүнд Англи, Бельги, Голланд, Дани, Франц, Швейцари, ЗХУ-аас Украин, Азербайжан, болон БНМАУ-ын театрын 33 жүжигчин оролцож Монголын театр тэргүүн байрт шалгарав. L’Humanite Хүмүн төрөлхтөн сонины 1933 оны 6 сарын 2-ны дугаарт энэ тунхаг мэдээлж байв.



Зураг 3.27. Бөмбөгөр ногоон театр



Үгийг Ц.Дамдинсүрэн  
Аяыг Л.Мердорж Б.Дамдинсүрэн

**Төрийн дуулал (1961 он)**

Дархан манай хувьсгалт улс  
Даяар монголын ариун голомт  
Дайсны хөлд хэзээ ч орохгүй  
Дандаа энхжиж үүрд мөнхжинө.  
Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хатан зориг, бүхий чадлаар  
Хайрт Монгол орноо мандуулья.  
Ачит Ленин Сталины заасан  
Ардын чөлөө, жаргалын замаар

Агуу Монгол орноо удирдсан  
Ачит Сүхбаатар, Чойбалсан  
Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хатан зориг, бүхий чадлаар  
Хайрт Монгол орноо мандуулья.  
Зоригт Монголын золтой ардууд  
Зовлонг тонилгож, жаргалыг эдлэв.  
Жаргалын түлхүүр, хөгжлийн тулгуур  
Жавхлант манай орон мандтугай.  
Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эгнээг бэхжүүлж  
Хатан зориг, бүхий чадлаар  
Хайрт Монгол орноо мандуулья

**Төрийн дуулал (1992 оноос)**

Дархан манай тусгаар улс  
Даяар монголын ариун голомт  
Далай их дээдсийн гэгээн үйлс  
Дандаа энхжин, үүрд мөнхжинө.  
Хамаг дэлхийн шударга улстай  
Хамтран нэгдсэн эвээ бэхжүүлж  
Хатан зориг бүхий л чадлаараа

Хайртай Монгол орноо мандуулья  
Өндөр төрийн минь сүлд ивээж  
Өргөн түмний минь заяа түшиж  
Үндэс язгуур, хэл соёлоо  
Үрийн үрдээ өвлөн бадраая.  
Эрэлхэг Монголын золтой ардууд  
Эрх чөлөө жаргалыг эдлэв.  
Жаргалын түлхүүр, тулгуур хөгжлийн  
Жавхлант манай орон мандтугай.



Зураг 3.28. 1929 оны Монголын зохиолчдын анхны эмхэтгэл “Уран үгсийн чулган”

1929 онд С.Буяннэмэх, М.Ядамсүрэн, Ц.Дамдинсүрэн, Б.Ринчен, Г.Навааннамжил нарын хүмүүс уран зохиолын бүлгэм байгуулав. Тэд өөрсдийн бүтээлээр бүтсэн “Уран үгсийн чулган” хэмээх цоморлигийг хэвлүүлсэн нь шинэ монголын зохиолчдын анхны эмхэтгэл байв. Үндэсний зохиолчдын эгнээ өргөжиж олон арван бүтээл туурвиснаас тоймловол: Д.Нацагдоржийн Дөрвөн улирлын шүлгүүд, “Ламбугайн нулимс”, “Харанхуй хад” өгүүллэг, Д.Намдагийн “Хөгшин чоно ульсан нь” тууж, С.Эрдэнийн “Өвгөн шувуу”, “Малын хөлийн тоос”, “Наран тогоруу” өгүүллэгүүд, П.Лувсанцэрэнгийн “Ус шиг цэнхэр”,




Зураг 3.29. Дашдоржийн Нацагдорж (1906-1937)

“Нурамтын өвөрт” өгүүллэгүүд, Б.Явуухулангийн “Хар-Ус нуурын шагшуурга”, “Тэхийн зогсоол”, “Туулын шугуй” зэрэг олон шүлэг, Д.Батбаярын “Цахилж яваа гөрөөс” туужийг давын өмнө нэрлүүштэй.

Монголын орчин үеийн уран зохиолыг үндэслэгчдийн нэг, зохиолч, яруу найрагч Д.Нацагдорж “Ушаандар, “Сандо амбаны харгис явдал” жүжиг, “Учиртай гурван толгой” дуурь, “Миний нутаг”, “Од”, “Октябрь” зэрэг олон арван шүлэг, “Хуучин хүү”, “Цагаан сар ба хар нулимс”, “Харанхуй хад” зэрэг өгүүллэгүүдээрээ алдаршжээ. Тэрээр А.С.Пушкиний “Гилбэрийн хатан”, “Буудалцсан нь”, Эдгар Погийн “Алтан цох”, Ж.Верн “Усан доогуур хорин мянган бээр аялсан нь” зохиолыг орос, герман хэлнээс анх орчуулжээ.

**Тодруулга**

БНМАУ-ын үед урлаг, соёлын талаар бодитой амжилт олж байсан. Гэвч нэг намын хэт үзэл сурталжуулах нөлөөний дор сэтгэлгээний эрх чөлөөг боогдуулах, үйл ажиллагааны хүрээг зааж нэг загварт оруулах, хуулбарлах, даган дууриах явдал газар авахад хүргэж байв. Тухайлбал, түүх, соёлоо өмгөөлж, хүний эрх, сэтгэлгээний эрх чөлөөг магтан дуулсан Р.Чойномын шүлэг, найраглалыг хааж байв. Гэвч түүний зохиол ард олны дунд нууцаар тарж байв. Түүнд 1990 онд Төрийн шагнал нөхөн олгосон.



Зураг 3.30. Ренчиний Чойном (1936-1979)



**ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ**

1. Төрийн сүлд дууллыг харьцуулан ялгааг гаргаж, дүгнээрэй

	1961	1991
Ижил тал		
Ялгаатай тал		
Дүгнэсэн нь		

2. Дараах асуултуудын дагуу хамтран ажиллаарай. Үүнд:

- а) Соёл урлагийг хөгжүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар саналаа илэрхийлээрэй.
- б) Соёлын довтолгоог хэрэгжүүлсний үр дүнд ямар амжилтад хүрсэн талаар дүгнэлт баримтад үндэслэн тайлбарлаарай.
- в) Соёл, урлаг утга зохиолыг хөгжүүлэх чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн өнөөгийн Монголын соёл, урлаг, утга зохиолын салбарт ямар өөрчлөлт, хөгжил авчирсан талаар баримт нотолгоо цуглуулж дүгнэлт хийгээрэй.



БНМАУ-ын үед нийгмийн оюун санааны хоцрогдлыг арилган, ард нийтийг бичиг үсэгтэн болгох их ажлыг амжилттай хэрэгжүүлжээ. Улмаар утга зохиол, урлагийн үндэсний мэргэжилтэй боловсон хүчин төрөн гарч олон арван бүтээлүүд туурвижээ. 1924-1989 онд урлагийн байгууллагууд төрөлжиж, дэлхийн соёл урлагтай танилцан арга туршлагаас суралцан, бие даасан үйл ажиллагаа явуулж төлөвшин хөгжсөн байна.

Тодруулга

БНМАУ-ын соёлын хөгжлийн түүхийг судлаарай.  
 “www.youtube.com academy.mongolia”

ҮНЭЛЭЭРЭЙ

БНМАУ-ЫН СОЁЛЫН ХӨГЖИЛ

Үг бүрийг 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Ахуй үйлчилгээ
- Соёлжилт
- Урлаг соёл
- Соёлын довтолгоон

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.				Гол санаагаа ойлгов уу?		Бүтээлчээр сэтгээрэй.	
1. БНМУ-ын Засгийн газраас соёл урлагийг хөгжүүлэх чиглэлээр				2. Өнөөгийн соёлын хөгжлийн суурийг тавьсан уу?		3. “Соёлын довтолгооны үр дагавар бидний амьдралд” сэдвээр эсээ бичээрэй.	
№	Авсан арга хэмжээ	Дэвшүүлсэн зорлго	Хүрсэн үр дүн	Үндэслэл	Дүгнэлт	4. Социализмын үеийн соёл, урлаг утга зохиолын хөгжлийн талаарх ололт амжилт, сургамжийг тодорхойлоорой.	
1						5. Орон нутгийнхаа соёлын байгууллагын түүхийг судалж танилцуулаарай.	
2							
3							

Дараах чиглүүлэг асуултын дагуу багаараа судалсан зүйлээ дүгнэж танилцуулаарай.

Сонирхон судлахыг хүсэж буй зүйл юу байсан бэ?	Яагаад үүнийг судлахыг хүссэн бэ?	Гол санаагаа ойлгохын тулд хэрхэн, яаж судлав?	Ямар үр дүнд хүрэв? Юу мэдэж авав?	Үргэлжлүүлэн судлахыг хүсэж буй зүйл?

ТОЛЬ

- Андуу
- Адсага
- Үхэг
- Усны сав
- Элдээгүй арьс
- Балчир хүүхэд саатуулах хашлага

# 7

## БНМАУ-ЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨГЖИЛ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Түүхийн энэ үеийн гол ололтуудын нэг бол эрүүл мэнд, нийгмийн хамгааллын тогтолцоог бий болгосон явдал юм.

### ГОЛ САНАА


- Хүн ард эрүүлжин, нас баралт, эх нялхсын эндэгдэл дорвитой буурчээ.
- Нийгмийн даатгал, нийгмийн хамгааллын суурь тавигджээ.

### ТҮЛХҮҮР ҮГ


- Эмчлэн сэргийлэх
- Даатгал
- Вакцин
- Иргэний эмнэлэг

### ЭРҮҮЛ МЭНДИЙН АЛБА БАЙГУУЛАГДСАН НЬ

Эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагыг 1925 онд Дотоод яамны бүрэлдэхүүнд Ардын эрүүлийг хамгаалах газар нэртэйгээр байгуулж, 1930 онд бие даасан яам болгон өргөтгөсөн байна. 1925 онд тарваган тахал, халдварт өвчнийг эсэргүүцэх станцыг байгуулжээ. 1932 онд эмнэлгийн эм хангамжийн удирдах газар, төв агуулахыг байгуулжээ. 1933 онд вакцин, ийлдэс үйлдвэрлэх зорилгоор ариун цэвэр бактер шинжилгээний хүрээлэнг байгуулав. 1938 онд аймгийн захиргаадын бүрэлдэхүүнд эрүүлийг хамгаалах хэлтсүүд байгуулагдав. 1939 онд багуудад сувилагчийн хэсгүүдийг бий болгожээ. 1940 онд Улсын ариун цэврийг шалган байцаах алба байгуулагджээ. Энэ бүхний дүнд Монгол улсад эрүүл мэндийн шинэ тогтолцооны суурь тавигдаж эхлэв.



Бүдүүвч 3.4. Нэг эмчид ногдох өвчтөний тоо



Бүдүүвч 3.5. Эрүүлийг хамгаалахад зориулсан төсөв (мян.төг)

Эрүүл мэндийн салбарын хөгжилд ЗХУ-ын туслалцаа дэмжлэг чухал хувь нэмэр оруулсан. Тухайлбал, П.Н.Шастин Монгол улсын Засгийн газрын урилгаар ирж нийт 14 жил ажилласан. Тэрээр Дотоод яамны Эрүүлийг хамгаалах газарт томилогдсон, “Онцгой комисс”-ийн долоон гишүүний нэг байлаа. П.Н.Шастин Монгол улсад анагаах ухаан, мал эмнэлгийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд хувь нэмрээ оруулж хүн, малын эмч нарын “Эрдмийн эвлэл” хэмээх байгууллагын анхны тэргүүнээр ажиллаж байлаа.



**АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ**

Дараах асуултуудын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллүүдээс юу олж авснаа эргэцүүлээрэй. Үүнд:

1. Монгол улсад эрүүл мэндийн алба байгуулагдан хөгжихөд нөлөөлсөн хүчин зүйлийн талаар таамаглал дэвшүүлээрэй.
2. Нэг эмчид ногдох өвчтөний тоо, эрүүлийг хамгаалахад зориулсан төсвийн графикийг ажиглаж эргэцүүлэн ярилцаарай.
3. Дараах хүснэгтэд эрүүлийг хамгаалах чиглэлээр төрөөс баримталж байсан бодлогын гол санааг түлхүүр үгээр тэмдэглэл хийж, одоогийнхтой харьцуулан ярилцаарай

1924 он	1940 он	1960 он	1977 он
Иргэн бүр үнэ төлбөргүй		Эдийн тусламж	

**ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХЫН БОЛОВСОН ХҮЧИН**

1923 оноос бага эмчийн болон сувилагчийн курсуудыг зохион байгуулжээ. 1934 онд Хүн эмнэлгийн техникум байгуулан эрүүл мэндийн үндэсний боловсон хүчнийг эх орондоо бэлтгэж эхэлсэн байна. 1942 онд МУИС-д хүн эмнэлгийн факультет байгуулан, 1947 онд анхны 14 их эмч төгсжээ. Энэ үеэс анагаах ухааны дээд боловсролтой мэргэжилтнүүдийг бэлтгэх болов. Улмаар эрүүлийг хамгаалах болон биеийн тамирын байгууллагад ажиллагсдын тоо 1969-1989 онд 20,3 мянгаас 47,6 мянга болж 2,3 дахин өссөн байна. 1986 онд бүх аймаг нэгдэл дундын рашаан сувиллын газартай болж түүнд жил тутам 20 шахам мянган хүн амарч байв. Нэгдэл бүр жирэмсэн эмэгтэйчүүд төрөхийн өмнөх болон дараа 14 хоног амраадаг байжээ. Түүнчлэн 0-1 настай хүүхдэд олгох эмийг үнэ төлбөргүй болгож, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэгчдийн эмийн зардлын нормыг нэмэгдүүлсэн ажээ.

*Хүснэгт 3.4: Эмнэлгийн салбарын өсөлт (1987 оны байдлаар, тоогоор)*

Төрөлжсөн эмнэлэг	62
Сум дундын эмнэлэг	32
Их эмчийн салбар	329
Бага эмчийн салбар	1252
Диспансерийн тоо	60
Амбулатори, поликлиник	6
Ариун цэвэр, халдвар судлалын станц	47
Эмийн сан	528
Эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар	123
Хүүхдийн сүүний газар	276
Хүүхдийн хэсгийн эмнэлэг	425
Түргэн тусламжийн станц	44
10000 хүн ногдох их эмч	26
Эмнэлгийн дунд мэргэжилтэй ажилтан	81,3
100 хүнд ногдох хэвтэж эмчлүүлэгчдийн тоо	27,2
Нэг хүнд ногдох эмчийн үзлэг	9,8

**ЗХУ-ЫН ТУСЛАМЖ ДЭМЖЛЭГ**

Монголын эрүүлийг хамгаалах систем үүсэн хөгжихөд ЗХУ-аас үзүүлсэн тусламж, дэмжлэг чухал байлаа. Тухайлбал, 1970-1989 онд ЗХУ-ын техник-эдийн засгийн тусалцаатай Хавдар судлалын төв, Клиникийн нэгдсэн III эмнэлэг, Эх нялхсын эрдэм шинжилгээний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төвийн иж бүрдэл, Дорноговь, Сэлэнгэ зэрэг зургаан аймгийн нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж баригдан ашиглалтад оржээ. 1924-1935 онд Монголд ажиллаж байсан Петр Николаевич Шастин, Самуил Моисеевич Немой нарын гавьяа зүтгэлийг үнэлэн Архангай аймгийн нэгдсэн эмнэлгийг С.М.Немойн нэрэмжит, Улаанбаатар хотын Клиникийн нэгдсэн III эмнэлгийг П.Н.Шастины нэрэмжит болгосон нь одоо ч

хэвээрээ байна. Зөвлөлтийн эмч нар монголд ажиллахаас гадна мэргэжлийн эмч, сувилагчдыг бэлтгэдэг бүх шатны сургуулиудад багшилж байв.



Зураг 3.31. Доктор П.Н.Шастин

Монгол улс эрүүлийг хамгаалах чиглэлээр дараах амжилтад хүрсэн байна. Үүнд:

1921-1940 он

- 1940 он гэхэд үндэсний 12 их эмч, 159 бага эмч, эмнэлгийн тусгай дунд боловсролтой 38 мэргэжилтэн, 269 сувилагчтай болж, хөдөөд багийн бага эмчийн 157 салбар, аймаг, хотод 37 эмнэлэгтэй болжээ.
- 1940 он гэхэд бөөсний хижиг, цагаан цэцэг өвчин бүртгэгдэхээ больж, хүн амын тоо жил тутам 0.2-0.5 хувиар өсч эхэлжээ.

1941-1989 он

- Улс, хот, аймаг, сум, САА зэрэг суурин газрын хүн амыг их эмчийн ерөнхий мэргэжлийн тусламжаар бүрэн хангав.
- Нарийн мэргэжлийн тусламжийг хөгжүүлсэн, үндэстний мэргэжилтнүүд цээжний хөндийн, тархины мэс засал, сэхээн амьдруулахын тусламжийг үзүүлэх арга барил, ур чадварыг эзэмшсэн байна.
- Дотуур дурандалт, дүрс оношлогоо, хүний генетик, вирус болон дархлал судлалын аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлж эхэлжээ.

## НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨГЖИЛ

1941-1942 онуудад нийгмийн даатгалын дүрэм, хөдөлмөрийн тухай хууль, 1973 онд тэтгэвэрийн хуулиуд гарч, даатгалд бүх ажилчин, албан хаагчдыг хамруулав. Хүн амд үйлчлэх ахуйн үйлчилгээний олон хэлбэрийг буй болгон хөгжүүлжээ. Үүний дүнд БНМАУ-ын хүн ам нь өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, тэжээгчээ алдагчид, цэргийн албан хаагчид, олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхчүүд, ардын хувьсгалын партизан, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, улсын болон хөдөлмөрийн баатар, гавьяат алдар цолтон зэрэг хүмүүс тусгай тэтгэвэр авах болов. Мөн оюутан сурагчид, аспирант, улсын бэлтгэлийн мал туугчид зэрэг 10 гаруй төрлөөр улсын тэтгэвэрт хамрагдаж байлаа. 1970 онд өндөр настанд олгох улсын тэтгэврийн доод хэмжээ сард 150 төгрөг болжээ.



Зураг 3.32. Алдарт эх одон

БНМАУ эх, нялхсын эрүүлийг хамгаалах талаар ихээхэн анхаарч бодитой үр дүнд хүрчээ. Тухайлбал, хөдөлмөрийн хуулиар жирэмсэн эмэгтэйчүүд, нэг нас хүрээгүй буюу хөхүүл хүүхэдтэй эхчүүдийг ажлаас халж болохгүй, хөдөлмөрийн хүнд хортой нөхцөлд ажиллуулахгүй, цалингийн хэмжээг бууруулахгүй, жирэмсэн болон амаржсан эмэгтэйчүүд хүүхдээ төрүүлэхээс өмнө 45 хоног, амаржсаны дараа 56 хоног амралт эдлэх, хоёр буюу түүнээс дээш хүүхэд төрүүлсэн бол амаржсаны дараах амралтыг 70 хоногоор бодох, жирэмсэн болон олон

хүүхэдтэй эхчүүд жилд нэг удаа амралтанд 14-21 хоног үнэ төлбөргүй амрах зэрэг хөнгөлөлт үзүүлж байв. Олон хүүхэдтэй эхчүүдэд улсаас тэтгэвэр олгож, хүүхдийн тоогоор нэмэгдүүлжээ. Үүнд: эхийн төрүүлж өсгөсөн 4 дэх хүүхдэд 400 төгрөг, 5 дахь хүүхдэд 750, 6 дахь хүүхдэд 1200, 7 дахь хүүхдэд 1750, 8 дахь хүүхдэд 2400, 9 дэх хүүхдэд 3150, ихэр хүүхэд төрүүлсэн бол тус бүр 500, гурван ихэр төрүүлбэл тус бүр 1000 төгрөг олгож байв. 1952 оноос олон хүүхэдтэй эхчүүдийг “Алдарт эх”-ийн I, II зэргийн одонгоор шагнаж болжээ. 1985 он болоход 0-1 насны хүүхдэд олгох эмийг үнэ төлбөргүй болгож, эмнэлэгт хэвтэн эмчлүүлэх эмийн зардлын нормыг нэмэгдүүлжээ.

Хүн амын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авчээ. 1971-1976 онд 300 хүртэлх төгрөгийн цалинтай ажилчин албан хаагчдыг, дараах таван жилд 500 хүртэлх төгрөгийн цалинтайг ашиг орлогын татвараас бүрмөсөн чөлөөлж, 501-ээс дээш цалинтай албан хаагчдаас авах татварыг 30% бууруулжээ. 1977 онд СнЗ аймаг, сумдын бага цалинтай зарим ажилтны албан тушаалын цалингийн хэмжээг тогтоосон тогтоол гаргав. Үүнд цалингийн хэмжээг аймгийн төв ба томоохон суурин газарт 220, суманд 200 төгрөг байхаар тогтоожээ. 1981-1985 онд Эрчим хүчний үйлдвэрийн газруудын инженер-техникийн ажилтан, ЕБС-ийн дунд ангийн багш, эмнэлгийн зарим төрлийн дунд мэргэжлийн ажилтны цалинг нэмэгдүүлж, мэргэжлийн дагуу тасралтгүй ажиллаж буй МАА-н мэргэжилтэн, барилгачдад цалингийн нэмэгдэл олгож, зарим хөнгөлөлт үзүүлдэг болов. Мөн цалин дээрээ говийн нэмэгдэл авдаг мэргэжилтнүүдийн хамрах хүрээг өргөтгөв.

## МОНГОЛ ТАМИРЧДЫН АМЖИЛТ

Монголын Үндэсний Олимпийн Хороо нь 1956 онд байгуулагдав. 1964 оноос олимп, Олон улсын тэмцээнд амжилттай оролцох болжээ. Дэлхийн аваргын анхны алтан медалийг Д.Дэмбэрэл сур харваагаар 1971 онд авчээ.

Хүснэгт 3.5: Тамирчдын амжилт

Медаль	Нэр	Он	Спорт	Байр	Төрөл
2 Мөнгө	Жигжидийн Мөнхбат	1968 Мехико	Чөлөөт бөх	10	87 кг
3 Хүрэл	Чимидбазарын Дамдиншарав	1968 Мехико	Чөлөөт бөх	10	- 52 кг
3 Хүрэл	Данзандаржаагийн Сэрээтэр	1968 Мехико	Чөлөөт бөх	10	70 кг
3 Хүрэл	Төмөрийн Артаг	1968 Мехико	Чөлөөт бөх	10	78 кг
2 Мөнгө	Хорлоогийн Баянмөнх	1972 Мюнхен	Чөлөөт бөх	12	100 кг
2 Мөнгө	Зэвэгийн Ойдов	1976 Монреаль	Чөлөөт бөх	12	62 кг
2 Мөнгө	Цэндийн Дамдин	1980 Москва	Жүдо	8	65 кг
2 Мөнгө	Жамцын Даваажав	1980 Москва	Чөлөөт бөх	9	78 кг
3 Хүрэл	Нэргүйн Энхбат	1988 Сөүл	Бокс	14	60кг

БНМАУ-ын хүн амын эрүүл мэндийн үзүүлэлтүүд сайжирч, орчин үеийн анагаах ухааны арга зүйд үндэслэсэн эрүүлийг хамгаалах тогтолцоо бүрэлдэн төлөвшжээ. Мөн цалин хөлс, тэтгэвэр, тэтгэмжийн хангамж, эрүүл мэнд, асрамж, амралт, сувиллын үйлчилгээ зэрэг хүн амын нийгмийн хамгааллыг хөгжүүлэх үндсэн төрлүүд бий болжээ.





### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

Дараах асуултуудын дагуу хамтран ажиллаарай. Үүнд:

1. Эмнэлгийн салбарын өсөлтийн үзүүлэлтээр график байгуулж, өсөлтөд нөлөөлсөн хүчин зүйлийг тодорхойлно уу.
2. Эрүүлийг хамгаалах үйлсэд ЗХУ-ын үзүүлсэн тусламж дэмжлэгийн талаар ярилцаж, эрүүлийг хамгаалах салбарын боловсон хүчний хөгжилд оруулсан хувь нэмрийг дүгнэж, одоогийн хөгжлийн суурийг тавьсныг батлаарай.
3. Нийгмийн хамгааллын болон хүн амын орлогыг нэмэгдүүлэх чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, тэдгээрийн ач холбогдлыг дүгнэн ярилцаарай.

### БНМАУ-ЫН ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ХӨГЖИЛ

### ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Эмчлэн сэргийлэх
- Даатгал
- Вакцин
- Иргэний эмнэлэг

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.				Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Монгол Улсын Засгийн Газраас эрүүлийг хамгаалах болон нийгмийн хамгааллыг хөгжүүлэх чиглэлээр...				2. Өнөөгийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөгжлийн суурийг тавьсан уу?	3. Социализмын үеийн эрүүл мэнд, нийгмийн хамгааллын хөгжлийн талаарх ололт амжилт, сургамжийг тодорхойлоорой.
№	Дэвшүүлсэн зорлго	Авсан арга хэмжээ	Хүрсэн үр дүн	Үндэслэл	Дүгнэлт
1					
2					
3					
					4. Орон нутгийнхаа эрүүл мэнд, нийгмийн хамгааллын байгууллагын түүхийг судалж танилцуулаарай.

Дараах чиглүүлэг асуултын дагуу багаараа судалсан зүйлээ дүгнэж танилцуулаарай.

Сонирхон судлахыг хүсэж буй зүйл юу байсан бэ?	Яагаад үүнийг судлахыг хүссэн бэ?	Гол санааг ойлгохын тулд хэрхэн, яаж судлав?	Ямар үр дүнд хүрэв? Юу мэдэж авав?	Үргэлжлүүлэн судлахыг хүсэж буй зүйл?

### ТОЛЬ

Вакцин  
Ийлдэс  
СнЗ

Халдварт өвчин эсэргүүцэн дархлаа суулгах шингэн бэлдмэл  
Халдварт өвчин эсэргүүцэх болон хүч тэнхээ сайжруулах бэлдмэл  
Сайд нарын зөвлөл



## БУРХНЫ ШАШИН БА СОЦИАЛИЗМ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Монгол уламжлалт шашин үндэсний үнэт зүйлсийг тээгч төдийгүй монголчуудын оюун санааг эзэмдэж байсан тул эл асуудал чухал болно.

### ГОЛ САНАА

Социализмын жилүүдэд монголчуудын соёл, зан заншил, уламжлалыг олон зууны турш тээж ирсэн бурхны шашин, түүний сүм хийдүүдийг устгажээ.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Бурхны шашин
- Лам хувраг
- Үндэсний соёл
- Хэлмэгдүүлэлт
- Шашингүй үзэл



### АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ

Аливаа хурлын төлөөлөгчдийг сонгох ба төлөөлөгчдөд сонгогдох эрхгүй хүмүүс нь: Урьдын ван, гүн ба хутагт хувилгаад, жич орон хийдэд үргэлж суух санваартан лам нар”

*Монгол Улсын Үндсэн хууль., 1924., дөрөвдүгээр бүлгийн Гучин тавдугаар зүйл*

Монгол Улсад төр нь шашнаа хүндэтгэж, шашин нь төрөө дээдэлнэ.

*Монгол Улсын Үндсэн хууль., 1992., Нэгдүгээр бүлэг. 9.1*

1. Хуулийн заалтуудын агуулгыг эргэцүүлнэ үү. Ямар ялгаа байна вэ? Яагаад ялгаатай байгаа юм бол...? Шашны үзэл, сургаал өөрчлөгдсөн юм болов уу? эсвэл ...
2. Шашны талаарх өөрсдийн мэдлэг болон үзэл бодлоо хуваалцана уу.
3. Монголд бурхны шашин дэлгэрсэн түүхийг сэргээн санаж, танилцуулга хийнэ үү.
4. Бурхны шашны үзэл санаа, сургаал номлолыг судлан хэлэлцэнэ үү.

1924 оны 5 сарын 20-нд Богд хаан таалал болсны дараа МАХН-ын Төв Хорооны Тэргүүлэгчдээс Монголд бүгд найрамдах засаглал тогтоох тухай шийдвэр гаргав. Өөрөөр хэлбэл, монгол улс хаангүй байх учиртайг илэрхийлэв. Мөн оны 11 сард анхдугаар Үндсэн хуулиар бүгд найрамдах засаглалын хэлбэр болон нийт ард олны шашин шүтэх эрхийг баталгаажуулахдаа лам нарыг нийгмийн хөдөлмөрт оролцдоггүй, бусдын хөдөлмөрөөр амьдрагчид хэмээн үзэж сонгох, сонгогдох эрхийг нь хассан байна.

Энэ үеэс ардын нам, засгийн газраас бурхны шашныг шахаж хавчсан бодлого дэс дараатай авч эхлэв. 1925 оны 4 сард ардын засгийн газар Богдын Их шавийн

засаг захиргааны бүтцийг хүчингүй болгов. Мөн удалгүй МАХН-ын IY их хурлаас Богд хааны хөрөнгийг хурааж, улсын мэдэлд шилжүүлэх шийдвэр гаргажээ. 1925-1926 онд “Их эндүүрсэн үү”, “Лам, харын ялгаа байна уу”, “Инээдэмтэй бөгөөд ичгүүртэй” гэх мэт үзэл санааны хувьд шашны эсрэг чиглэсэн шог өгүүллүүд Үнэн сонинд хэвлэгджээ. Цаашид дараах арга хэмжээг авсан байна. Үүнд:

1925 онд “МАХН-ын шашин шүтлэгийн тухай гол бодлого ба товч тогтоол”: Монгол шиг “олон лам нартай улс дэлхий дээр Төвөдээс” өөр байхгүй гэж заагаад нам, төрөөс шашин, лам нарын тухайд хатуу бодлого явуулахаа ил тод зарласан байна.

1926 оны 3 сард МАХН-ын Төв Хорооны шийдвэрээр Шашны хэрэг эрхлэх газар байгуулжээ. Энэ бол хүрээ, хийдийн дэргэд төлөөлөгч суулгаж, үйл ажиллагааг хянах үүрэгтэй газар байв.

### Тодруулга

“Богдын зэрэг хутагт, хувилгаадыг залж тодруулах хэмээхийг бүрмөсөн зогсоохоос гадна энэ тухайн учрыг олон ардад тусгайлан ухуулж тайлбарлан таниулах явдлыг чухал болговоос зохино”

Улсын 5  
дугаар их хурлын  
тогтоолоос, 1929 он

Богд хаан таалал болсноос хойш Богдын хойт дүрийг залах тухай асуудал сүсэгтэн олон, лам нарын дунд ихээр гарах болов. Энэ талаар мэдсэн Коминтерн захидал ирүүлж түүндээ “Богд гэгээний хойт дүрийг дахин тодруулахаар оролдон буй ажээ. Энэ мэт явдлыг үндсээр устгахын аргыг эрүүлэхийг хичээвээс зохино... Лам нарын зүгээс энэ мэт хэрэг явдал гаргадаг нь урьдын лам ноёдын байдлыг хэвээр сэргээхийг хүссэнээс өөр зүйлгүй” хэмээн зааварлав. Тэрхүү зааврын дагуу нам, засаг 1926 оны 9 дүгээр сард Шашныг төрөөс тусгаарлах тухай хууль батлав. 1928 онд хуралдсан МАХН-ын 7 ба Улсын 5 дугаар их хурлаас VIII Богд Жавзандамба хутагт болон бусад хутагт хувилгаадын “хойт дүрийг” залж тодруулах явдлыг бүрмөсөн хориглосон байна.

Ардын төр Монголын нийт ард түмний улс төрийн ба ангийн ухамсар мөхөс, тэдний дунд шашны нөлөө багагүй хүчтэй байгааг харгалзан, VIII Богдын “хойт дүрийг” залахыг шууд татгалзах шийдвэр гаргаагүй юм. Харин хуучин заншил ёсоор Төвөдийн Далай ламаас асууж гүйцэтгэнэ хэмээн цаг хожин, хойшлуулж байсаар эцэстээ хуулиар хориглосон байна. ЗХУ-д 1928 оноос “шашны эсрэг тэмцэл бол социализмын төлөө тэмцэл мөн” гэсэн уриан дор шашны эсрэг тэмцэл хүчтэй явуулж эхэлснийг Монголын удирдагчид шууд хуулбарлан дуурайв. Энэ үеэс Монголд шашин, сүм хийдийг эрс үгүйсгэх хандлага хүчтэй болж, сүм хийдийг албадан хаах, их хэмжээний албан татвар ногдуулах болов. Хүн амын дунд шашингүй үзлийг хүч түрэн түгээхийг зорьж байв.

### Тодруулга

“Төрөөс Монголын ард түмний эв нэгдэл, соёл иргэншлийн түүхэн уламжлалаа эрхэмлэхийн үүднээс Монгол улс дахь буддын шашны зонхилох байр суурийг хүндэтгэн үзнэ. Энэ нь иргэд бусад шашин шүтэхэд саад болохгүй”

“Төр сүм хийдийн харилцааны тухай хууль”  
дөрөвдүгээр зүйл, 1993 он

Тодруулга


“Танайд улсын дотор улс байгаа байдалтай болжээ. Нэг засгийн газар нь Гэндэнгийн засгийн газар, нөгөө нь лам нарынх. Гэхдээ лам нарын засгийн газар нь хүчтэй байна” хэмээгээд лам нартай “ажмаар тойруу замаар тэмцэх хэрэгтэй. Гэндэнгийн засгийн газар лам нарынхаас хүчтэй байх хэрэгтэй. Лам нарыг өөрийн гарт хатуу авах хэрэгтэй”

И.В.Сталин



Зураг 3.28. В.И.Сталин (1878-1953) ЗСБНХУ-ын ардын комиссаруудын Зөвлөлийн дарга, Зэвсэгт хүчний дээд командлагч, Батлан хамгаалах улсын хорооны дарга, ЗХУ-ын генералисмуc

Бүдүүвч 3.6. Бурхны шашны эсрэг үйл ажиллагаа



ЗХУКН-ын Төв Хорооны Улс Төрийн Товчооны 1935 оны 11 сарын 34-р тогтоолд: “Лам нарын хувьсгалын эсэргүү байгууллага нь Монголын олон улсын байдал хурцдах тусам төдий чинээ хүчтэй болж Японы булаан эзлэгчдийн талд өөрийн ард түмнээс урвагчид болох тул лам нартай хийх тэмцлийг сулруулахгүй байхыг Монгол удирдлагад зөвлөх хэрэгтэй” гэж заагаад Сталин гарын үсэг зурсан байна.

1937 оны 12 сарын 27-нд МАХН-ын Төв хорооны Тэргүүлэгчдийн хурлаас тогтоол гаргаж, Монголын сүм хийдүүдийн гол төв болсон Гандантэгчэнлин хийд, Богд хааны зуны ордон, Дэчин галбын дацан, Очирдарын сүмийн үйл ажиллагааг зогсоов. Гандангийн барилга, эд хөрөнгийг улсын санд хураав. 1911-1913 онд сүсэгтэн олны хандиваар бүтээсэн 80 тохой өндөр Мэгжид Жанрайсиг бурхныг монголд байсан ЗХУ-ын цэрэг, техникийн хүчээр буулган улмаар ЗХУ-ын цэргийн үйлдвэрийн газарт шилжүүлсэн байна. Улмаар 1937 оны аравдугаар сард байгуулагдаж, хоёрхон жилийн дотор хэдэн арван мянган хүмүүс, түүний дийлэнх нь лам нарыг хөнөөсөн билээ. Тэрхүү онцгой комиссын даргаар Х.Чойбалсан томилогдож, гишүүдэд Д. Лувсаншарав, Б.Цэрэндорж нар багтсаны зэрэгцээ орос



Зураг 3.34. Нурсан сүм, хийд хүүхдийн тоглоом болов. 1937 онд улаантнууд Монголын ард түмний таван зууны турш бүтээн байгуулсан 800 шахам буддын сүм хийд, 3000 буддын дацанг нурааж устгав.

### Тодруулга

XX зууны эхэн үеийн байдлаар гэхэд бурхны шашин дэлхийн бүх шашинтны 40 %, христос 26 %, мусульман 12.5 % эзэлж байжээ. Бурхны шашны гол номлол сургаал, түүний үзэл санааны үндсэн чиглэлийн талаар товч танилцуулбал, Бурхан багш өөрийн шашныг ийн товчлон айлдсан байдаг.

1. Нүгэл хилэнц үл үйлдэх
  2. Буяныг асар ихээр эдлэх
  3. Өөрийн сэтгэлийг номхон байлгах
- Цааш нь задалбал хилэнц буян, сэтгэл номхотгох гэгч нь дотроо олон задарч Бурхны шашны үндсэн номлол сургаалыг загварчлан үзүүлсэн тайлбар гарч ирнэ. Бурхны шашин нь энэрэнгүй, хүмүүнлэг шашин болно.

<http://www.budda.mn/news/515.html>

сургагч И.И.Васильев онцгой үүрэгтэй оролцож байв. Энэ шүүн таслах онц бүрэн эрхт комиссын шийдвэрээр улс төрийн хэргээр хэлмэгдэгсдийн 55.7 хувь нь лам нар байжээ.

1937 онд Дотоод явдлын яамны сургагч Кичиковын удирдлагаар Гандан хийдийн толгой лам нарын нарийн бүртгэл гаргаж, “лам нар бол ангийн хувьд дайсан, эднийг устгах хэрэгтэй, тиймээс заавал эсэргүү хэрэг хүлээлгэх ёстой” гэдэг шаардлагыг баримтлан ажиллаж байжээ. Энэ үед “Шашин бол хүмүүсийн ухамсрыг хордуулагч төдийгүй хүмүүсийн эрүүл мэндийг хордуулан, эмгэг өвчнийг тэтгэн тэжээгч” хэмээн шашныг буруутган, шашингүй үзлийг сурталчлах явдал Монгол даяар өрнөж байлаа. Лам нарыг бөөнөөр нь барьснаас шоронд багтахгүй болов. Иймээс мяндаг тушаалтай, олон шавьтай, ном гүрэм уншдаг нөлөө бүхий лам нарыг хамгийн түрүүнд сонгон, нэг явахдаа 2-3 машин дүүрэн хүн авч явж бууддаг байжээ.

1944 оны 6 сарын 1-ний өдөр төрийн хатуу хяналтын дор Ганданд мөргөлийн ганц дуган арван ламтай, хоёр манаачтайгаар үйл ажиллагаагаа сэргээсэн байна. Зарим мэдээгээр Зөвлөлтийн удирдагч Сталины заавраар сэргээсэн гэдэг бол зарим нь АНУ-ын дэд ерөнхийлөгч Хенри Уэлсийг Монголд ирэхэд ардчилал, шүтэх бишрэх эрхийг хааж боогдуулаагүйг харуулах зорилгоор байгуулсан гэдэг.



### УНШААРЙ, ОЙЛГООРОЙ

1. Тодруулга болон мэдээллийн агуулгыг тайлбарлаарай.
2. 1925-1930-аад оны дунд үе хүртэл Монголын нам төрийн зүгээс шашны талаар явуулж байсан бодлого, үйл ажиллагааг дүгнэн бичээрэй.
3. “Монголын шашны бодлого ба ЗХУ” гэсэн сэдвийн хүрээнд хэлэлцүүлэг хийгээрэй.



Монголын 800 шахам сүм хийдийн 71.0 тонн алт, мөнгө, гуулин бурхад, эд зүйлсийг Зөвлөлт улсад шилжүүлсэн байна. 1924 онд Монголд 112.0 мянган буддын лам хуврага байсан бол, 1937 онд лам нарын олонхийг егүүтгэж үлдсэнийг нь шоронд хорьж заримыг нь хвчээр хар болгов.



Зураг 3.35. 1937 онд хаагдсан Мэжид Жанрайсиг шүтээнийг 1991-1996 онд дахин бүтээжээ.

Төрөөс шашны талаар явуулсан бодлого, үйл ажиллагаа хэдэн зууны турш бүтээсэн Монголын түүх, соёл, уран барилгын өв соёлд сүйрэл авчрав. Монголын нийгмийн оюун санааны амьдрал, шашин суртахуун, уламжлалт зан заншилд асар их гарз хохирол учирсан байна. Хэлмэгдүүлэлтийн он жилүүдэд олон зууны турш бүтээгдэн хадгалагдсан, түмэн олныг соён гэгээрүүлэхэд ач тусаа өгч байсан шашны олон сүм хийд, нандигнан хайрлаж, шүтэж ирсэн шашны ховор ном судрууд, бурхад зэрэг олон мянган үнэт зүйл үгүй болсон юм.



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Дараах асуултын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллээс юу олж авснаа эргэцүүлээрэй. Үүнд:
  - а. Бурхны шашны талаар таны өөрийн бодол, хандлага
  - б. Социализмын үед бурхны шашны талаар баримталсан:
    - бодлого
    - түүний үр дагавар
    - сургамж
2. Буддын шашны сургаал зан үйлээр дамжин хадгалагдсан монголчуудын зан заншил, уламжлалыг сурвалжлан ярилцана уу.
3. Наян тохой Мэгжид Жанрайсиг бурхны түүхийг сэргээн судлаарай. Монголчууд яагаад энэ бурхныг хоёр удаа сэргээн босгосон бэ?

### ҮНЭЛЭЭРЭЙ

### БУРХНЫ ШАШИН БА СОЦИАЛИЗМ

Үг бүрийг 1-2 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- |                 |                 |
|-----------------|-----------------|
| • Бурхны шашин  | • Хэлмэгдэл     |
| • Лам, хувраг   | • Шашингүй үзэл |
| • Үндэсний соёл |                 |

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Социализмын жилүүдэд бурхны шашны талаар авсан арга хэмжээ, тэдгээрийн үр дагавар, сургамжийг ярилцана уу.	2. Лам нарыг яагаад хэлмэгдүүлсэн бэ? Тэд хэнд, ямар төвөг учруулав.	3. Анги хамт олноороо орон нутгийнхаа сүм хийдээр танилцах аялал хийгээрэй. 4. Бурхны шашны сургаалыг бие даан судлаад, танилцуулаарай. 5. “Бурхны шашин, социализм хоёр” сэдвээр эсээ бичээрэй.

## ЛАМ НАРЫН “ЭСЭРГҮҮ БОСЛОГО”

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Нам, төрийн буруу бодлогоос үүдэж лам, хар олныг хамарсан хөдөлгөөн, бослого 1930-аад онд монгол даяар дээдсэн юм. Энэ бол Монголын түүхэнд сургамж болохуйц том үйл явдал мөн.

### ГОЛ САНАА

1932 онд гарсан социализмыг эсэргүүцсэн бослогыг “лам нарын эсэргүү бослого” хэмээн буруутгаж иржээ. Энэ бол тухайн үеийн нам, төрийн бодлогыг эсэргүүцсэн томоохон үйл явдал байлаа.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Дүрвэлт
- Бослого
- Ангийн тэмцэл
- Түүхийн сургамж



### АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ



Зураг 3.36.  
Дүрвэгсэд  
1930-аад оны  
эхээр

1. Гэрэл зургаас 1930-аад оны хүмүүсийн хувцас хэрэглэл, өмсгөл зүүсгэлийн талаар ямар мэдээлэл авч байна вэ?
2. Эдгээр зураг ямар түүх өгүүлж байна вэ?
3. 1930-аад оны Монгол орны, монголчуудын байдлыг төсөөлөөрэй



Зураг 3.37. Бослогын толгойлогчидыг шүүж байгаа нь

Зүүнтний алдаатай бодлогын үрээр хөрөнгө мал төдийгүй бурхан шүтээнээ хураалгаж, мал сүргээ хамтралжуулж сэтгэл санааны хувьд айж балмагдсан, эгдүүцэж дургүйцсэн ард олны эсэргүүцэл янз бүрийн хэлбэрээр илэрч байлаа. 1930 оны эцсээс Өмнөговь, Алтай зэрэг аймгаас айл өрх, ард олноороо оргож хил даван нүүх, дүрвэх болов. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Өлзийт сумын гишүүн Сэнгэлдэрээс 1931 оны 8 сард ирүүлсэн мэдээнд өгүүлэхдээ: “Өнгөрсөн намар цаг Өвөрхангайн баруун хилээс Очив нар хэмээх тэргүүлэн үлэмжхэн тооны ажил хөрөнгийн хамтаар оргосон. Эдүгээ бас л олон өрх айл оргосон бөгөөд замд тохиолдсон хоршооны салбар, хамтрал, нөхдийг дайчлан барин авч алах талах

зэрэгт хүргүүлэх ба мөн тэдний хэлэх нь танай өнөөх хэдэн орос чинь ирж тавьмой хэмээхийн хамт феодалын хөрөнгийг тэд нар ингэж хураасан бол бид нар одоо ингэж хураадаг юм хэмээхийн дээр танай муусайн мухар толгойтнуудыг хүйс тэмтрэн арилгана хэмээх лоозонг тавьж явсныг нутгийн ардууд цуурхаж байна” гэжээ.

Ард олны дотор бухимдал үүсч, хөдөлгөөнд орсон энэ үед нам, засгаас ангичлан ялгаварлах бодлогоо хатуу баримталж байсан явдал нам төрийн бодлогыг эсэргүүцсэн зэвсэгт бослого гарах үндэс болжээ. Улаангом, Төгсбуянтын хүрээнд лам нарын бослого 1930 онд гарч, түүнийг дарах комиссыг Намын Төв Хорооны нарийн


бичгийн дарга Элдэв-Очироор тэргүүлүүлэн илгээжээ. Улмаар “Улаангом ба Төгсбуянтын хошуудыг цэргийн байдалтай болгомой” “Төгсбуянтын эсэргүүцлийг өдүүлэгч ба удирдагч нарыг харьяа нутгийн албан газраар илэрхийлэн авч мөн тэрхүү хөдөлгөөн дор оролцож бүхий нам эвлэлийн гишүүдийн хамт буудан цаазалмой” хэмээн босогчдын удирдагчдыг олны өмнө буудан алах зөвшөөрлийг Элдэв-Очир тэргүүтэй комисст өгсөн байна.

### Тодруулга

1932 оны дунд үе хүртэл үргэлжилсэн энэхүү дүрвэх хөдөлгөөнд БНМАУ-ын хилийн дагуу орших засаг захиргааны одоогийн Ховд, Баян-өлгий, Говь-Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Дорноговь, Дундговь, Дорнод, Өмнөговь, Хөвсгөл аймгууд хамрагдсан байна. Эндээс үзвэл хил даван дүрвэх явдал хил залгаа бараг бүх аймгийг хамарсан хөдөлгөөний хэлбэртэй байжээ. Дүрвэгсдийн дотор лам, хар феодал агсад, нам, эвлэлийн гишүүд хүртэл оролцсон байв. Бүрэн бус мэдээгээр нийтдээ 7542 өрх айл буюу дунджаар 30 мянга гаруй хүн дүрэвсэн нь мэдэгдэж байна.



Зураг 3.38. 1932 оны бослого гарсан Хөвсгөл аймгийн газар зүйн зураг



1932 оны 4 сарын 11-нд Хөвсгөл аймгийн Рашаант сумын Хялганатын хүрээний 10 орчим лам нар тэр хавийн шинэ хар болсон хүмүүстэй нийлж нэгэн зуу гаруй хүн зэвсэгт бослого эхэлжээ. Тэд Хялганатын хүрээний орчмоос 60 шахам километр зайтай орших Рашаантын Тарва бандидын хүрээнд 4 сарын 12-13-нд ирж, замд тааралдсан бүгдийг сүйтгэж, хүмүүсийг

дайчлан тоогоо олшруулсаар байжээ. Босогчид Рашаантад ирээд “Очирбатын цэргийн яам” гэгчийг байгуулан өөрийн тамга, тэмдэг, өөрийн сахиус, банз шаахайтай болжээ. Босогчдыг “шар цэрэг” гэж нэрлэв.



*Зураг 3.39. Ж.Лхүмбэ. Түүнд "Японы эсэргүү байгууллагын толгойлогч" хэргийг тулгаж ЗХУ-д аваачин байцаасан боловч хэрэг хүлээлгүй бүтэн жил болсны дараа 1934 оны 6 сард буудан хороожээ.*

Энэ зэвсэгт бослого гарсан тухай мэдээллийг үндэслэн 1932 оны 4 сарын 14-нд МАХН-ын ТХ, Засгийн газраас бослогыг дарах тухай шийдвэр гаргаж, Ж.Лхүмбэ даргатай засгийн газрын бүрэн эрхт комиссыг томилжээ. БНМАУ-ын Бага хурал, засгийн газрын товчооны Тэргүүлэгчдийн 1932 оны 4 сарын 17-ний өдрийн хамтарсан хурлын тогтоолд "эсэргүү хөдөлгөөнийг газар авахуулахгүй цохиж, хор аюулыг нийтэд таниулахын тулд Ж.Лхүмбэ тэргүүнтэй Ц.Гиваапил (Дотоодыг хамгаалах газар), Санжмятав (цэргийн), Г.Цэдэн-Иш (Эвлэлийн Төв Хороо) нарын таван хүнтэй комиссыг шүүн таслах эрх хэмжээтэйгээр томилжээ.

Бослого Хөвсгөл, Архангай, Өвөрхангай, Завхан, Говь-Алтай зэрэг монголын бараг бүх аймгийг хамарсан зэвсэгт тулалдаан хийж, түүнд лам, хар нийлсэн хэдэн арван мянган ард иргэд хамрагджээ. Энэхүү зэвсэгт бослогын уршгаар олон хүний амь эрсдэж улс оронд ихээхэн хэмжээний хохирол учирсан юм. 1932 оны бослогыг Монголын түүх бичлэгт саяхан болтол "лам нарын эсэргүү бослого" гэж нэрийдэж байв. Бослогын толгойлогчдыг шүүх хурал 1932 оны 4 сарын 19-30-нд болж, 18 хүнийг цаазаар авч, 15 шүүгдэгчдэд хорих ял оноожээ.

Зэвсэгт бослого гарсан шалтгаан:

- Хувийн худалдааг хязгаарлаж, ардын аж ахуйтны өмч хөрөнгийг ноёдын хөрөнгөтэй адилтгаж хураасан;
- Ард олныг хамтралд хүчээр албадан оруулсан;
- Лам нарыг хүчээр хар болгосон, шашин шүтлэгийг мөрдөж мөшгисөн зэрэг зарим тохиолдолд үндсэн хууль зөрчсөн гэмт хэргийн шинжтэй алдаа, нугалаануудыг удирдах албан газрууд, орон нутаг дахь түүний төлөөлөгчдөөс гаргаж байсан явдал юм.

Зөвлөлтийн нам, төр, Коминтерноос ирүүлсэн заавар ёсоор БНМАУ-ын ХҮИ онц бага хурал (1932 оны 7 сар)-аар тухайн үеийн нам, төрийн удирдагчид дээрх алдаагаа хүлээн зөвшөөрч, хувьсгалын эсэргүү бослогод оролцсон хэргээр баригдан мөрдөгдөн буй томоохон феодал, лам, нарын зэрэг толгойлогчдоос бусад иргэдийг суллажээ. Мөн хөрөнгө хураах асуудлаар баригдсан феодалуудыг суллах, мөн цаазлах ял заагдсан боловч тушаал нь хэрэгжээгүй хүмүүсийн ялыг 10 жилээр солих тухай өршөөлийн тогтоол гаргаж байжээ.

Монгол улсад гарсан ард олны эсэргүүцэл, ардын бослого нь ЗХУ-ын бодлогыг механикаар хуулбарласан, бүр тодруулбал коммунизмын үзэл санааг монголчууд хүлээж аваагүйгээс үүдэлтэй юм. Энэ үйл явдлын үр дүнд оросууд монголчуудад социализм байгуулахыг улайран тулгаж байснаасаа түр боловч ухарчээ.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

Дараах асуултын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллээс юу олж авснаа эргэцүүлээрэй. Үүнд:

- Эсэргүүцэл хөдөлгөөн болон бослого гарсан газруудыг газар зүйн зурагт тэмдэглэнэ үү. Танай орон нутагтай холбогдож байна уу?
- Тэмцэгчид юуг, яагаад эсэргүүцэж байв?
- Үйл явдалтай холбоотой түүхэн хүмүүс болон он цагийг тогтооно уу.
- Эсэргүүцлийн хөдөлгөөн, бослогын үр дагаврыг тодорхойлно уу.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### ЛАМ НАРЫН “ЭСЭРГҮҮ БОСЛОГО”

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Дүрвэлт
- Бослого
- Ангийн тэмцэл
- Түүхийн сургамж

<i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i>	<i>Гол санаагаа ойлгов уу?</i>	<i>Бүтээлчээр сэтгээрэй.</i>
1. 1930-аад оны социализмыг эсэргүүцсэн ард олны хөдөлгөөн ямар хэлбэрээр, хэрхэн өрнөж байсныг хүснэгт, бүдүүвч зэргээр илэрхийлнэ үү. 2. Мөн эдгээртэй холбоотой түүхэн хүмүүс, газар нутгийн нэрийг сэргээн санаарай. Гол он цагуудыг тэмдэглэсэн он тооллын шугам хийгээрэй.	3. Ард олны хөдөлгөөн, бослого тэмцэл гарах болсон учир шалтгаан болон үр дагаврыг тодорхойлно уу. 4. Монголын түүхэн дэх “зүүнтний бодлого” ба ард олны эсэргүүцэл хоёрын холбоо уялдааг тодруулсан 3-5 өгүүлбэр бичээрэй.	5. 1932 оны үйл явдлыг “лам нарын эсэргүү бослого” хэмээн буруутгаж байснаа “энэ бол тухайн үеийн нам, төрийн бодлогыг эсэргүүцсэн томоохон үйл явдал” хэмээн үзэх болсны учрыг тайлбарлана уу.

## ТОЛЬ

- Бослого: Хэсэг бүлэг хүмүүс төр засаг буюу тодорхой хүмүүсийн эсрэг тэмцэхийг хэлнэ.
- Ангийн тэмцэл: Хүмүүсийг нийгмийн байдал болон бусад зүйлээр ялгаварлан гадуурхаж тэдний эсрэг явуулж буй бодлого, үйл ажиллагаа.



**СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ**

Түүх судлахын нэгэн учир холбогдол нь түүнээс сургаамж авч, ирээдүйдээ бүтээх билээ. Өөрөөр бодож сэтгэж, өөрөөр хийж бүтээснийхээ төлөө хэн ч хэлмэгдэх ёсгүй.

**ГОЛ САНАА**

Монголоо гэсэн үндэсний үзэлтэй дээдэс, ноёд, лам хувраг, төрийн түшээдийг олноор нь хоморголон зайлуулсан хэлмэгдүүлэлтийн сүүдэр Монголын түүхэнд хар толбо үлдээсэн юм.

**ТҮЛХҮҮР ҮГ**

- Хэлмэгдүүлэлт
- Онцгой бүрэн эрхт комисс
- Улс төрийн хилс хэрэг
- Цагаатгал
- Түүхэн сургаамж



**АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ**

“Халуун итгэл цөхөрсөн  
Хатан зүрх шархирсан  
Хар дарсан жилүүдийг  
Хамаг монголчууд бүү мартаг”

*Хэлмэгдэгсдийн хөшөөний бичээс*



Зураг 3.40. Хэлмэгдэгсдийн хөшөө


1. Юуг, яагаад “Халуун итгэл цөхөрсөн, Хатан зүрх шархирсан”-тай зүйрлэв?
2. Хэлмэгдүүлэлтийн тухай мэдлэг, мэдээллээ хуваалцана уу.
3. Энэ үеийн улс орны байдал, хүмүүсийн дүр төрхийг төсөөлнө үү. Ямар мэдрэмж, сэтгэгдэл төрж байна вэ?



**УНШААРЫ, ОЙЛГООРЫ**

Хэлмэгдүүлэлт бол монголын түүхэнд үлдсэн хар толбо юм. 1937 оны 9 дүгээр сарын 10-ны өдөр Монголын төр, цэргийн нөлөө бүхий 14 хүнийг хилс хэрэгт холбогдуулан цаазалсан байна. Иймээс монголчууд бид жил бүрийн 9 сарын 10-ны өдрийг Улс төрийн талаар хэлмэгдэгсдийн дурсгалын өдөр болгон тэмдэглэж буй билээ. Монголын түүхэн дэх хэлмэгдүүлэлтэд төрийн түшээд, цэргийн дарга, тайж ноёд, лам нар, сэхээтэн, намын гишүүд, энгийн иргэд зэрэг нийгмийн бүх давхаргыг хамарсан байдаг. Энэ аймшигт үйл явдлын хамгийн гашуун үр дагавар бол нийт ард олныг ангичлан ялгаварлах, хүн хүндээ үл итгэх явдал дээд цэгтээ хүрч энэ нь олон жил үргэлжилсэн явдал юм. Улс төрийн хилс хэрэгт баривчлагдсан хүн өөрөө егүүтгэгдээд зогсохгүй, түүний ар гэр, ахан дүүс, төрөл төрөгсөд, найз нөхөд, нутаг усныхан хэлмэгдүүлэлтэд өртөж байв. Тэднийг нийгэмд эзлэх өөрийн гэсэн байр суурьгүй болгож, ирээдүйдээ итгэлгүй, амьдралын баталгаагүй болгон хөсөр хаях явдал тухайн үед түгээмэл үзэгдэл болсон юм.

Бүдүүвч 3.7. Хэлмэгдүүлэлт



Зураг 3.41. Х.Чойбалсан (1895-1952 он)

1939-1952 онд БНМАУ-ын Ерөнхий сайд, МАХН-ын ТХ-ны тэргүүлэгч гишүүн, Дотоод, Гадаад болон Цэргийн яамны сайд зэрэг алба хашиж байв. Улсын маршал.

1921 онд Саж лам тэргүүтэй хэсэг хүмүүсийг баривчилснаар эхэлсэн энэ хэлмэгдүүлэлт Монголын түүхийн бараг нэг үеийг хамарсан юм. Саж ламын хэргийн дараа 1922 оны 8 сард улаантнууд Ерөнхий сайд асан Бодоо, Дотоод яамны сайд асан Да лам Пунцагдорж, түр засгийн газрын Ерөнхий сайд асан Чагдаржав нарыг хилс хэрэгт гүтгэн буудан хороов. 1924 оны 8 сард Ерөнхий сайдын орлогч С.Данзанг “Монгол эх орноо улаан Оросын нөлөө, үзэл суртлаас ангид байлгах, эх орноо Швейцарь лугаа гурав дахь орон мэт төвийг сахин хөгжүүлэх, хөрөнгө өмчийн харилцааг чөлөөтэй хөгжүүлэх” гэсэн эрмэлзлэлийнх нь төлөө буудан хороожээ.

1928 онд хуралдсан МАХН-ын VII их хурлын дараа нийгэм журам байгуулах зорилт тавьж, ноёд, тайж, лам хуврагуудыг феодал хэмээн зарлаж, тэдний хөрөнгийг хураах, шахаж хавчих бодлогоо улам хвчтэй болгов.

1937 оны 10 сарын 2-ны өдөр байгуулагдсан Х.Чойбалсан даргатай Онцгой бүрэн эрхт комисс 1939 оны 4 сарын 15-ныг хүртэлх хугацаанд 50 удаа хуралджээ. Уг комисс улс төрийн хэрэгт баривчлагдсан 25824 хүнийг хувьсгалын эсэргүү, гадаадын тагнуул хэмээх хэргээр таслан шийдвэрлэснээс 20474 хүнийг буудан алах, 5103 хүнийг 10 жил, 240 хүнийг 10 жил хүртэл хугацаагаар хорих ялаар шийтгэжээ.

Х.Чойбалсан 1936 онд Дотоод явдлын яамны сайд, 1937 онд Цэргийн яамны сайд болж бүх эрх мэдлийг гартаа авсны дараа улаан хядлага

Тодруулга

Оросын олон нийтийн “Мемориал” байгууллагын тооцоогоор 1917-1985 онд Орос оронд 10-12 сая хүн улс төрийн хэлмэгдүүлэлтэд өртсөн. Тухайн үеийн ЗХУ-ын Дотоод явдлын яамны сайд Ягодагийн зуслан Бутово дахь буудлагын талбайд олон үндэстний 70000 гаруй хүнийг хилс хэрэгт буудан хороосны дотор Ерөнхий сайд А.Амар, П.Гэндэн, Улсын Бага Хурлын дарга Д.Догсом, МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Д.Лувсаншарав зэрэг Монголын төр засаг, цэргийн зүтгэлтэн хэдэн зуун иргэн алтан амиа алдсан ажээ.

буюу их хэлмэгдүүлэлтийн ажлыг гардан зохион байгуулав. Тэрээр 1937 онд ЗХУ-ын Дотоод хэргийн комиссар Ежовт бичсэн албан захидалдаа “1937 оны эхээр бид 1600 лам хуврагийг баривчилж, чангаар шийтгэв. Чойбалсан миний бие буддын лам нарыг устгах ажлыг эрчимтэй явуулахыг өөрийн ариун үүрэг болгоно” хэмээжээ. 1934 онд улаантнууд буриадуудыг “цагаантны үлдэгдэл, японы тагнуул” хэмээн нэр зүүж, Хэнтийн бүлэг, Дорнодын бүлэг хэмээх улс төрийн зохиомол хэрэг үүсгэж хэдэн зуун хүнийг буудан хороов. 1937 оны 9 сарын 10-ны шөнө Х.Чойбалсан даргатай комиссын шийдвэрээр 14 хүнийг цаазлав. ЗХУ-ын Дотоодыг хамгаалахын төлөөлөгч Фриновский гэгч Монголд ирж “Заговор-хуйвалдаан” гэгч улс төрийн зохиомол хэрэг дэгдээж, ямар ч гэмгүй 115 монгол хүнийг нэг шөнө баривчилж, буудан хороов. 1932-1938 онд Улсын бага хурлын гишүүн Дарьсүрэн МАХН-ын Гадаад харилцааны гишүүн Долгоржав Хошуу дарга Д.Дунгаржид, Жанжин Дэмидийн гэрч Богдановын Навчаа, Богдановын Зина, Магсарын Дулмаа, Богд хааны суулчийн хатан Наваан Лувсангийн Гэнэпил нарын 7 эмэгтэйг цаазаар авсны 2 нь жирэмсэн байсан.



Зураг 3.42. БНМАУ-ын Ерөнхий сайд асан Пэлжидийн Гэндэн 1936 онд ЗХУ-д нутаг заагдан байхдаа эл захидлыг бичсэн бөгөөд тэрбээр 1937 оны 11 сарын 26-ны өдөр хилс хэргийн улмаас цаазлагдсан билээ.

*Гэндэнгээс Амарт бичсэн захидлаас*

...Өчүүхэн мунхаг би дөчин хэдэн жил оршсон зах хязгаар нь үзэгдэхгүй их шар тал нутаг ба сэргэлэн шар нар салхины цэвэр амьсгал болон мөн элэг махны садан салбар хийгээд та их баригчид удирдагчдаас ёслон салсаар нэгэн жил хагас болов...

Ер нь миний санаанд өөрийн орны эртний хуучин бүдүүлэг үгэнд хүний газар нэрээ, өөрийн газар ясаа хэмээгчийг хэдий бүдүүлэг боловч туйлын зүйтэй бөгөөд сайхан сургаал хэмээн урьд ч боддог, одоо ч бодож байна, үүнээс хойш ч бодно.

Би ийм эрх чөлөөгүй байх нь ямар учиртай юм бэ.

Миний бие Монголын хөрөнгийг хулгайлан завшсан буюу санаатайгаар бүрэлгэн сүйтгэсэн зүйл үгүй ба мөн монголын үндэсний тусгаар тогтносон байдлыг устгахаар гадаад дотоодын харгис нартай ам ба бичгээр сүлбэлдсэн зүйл үгүйн дээр тагнуул болон бүлэглэн худалдахыг оролдсон зүйлүүд үүнээс урьд ч байхгүй, үүнээс хойш ч гарахгүйг би ойлгоно.

Монгол Улсын үндэсний тусгаар тогтносон байдал хөдөлшгүй мандах болтугай.

*Ёслогч гээгдэн жигшигдсэн тэнэг Гэндэн мөн 1937.6.14*

Улс төрийн их хэлмэгдүүлэлтийн уршгаар БНМАУ-ын хууль тогтоох дээд байгууллага Улсын Бага Хурал, эрх баригч МАХН-ын удирдах байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах бүрэлдэхүүнгүй болтлоо хядлагад өртөж, Монгол оронд улс төрийн дарангуйлах дэглэм хуваарьгүй ноёрхох болсон юм.

Хэлмэгдүүлэлт 1960-аад онд үргэлжилсэн бөгөөд Монголын шинэ үеийн сэхээтнүүдийн эсрэг хандаж, тэдний үндэс угсаагаа сэргээх эх оронч үзлийг мохооход чиглэжээ. Энэ үед Д.Дамба, Д.Төмөр-Очир, Ц.Лоохууз, Б.Сурмаажав, Х.Нямбуу, Л.Цэнд тэргүүтэй олон сэхээтнүүдийг “үндсэрхэг үзэл гаргалаа, Марксизм-Ленинизмын жанжин шугамаас ухарлаа” хэмээн хэлмэгдүүлсэн юм. 1964 онд МАХН-ын Бүгд хурал дээр Ю.Цэдэнбал болон түүний тойрон хүрээлэгчдийн алдаа завхралыг шүүмжилж, эх орноо хөгжүүлэх санал гаргасан Ц.Лоохууз, Х.Нямбуу, Б.Сурмаажав нарыг “намын эсрэг бүлэглэл” хэмээн улс төрийн зохиомол хэргээр ял тулгав. Ц.Лоохуузыг хөдөө хоньчин болгож, Б.Сурмаажавыг Бэрхийн уурхайд ажилчин болгожээ. Намын эсрэг бүлэглэлийн хамсаатан хэмээн тэдний

найз нөхөд, эхнэр хүүхдийг нь хвртэл ажил, сургуулиас нь гаргаж хөдөө цөлж байв. 1962 онд Д.Төмөр-Очирыг Чингис хааны 800 жилийн ойг тэмдэглэж, үндсэрхэг үзэл гаргав хэмээн бvх албан тушаалаас нь буулгаж, мөн нутаг заав. Ийнхүү Монгол дахь улс төрийн хэлмэгдүүлэлт эхэн үедээ алан хядах замаар хэрэгжсэн бол дараагийн үедээ төрхөө өөрчлөн нам захиргааны арга хэмжээ авч шийтгэх, нэр төрийг нь гутаах, үзэл бодлоор хавчин гадуурхах зэрэг хэлбэрт шилжсэн юм.

### Тодруулга

1998 оны 1 дүгээр сарын 02-ны өдөр “Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийг цагаатгах, тэдэнд нөхөх олговор олгох тухай” хууль гарсан. Уг хуулиар улс төрийн хилс хэрэгт холбогдуулан цаазаар авах ял шийтгүүлсэн хэлмэгдэгчийн гэр бүлийн гишүүдэд болон хорих ялаар шийтгүүлсэн хэлмэгдэгчид, хэрэв хэлмэгдэгч нас барсан бол түүний гэр бүлийн гишүүдэд 100000 төгрөгийн, бусад хэлмэгдэгчид 500000 төгрөгийн нэг удаагийн нөхөх олговор олгохоор заажээ.

*ЗХУ-ын цэргийн коллегийн шүүхийн хаалттай хуралдаанд өгсөн А.Амарын мэдүүлгээс 1941 оны 7 дугаар сарын 10, Москва хот*

Би Монголын ард түмэндээ хайртай, би Оросын ард түмэнд элэгтэй, харин улаантан, тэдний засагт дургүй. Учир нь тэд аливаа том гүрний нэгэн адил Монгол улсыг эзлэн түрэмгийлэх бодлого явуулж байна. Манай Монгол улстай хил залгадаг учир ЗХУ-тай ч, Японтой ч дотносохыг би хүсдэггүй. Монгол улсаас хол оршдог учир Герман улстай холбоо тогтоохыг эрмэлзэж байна. 1928 оныг хүртэл Германы ГЯЯ-ны сайдтай дотно холбоотой байж, түүнтэй бичиг захидлаар харилцдаг байв. Германд сургахаар оюутан сурагчид илгээж байлаа. БНМАУ-ын хувьсгалын эсэргүү, нармай Монголын тагнуул-хуйвалдааны байгууллагын удирдагчдын нэг нь гэж намайг буруутгаж байна. БНМАУ-д хувьсгалын эсэргүү ямар ч байгууллага байгаагүй. Би Зөвлөлтийг эсэргүүцдэг, түүнийгээ нууж хааж байгаагүй, нуух ч үгүй. Хүчинд автаж аргагүйн байдалд хүрч өгсөн миний мэдүүлэг гэгчээр баригдсан улсууд бол хувьсгалын эсэргүүнүүд огт биш. Тэднийг гэм зэмгүй байхад нь баривчилсан. Урьдчилсан байцаалтан дээр манай олон монголчууд хатуу ширүүнээр тамлуулсны учир өөрсдийнхөө тухай болон бусдын талаар худал мэдүүлэг өгсөн. Гэхдээ тэд цөм гэм буруугүй хүмүүс.



*Зураг 3.43. Ерөнхий сайд асан А.Амар. 1886 онд одоогийн Булган аймагт мэндэлжээ. 1941 оны 7 дугаар сарын 10-ны өдөр ЗСБНХУ-ын дээд шүүхийн цэргийн коллегийн шийдвэрээр түүнийг буудан алах ялаар шийтгэжээ.*

### Тодруулга

1962 оны хавар болсон МАХН-ын Төв Хорооны Улс төрийн товчооны хуралд үзэл суртал хариуцсан нарийн бичгийн дарга Д.Төмөр-Очир “Чингис хааны 800 жилийн ойг тэмдэглэх тухай” асуудал оруулж ирэв. Уг хурлаас Чингис хааны 800 жилийн ойд зориулсан эрдэм шинжилгээний хурал хийх, дурсгалын хөшөө босгох, шуудангийн марк гаргах болон баримтат кино хийхээр тогтжээ. 1962 оны 9 сарын 10-нд болсон МАХН-ын ТХ-ны III бүгд хурлын шийдвэрээр зохисгүй баяр ёслол санаачлан “үндэсний үзлийг дэвэргэсэн” хэмээн Д.Төмөр-Очирыг буруутгаж бүх албан тушаалаас нь чөлөөлж Чингисийн марк болон бусад дурсгалын зүйлсийг яаралтай устгажээ.



*Зураг 3.44. Д.Төмөр-Очир (1921-1984) МАХН-ын төв хорооны нарийн бичгийн дарга, намын түүхийн институтын захирал, академич*





Зураг 3.45. Ц.Лоохууз

Говь-Алтай аймгийн намын хорооны дарга, САА-г удирдах газрын дарга, ХАА-ны Яамны 1-р орлогч сайд зэрэг ажлуудыг хийж байжээ.

### Ц.Лоохууз гуайн дурсамжаас

1956 онд аймгийн намын хорооны дарга байхдаа Ю.Цэдэнбал даргыг шүүмжилсэн. Тэрнээс болж жаахан хавчлагад орсон. Тэгээд надад атар газар эзэмших даалгавар өгч ажиллуулсан. Улсын даалгаврыг биелүүлэхийн төлөө нойр хоолгүй үзэж, дайчилж ажилласан. Гэвч сүүлдээ намайг хавчих хандлага руу орж эхэлсэн юм. Тэр үед үзэл санаа нэгтэй Монголын сэхээтнүүд Төмөр-Очир, Цэнд гээд том улсуудыг ажлаас нь халж эхэлсэн. Ажлаа өгөөд өөрийнхөө мэдлэг боловсролыг дээшлүүлнэ гээд Орост эрдмийн зэрэг хамгаалахаар сургуульд явсан. Улмаар 1964 онд сургуулиа арай төгсөөгүй байхдаа намын төв хорооны бүгд хурлаар ирж Ю.Цэдэнбалыг ул үндэстэй, нэлээн сайн шүүмжилсэн. Тэрүүгээр далим хийж, намын эсрэг бүлгэм зохион байгуулсан нэрээр Нямбуу, Сурмаажав бид гурвыг “Улс төрийн дайсан бий боллоо” гэж худлаа дэвэргээд нам төрийн удирдлагаас зайлуулж, малчин, хоньчин, үхэрчин болгож байлаа. Тэгээд малчин болоод түмэн олны дэмжлэгтэйгээр ажиллаж амьдраад өөрийн гэсэн идэх уух амьдралтай байж байтал түүгээр маань далим хийж хориотой үйлдвэр явуулсан, дамын наймаа хийсэн гэж гэмт хэрэгтэн болгож шоронд хийсэн.

- Тэр хэдэн оны үе вэ?
- 1976 онд шоронд орсон. Түүнээс хойш шоронгоор бараг арваад жил шахуу явсан. Түүний дараагаар нутаг заагдана гэж байдаг. Нутаг заалтад мөн гурван жил боллоо. Тэгээд дараа нь хэлмэгдлийн амьсгаа буураагүй. Гэмтэн маягтай үзэгдэж явлаа. Түүнээс хойш 1990 онд ардчиллын хөдөлгөөн өрнөж, Ардчилсан хувьсгал ялсан. Энэ ялалт биднийг аварч, цагаатгаж, гэм зэмгүй хүн болгож, үнэн мөнийг олгож өгсөн түүхтэй.

Эх сурвалж:

<http://politics.news.mn/content/170970.shtml>



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Дараах асуултын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллээс юу олж авснаа эргэцүүлээрэй. Үүнд:
  - а) Хэлмэгдүүлэлттэй холбоотой он цаг болон тоо баримтуудыг задлан, нягтлаарай.
  - б) Хэлмэгдүүлэлтэд өртсөн П.Гэндэн, А.Амар, Ц.Лоохууз гуай нарын тухай анхдагч эх сурвалжийг үндэслэн хүмүүсийн аж амьдрал, үзэл бодлыг төсөөлөөрэй, мэдрээрэй.
  - в) Энэ үйл явдлын учир шалтгаан, хор холбогдол, үр дагаврыг тогтоогоорой, баримтжуулаарай.
  - г) Хэлмэгдүүлэлт бидэнд ямар сургамж үлдээж, юуг анхааруулж буйг тогтоогоорой
2. Сурах бичгийн “Тодруулга”, “Хожим” зэрэг хэсэгт буй эх сурвалжуудыг ашиглан дараах ажлыг хийнэ үү.
  - а) Монгол дахь хэлмэгдүүлэлт тухайн үеийн ЗХУ-тай хамааралтай болохыг илтгэсэн 2-3 үндэслэл бичиж, танилцуулаарай.
  - б) Хэлмэгдүүлэлт ба цагаатгалын тухай ярилцаарай



## ҮНЭЛЭЭРЭЙ

## МОНГОЛЫН ТҮҮХЭН ДЭХ ХАР ТОЛБО

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Хэлмэгдүүлэлт
- Онцгой бүрэн эрхт комисс
- Улс төрийн хилс хэрэг
- Цагаатгал
- Түүхийн сургамж

<i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i>	<i>Гол санаагаа ойлгов уу?</i>	<i>Бүтээлчээр сэтгээрэй.</i>															
<p>1. “Хэлмэгдүүлэлт” сэдвээр дараах хүснэгтийг бөглөнө үү.</p> <table border="1" data-bbox="136 668 484 891"> <thead> <tr> <th>Хэлмэгдүүлэлт</th> <th>Баримт, тоо</th> <th>Хор уршиг</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улс төрийн хувьд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Шашин сүм хийдийн хувьд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Хүний оюун санааны хувьд</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>.....</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table>	Хэлмэгдүүлэлт	Баримт, тоо	Хор уршиг	Улс төрийн хувьд			Шашин сүм хийдийн хувьд			Хүний оюун санааны хувьд			.....			<p>2. Хэлмэгдүүлэлтийн цаг хугацаа болон шалтгааныг холбон 3-5 өгүүлбэр бичнэ үү.</p> <p>3. Монголын түүхэнд дахин хэлмэгдүүлэлт гаргуулахгүйн тулд хэн, юуг, яаж хийх хэрэгтэй гэж та бүхэн бодож байна вэ?</p>	<p>4. Хэлмэгдүүлэлтийн талаар нэмэлт судалгаа хийвэл та ямар чиглэлийг барьж судлах вэ? Яагаад?</p> <p>5. Хэлмэгдүүлэлтийн тухай мэдэх хүмүүсийг сурвалжлан олж, ярилцлага авна уу. Түүнийгээ тохиромжтой арга, хэлбэрээр бусдадаа танилцуулаарай.</p>
Хэлмэгдүүлэлт	Баримт, тоо	Хор уршиг															
Улс төрийн хувьд																	
Шашин сүм хийдийн хувьд																	
Хүний оюун санааны хувьд																	
.....																	

Улс төрийн их хэлмэгдүүлэлтийн хор уршгийг дараах байдлаар тодорхойлж болно. Үүнд:

- Монголын түүх, соёл, уран барилгын асар их ололт, хэдэн зууны турш бүтээн туурвисан соёлын их өв сүйрэлд автаж, Монголын нийгмийн оюун санааны амьдрал, шашин суртахуун, уламжлалт зан заншилд асар их гарз хохирол учирсан байна.
- БНМАУ-ын хууль тогтоох дээд байгууллага Улсын Бага Хурал, эрх баригч МАХН-ын удирдах байгууллага хэвийн үйл ажиллагаа явуулах бүрэлдэхүүнгүй болтлоо хядлагад өртөж, Монгол оронд улс төрийн дарангуйлах дэглэм хуваарьгүй ноёрхох болсон юм.
- Үндэсний уламжлал, өв соёлын залгамжлалыг үгүйсгэн тасалдуулж, үндэс язгуураа гэсэн эх оронч үзэл санааг “үндсэрхэг үзэл” хэмээн хавчин хяхаж, шударга зарчимт шүүмжлэл, бүтээлч санал, санаачилга гаргагчдад “сэхээтний төөрөгдөл” гэх мэт нэр хаяг оноон хэлмэгдүүлж, олон ургальч үзэл, чөлөөт сэтгэлгээг хязгаарлан боогдуулсан.

Энэ бүхний улмаас хүн амын дунд идэвхгүй, үлбэгэр дорой байдал, бэлэнчлэх сэтгэлгээ газар авсаар 1990-ээд онтой залгажээ.

## ДЭЛХИЙН II ДАЙН (1939-1945 он)

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

*Дайны шалтгаан, түүний сургамжийн талаар тунгааан бодох нь хүн төрөлхтний энх тайвнаар зэрэгцэн оршиж, хөгжин дэвших үйлсэд тустай.*

### ГОЛ САНАА

*Дайны эхлэл, явцад гарсан өөрчлөлт, дайны төгсгөл, үр дүн, хор уршиг, ЗХУ-ын аугаа эх орны дайн*

### ТҮЛХҮҮР ҮГ

- *Нацист нам*
- *ЗХУ*
- *Холбоотон гүрнүүд*
- *Эх орны дайн*
- *В.И.Сталин*
- *Адольф Гитлер*



### АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

**Манж Го улс:** Япон улс эх газар ялангуяа Хятад Монголын нутагт стратегийн байрлалтай болох зорилгоор Хятад, Японы зөрчлийг ашиглаж Зүүн хойд Хятадын нутгийг 1931 онд эзэлж Манж Го улсыг байгуулав. 1932 оны 3 сард Манж Го улсыг тунхаглаж Чингийн сүүлчийн хаан Сюань тун (Пу-и)-г төрийн тэргүүнээр томилов. 1934 оны 1 сарын 20-нд Манж Гогийн ерөнхий сайд Чен Сяо-шу тус улс хаант засагтай болж буйг зарлаж Пу-И-г хаанаар өргөмжлөв. 1931 оны 9 сард Япон Манж Го улсууд гэрээ байгуулж, Манж Го улсын нутаг дэвсгэрт Япон улсын ба иргэдийнх нь эрх ашгийг тууштай хамгаалахаар тохиролцов. Тус улс Японы байнгын заавраар дотоод, гадаад бодлогоо хэрэгжүүлж байсан учир түүнийг “тоглоомын улс” гэж зарим түүхчид нэрлэжээ.

1. Манж Го улсын тухай мэдлэгээ хуваалцана уу, энэ улсын түүх Монголын түүхтэй ямар холбоотой юм бол ...?

### ХАЛХ ГОЛЫН ДАЙН



Зураг 3.46.  
Х.Чойбалсан, Г.К.Жуков

Японы түрэмгийлэгчид Зүүн хойд Хятадыг эзлэн авч улмаар Монгол Улсын эсрэг өдөөн хатгалгаа улам идэвхжүүлж, улмаар 1935 оны 1 сард Халхын сүмийн чиглэлээр зэвсэглэн хил зөрчсөн бол, 11 сарын 29-нд Булан дэрсний харуулын чиглэлээр Япон-Манж Гогийн цэргүүд давуу хүчээр гэнэдүүлэн дайрав. 1936 оны 1-р сарын 28-нд Булан дэрсний Цагаан ухаагийн чиглэлд, 1936 оны 3-р сард Адаг дулааны чиглэлээр, 1938 оны 1 сараас 1939 оны 5 сарын 15-ныг хүртэл хугацаанд их бага 30 гаруй удаагийн халдлага гарч байжээ.

1939 оны 5 дугаар сарын 11-нд Номун хан, Бүрдэн Овооны чиглэлээр Япон-Манж Гогийн миномёт, пулемёттоор дэмжүүлсэн 200 цэрэг бүхий салбарууд хилээс дотогш холгүй зайд орших Бойтогт манханд үүрэг гүйцэтгэж байсан 10 хүний бүрэлдэхүүнтэй

хилийн харуул руу дайрсныг Халхын голын байлдааны буюу зарлаагүй дайны эхлэл хэмээн тооцдог.

Халхын голын дайнд Монголын талаас морьт дивиз 5, моторжуулсан хуягт болон нисэх бригад тус бүр 1, их буу, хуягтын хэд хэдэн дивизион, хангалт үйлчилгээний тусгай анги, салбарууд, ЗХУ-ын талаас мото буудлагын дивиз 3, моторжуулсан хуягт бригад тус бүр 3, танкийн бригад 2, их бууны хороо 4, нисэх хороо 6, тусгай анги, салбарууд оролцож, манай орны хил хязгаар, улс орны тусгаар тогтнолыг хамгаалахад үнэлж баршгүй үүрэг гүйцэтгэсэн байдаг.

Зөвлөлт Монголын цэргийн давшилт 8 сарын 20-нд эхэлж, 8-р сарын 31-ний өглөө гэхэд Японы цэргүүдийг БНМАУ-ын нутаг дэвсгэрээс үлдэн хөөсөн юм. 1939 оны 9-р сарын 15-ны өдөр ЗХУ, БНМАУ, Япон улс хэлэлцээр хийснээр Халхын голын дайны ажиллагааг зогсоох тухай шийдвэр гарчээ.



### АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

1941 онд нэгэн сурвалжлагч Германы байлдан дагууллын өмнө 10000 хүн амьдарч байсан Оросын нэг хотод зочилсон байна. Сурвалжлагч ганцхан амьд үлдсэн хүнийг олжээ. “Тэрхүү өндөр настай сохор эмэгтэйн ухаан санаа самуурсан байлаа. Тосгоныг газрын зургаас арчиж байхад тэр хэдийнээ галзуурчихсан байв. Тосгоны ойролцоо ноорхой хувцас, хөл нүцгэн гайхширсан янзтай алхаж байхыг нь би харсан юм” гэж тэр сурвалжлагч бичжээ.

*Дайны дараах Орос орны нөхцөл байдлыг дурсан бичсэн сэтгүүлчийн тэмдэглэлээс...*

“Харанхуйлсан аймшиг нөмрөн ирэхэд Хамаг Европын бүх ноход гийнан хуцаж Үзэн ядалтын галд хуйхлагдахаа Улс үндэстнүүд мэдрэн хүлээнэ”

хэмээсэн нь тэр үеийн Европын хүн ардын сэтгэлийн илэрхийлэл болж байлаа.

*Их Британы яруу найрагч У.Х.Ауден*

Он цаг	Эзлэн түрэмгийлэх гэрээ, хэлэлцээрүүд
1936 оны 10 сарын 25	Берлин Ромын “Тэнхлэг”-ийн эх үүсвэрийг тавьсан улс төрийн түншлэлийн тухай Герман, Италийн хэлэлцээр хийсэн.
1936 оны 11 сар	Герман, Япон улс коминтерны эсрэг гэрээнд гарын үсэг зуржээ.
1937 оны 11 сарын 6	Коминтерны эсрэг гэрээнд Итали болон нэлээн хэдэн улс нэгдэж оржээ.
1940 оны 9 сарын 27	Герман, Япон, Итали улсууд нь эзлэн түрэмгийлэх бодлогоо эцсийн байдлаар боловсруулсан гурвалсан гэрээнд гарын үсэг зуржээ.

1. Дэлхийн дайны тухай мэдлэг, мэдээллээ хуваалцаарай.
2. Дайны өмнөх гэрээ, хэлэлцээр болон дайны дараах сурвалжлагчийн тэмдэглэл та бүхэнд дайны тухай ямар төсөөлөл төрүүлж байна вэ?
3. Сурвалжлагчийн тэмдэглэл болон яруу найрагчийн дөрвөн мөртийг үндэслэн тухайн үеийн хүмүүсийн ахуй амьдрал, сэтгэл санааны байдлыг дүрсэлнэ үү.

## ГЕРМАНЫ БАЙДАЛ

1939 он гэхэд Европ дахин хоёр том хүчинд хуваагдсан байв. Үүнд:

Холбоотнууд	Тэнхлэгийнхэн
<ul style="list-style-type: none"> <li>• Их Британи</li> <li>• Франц</li> <li>• ЗХУ</li> <li>• АНУ</li> <li>• Хятад зэрэг 45 улс оржээ.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>• Герман</li> <li>• Итали</li> <li>• Япон</li> </ul>

Дэлхийн I дайн дууссаны дараа Герман улс эмх замбараагүй байдалд оржээ. Олон жижиг намууд засгийн эрхийн төлөө өрсөлдөж байв. Ажилгүйдэл, ядуурал, өлсгөлөн их нэмэгдэж, мөнгөний ханш унаж, хэмжээ хязгааргүй үнийн хөөрөгдөл бий болжээ. Жишээ нь, 1922 оны үеийн 100 марк 1923 он гэхэд 944 болтлоо



Зураг 3.47. А.Гитлер (1889-1945) Германы Үндэсний Социалист Ажилчны Нам буюу Нацист намын удирдагч. 1933-1945 онд Германы канцлер, төрийн тэргүүн байв.

унав. Нэг зүсэм талх хэдэн мянган маркийн үнэтэй болж, гар дээр авах цалин хэдэн саяар тоологдох болжээ. 1929 онд эхэлсэн дэлхийн эдийн засгийн хямрал Германы санхүү-эдийн засаг, үйлдвэрлэл, бизнесийн салбарыг уналтанд оруулж байдлыг улам дордуулав.

Ийм хүнд үед Австри гаралтай Адольф Гитлерийн “Нацист” нам олон түмний дэмжлэгийг авчээ. Тэр нийгмийн доод, дунд давхаргын хүмүүстэй уулзаж, тэдний санаанд нийцсэн хөтөлбөр боловсруулан сонгуульд ялжээ. 1933 онд Гитлер ерөнхий сайд болж бусад намуудын үйл ажиллагааг шууд хориглосноор Герман улс нэг намын тогтолцоотой болов. А.Гитлер зовж зүдэрсэн германчуудад хандан “Та бүхэн мастер буюу дээд үндэстэн” тул бусад үндэстнийг захирах тавилантай” хэмээн хэлснээр Германы ард түмэн түүнд найдах болжээ. Тэрээр “Өнөөдөр Герман биднийх, маргааш дэлхий биднийх болно” хэмээн олон сая германчуудыг араасаа дагуулав.

## ЦАХИЛГААН ДАЙН

1939 оны 9 сарын 1-нд Герман улс Польш руу довтолсноор дайн эхэлсэн юм. Онгоц жижиг хотуудыг бөмбөгдөж 48 цагийн дотор Польшийн агаарын хүчнийг газартай тэгшитгэв. Германы танк, байлдааны машинууд Польшийн хилийг 1 сая орчим цэргийн хүчээр нэвтрэв.Тэд Польшийн тал нутгийг гатлахдаа замдаа дайралдсан бүгдийг эзэлж байлаа. Ийнхүү сар хүрэхгүй хугацаанд нацистууд Польшийг буулган авав. Германы цахилгаан дайны үйл ажиллагаа үргэлжилж, 1940 оны намар Норвеги, Дани, Бельги, Голландыг эзэлж харин 6 сард Францыг буулган авав. 1939 оны сүүлээс 1941 оны эхэн үе хүртэл германчууд Европын ихэнх нутгийг эзэлсэн байв. Европд зөвхөн Их Британи л Гитлерийг сөрөн зогслоо. Өдөр шөнөгүй дайрч байсан ч англичууд бууж өгөөгүй юм.

1941 оны зун Германы халдашгүй байдал ганхах болов. 1941оны 6 сарын 22-нд Гитлер Сталинтай байгуулсан гэрээгээ зөрчин ЗХУ-д гэнэт халдан довтолж, ЗХУ-ын аугаа эх орны дайн эхэлсэн байна.

1942 оны 11 сарын 19-нд Зөвлөлтийн цэрэг сөрөг давшилтад орж, 330 мянган немцийн бүлэглэлийг устгаснаар дайнд үндсэн эргэлт гарчээ. 1943 оны зун, намар Зөвлөлтийн цэрэг Орел, Белград, Харьков, Смоленск, Киевийг чөлөөлжээ.

Зөвлөлтийн эх орны дайн эхлэхэд БНМАУ харилцан туслалцах протокол гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ЗХУ-д бүхий л чадлаараа туслхаа илэрхийлсэн юм.

### Тодруулга

Гитлер Польшид довтлох үеэр хуучин холбоотон болох Их Британи, Франц нь Польшийн аюулгүй байдлыг хамгаалахыг амлан, өөрсдийн талд ЗХУ-ыг татахыг оролджээ. Гэвч ЗХУ-ын удирдагч И.Сталин А.Гитлertэй “Эв найрамдлын гэрээ”-г байгуулсан байна. Гэрээний дагуу хоёр улс Польшийг хэсэгчлэн хуваахаар тохирчээ.



Зураг 3.48. Европ дахь дайн (1942-1945)

Хүснэгт 3.6. Гитлерийн эсрэг эвсэл, холбоотнууд бүрэлдэх үйл явц

1941 оны 6 сарын 12	Москвад Германы эсрэг дайнд хамтрах тухай Зөвлөлт-Английн зөвшилцөл хийв.
1941 оны 8 сарын 14	Атлантын хартид Англи, Их Британи гарын үсэг зурав.
1941 оны 9 сарын 24	ЗХУ Атлантын хартид нэгдэв
1942 оны 1 сарын 1	Фашизмын эсрэг дайны зорилгын тухай Вашингтоны тунхаглалд 26 улс гарын үсэг зурав.
1942 оны 5 сарын 26	Германы эсрэг дайнд холбоо байгуулах тухай Зөвлөлт-Английн гэрээг Лондонд байгуулав.
1942 оны 6 сарын 11	Вашингтонд түрэмгийллийн эсрэг, дайнд харилцан туслалцаа үзүүлэх зарчмын тухай Зөвлөлт-Америкийн хэлэлцээр хийжээ.

Гитлерийн Германы эсрэг ЗХУ, Их Британи, АНУ гурван их гүрний холбоо байгуулагджээ. Зөвлөлтийн цэрэгтэй зэрэгцэн Англи, АНУ-ын цэрэг давшилтад оров. 1942 оны 11 сарын 8-нд Хойд Африкт буусан Д.Эйзенхуар тэргүүтэй Америкийн цэргүүд Английн генерал Б.Монтгомерийн Египетээс давшсан цэргүүдтэй хамтран Хойд Африкийн Эль-Аламейны дэргэд Итали-Германы бүлэглэлийг бут цохив. 1943 оны 7 сарын 10-нд Англи, Америкийн цэргүүд Италийн өмнөд хэсэг рүү довтлон, улмаар Итали дайнаас гарах, найрамдах хэлэлцээрт гарын үсэг зуржээ.




1943 оны 11-12 сард Тегеран хотноо 3 их гүрний бага хуралд Черчилль, Рузвельт, Сталин нар оролцож, 1944 оны зун Францад II фронт нээх, Сталин Европод дайн дууссаны дараа Японы эсрэг дайнд оролцох амлалт авчээ. Энэ дагуу 1944 оны 6 сарын 6-нд Англи-Америкийн цэргүүд хойд Францын Нормандад, 8 сарын 15-нд Францын өмнөд хэсэгт тус тус буужээ.



Зураг 3.49. Германыг Англи, АНУ, ЗХУ, Францын гэсэн 4 бүсэд хуваажээ.

1945 оны 2 сард Будапештийн ажиллагаа явагдаж, Германы Европ дахь сүүчийн холбоотон Унгар бууж өгөв. Польшийг чөлөөлөх ажиллагаа эхэлж, Улаан Арми Дорнод Пруссийг эзлэн авлаа. 1945 оны 5 сарын 8-наас 9-нд шилжих шөнө немцийн цэргийн удирдлага нацист Герман үг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зуржээ.

Европт дайн дууссаны дараа фашист эвслийн сүүлчийн улс Япон үлджээ. Тэр үед 60 гаруй улс Японд дайн зарлав. Америкчууд 1945 оны 8 сарын 6-нд Хирошима хотод цөмийн бөмбөг хаяв. Хотын оршин суугчид хурц тод гялбах туяаг хоромхон зуур харсны дараа бүх юм устаж алга болжээ. Цөмийн бөмбөг 4 бээр газрыг тэгшилж, 70 000 гаруй хүнийг шууд устгав. Түүнээс 3 өдрийн дараа Нагасаки хотод атомын бөмбөг хаяж, 40 000 гаруй хүний аминд хүрэв. Дараагийн саруудад цөмийн тэсрэлтээс үүдсэн цацрагийн өвчин газар авч улам олон хүн нас баржээ.



Зураг 3.50. Дорнод дахь дайны үйл ажиллагаа (1943)

Холбоотнууд Манж-го дахь Японы Квантуны армид сүйрлийн цохилт өгч, 9 сарын 2-нд Токиогийн цагаар 9:02-д Япон үг дуугүй бууж өгөх гэрээнд гарын үсэг зурав.

Дайны удирдагчид өмнөх дайнд хэрэглэсэн зэвсгүүдээс гадна энэ дайнд атомын зэвсэг хэрэглэсэн нь үй олон хүний амь насанд хүрчээ.

1939-1945 оны хооронд 6 жил үргэлжилсэн II дайн нь дэлхий дахины томоохон зөрчил байсан бөгөөд хүн төрөлхтний түүхэн дэх хамгийн аймшигт дайн байсан билээ. Энэ дайнд зарим улс орнууд 2 хэсэгт хуваагдсан нь Холбоотнууд болон Тэнхлэгийнхэн байв. Тус дайнд 61 улс орон, дэлхийн хүн амын 80% шахам оролцож, 110 сая гаруй хүн цэргийн албанд татагджээ. Нийт 65 сая хүн амь үрэгджээ.

Гитлер дайны үеэр олон харгислал үйлдсэний дотор зургаан сая еврейг аймаглан устгах бодлого явуулж байв. Тэрээр гомосекс, цыган, коммунист гэсэн үндэслэлээр 17 сая энгийн иргэнийг бөөнөөр нь хороосон бөгөөд энэ бүхэн нь хүн төрөлхтөнд гашуун сургамж болон үлдсэн юм.

### Тодруулга

Зөвхөн Европт 23,6 сая орон сууцны байшин, 14,5 сая нийтийн барилга, аж үйлдвэрийн газрууд, 200 мянган километр төмөр зам үгүй болжээ.

Зөвлөлтийн ард түмэн ч эд материалын асар их хохирол хүлээж, 25 сая хүн орох оронгүй үлджээ. 1710 хот суурин, 70 мянга гаруй тосгон, 6 сая барилга, 32 мянган аж үйлдвэрийн газар, 4100 төмөр замын өртөө, 63 мянган километр орчим төмөр зам, 1870 төмөр замын гүүр болон бусад байгууламж эвдрэн сүйджээ.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

- 107-108 талын газар зүйн зургийг уншиж, дэлхийн II дайны үйл явцыг төсөөлнө үү.
- Энэ дайн түүхээр он цагийн шугам хийгээрэй.
- Дайнтай холбоотой статистик тоо баримтыг баяжуулан ярилцаарай.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

- Герман улс дэлхийн дайныг яагаад өдөөх болсон учир шалтгааныг баримтад үндэслэн хэлэлцээрэй.
- Дайнд оролцсон том гүрнүүдийн зорилго, тактикийг хэлэлцэж жишээгээр нотлоорой. Тухайлбал, Герман, ЗХУ, Англи, Франц, АНУ гэх мэт
- Дайны үйл явцад эргэлт гаргахад нөлөөлсөн гол хүчин зүйл юу вэ?
- Дайны хор уршиг, сургамжийг тодорхойлно уу.

Дэлхийн II дайн хүн төрөлхтний түүхэнд болсон бусад дайнаас цар хүрээ, орон зайн хувьд хамгийн том нь юм. 1939-1942 оны зун хүртэл тэнхлэгийн хүчнүүд давамгайлж байсан боловч дайн дуусахад ЗХУ, АНУ хоёр л ялагч болон тодорсон юм. Гэвч энэ хоёр их гүрэн цаашид хүчтэй өрсөлдөж, дэлхий дахиныг хүйтэн дайнд хүргэсэн билээ.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### ДЭЛХИЙН II ДАЙН (1939-1945 он)

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Нацист нам
- ЗХУ
- Холбоотон гүрнүүд
- Эх орны дайн
- В.И.Сталин
- Адольф Гитлер

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.												
<ol style="list-style-type: none"> <li>Дайны үйл ажиллагаа Европ болон Азид хэрхэн өрнөснийг ярилцаж зурагт тэмдэглээрэй.</li> <li>“Та бүхэн мастер буюу дээд үндэстэн тул бусад үндэстнийг захирах тавилантай” гэсэн Гитлерийн хэлсэн үгийн утгыг өөрийн үгээр тайлбарлаарай.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>Хүснэгтэд тохирох хариултыг нэг өгүүлбэрээр илэрхийлээрэй.</li> </ol> <table border="1" style="margin-left: 20px;"> <thead> <tr> <th colspan="2">Дэлхийн II дайн</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шалтгаан</td> <td></td> </tr> <tr> <td>Шалтаг</td> <td></td> </tr> <tr> <td>Оролцогчид</td> <td></td> </tr> <tr> <td>Хор уршиг</td> <td></td> </tr> <tr> <td>Сургамж</td> <td></td> </tr> </tbody> </table>	Дэлхийн II дайн		Шалтгаан		Шалтаг		Оролцогчид		Хор уршиг		Сургамж		<ol style="list-style-type: none"> <li>Дэлхийн II дайнд АНУ ямар бодлого баримталсан талаар мэдээлэл цуглуулж танилцуулга бэлтгээрэй.</li> <li>Дэлхийн I ба II дайныг санаачлагч нь ямар улс вэ? Энэ хоёр дайн зорилгодоо хүрч чадсан уу? Чадаагүй бол яагаад?</li> </ol>
Дэлхийн II дайн														
Шалтгаан														
Шалтаг														
Оролцогчид														
Хор уршиг														
Сургамж														

## ТОЛЬ

- |          |  |
|----------|--|
| Нацист   | Германы Үндэсний Социалист Ажилчны Нам товчилсон нэр   |
| Холокост | Үхлийн хуаран. 1945 он гэхэд нацистууд 6 сая гаруй жүд еврейг устгасан үйл явдлыг ийнхүү нэрлэжээ. |

**СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ**

*БНМАУ-ын тусгаар тогтнолын асуудал, гадаад орчин.*

**ГОЛ САНАА**

*Дэлхийн II дайнд Монголын оролцоо:*

- *Халх голын дайн*
- *Эх орны дайны үеийн тусламж*
- *Чөлөөлөх дайн*

**ТҮЛХҮҮР ҮГ**

- *Халх голын дайн*
- *Чөлөөлөх дайн*
- *Статус кво*



**АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ**

- Монгол овогтон нэгэн улс гэр болж айл зэргэлдээ ардчилсан улсуудтай найртай сайхнаар оршин суухыг хүсэж ирснийг үндэслэж;
- ЗХУ-ын ард түмэнд ах дүүгийн найртай сэтгэлийн үүднээс 1936.03.12-ны өдөр байгуулсан ЗСБНХУ ба БНМАУ хоёр харилцан туслалцах гэрээний үүргээ үнэнчээр биелүүлэх;
- Нийтийн дайсныг түргэнээр бүрмөсөн цохиж устгах гэсэн ардчилсан улсууд ба... нэгдсэн үндэстний үйлсэд өөрийн тус нэмрийг оруулахын тулд дайнд орох болсноо илэрхийлсний хамт энэ тэмцэлд бүх “монгол овогтон... нэгэн зэргээр хөдлөн босоцгоох”-ыг уриалсан байна.

*БНМАУ-аас Японд дайн зарлах тухай тунхаг бичгээс: МАХЦ-ийн түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1921-1945 он. УБ., 1974. т 589*

1. БНМАУ хэзээ, ямар улсад, яагаад дайн зарласан юм бол?



*Зураг 3.51. Монголын ард түмний хөрөнгөөр бүтсэн “Хувьсгалт Монгол” танкийн бригад*

**МОНГОЛЧУУД БА ЗӨВЛӨЛТ ЭХ ОРНЫ ДАЙН**

Зөвлөлт эх орны дайн эхлэхэд БНМАУ харилцан туслалцах протокол гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу ЗХУ-д бүхий л чадлаараа туслахаа илэрхийлсэн юм. Улс орон даяар “Бүхнийг фронтод, бүхнийг ялалтын төлөө” уриан дор ажиллав. Ажлын өдрийг уртасган, ажилчин албан хаагчдын ээлжийн амралтыг хойшлуулж, экспортлох зүйлийг аль болох ихэсгэж, импортыг багасгах, дотоод нөөц бололцоогоо ашиглан үйлдвэрийг хөгжүүлэх бодлого явуулсан нь тодорхой амжилтад хүрсэн юм. Монголын төлөөлөгчид Зөвлөлтийн фронтод удаа дараа хүрэлцэн очиж, 700 гаруй вагон дулаан хувцас, хүнсний зүйл, хувийн бэлэг, захидал гардуулсны дээр “Хувьсгалт Монгол” танкийн бригад, “Монгол ард” нисэх онгоцны эскадрилийг



Зураг 3.52. Увс аймгийн Наранбулаг сумын малчин эмэгтэй Ингэлийн Бадам улаан армид 1942 онд 5000 төгрөг 1600 хонь, 6 тэмээ, 94 адуу бэлэглэж “Фронт Бадам” хэмээн алдаршиж байжээ



Зураг 3.53. Улаан армид бэлэг хүргэсэн монголын төлөөлөгчид

байгуулж, Улаан армид хүлээлгэн өгчээ. Мөн хагас сая шахам шилдэг морьдоо фронтод хямд үнээр худалдаж, 32 мянга гаруй морио бэлэглэжээ. Зөвлөлт эх орны дайны жилүүдэд Монголын ард түмэн улаан армид бүгд 60 сая орчим төгрөгийн бэлэг явуулжээ. БНМАУ-аас ЗХУ-д гаргах зүйлээ 2 дахин нэмэгдүүлж, авах зүйлээ 2 дахин багасгажээ. Монголын ард түмний тусламжийг Зөвлөлтийн тал “Зовох цагт нөхрийн чанар танигдав” гэж үнэлсэн байдаг билээ. Зөвлөлт эх орны дайны жилүүдэд МАХН-ын үзэл суртал хүмүүжлийн ажлын гол нь хөдөлмөрчдийг эх оронч, интернационалч үзлээр хүмүүжүүлэхэд чиглэж байв.

## ГУРВАН ГҮРНИЙ ТЭРГҮҮН НАРЫН УУЛЗАЛТ

1945 оны 2 сард ЗХУ-ын Хар тэнгисийн эрэг дээр орших Ялта хотод дэлхийн II дайны үед холбоотны эвслийг бүрдүүлэгч гол гурван улсын тэргүүн ЗХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөлийн дарга, зэвсэгт хүчний дээд командлагч И.В. Сталин, АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт, Их Британийн Ерөнхий сайд Уинстон Черчилль нар уулзжээ. Ялтын уулзалтаар Германыг ялсны дараа Европ болон дэлхийн хэмжээнд нөлөөллийн хүрээгээ хэрхэн хуваах талаар тохиролцоог хийсэн байна. Холбоотон болох АНУ, Англи хоёр Германыг ялсны дараа ЗХУ-ыг Японы эсрэг дайнд оролцохыг хүссэн байна. И.Сталин “Японы эсрэг дайныг эхлүүлэх боломжтой, гэхдээ дараах нөхцөлүүдийг биелүүлсэн тохиолдолд дайнд оролцоно” гэсэн байна.

В.И.Сталины санал нь:

1. Гадаад монголын (БНМАУ) статус квог хадгалах;
2. Сахалин арлын өмнөд хагас, Курилын арлуудыг ЗХУ-д өгөх;
3. Дорнод хятадын төмөр зам ба Порт-Артурын боомтыг ЗХУ-д удаан хугацаагаар түрээслүүлэх зэрэг юм.

Энэхүү уулзалтын үр дүнд БНМАУ буюу Монгол улсын бие даасан байдлыг дэлхийн их гүрнүүд хүлээн зөвшөөрчээ.

Гурван гүрний тэргүүн нарын Подостамын уулзалтаар ЗХУ нацист Германыг бут цохисны дараа 3 сар болоод Японы эсрэг дайнд оролцох боломжтойгоо мэдэгджээ. Тэд үүний тулд Ялтын уулзалтаар тохиролцсон тохироог дахин баталгаажуулах

### Тодруулга

1945 он 2 сард ЗХУ, АНУ, Англи гурван их гүрний удирдагчдын Ялтын бага хурал дээр дайны дараа Гадаад Монголын статус квог хэвээр үлдээнэ гэж тохиролцсон явдал БНМАУ-ын тусгаар тогтнолыг олон улсын хэмжээнд баталгаажуулах нөхцөлийг хангажээ.









Монгол улсын баатар  
Лувсанцэрэнгийн Аюуш  
(1922-1945)



Монгол улсын баатар  
Дашийн Данзанваанчиг  
(1918-1981)



Монгол улсын баатар  
Лодонгийн Дандар  
(1914-1986)



Монгол улсын баатар  
Сэнгийн Дампил  
(1922-1991)

Зураг 3.55. Монгол улсын баатрууд

Монгол улсын гадаад байдал тогтвортой болж, дотооддоо эдийн засаг, аж ахуй соёлоо хөгжүүлэх боломж ч нээгдсэн юм.

БНМАУ зэвсэгт хүчнээ оролцуулж, Зөвлөлтийн армийн хамт Японы хуурай замын цэргийн гол хүч Квантуны армийг бут цохисноор Ази тивд дайны голомт унтарч энх тайван байдал тогтоох, дорно дахины улс түмний эрх чөлөөгөө олж авах тэмцэлд хүчтэй дэмжлэг үзүүлсэн юм.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Монгол улсын дорнод хилээр Япон, Манж го улсууд халдан довтолсон нь дэлхийн дайныг өдөөсөн том гүрнүүдийн эзлэн түрэмгийлэх бодлоготой ямар холбоотойг эргэцүүлэн хэлэлцээрэй.
2. Дайнд оролцсон улсуудын хүчний харьцааг тооцоолон дүгнэлт хийж ялалтад хүргэхэд нөлөөлдөг чухал хүчин зүйлүүдийн талаар ярилцаарай.
3. 1945 оны дайныг чөлөөлөх дайн хэмээн нэрлэсний учрыг тайлбарлаарай.
4. Дайны хор уршиг, сургамжийн талаар багаар ажиллаж дүгнэлт хийгээрэй.

## ДЭЛХИЙН II ДАЙНЫ ТӨГСГӨЛД

БНМАУ-ын гадаад орчинд эргэлтийн шинжтэй өөрчлөлт гарав. 1945 оны 2 сард Ялтад хуралдсан ЗХУ, АНУ, Их Британийн Засгийн Газрын тэргүүн нарын бага хурлаар ЗХУ-ын саналын дагуу Гадаад Монголын статус-квог (одоогийн байгаа байдлаар нь хүлээн зөвшөөрөх) хэвээр байлгахаар тогтжээ. Энэ нь Монгол улсын тусгаар тогтнолыг дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөх эхлэлийг тавьсан юм. Харин Дундад иргэн улс цааргалсаар байв. И.В. Сталин Ялтын тохиролцоон дээр хатуу зогссон юм. Эл хэрэг явдалтай холбогдуулан БНМАУ-ын ерөнхий сайд, маршал Х.Чойбалсанг Москвад яаралтай урьжээ. 1945 оны 7 сарын 5-нд Москвагийн нисэх онгоцны буудалд БНМАУ, ЗСБНХУ-ын төрийн далбаа мандуулж, хүндэт харуул жагсаж, хөгжим эгшиглүүлэн бусад гадаад орны тэргүүний хэмжээнд Х.Чойбалсанг угтан авчээ.

И.В.Сталин Монголын асуудлаар Хятадын Засгийн Газрын баримталж буй байр суурийг Х.Чойбалсанд мэдээлээд, БНМАУ-ын тусгаар тогтнолыг хүлээн зөвшөөрсөн баримт бичиг гаргана гэдэгт найдаж байгаагаа илэрхийлжээ. Мөн Японы эсрэг дайн зарлавал Монгол улс түүнд оролцохыг санал болгожээ. 1945 оны 8 сарын 9-нд ЗХУ-аас Японд дайн зарласны дараа мөн сарын 10-нд БНМАУ Японд дайн зарлав. Ийнхүү Монголчууд дэлхийн II дайнд оролцож, алс дорно дахинд энх тайван тогтооход хувь нэмэр оруулав.

Ийнхүү БНМАУ дайны үеийн хүнд бэрхийг даван туулж, гадаад орчны аятай нөхцөлийг бүрэлдүүлснээр тайван цагийн босгыг алхжээ.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### БНМАУ ДЭЛХИЙН II ДАЙНД ОРОЛЦСОН НЬ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Статус кво
- Чөлөөлөх дайн
- Халх голын дайн
- Тусламж

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.																
1. Халх голын дайны үйл явцыг харуулсан зураглал зохиогоорой. 2. Халх голын болон чөлөөлөх дайны ажиллагаа болсон газар нутгуудыг Монголын газрын зурагт олж тэмдэглээрэй.	3. Хүснэгтийн дагуу ажиллаарай.	5. Дайнд оролцож гавьяа байгуулсан баатарлаг дайчид болон тэр үед цэргийн алба хааж дайнд оролцож явсан нутгийн хүмүүс, ахмад дайчдыг сурвалжилж тэмдэглэл хийгээрэй. 6. Халх голын ялалтанд зориулсан хөшөө дурсгал хаана байдаг, төрийн ямар одон медалиудаар хэн хэн шагнуулсан талаар мэдээлэл цуглуулж танилцуулаарай.																
	<table border="1"> <tr> <td></td> <td>Халх голын дайн</td> <td>Чөлөөлөх дайн</td> </tr> <tr> <td>Он цаг</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Газар нутаг</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Түүхэн хүмүүс</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Үр дүн, сургамж</td> <td></td> <td></td> </tr> </table>			Халх голын дайн	Чөлөөлөх дайн	Он цаг			Газар нутаг			Түүхэн хүмүүс			Үр дүн, сургамж			
			Халх голын дайн	Чөлөөлөх дайн														
	Он цаг																	
	Газар нутаг																	
Түүхэн хүмүүс																		
Үр дүн, сургамж																		
	4. “Зовох цагт нөхрийн чанар танигдана” сэдвийн хүрээнд Зөвлөлт эх орны дайны үед монголчуудын оруулсан хувь нэмрийг хэлэлцээрэй.																	

## ТОЛЬ

Статус кво	Оршин байгаа байдлыг илэрхийлсэн олон улсын нэр томьёо
Милитаризм	Цэрэг зэвсгээр хөөцөлдөх
Подстам	Берлин хотын нэг дүүрэг
Ялта	ЗХУ-ын Крымын хот

## 13

## ХҮЙТЭН ДАЙН (1946-1991)

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Дэлхийн улс орнууд ЗХУ тэргүүтэй социалист улсууд болон АНУ тэргүүтэй бусад улсууд хэмээн хоёр хуваагдаж үзэл суртлын төмөр хөшгөөр зааглагдав

## ГОЛ САНАА

АНУ болон ЗХУ-ын эдийн засаг болон улс төрийн үзэл баримтлал нь бүх дэлхийг хамарсан өрсөлдөөнийг бий болгов.

## ТҮЛХҮҮР ҮГ

- НҮБ
- Хүйтэн дайн
- Төмөр хөшиг
- Маршал төлөвлөгөө
- НАТО
- Варшавын гэрээ



## АСУУГААРЫ, ТААМАГЛААРЫ



Зураг 3.56. Их Британы Ерөнхий сайд Уинстон Черчилль, АНУ-ын Ерөнхийлөгч Франклин Рузвельт, ЗХУ-ын Ардын Комиссаруудын Зөвлөлийн дарга И.Сталин

## АНУ: зорилго, бодлого

- Улс орнуудад ардчиллын зарчмыг сурталчилж, коммунист засаглал тогтохоос сэргийлэхэд туслах;
- Үйлдвэрлэлээ дэмжихийн тулд түүхий эд материал цуглуулах зах зээлийг эзлэх;
- Европын засгийн газруудыг хөл дээрээ босоход туслах, тогтвортой байдлыг дэмжих замаар АНУ-ын бараа бүтээгдэхүүнийг борлуулах зах зээлийг бий болгох;
- Германыг нэгтгэж тогтворжуулах, Европын аюулгүй байдлыг бататгах.

## ЗХУ: зорилго, бодлого

- Ажилчны хувьсгалыг сурталчилж, бусад оронд коммунист нийгэм тогтоохыг дэмжих;
- Зүүн Европын үйлдвэр, түүхий эдийг ашиглан дайнд сүйтгэгдсэн эдийн засгаа сайжруулах;
- ЗХУ-ын хилийн шугамыг бататган Зүүн Европыг эрхэндээ байлгах, Баруун Европ дахь АНУ-ын нөлөөллийг тэнцвэржүүлэх;
- Ахин дайн гаргуулахгүйн тулд Германыг хуваагдсан чигээр нь байлгах.

1. Зураг дээрх хүмүүсийг нэрлэнэ үү.
2. Энэ хүмүүс дэлхийн түүхэнд ямар үүрэг гүйцэтгэсэн бол...?
4. АНУ, ЗХУ-ын зорилго, бодлогыг харьцуулж ярилцаарай. Тухайлбал:
  - Ямар ялгаатай байна вэ?
  - Яагаад ялгаатай байгаа вэ?

Холбоотны цэргүүд 1945 онд ялалт байгуулаад Элба мөрний эрэг дээр нийлж байхдаа бүгд баяр хөөртэй байсан. Харин удирдагчид нь тийм байсангүй. Дайн дуусахаас өмнө л АНУ, ЗХУ хоёр зөрчилдөж эхэлсэн. Тухайлбал, 1939 онд ЗХУ-

ыг Германтай үл довтлох гэрээ зурсны төлөө Америк Оросыг буруутгаж байсан бол Сталин Америкийг 1944 оноос өмнө германд эзлэгдсэн Европыг чөлөөлсөнгүй хэмээн буруутгаж байв.

Дэлхийн II дайн дууссаны дараагаас эхэлж 1991 он хүртэл АНУ тэргүүтэй өрнөдийнхөн, ЗХУ тэргүүтэй коммунистуудын хооронд үргэлжилсэн сөргөлдөөнийг дэлхийн түүхэнд хүйтэн дайн гэдэг. Энэ нэр томъёог анх Их Британи зохиолч Жорж Оруэлл 1945 оны 10 дугаар сард хэрэглэжээ. Тэрээр “цөмийн зэвсэгтэй учир нэг нь нөгөөгөө жинхэнэ дайнаар дийлэх боломжгүй нийгмийн хоёр эрс өөр тогтолцоо одоо “хүйтэн дайны” байдалд оршин тогтнохоос өөр аргагүй боллоо” гэж бичсэн байна.

### ЗҮҮН ЕВРОПЫН ТӨМӨР ХӨШИГ

ЗХУ-ын гол зорилго бол барууныхны ахин дайралтаас өөрсдийгөө хамгаалах явдал байв. Иймээс дайнаар чөлөөлсөн Зүүн Европын газар нутгийн зарим хэсгийг ЗХУ-ын баруун зүгийн хил болгон авч үлдлээ. Сталин үүнийг зайлшгүй шаардлагатай хамгаалалтын хана гэж үзсэн бөгөөд Ялтын гэрээг умартан Албани, Болгар, Унгар, Чехославак, Румын, Польш, Югославыг коммунист улсууд болгов. Мөн Бүгд Найрамдах Герман Ард Улсыг байгуулж, нийслэл Берлиний талыг эрхэндээ авав. Харин баруун хэсэг 1949 онд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болов. Европын энэхүү хуваагдлын талаар Их Британи ерөнхий сайд асан Уинстон Черчилль 1946 онд “Балтийн тэнгисийн Штетин хотоос Адриантын тэнгисийн Триест хот хүртэл Европ тив даяар төмөр хөшиг татагдчихлаа” гэсэн алдарт үгээ хэлжээ.

1946-1947 онд АНУ, ЗХУ-ын харилцаа муудсаар байв. ЗХУ-ын Зүүн Европ дахь нөлөө урам өргөжиж, харин АНУ үүнийг нь зогсоохыг оролдож байв. Үүний нэг жишээ бол 1947 оноос Маршаллын төлөвлөгөөг сэдэж 1948 оноос хэрэгжүүлсэн явдал юм. Энэ нь дайнд нэрвэгдсэн Баруун Европын бүтээн босголтод шаардлагатай хоол хүнс, машин тоног төхөөрөмж, түүхий эдийг нийлүүлэх төлөвлөгөө байлаа. 1948 онд 12,5 тэрбумын хөрөнгө шаардлагатай энэхүү төлөвлөгөөг АНУ-ын Конгрес



*Зураг 3.57. 1948 оны 6 сараас 1949 оны 5 сар хүртэл Баруун Берлинд 3 минут тутам Холбоотнуудын онгоц бууж, хөөрч байлаа. Нийт 278000 нислэг үйлдэж, 2,3 сая тонн хоол хүнс, шатахуун, эм тариа, зул сарын бэлэг хүртэл Баруун Берлинд хүргэгдэж ирсэн байдаг.*

хэлэлцэж байх хооронд ЗХУ Чехославакт эрх мэдлээ тогтоожээ. Энэ нь Конгрессоос уг төлөвлөгөөг тэр дор нь батлахад хүргэсэн байна. 1948-1951 онд хэрэгжсэн энэ төлөвлөгөөгөөр Англи, Франц, Итали, баруун Герман, Голланд, Австрали, Бельги, Грек, Дани, Турк, Швед, Протугали зэрэг улсууд тусламж авсны зэрэгцээ Югослав ч үүнээс хүртсэн байна.

1948 онд Берлин Франц, Британи, АНУ, ЗХУ-ын гэсэн 4 бүсэд хуваагдсан байлаа. Зөвлөлтийн цэрэг тухайн үед бусад холбоотнуудынхаа эзэмшилд байсан Берлиний баруун хэсгийн зам, ус, төмөр замыг хааж оршин суугчид хүнд байдалд оров. Америк, Британи хоёр бараг 11 сарын турш Баруун Берлиний хоол хүнсийг онгоцоор зөөвөрлөн хангаж байв. 1949 оны 5 сард ЗХУ бүслэлтээ зогсоосон юм.



## ХҮЙТЭН ДАЙН ДЭЛХИЙГ ХУВААЛАА

1949 оны эх гэхэд хоёр улс тагнуул, суртал ухуулга, дипломат зам, нууц ажиллагаагаар бие биетэйгээ харилцаж байв. Дэлхийн олон улсууд хоёр улсын аль нэгнийх нь талд хуваагдсан байлаа. Хоёр тал бие биенийхээ эсрэг цэргийн холбоодыг байгуулав. 1949 онд Баруун Европын 10 улс, АНУ, Канадтай нэгдэн цэргийн холбоог байгуулсан нь “Умард Атлантын Эвсэл” бөгөөд нэг гишүүн орон руу довтолвол бусад гишүүн орнуудын арми хамгаалалтад ороход бэлэн гэсэн үг юм. Үүний эсрэг ЗХУ 1955 онд ЗХУ, Зүүн Герман, Чехославак, Польш, Унгар, Румынь, Болгар, Албани зэрэг орнуудыг багтаасан өөрийн холбоог байгуулсан нь “Варшавын гэрээ” байв. Гэсэн хэдий ч улс орон болгон шинэ холбоодод нэгдээгүй юм. Үүний тоонд Энэтхэг, Хятад улс орно. Дэлхийн хуваагдал нь цөмийн дайны аюулыг авчрав. Энэ олон жилийн турш цөмийн зэвсэгтэй хоёр их гүрэн шууд халз дайн хийхээс зайлсхийсэн боловч дэлхийн янз бүрийн бүс нутагт дэгдсэн олон тооны жижиг дайн, зэвсэгт мөргөлдөөнд сөргөлдөгч талуудад мөнгө санхүү, зэвсгээр тусалж байв. Мөн зарим дайнд цэргээ илгээн шууд оролцож байсан нь 1950-1953 оны Солонгос, 1964-1975 оны Вьетнам, 1979-1989 оны Афганистаны дайн юм. Хоёр тал зэвсэглэлээр хөөцөлдөхөөс гадна бие биенээ үгүйсгэсэн үзэл суртлын дайн хийж байв. Зөвлөлтийн тал марксист үзэл санаа, коммунизмыг дэлгэрүүлэхийг оролдож байхад Өрнөдийн орнууд “Америкийн дуу хоолой”, “Эрх чөлөөний радио”, “Чөлөөт Европ” зэрэг радио станцууд байгуулж олон орны хэл дээр хүний эрх, эрх чөлөө, ардчилал чөлөөт сонгууль, зах зээлийн эдийн засгийн тухай нэвтрүүлгүүд цацаж байв.

Зүүн Европод коммунист дэглэмийг эсэргүүцсэн бослого, тэмцлийг ЗХУ цэрэг зэвсгийн хүчээр хөндлөнгөөс шууд оролцон дарж байв. Үүнд Дэлхийн II дайны дарга бий болсон. ЗХУ тэргүүтэн социалист тогтолцооны орнуудад 1952 оноос 1989 он хүртэлх хугацаанд ЗХУ ба социализмыг эсэргүүцсэн хэд хэдэн томоохон бослого, хөдөлгөөн, эсэргүүцэл, үймээн дэгдсэн юм. Гэвч ЗХУ ба тэдгээр орны цэрэг зэвсгийн хүчээр дарсан юм. Тухайлбал,

- 1952 оны 7 дугаар сард БНМАУ-ын ажилчид “Социализмыг төлөвлөгөөтэй хөгжүүлэх” бодлогыг эсэргүүцэж бослого дэгдэв.
- 1953 оны 5 дугаар сард Болгарын тамхины үйлдвэрийн ажилчид
- 1953 оны 5-6 дугаар сард Чехословакийн хэд хэдэн үйлдвэрийн ажилчид
- 1956 оны 6 дугаар сард Польшин Пизнань хотын Сталины нэрэмжит машин үйлдвэрлэх камбинатын ажилчдын бослого
- 1956 оны Унгарын хувьсгал
- 1961 оны Берлины хямрал (АНУ, ЗХУ-ын зөрчлөөс болж Берлины зүүн, баруун хэсэг ба хоёр Германы хил тусгаарласан нийт уртаараа 106 км, 36м өндөр хэрэм (хана) босгов. Уг нь 1989 оны 11 дүгээр сарын 9 хүртэл байна)
- 1968 оны Чехословакийн бослого зэргийг дурдаж болно.

Гэсэн ч Берлиний ханыг 1989 оны 9 сарын 9-нд нураах хүртэлх хугацаанд 5 мянган хүн Баруун Берлин рүү зугтах оролдлого хийж, 200 шахам хүн буудуулан



Зураг 3.58. Берлиний хана. (Дээрээс)



Зураг 3.59.  
Л.И.Брежнев (1907  
- 1982)

### Тодруулга

Зөвлөлтийн нам төрийн тэргүүн Л.И. Брежнев анх 1966 онд БНМАУ-д айлчилсан юм. Түүний айлчлалаар бэлгийн хороолол барих, хөрөнгө оруулалт зэргийг шийдсэний зэрэгцээ монголд цэрэг байрлуулах асуудлыг шийдвэрлэжээ.



амиа алдсан байна. Берлиний ханыг босгохоос өмнө 3,5 сая хүн зүүн Германаас өрнөд рүү дүрвэж байв. Ганц Зүүн Герман гэлтгүй социалист системийн олонх орон иргэдийнхээ гадаадад чөлөөтэй зорчих эрхийг хааж боогдуулж байлаа.

Хүйтэн дайн 1970-аад онд намжсан байдаг. Учир нь 1960-аад онд хоёр тал цөмийн зэвсгээ боловсронгуй болгохын тулд олон удаа туршилт хийсний эцэст энэ төрлийн зэвсэг дэлхийг бүхэлд нь устгах аюултайг мэдэрч зэвсгийг хорогдуулах талаар гэрээнүүд байгуулсан юм. Гэвч энэхүү намжмал байдал 1979 онд ЗХУ хөрш зэргэлдээ Афганистан улсад цэргээ оруулснаар төгсгөл болжээ.

1980-аад оны дунд үеэс социалист системийн тэргүүлэх орон ЗХУ эдийн засгийн гүнзгий хямралаас гарахын тулд “өөрчлөн байгуулалт” нэртэй шинэ бодлого зарласан боловч үр дүнд хүрсэнгүй. Эдийн засгийн хөгжил нь мухардалд орсон учраас социалист системийн орнуудад ард түмний дургүйцэл хүчтэй болж байв. 1989- 1990 онд Зүүн Европын орнуудад ардчилсан хувьсгал өрнөж германууд Берлиний ханыг нураав. 1990 онд социалист систем, 1991 онд ЗХУ задран унаснаар хүйтэн дайн төгсгөл болсон юм.



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

- Хүйтэн дайнтай холбоотой уншиж судалсан мэдээллүүдээ задлан шинжилнэ үү.
  - Он цагийн хэлхээс хийгээрэй.
  - Улс орнуудыг газрын зурагт зааж, тэмдэглээрэй.
  - Гол гол үйл явдлуудыг нэрлэж, үйл явц, үр дагавруудыг хэлээрэй.
- Маршалын төлөвлөгөөнд хамрагдсан улсуудыг нэрлэж, газрын зурагт заана уу.
- АНУ яагаад дээрх төлөвлөгөөг хэрэгжүүлэв?
- Берлиний хуваагдлыг газрын зурагт тайлбарлана уу.
- ЗХУ-ын ямар үйлдэл нь АНУ, Их Британыг ямар үйлдэл хийхэд хүргэв?

### ХҮЙТЭН ДАЙН (1946-1991)

### ҮНЭЛЭЭРЭЙ

<p><i>Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• НҮБ</li> <li>• Төмөр хөшиг</li> <li>• Маршалын төлөвлөгөө</li> <li>• Хүйтэн дайн</li> <li>• НАТО</li> <li>• Варшавын гэрээ</li> </ul>		
<p><i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i></p>	<p><i>Гол санаагаа ойлгов уу?</i></p>	<p><i>Бүтээлчээр сэтгээрэй.</i></p>
<p>1. Хүйтэн дайн дэлхий дахины түүхэнд ямар үр дагавар учруулсныг ярилцаарай</p>	<p>2. Хүйтэн дайны үед дэлхийг хамарсан өрсөлдөөн бий болсныг жишээгээр тайлбарлаарай.</p>	<p>3. Хүйтэн дайны сургамжийн талаар эргэцүүлэмж бичээрэй</p>

### ТОЛЬ

НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ЗХУ	Зөвлөлт Холбоот улс
АНУ	Америкийн нэгдсэн улс

## 14

## НҮБ БА МОНГОЛ УЛС

СЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

НҮБ-ын тогтолцоо, үйл ажиллагаа, хүний эрхийн түгээмэл тунхаглал, БНМАУ-ын статус кво, НҮБ дэх Монгол улсын оролцоог судална.

## ГОЛ САНАА

НҮБ болон дэлхийн хамтын нийгэмлэг, Монгол улсын оролцоог судлах төрийн гадаад бодлогын чигийг тодорхойлоход тусална.

## ТҮЛХҮҮР ҮГ

- ХЭТТ
- Энхийг сахиулах үйл ажиллагаа
- Статус кво



## АСУУГААРАЙ ТААМАГЛААРАЙ

Дэлхийн II дайн Европт дууссаны дараа 1945 оны 6 сарын 26 -нд 51 улсын төлөөлөгчид Олон улсын байгууллага үүсгэн байгуулах зорилгоор АНУ-ын Сан-Франциско хотод хуралдаж Нэгдсэн үндэстний байгууллагын дүрмийг баталж гарын үсгээ зурцгаажээ. НҮБ нь дэлхийд энх тайван, аюулгүй байдлыг сахиулан хамгаалах өөрийн эрхэм зорилгоо “хүн төрөлхтнийг өгүүлшгүй их гай зовлонд унагаасан дайны аюулаас авран хамгаалах, хүний нэр төр, үнэ цэн, язгуур эрхүүдийг болон эрэгтэй, эмэгтэй хүмүүс, том жижиг үндэстнүүд ижил тэгш эрхтэйг дахин нотлож, олон улсын хууль ёсыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдүүлэх нийгмийн дэвшил, илүү эрх чөлөөтэй орчинд амьдралын илүү сайн орчин нөхцөл бий болгох явдал” гэж тодорхойлжээ. Өнөөдөр НҮБ-ын гишүүнээр дэлхийн 193 улс элсээд байна.

НҮБ нь Ерөнхий ассамблей, Аюулгүйн зөвлөл, нарийн бичгийн дарга нарын газар, Олон улсын шүүх, Эдийн засаг болон нийгмийн зөвлөл зэрэг удирдах бүтэцтэй. Олон улсын атомын энергийн агентлаг, Хүнс хөдөө, аж ахуйн байгууллага, Дэлхийн банк, Нэгдсэн үндэстний, боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага -ЮНЕСКО, Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Нэгдсэн үндэстний хөгжлийн хөтөлбөр, Олон улсын валютын сан, Олон улсын хөдөлмөрийн байгууллага зэрэг харьяа 17 томоохон агенттай. Монгол Улс нь НҮБ-ын гишүүн орны хувьд эдгээр агентлаг байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байна.

“Бидний үед хүн төрөлхтөнд хоёр удаа өгүүлшгүй гай зовлон учруулсан дайны гамшгаас хойч үеийнхнийг ангижруулах, хүний үндсэн эрх, хувь хүний нэр төр, үнэ цэнд итгэх итгэл болон эрэгтэйчүүд, эмэгтэйчүүд түүнчлэн том, жижиг үндэстэн адил тэгш эрхтэй хэмээх итгэлийг дахин нотлох, шударга ёсыг сахих, гэрээ болон олон улсын эрх зүйн бусад эх сурвалжаас үүдэн гарах аливаа үүргийг хүндэтгэн мөрдөх нөхцөлийг бүрэлдүүлэх, илүү эрх чөлөөтэй байдалд нийгмийн дэвшлийг урагшлуулах, амьдралын түвшинг сайжруулахад тус дөхөм үзүүлэх ЗОРИЛГЫН ҮҮДНЭЭС. . . хүч чармайлтаа нэгтгэхээр шийдвэрлэв. Үүний учир манай холбогдох засгийн газрууд, Сан Франциско хотноо хуран цугларсан зохих хэлбэрээр ёсчлон үйлдсэн, бүрэн эрхийн үнэмлэх бичиг бүхий төлөөлөгчдөөрөө уламжлан Нэгдсэн Үндэстний Байгууллагын энэхүү дүрмийг батлахаар тохиролцож, “Нэгдсэн Үндэстэн” гэдэг нэр бүхий олон улсын байгууллагыг үүгээр үүсгэн байгуулжээ” хэмээн тэмдэглэсэн байна.

НҮБ-ын дүрмээс 1945 оны 6 сар.

## Тодруулга

Монгол Улс 1946 онд НҮБ-д элсэхээр өргөдөл гаргасан боловч 15 жилийн дараа 1961 оны 10 сарын 27-нд 101 дэх гишүүнээр элсжээ. Тус хуралдаанд Монгол улсыг төлөөлж Гадаад Явдлын Яамны орлогч сайд Д.Цэвэгмид тэргүүтэй Б.Жаргалсайхан, Б.Дашцэрэн, Б.Ванчиндорж нарын зэрэг хүмүүс оролцжээ.

1. Дээрх эх сурвалжуудаас ямар мэдээлэл олж авснаа ярилцаарай.
2. Монгол улс НҮБ-д 15 жилийн турш элсэж амжихгүй байсан учир шалтгаан болон тус байгууллагад элссэний ач холбогдлын талаар эргэцүүлэн хэлэлцэнэ үү.
3. НҮБ-ын талаар дэлгэрэнгүй судлахад та бүхэнд ямар мэдээлэл шаардлагатай байгааг ярилцаарай.



Зураг 3.60. НҮБ-ын төв байр, Нью-Йорк хот

Ерөнхий Ассамблей: Бүх гишүүн улсаас бүрдэх Ерөнхий Ассамблейд улс бүр 1 саналын эрхтэй бөгөөд чухал асуудлуудыг гуравны хоёр, энгийн асуудлуудыг олонхийн саналаар шийдвэрлэдэг.



Зураг 3.61. Ерөнхий Ассамблейн чуулганы танхим

НҮБ-ын Аюулгүйн зөвлөл: НҮБ-ын байгууллагууд дундаас гаргасан шийдвэрээ хэрэгжүүлэх эрхтэй цорын ганц байгууллага юм. АНУ, Франц, ОХУ, Их Британи, БНХАУ гэсэн байнгын 5 гишүүн оронтой.



Зураг 3.62. НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн танхим

НҮБ-ын Эдийн Засаг, Нийгмийн Зөвлөл: Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллага зэрэг тусгай байгууллагуудаар дамжуулан үйл ажиллагаагаа явуулдаг.

НҮБ-ын Нарийн Бичгийн Даргын Газар: НҮБ-ын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулдаг. НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга удирддаг.

НҮБ-ын Олон улсын шүүх: 1945 онд байгуулагдсан, Нидерландын Гаг хотод байрлана. Зорилго нь улс хооронд гарсан маргааныг таслан шийдвэрлэх юм.

## ЭНХИЙГ САХИУЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА



Зураг 3.63. Энхийг сахиулах монгол цэргүүд

Энхийг сахиулах нь НҮБ-ын хамгийн чухал үүрэг бөгөөд цэргийн хүч хэрэглэх тухай 7-р бүлэгт зааснаар зөвшөөрөгддөг. Монгол Улс анх 2002 оноос НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцож эхэлсэн юм. 2015 оны байдлаар Монгол Улсын зэвсэгт хүчин Ирак, Сьерра-Леоне, Косово, Этиоп, Эритрей, Баруун Сахар, Афганистан, Либер, Чад, Өмнөд Суданд зэрэг дэлхийн 10 гаруй оронд 12 ээлжээр 6 мянга цэргээ энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцуулжээ.

Энхийг сахиулах үүрэг гүйцэтгэж байгаа Монгол цэрэг НҮБ-ын бие бүрэлдэхүүн, хүмүүнлэгийн байгууллагын ажилтнууд болон энгийн иргэд, барилга байгууламж, техник, тоног хэрэгслийг хамгаалах, хүчирхийллийг таслан зогсоох ажиллагаанд дэмжлэг үзүүлэх үндсэн үүргээ нэр төртэй биелүүлж байна.

Нэг жишээ дурдахад 2004 онд Ирак дахь НҮУ-ын энхийг сахиулагчдын бааз руу хийсэн халдлагыг манай цэргийн баг шуурхай ажиллаж таслан зогсоосноор олон зуун хүний амь насыг аварчээ. Өнгөрсөн хугацаанд манай цэргүүд мэргэжлийн ур чадвар, сахилга зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэж байгаа байдлаараа олон улсын бусад цэргийн албан хаагчдад үлгэр дууриал болсоор байгааг НҮБ, энхийг дэмжих ажиллагаанд оролцогч улс орнууд өндрөөр үнэлдэг юм.

2012 онд Засгийн газар тогтоол гаргаж Энхийг сахиулагчдын олон улсын өдөр буюу жил бүрийн 5 дугаар сарын 29-ний өдрийг Монгол Улсад “Энхийг сахиулагчдын өдөр” болгон тэмдэглэж байхаар шийдвэрлэсэн байна.

## ХҮНИЙ ЭРХ

Хүний эрхийн Түгээмэл Тунхаглалыг Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассемблей 1948 оны 12 сарын 10-ны өдөр Парист баталсан. Энэхүү тунхаглал нь Дэлхийн хоёрдугаар дайны туршлагаас үүдэж “хүн бүхэнд төрөлх заяасан эрх бий” хэмээх санааг анх дэлхийн түвшинд гаргаж ирсэн болно. Нийт гучин зүйл ангиас бүрдсэн энэхүү тунхаглал нь олон улсын болон бүс нутгийн хэмжээний хүний эрхийн гэрээ, хуулиудын үндэс болдог.

НҮБ-ийн Ерөнхий Ассемблейн энэхүү тунхаглалыг 48 улс дэмжиж, 8 улс түдгэлзсэн саналтайгаар баталжээ. Энэхүү Хүний эрхийн түгээмэл тунхаглалд Хүн бүр арьсны өнгө, үндэс, хүйс, хэл, шашин шүтлэг, нийгмийн гарал, эд хөрөнгө, язгуур угсаа болон бусад байдлыг үл харгалзан адил тэгш эрхтэй байхыг тунхаглан баталгаажуулж хүн төрөлхтөн нийтээрээ хүлээн зөвшөөрсөн хүний эрхийн тухай анхны баримт бичиг юм.

Монгол Улс эдүгээ олон улсын 240 гаруй гэрээ, конвенцид нэгдэн орсны дотор Зэвсгийн худалдааг зохицуулах тухай олон улсын гэрээ, Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протокол, Хүүхдийн эрхийн конвенцийн Мэдээлэл хүргүүлэх журмын тухай Нэмэлт протокол, Тамхин бүтээгдэхүүний хууль бус худалдааг устгах тухай протоколд 2013 онд гарын үсэг зурсан. 2015 онд эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн нэмэлт протоколыг УИХ соёрхон батласан. Энэ бүхэн нь олон улсын хамтын нийгэмлэгийн нийтлэг эрх ашгийг хөндсөн асуудалд Монгол Улс идэвхтэй оролцож байгааг харуулахын хамт дэлхийн хэрэг явдалд манай улсын эзэлж буй орон зай, хүлээж буй үүрэг, хариуцлага өсөн нэмэгдэж буйг илэрхийлдэг юм.

НҮБ нь байгуулагдсан цагаасаа эхлэн өмнөө тавигдсан зорилтоо хэрэгжүүлж, хүний эрхийн түгээмэл тунхаглалыг батлан, энхийг сахиулах үйл ажиллагаа явуулж иржээ., Монгол улс 1961 онд НҮБ-д элсэн орж, үйл ажиллагаанд идэвхтэй оролцож цөмийн зэвсэггүй статус, бичиг үсгийн боловсрол зэрэг асуудлыг санаачлан хэлэлцүүлж нийт 80 гаруй удаа тогтоол батлуулжээ.

## Тодруулга

Дэлхийн 2-р дайны үеэр холбоотныхон буюу Их Британи, Франц, ЗХУ-уд хүний дөрвөн эрхийг хүлээн зөвшөөрч хэрэгжүүлэхийг уриалсан юм. Эдгээр нь

- 1/ үг хэлэх эрх чөлөө,
- 2/ шашин шүтэх эрх чөлөө,
- 3/ айдсаас ангид байх эрх чөлөө,
- 4/ хүслээс ангид байх эрх чөлөө болно

## Тодруулга

Өнөөдөр хүний эрхийн түгээмэл тунхаглалыг дэлхийн 375 хэлээр орчуулж, Хүний эрхийн түгээмэл тунхаглалд үндэслэн, түүнээс салбарласан хүний эрхтэй холбоотой гэрээ, конвенц, хууль, эрх зүйн баримт бичгүүд гарсаар байна.

Монгол улс, НҮБ-д элссэнээс хойш өнөөг хүртэл Ерөнхий ассамблейн дэд ерөнийлөгчөөр 6 удаа, ерөнхий ассамблейн гол хороодын итгэгч, дэд даргаар нийт 14 удаа сонгогджээ. Монгол улсын Ерөний ассамблейн чуулганд төрийн тэргүүний түвшинд 6 удаа оролцжээ. Үүнд: Ю.Цэдэнбал (1967), П.Очирбат (1992,1995), Ерөнхий сайд М.Энхсайхан (1996), Н.Багабанди (2000), Н.Энхбаяр (2005), Ц.Элбэгдорж (2009, 2011, 2012, 2013, 2014) тус бүр оролцсон байна.

### Тодруулга

Монгол Улс НҮБ-тэй дараах чиглэлээр ажиллаж иржээ. Үүнд:

- Нийгмийн хөгжил дэх хоршооллын үүрэг ролийг бэхжүүлэх
- Бичиг үсэг үл мэдэх явдлыг арилгахад тус дөхөм үзүүлэх
- Далайд гарцгүй орнуудын байдлыг сайжруулах
- Монгол улсын цөмийн зэвсэггүй статусыг баталгаажуулах
- Шинээр болон сэргээн тогтоосон орнуудын ардчиллыг дэмжих, хувь нэмэр оруулах



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Он цагийн шугам хийж, НҮБ-ын түүхтэй холбоотой гол гол он цагийг тэмдэглэнэ үү.
2. НҮБ-ын бүтэц, зохион байгуулалтыг бүдүүвчээр харуулж, тайлбарлаарай.
3. Монгол улс НҮБ-д элссэний ач холбогдлыг тодорхойлоорой. Манай улс НҮБ-ын үйл ажиллагаанд идэвхтэй оролцож байгааг хэрхэн батлах вэ?
4. Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг уншиж, хүний эрхийг хамгаас чухалчлан үзэхийн учир холбогдлыг тунгаан хэлэлцээрэй.

### ҮНЭЛЭЭРЭЙ

### НҮБ БА МОНГОЛ УЛС

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- ХЭТТ
- Энхийг сахиулах үйл ажиллагаа
- Статус кво
- Айдсаас ангид байх эрх чөлөө
- Хүслээс ангид байх эрх чөлөө

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.		Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Хүний эрхийн түгээмэл тунхаглалын ач холбогдлыг тодорхойлоорой.		3. НҮБ-ын байгуулагуудын гол үйл ажиллагааг жагсаан бичээрэй.	5. Өнөө үеийн НҮБ-ын үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж танилцуулга бэлтгээрэй.
2. Хүснэгтийг дагуу ажиллаарай.		4. Монгол улс энхийг сахиулах үйл ажиллагаанд хэрхэн оролцож байна вэ?	
	Ялтын	Подстамын	
Он цаг			
Хэлэлцсэн асуудал			
Шийдвэр			




## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүүхдүүдээ та бүхэн энэхүү бүлэг сэдвээр Монгол орны 1924-1990 оны түүхийг судалж тухайн үеийн гол үйл явдлыг шинжлэн судалсан гэдэгт найдаж байна.

1. Дараах даалгаврыг хийгээрэй.

а) Он цагийн шугамыг гүйцээнэ үү.



б) Б. Судалсан бүлгийнхээ түүхийг дотор нь үечилж, ямар үндэслэлээр хэрхэн үечилснээ тайлбарлана уу.

Үечлэл	Хэрхэн хийсэн	Тайлбар

2. Дэлхийн түүхтэй холбоотой үйл явдлуудыг ялган бичиж, Монголын түүхэнд ямар нөлөө үзүүлснийг, мөн ямар холбоотойг тодорхойлон ярилцаарай.

3. Энэхүү бүлэгт гарсан түүхэн хүмүүсийн нэрсийг жагсаан бичиж дараах даавгаврыг гүйцэтгэнэ үү.

а) Хүмүүсийн нэрсээс Монгол Улсын болон дэлхийн түүхэнд хувь нэмэр оруулсан 3-5 хүний нэрийг сонгож, яагаад ийнхүү үзэж буйгаа тайлбарлаарай. Дараах хүснэгтийн загварыг ашиглаарай.

№	Түүхэн хүмүүсийн нэрс	Оруулсан хувь нэмэр		Тайлбар
		монголын түүхэнд	дэлхийн түүхэнд	

4. Хүснэгтийг нөхөж гүйцээгээрэй.

Үйл явдал	1924-1990 оны үеийн Монгол орны		Түүхэн хүмүүс	Гол үйл явдал	Үр дүн	Сургаамж
	гадаад байдал	дотоод байдал				
Шинэ эргэлтийн бодлого						
Соёлын довтолгоон						
Нэгдэлжих хөдөлгөөн						
.....						

5. Энэхүү бүлгээр үзсэн сэдвүүдээ жагсаан бичиж, бие дааж болон багаараа хамтран ажлынхаа үр дүнг тэмдэглэнэ үү.

№	Сэдэв	Мэдсэн	Сурсан	Бодсон
1	Монголын хөгжлийн биг баримжаа ба ЗХУ-ын нөлөө			

6. Дараах бүлэглэсэн түлхүүр үгсийг ашиглан 1-3 өгүүлбэр зохиогоорой:

- Социализм, капитализм, коминтерн
- Бүгд нариймдах засаглал, Үндсэн хууль, жинхэнэ ард
- Баруунтан, зүүнтэн, өмчийн хэлбэр
- Шинэ эргэлтийн бодлого, жасын компани
- Ахуй үйлчилгээ, соёлжилт, соёлын довтолгоон
- Бурхны шашин, үндэсний соёл, хэлмэгдүүлэлт
- Эдийн засгийн хямрал, Герман, Гитлер, Сталин
- Статус кво, чөлөөлөх дайн, Халх голын дайн

7. Бүлгийг судлахад ашигласан эх сурвалжуудаа жагсаан бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү .

- а) Эх сурвалжийг ашиглан түүхийн тодорхой асуудлыг судлахын тулд шинжлэн судлах үйл ажиллагааны ямар дараалал баримтлан, юу хийснээ тэмдэглэнэ үү.

Үйл ажиллагааны дараалал	Юу хийсэн?	Ямар үр дүнд хүрсэн?

- б) Жагсаан бичсэн эх сурвалжуудаасаа сонгон дараах хүснэгтийг гүйцээнэ үү.

Эх сурвалжууд	Гарал	Төрөл	Юунд ашигласан?

8. Бүлэгт гарсан улсууд болон газар орны нэрийг бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү?

- а) Жагсаасан газар нутгаа монголын болон дэлхийн газар зүйн зурагт заагаарай.
- а) Газар зүйн зурагт зааж чадаж буй эсэхээ дараах хүснэгтийн дагуу тэмдэглэж, өөрийгөө үнэлээрэй.

№	Улс, газар нутаг	Өөрийн үнэлгээ			Өөртөө өгөх зөвлөлгөө
		шууд зааж чадсан	нэмэлт мэдээлэл уншиж байж заасан	зааж чадахгүй байна	

9. Дараах сэдвүүдээс сонгож хэлэлцүүлэг зохион байгуулна уу.

- Монголын удирдагчид тэдний үзэл бодол
- Социализм бидэнд юу үлдээв?
- Түүх ба сургамж



**АРДЧИЛСАН  
МОНГОЛ УЛС  
БА ӨНӨӨГИЙН  
ДЭЛХИЙ ДАХИН  
(1990-ӨНӨӨ ҮЕ)**

# 1 СОЦИАЛИСТ СИСТЕМ ЗАДРАН УНАСАН НЬ

## СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

- Социалист систем задран унаснаар дэлхийн түүхийн шинэ үе эхлэв.
- Энэ задрал нь социалист системийн нэг хэсэг байсан Монголд нөлөөлөв.

## ГОЛ САНАА

*Монголын ардчилсан хувьсгалын түүхийг судлах нь өнөөгийн нийгмийг таньж мэдэх, ирээдүйгээ зөвөөр төсөөлөх нэг нөхцөл болно.*

## ТҮЛХҮҮР ҮГ

- Өөрчлөн байгуулалт
- Социализмын мөхөл
- Берлиний хана
- Зөвлөн хувьсгал
- Европын холбоо



## АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ



Зураг 4.1. Социализмын үеийн газар зүйн зураг

1. Дээрх зургийг дэлхийн өнөөгийн улс төрийн газар зүйн зурагтай харьцуулан ярилцаарай. (Шинээр ямар улсууд бий болов? Үүний шалтгаан, үр дагавар юу вэ? гэх мэт)
2. Улаан өнгөөр тэмдэглэсэн улсуудын тухай мэдлэг, бодлоо хуваалцаарай.
3. Социализмын үеийн болон өнөө үеийн улс төрийн газар зүйн зургийн өөрчлөлтийн талаар асуулт гаргаж, асуудал дэвшүүлээрэй.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1. Мэдээлэлд (131-133 дахь тал) гарсан үгсийг бие биедээ тайлбарлаж өгөөрэй. Тухайлбал Өөрчлөн байгуулалт, социализм, Зүүн Европ, Берлиний хана . . .
2. Хүснэгтийг нөхөх замаар уншсан мэдээллийн агуулгыг тэмдэглэнэ үү.
3. Та бүхний сонирхсон асуултад хариулт өгөх мэдээлэл олов уу? Өөр ямар мэдээлэл хэрэгтэй байгаа, түүнийг хаанаас, хэрхэн олж болох талаар ярилцаарай.

Мэдээлэл	Холбогдох			
	Цаг хугацаа	Хүмүүс	Газар нутаг, улс	Онцлох үйл явдал
Өөрчлөн байгуулалт				
Социализмын мөхөл				
Берлиний хана нурсан				
Олон улсын харилцаа				

### ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ

1980-аад оны дунд үеэс социализм мухардалд орлоо. Үүнийг социалист системийн тэргүүн гүрэн болох ЗХУ хүлээн зөвшөөрч, М.С.Горбачев өөрчлөн



Зураг 4.2. М.С.Горбачев 1985-1991 онд ЗХУ-ын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга, ЗХУ-ын төрийн тэргүүн байв.

байгуулалтыг эхлүүлсэн юм. Өөрчлөн байгуулалт бол угтаа социализмыг аврах гэсэн оролдлого байв. Үүгээр нэг намын үзэл суртал ноёрхсон нийгэмд ил тод байдал, олон ургальч үзлийг анх удаа хүлээн зөвшөөрчээ. Гэвч системийнхээ хүрээнд социализмыг

сайжруулж, илүү хөгжүүлэхийн тулд зарласан өөрчлөн байгуулалт нь бодитой үр дүнд хүрсэнгүй. Социализм нь зассанаар сайжрах нийгэм биш байлаа. Энэ нийгэм хувийн өмч, ялгаатай үзэл

бодлыг хүлээн зөвшөөрдөггүй, ганц үзэл суртлыг тахин шүтдэг зэргээрээ хүний эрх, ашиг сонирхолтой зөрчилддөг байв.

### ЗҮҮН ЕВРОПД СОЦИАЛИЗМ ЗАДРАН УНАСАН НЬ

Зүүн европын улс орнууд ХХ зууны дунд үеэс социализмыг эсэргүүцэн тэмцэж байжээ. Тухайлбал, 1956 онд Унгарт, 1968 онд Чехословакт, 1970-аад онд Польшид олон түмний нийгмээ өөрчлөн шинэчлэх гэсэн хөдөлгөөн өрнөв. Унгар, Чехословакт болсон олон түмний хөдөлгөөнийг ЗХУ болон Варшавын гэрээний орнууд хүчээр нухчин дарж байв. Гэвч 1980-аад оны дунд үеэс коммунист үзэл санаа, нэг намын үзэл суртлыг шүүмжлэн хэлэлцэж, түүнээс ангижрах, хүний эрх, эрх чөлөөг дээдэлсэн ардчилсан нийгэмд шилжих үзэл санаа хүчтэй дэлгэрэв.

1989 онд Чехословак, Болгар, Унгар, Румынд бослого тэмцэл өрнөж, Румынд коммунист дэглэм цус урсгасан, хүнд ширүүн үйл явцын дүнд нуран

МоАХ-ны удирдлага Румыны ард түмэнд эгзэгтэй хүнд цаг мөчид нь сэтгэл санааны дэмжлэгээ илэрхийлж, засгийн газар нь энгийн номхон иргэдийн тайван жагсаал цуглааныг хүч хэрэглэн тараасныг зэмлэн буруушааж, олон хүний амь эрсэдсэнд нь эмгэнэл илэрхийлэхээр шийдвэрлэв. Тэд 12 сарын 25-нд Румыны элчин сайдын яаманд дараах албан бичгийг гардуулжээ.

Бухарест хот.

**АХ ДҮҮ РУМЫНЫ БҮХ ДЭВШИЛТ ХҮЧИН, ҮНДЭСНИЙ ИХ ХУРАЛД**

Монголын олон нийтийн төлөөлөгчид Бид, танай оронд болж буй олон хүний амь насыг хохироосон эмгэнэлт хэрэг явдлын тухай гунигт мэдээг сэтгэл шимшрэн хүлээн авлаа...

Монголын Ардчилсан Холбооны гишүүд Чаушескугийн дарангуйлагч дэглэмийн зүгээс өөрийн ард түмний эсрэг үйлдсэн хүчирхийллийг тууштай хилэгнэн буруушааж, улс үндэстнээ аврахын төлөө хийсэн тэмцэлдээ амь эрсэдсэн Румыны чин зоригт эх орончдын гэгээн дурсгалыг мэхийн хүндэтгэж байна. Бид Румыны ард түмний эрх чөлөө, ардчиллын төлөө хийж буй шударга тэмцлийг бүрэн дүүрэн дэмжиж, Румыны Улс Үндсээ Аврах Фронтын Зөвлөлд мэндчилгээ дэвшүүлж байна.

**МОНГОЛЫН АРДЧИЛСАН ХОЛБООНЫ ЗОХИЦУУЛАХ ЗӨВЛӨЛ**

Улаанбаатар хот 1989 оны арван хоёрдугаар сарын 24

уналаа. Энд эрх баригчид жагсагчдыг буудснаар дайны нөхцөл үүсэж, улмаар улсыг аюулаас хамгаалах байгууллага, арми хоёрын хооронд зэвсэгт мөргөлдөөн өрнөлөө. Бухарест хотод өрнөсөн мөргөлдөөнд хотын тэн хагас нь оролцсоноос мянга илүү хүн амь үрэгджээ. Энэ тэмцэл 1989 оны 12 сарын 25-нд цэргийн шүүн таслах хурлын шийдвэрээр Румыны коммунист намын удирдагч Н.Чаушескуг гэргийн хамт буудан хороосноор дууссан байна.

1990 оны эхээр Югослав улс задарч, тусгаар тогтносон бүгд найрамдах улсууд болжээ. Словенд засгийн эрх “Словений ардчилсан эсэргүүцлийн хүч” ДЕМОС-т, Хорватын засгийн эрх “Хорватын ардчиллын нөхөрлөл”-д очжээ. Зүүн европын улс орнуудад засгийн эрх тайван замаар, цус урсгалгүй шилжсэн үйл явцыг “Хамба хилэн буюу зөөлөн хувьсгал” гэж нэрлэдэг. Энэ хувьсгалын дараа хуучин социалист гэгдэж байсан улсууд олон намын тогтолцоотой болж, чөлөөт сонгууль явагдсан байна.

Арван таван бүгд найрамдах улсыг эгнээндээ нэгтгэсэн ЗХУ 1991 онд задрав. ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан Балтийн тэнгис хавийн улсууд бүгд тусгаар тогтносноос Эстони, Латви,

Литва улс дэлхийн хамтын нийгэмлэгт албан ёсоор элсэж, цаашид ЗХУ болон бусад БНУ-тай янз бүрийн интеграцийн хөтөлбөрт оролцохоос татгалзжээ.

### БЕРЛИНИЙ ХАНА НУРЖ ХОЁР ГЕРМАН НЭГДСЭН НЬ

1989 оны 11 сарын 9-ний өдөр хоёр германыг тусгаарласан, дэлхийн хүйтэн дайны бэлгэ тэмдэг болсон Берлиний ханыг нураасан юм. 1980 аад оноос хоёр Германы харилцаанд шинэ уур амьсгал орсон байв. 1981 онд Э.Хоннекер, Шмидт нарын дээд хэмжээний уулзалтын үеэр Европ тивийн аюулгүй байдлын төлөө БНАГУ, ХБНГУ нь



Зураг 4.3. Берлиний хана нурсан нь  
1989 оны 11 сарын 9



“нийтийн хариуцлага”-д нэгджээ. Энэ бол хүйтэн дайны үед энхийн төлөө хийсэн томоохон алхам байв.

1989 оны 10 сард БНАГУ-ын удирдагч Э.Хонеккер албан тушаалаасаа бууж, 12 сар гэхэд Үндсэн хуулиараа олон намын тогтолцоог баталгаажуулжээ. 1990 оны 9 сард хоёр герман дайны дараах хил, газар нутагтайгаа нэгдэх, ХБНГУ-ын зэвсгийн болон үй олноор хөнөөх үйлдвэрлэлийг хориглох, хорогдуулах үүрэг бүхий “Германы харилцааг бүр мөсөн зохицуулах” гэрээ байгуулав. Мөн зүүн Германы нутгаас 1994 он гэхэд Зөвлөлтийн цэргийг бүрэн гаргаж дуусгахаар болжээ. 1990 оны 8 сард Бүх Германы нэгдсэн сонгуулийг ХБНГУ-ын сонгуулийн хуулийн дагуу явуулснаар мөн оны 10 сар гэхэд БНАГУ буюу зүүн Герман улс төрийн байгууллын хувьд оршин тогтнохоо болив.

## ОЛОН УЛСЫН БАЙДАЛ

ЗХУ-д өөрчлөн байгуулалт өрнөж, зүүн европын улс орнууд нийгмийн чөлөөт сонголт хийх болсноор олон улсын харилцаа ч өөрчлөгдөж ирлээ. Тухайлбал, Зөвлөлт, Америкийн харилцаа сайжирч, цөмийн зэвсгийг устгах зарим гэрээ, хэлэлцээр байгуулагдлаа. Европын улс түмний

харилцаа сэргэлээ. 1986 оны 11 сард ЗХУ-ын Коммунист намын Ерөнхий нарийн бичгийн дарга М.С.Горбачев, АНУ-ын ерөнхийлөгч Р.Рейган нар Женевт хэлэлцээр хийж, ЗХУ, АНУ хоёр зэвсэглэлд зарцуулах хөрөнгөө 50 хувь хүртэл бууруулахаар тохиролцжээ. Урт хугацааны дайсагнасан харилцааны дараа хоёр улс анх удаа эдийн засаг, соёлын хамтын ажиллагааны тухай, бага, дунд, холын тусгалтай пуужингийн үйлдвэрлэлийг багасгах гэрээ байгуулжээ.

1990-ээд онд олон улсын нөхцөл байдалд шинэ хандлага бий болжээ. 1988 онд Европын парламентын ассамблей хуралдаж “Европын холбооны нэгдсэн бодлого”-ын талаар ярилцаж зүүн, баруун европын харилцааны тухай авч үзжээ. 1989 оны 6 сард Европын холбооны парламентын ассамблейд М.С.Горбачев үг хэлж “Нэг европ” үзэл санааг дэвшүүлсэн байна. 1990 оны 11 сард Парист европын болон АНУ, Канадын 32 орны засгийн газрын төлөөлөгчид хуралдаж европ тив дэх улс төрийн байдлын өөрчлөлтийн талаар ярилцаж, хэд хэдэн гэрээ, хэлэлцээр хийсний дотор “Шинэ европын төлөөх Парисын тунхаглал”-ыг баталжээ.



Зураг 4.4. “Хамба хилэн” хувьсгал. Чехословакийн нийслэл Прага хот. 1989 он



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

- Дараах асуултын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй. Үүнд:
  - Социалист систем хэрхэн задрав, энэ үйл явцын нийтлэг болон ялгаатай талууд юу байв?
  - Социалист системийн задрал нь:
    - Монголын түүхэнд, монголчууд бидний амьдралд,
    - Дэлхийн түүхэнд хэрхэн нөлөөлснийг эргэцүүлэн төсөөлж, баримтаар баяжуулан танилцуулаарай.
- Дэлхийн болон Монголын түүхэнд “хүйтэн дайны төгсгөл, социализмын задрал” гэсэн хоёр том түүхэн үйл явдал хэрхэн нөлөөлсөн талаар эргэцүүлэл бичээрэй.
- Эх сурвалжуудыг шинжилсэн үр дүнг дүгнэж танилцуулаарай.
- “Социалист систем задран унасан нь” сэдвийн хүрээнд хийсэн ажил, эзэмшсэн чадвар, арга барилаа үнэлээрэй.
- Энэ сэдэвтэй холбоотойгоор цаашид та юу сонирхон судлахыг хүсэж буйгаа бусадтайгаа хуваалцаарай.

## ҮНЭЛЭЭРЭЙ

### СОЦИАЛИСТ СИСТЕМ ЗАДРАН УНАСАН НЬ

Үе бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Өөрчлөн байгуулалт
- Социализмын мөхөл
- Берлиний хана
- Зөөлөн хувьсгал
- Европын холбоо

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
<ol style="list-style-type: none"> <li>Дэлхийн 10 гаруй орныг нэгтгэж байсан социалист систем хэрхэн, яаж задрав?</li> <li>Энэ задралыг социализмын мөхөл гэж үздэгийн учир юу вэ?</li> <li>Социализмын мөхлийн үр дагаврыг тодорхойлно уу.</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>ЗХУ болон Зүүн Европ дахь өөрчлөн байгуулалт, социалист системийн задрал зэрэг нь Монголын ардчилсан хувьсгалтай ямар холбоотой вэ?</li> </ol>	<ol style="list-style-type: none"> <li>1980-аад оны сүүл үеийн Германы түүхтэй холбоотой баримт, эх сурвалж цуглуулж, шинжлээрэй.</li> </ol>

### ТОЛЬ

БНАГУ	Бүгд Найрамдах Ардчилсан Герман Улс
ХБНГУ	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
АНУ	Америкийн Нэгдсэн Улс

2

МОНГОЛД АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ ЭХЭЛСЭН НЬ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

- Бидний амьдарч буй өнөөгийн нийгмийн эхлэлийг 1989 онд эхэлсэн ардчилсан хувьсгалаар тавьсан юм.
- Ардчиллын цөм үнэт зүйл бол хүний эрх, эрх чөлөө, шударга ёс мөн.

ГОЛ САНАА

- Ардчилал бол хүн төрөлхтний үнэт зүйл, хөгжлийн нийтлэг чиг хандлага.
- Монголчууд бид өөрсдөө ардчиллыг сонгосон.

ТҮЛХҮҮР ҮГ

- Ардчилал,
- Хүний эрх, эрх чөлөө
- Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Монголын Ардчилсан Холбоо



УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ



Зураг 4.5. 1989 оны 12 сарын 10. МоАХ-ны анхны цуглаан, өргөн барих бичгээ сонордуулж байгаа нь

1

1. Монголын ардчилсан холбоо анхны цуглаанаа зохион байгуулж, ардчилсан хувьсгал эхэлснийг зарлалаа.
2. Цуглаанд 300 шахам хүн сайн дураараа оролцжээ.
3. Оролцогчид 13 зүйл бүхий улс төрийн шаардлага тавьсан өргөн барих бичгийг эрх баригч нам, төрийн удирдлагад хүргүүлжээ.
4. 1989 оны 12 сарын 10 Олон улсын хүний эрхийн өдөр байлаа.


2

...МоАХ-ны улс төрийн шаардлага болгон дэвшүүлж байна. Үүнд:

А. БНМАУ-ын Үндсэн хуульд дараах өөрчлөлтийг оруулах

1. Намаас төр, засгийн үйл ажиллагааг шууд удирдан чиглүүлэх замаар нөлөө үзүүлэх явдлыг зогсоож тус улсын улс төрийн амьдралыг олон намын системийн үндсэн дээр зохицуулах зарчмыг хууль эрхийн баталгаатай болгож, АИХ-аас намын тухай хууль боловсруулан гаргах;
2. Хүний эрхийн түгээмэл тунхаглалд тодорхойлсон хүн ард иргэдийн дархан эрхийг төр, засаг намын үйл ажиллагаанд дээдлэн хүндлэх зарчмыг нэгэн адил хатуу мөрдүүлэх;
3. БНМАУ-ын АИХ-ыг байнгын ажиллагаатай парламентын хэлбэрт оруулж түүний дэргэд хүний эрхийг хамгаалах ардын сонгуульт зөвлөл байгуулах;
4. Үндэсний эрх ашгийг хөндсөн нийгэм, улс төр, эдийн засгийн асуудлыг бүх ард түмнээр ил тод хэлэлцүүлэх, орон нутгийн эрх ашгийг хөндсөн асуудлыг тухайн нутаг дэвсгэрийн оршин суугчдын саналыг авах замаар шийдвэрлэж байх зарчмыг АДХ-ын ажлын мөрдлөг болгох ...

1989 оны 12 сарын 10-ны цуглаанд оролцогчдоос тухайн үеийн нам, төрийн эрх баригчдад өргөн барьсан бичгээс



Зураг 4.6. С.Цогтсайханы хөшөө. (1960-2004 он)

**Хонхны дуу**

Урт гар намайг зовооно  
Хэлэх үгийг минь боогдуулж  
Харах нүдийг минь халхална  
Аз болж хонх дуугарлаа  
Арай ядан нойрноос сэрлээ  
Хонхны дуу биднийг сэрээ,  
сэрээ  
Хонхны дуу биднийг сэрээ

.... “Манай нэг хүнд ногдох үндэсний орлого ЭЗХТЗ-ийн гишүүн Европын орнуудын 1985 оны дундаж түвшний гуравны нэг орчимд, нэг хүнд ногдох хэрэглээний фондын хэмжээгээр 40 орчим хувьд нь байна”

Монгол улсын нам, төрийн удирдагч Ж.Батмөнх 1988 онд хуралдсан МАХН-ын ТХ-ны Ү бүгд хурал дээр ийн мэдэгдсэн нь ард түмний амьдралын түвшин доогуур байгааг анх удаа хүлээн зөвшөөрсөн хэрэг байв.

...Мах олдохгүй, идэх уух юм ховордсон, хүнд хэцүү амьдарч байна.... Энэ улс орон юу болоод байнаа.. Нам засаг арга хэмжээ авахгүй байна...

1988 оны өвөл “Шар дэлгүүр”-ийн хананд наасан бичгийн товч агуулга

**ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ**

1. Дараах асуултын дагуу ярилцаж, эх сурвалж, мэдээллээс юу ойлгож авснаа эргэцүүлээрэй. Үүнд:
  - а) 1980-аад оны Монголчуудын амьдрал ямар байв? Яагаад ингэж амьдрахад хүрэв? Энэ талаар илүү сайн мэдэх, ойлгохын тулд та бүхэн ямар баримт, мэдээлэлтэй танилцмаар байна?
  - б) Монголчууд ямар нийгэмд амьдрахыг хүсэж байв? Энэ талаар МоАХ-ны улс төрийн шаардлагаас иш татан ярилцаарай.
  - в) Монголд ардчилсан хувьсгал хэрхэн эхлэв?



2. Хүснэгтийн дагуу ажиллаж, эх сурвалжийн агуулгыг нэгтгэн дүгнээрэй.
3. Эх сурвалжуудыг шинжилсэн үр дүнг танилцуулаарай.

Эх сурвалжийн төрөл	Хэнд зориулсан	Хэн бичсэн	Бичсэн зорилго, шалтгаан	Юуг шийдүүлэхийг хүсэв?

4. Багаар ажиллаж тэр үеийн нөхцөл байдлын талаар асуулт гарган ярилцаарай.



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1988-1989 онд залуучуудын дунд “Шинэ Үе”, “Орчлон” зэрэг улс төрийн нууц бүлгэм, клубүүд байгуулагдан нам, төрийн тогтолцоог шүүмжлэн хэлэлцэх

хэрэгжүүлэх явц нь удаан байлаа. 1989 оны эхээр нийслэлийн гудамж талбайд наасан ухуулах хуудсуудад тухайн үеийн нам, төрийн бодлогыг хурцаар шүүмжилж, ардчилал, олон ургальч үзэл, хүний эрхийг шаардсан нь улс төрийн “Шинэ Үе” бүлгэмийн үйл ажиллагаа байв. Энэ шаардлагын хариуд 2 сард нам, засгийн “Үнэн” сонинд Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг нийтэлснээр монголын олон нийт анх удаагаа хүний эрхийн талаар ойлголт авсан юм. 1989 оны 11 сард МХЗЭ-ийн Төв хорооноос зохион байгуулсан Залуу уран бүтээлчдийн улсын II зөвлөгөөн боллоо. 1989 оны 12 сарын 9-нд цоо шинэ улс төр-олон нийтийн байгууллага болох Монголын ардчилсан холбоо (МоАХ) байгуулагдав. МоАХ-ны анхны Ерөнхий зохицуулах зөвлөл (ЕЗЗ)-ийн гишүүнээр С.Амарсанаа, Э.Бат-Үүл, Б.Билэгт, Д.Баасан, С.Зориг, Л.Нямсүрэн, Д.Нинж, Д.Сосорбарам, Дарь.Сүхбаатар, Ц.Элбэгдорж, В.Энхболд, Б.Энхтүвшин, Д.Энхбаатар, Г.Бошигт, Ч.Энхээ нарын 15 хүнийг сонгосон байна. 12 сарын 17-ны цуглааны дараа болсон ЕЗЗ-ийн хурлаар С.Зоригийг ЕЗЗ-ийн Ерөнхий зохицуулагчаар сонгожээ. Тухайн үеийн нам, төрийн удирдлагууд МоАХ-г БНМАУ-ын Үндсэн хуулиар зөвшөөрсөн олон нийтийн байгууллага биш гэж



Зураг 4.7. С.Зориг (1962-1998 он)  
“Би монгол хүний саруул ухаанд итгэдэг”

болов. Баабарын «Бүү март, мартвал сөнөнө» гэдэг гар бичмэл болон зарим хүмүүсийн нийгмийн тухай шүүмж гараас гарт дамжин тарж байв. 1988 оны 12 сард МАХН-ын Төв хорооны V бүгд хурал хуралдаж нийгмээ шинэчлэх, намын байгууллага, аж ахуйн ажилд шууд хутгалдан оролцохыг багасгах, ил тод байдлыг нэвтрүүлэх зэрэг шүүмжлэл өрнүүлсэн боловч амьдралд



үзээд улс төрийн шаардлагуудад нь албан ёсны хариу өгөхгүй байв. Иймд МоАХ өргөн барих бичгийнхээ хариуг шаардаж нийслэлд ухуулах хуудас наах, олон арван мянган хүн оролцсон цуглаан зохион байгуулах зэргээр тайван тэмцлээ тасралтгүй өрнүүлжээ. Мөн энэ үед МоАХ салбар зөвлөлүүдээ орон даяар байгуулж эхэллээ.

МоАХ байгуулагдсаны дараа 1989 оны 12 сард Ардчилсан социалист хөдөлгөөн (АСХ), 1990 оны 2 сард Шинэ дэвшилт холбоо (ШДХ) үүсэн байгуулагдав. Эдгээр хөдөлгөөн, холбоог Р.Хатанбаатар, Д.Батсүх нар удирдаж байлаа.

МОНГОЛД АРДЧИЛСАН ХУВЬСГАЛ ЭХЭЛСЭН НЬ

ҮНЭЛЭЭРЭЙ

<p><i>Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.</i></p> <ul style="list-style-type: none"> <li>• Ардчилал</li> <li>• Хүний эрх</li> <li>• Хүний эрхийн түгээмэл тунхаглал</li> <li>• Эрх чөлөө</li> <li>• Монголын Ардчилсан Холбоо</li> </ul>		
<i>Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.</i>	<i>Гол санаагаа ойлгов уу?</i>	<i>Бүтээлчээр сэтгээрэй.</i>
<p>1. Социализмын мухардал нийгмийн амьдралын бүх хүрээг хамарч байсныг жишээгээр тайлбарлаарай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Эдийн засгийн хүрээнд</li> <li>• Улс төрийн хүрээнд</li> <li>• Оюун санааны хүрээнд</li> </ul>	<p>2. Ардчилал яагаад хүн төрөлхтний хөгжлийн нийтлэг чиг хандлага болох вэ? 2-3 үндэслэл гаргана уу.</p> <p>3. Монголд ардчилсан хувьсгалыг эхлүүлсэн анхдагчид, түүхэн зүтгэлтнүүдийн үйл ажиллагааны талаар мэдээлэл цуглуулж, судалгаа хийгээрэй.</p>	<p>4. 1980-аад оны сүүлч, 1990-ээд оны эхэн үеийн иргэдийн амьдралыг эцэг эх, бусад хүмүүсээс асууж, төсөөлснөө зураглаарай.</p> <p>5. Ардчилсан хувьсгал яагаад гарах болов? (Дотоод, гадаад хүчин зүйл юу байв?)</p> <p>6. Цуглаанд оролцогчдын шаардлага шинэ Үндсэн хуульд хэрхэн туссаныг харьцуулж танилцуулаарай.</p>

ТОЛЬ

МоАХ	Монголын ардчилсан холбоо
ЕЗЗ	Ерөнхий зохицуулах зөвлөл
АСХ	Ардчилсан социалист хөдөлгөөн
ШДХ	Шинэ дэвшилт холбоо

# 3

## АРДЧИЛСАН ХУВЬСГАЛЫН ӨРНӨЛ

### СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Монголын ардчилсан хувьсгалын түүх олон оронд туршлага болдог.

### ГОЛ САНАА

- Монголын ардчилсан хувьсгал тайван замаар болсон.
- Ардчилсан хувьсгалд өргөн олон нийт оролцсон.

### ТҮЛХҮҮР ҮГ

- Цуглаан, жагсаал
- Улс төрийн өлсгөлөн
- Чөлөөт хэвлэл
- Зөвшилцөл
- Чөлөөт ардчилсан сонгууль



## УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ



Зураг 4.8. 1990 оны 3 сарын 4  
Ардчиллын төлөөх жагсаал цуглаанд, 100 гаруй мянган хүн оролцов  
1990 оны 3 сар

	Ня	Да	Мя	Лха	Пү	Ба	Бя
Монголын Социал демократ нам байгуулагдснаа зарлав.	25	26	27	28	1	2	3
МоАХ-ны ЕЗЗ-ийн 10 гишүүн Улс төрийн өлсгөлөн зарлав.	4	5	6	7	8	9	10
МАХН-ын ТХ-ны УТТ огцрохоо мэдэгдэж, улс төрийн өлсгөлөн зогсов.	11	12	13	14	15	16	17
МАХН-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцров.	18	19	20	21	22	23	34
Улс төрийн нам хүчнүүд хамтарсан тунхаглал гаргав.	25	26	27	28	29	30	31

- Үндсэн хуулиас "...төр нийгмийн удирдан чиглүүлэгч хүч бол бүхнийг ялагч Марксист-Ленинист онолыг үйл ажиллагаандаа удирдлага болгосон МАХН мөн" гэсэн заалтыг хасав.
- Үндсэн хуульд "...улс төрийн нам, олон нийтийн байгууллагад эвлэлдэн нэгдэх" эрхтэй гэсэн заалт нэмжээ.

1. Тухайн үед ганцаараа төр барьж байсан МАХН-ын ноёрхол хэзээ, хэрхэн унав?

МоАХ-ны анхны ЕЗЗ-д Гандан хийдийн голч лам Д.Баасан сонгогдсон юм. Тэрээр МоАХ-ны анхдугаар их хурлын “Сүсэг бишрэлийн эрх чөлөө” хавсралт илтгэл болон “Монголын тулгар төр улс сэргэн мандсаны 80 жилийн ойн тухай” уриалгыг бэлтгэсэн нь уламжлалт шашин, соёл, ёс заншил, түүхийн үнэнийг сэргээх их үйлсийн анхны уриа дуудлага нь болсон юм. Д.Баасан лам анхны цуглаанаас эхлээд бүх цуглаан жагсаалд лам хувцастайгаа оролцдог байлаа. Улс төрийн өлсгөлөн зарласан өдрүүдэд лам нар залан ном хуруулж байсан нь олон түмэнд тайвшрал, итгэл найдвар өгч байв.



Зураг 4.9. Д.Баасан лам (1955-2011)



Зураг 4.10. БНМАУ-ын нам, төрийн тэргүүн Ж.Батмөнх (1926-1997) МАХН-ын Улс төрийн товчоо бүрэн бүрэлдэхүүнээрээ огцроход шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн юм.

2. Зураг болон тэдгээрийн тайлбар нь та бүхэнд ардчилсан хувьсгалын талаар юу хэлж байна вэ?
3. Монголын ардчилсан хувьсгалын өрнөлийг газар зүйн зургаас уншина уу.



Зураг 4.11. Аймаг, орон нутагт хийсэн жагсаал цуглаан, өлсгөлөн

- Жагсаал цуглаан суугаа эсэргүүцэл
- Улс төрийн өлсгөлөн
- Оюутны хичээл хаялт, суугаа эсэргүүцэл

1990 оны 2 сарын 18 нд хуралдсан МоАХ-ны анхдугаар их хурал дээр МоАН үүсэн байгуулагдсанаа зарласнаар олон намын тогтолцооны эхлэл тавигдав. МоАХ-ны анхдугаар их хурлын дараа Ардчилсан хувьсгал өргөн олон түмнийг хамарч шинэ эрч хүчээр өрнөлөө. МоАХ, АСХ, ШДХ, Монголын оюутны холбоо хамтран 1990 оны 3 сарын 4-нд 100 гаруй мянган хүн оролцсон цуглаан, жагсаал зохион байгуулж дараах шаардлагыг тавьсан байна. Үүнд:

- намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлах;
- улс төрийн бүх хүчнийг тэгш эрхтэй оролцуулсан Ардын түр хурал байгуулж, шинэ үндсэн хууль, сонгуулийн хуулийн төсөл боловсруулах;
- сонгуулиар шинэ төр байгуулаад хуучин төр засаг огцрох;

Нам төрийн удирдлага уг шаардлагад хариу өгөөгүй тул МоАХ-ны ЕЗЗ-ийн 10 гишүүн 3 сарын 7-нд улс төрийн өлсгөлөн зарлав. Дараах хоёр өдрийн дотор өлсгөлөн зарлагчдын тоо



Зураг 4.12. 1990 оны 2-4 сард эрх баригч нам, төр засгаас хараат бус “Шинэ толь”, “Ардчилал” сонинууд хэвлэгдэн гарснаар чөлөөт хэвлэлийн үндэс суурь тавигдав.

нэмэгдэж 33 болжээ. Тэд 1990 оны 3 сарын 9-нд МАХН-ын ТХ-ны УТТ-г бүрэн бүрэлдэхүүнээрээ огцрохыг шаардаж, амь насаараа дэнчин тавьсан

## ТОДРУУЛГА

- Ардчилсан хувьсгал ба статистик*
- 1989 оны 12 сарын 10-наас 1991 оны 6 сар хүртэл нийслэлд 8 удаа томоохон жагсаал цуглаан болсон. Түүнчлэн 17 аймагт жагсаал цуглаан болжээ.
  - 1990 оны 3 сарын 4-ний цуглаан жагсаалд 100 шахам мянган хүн оролцжээ. Үүнийг шинээр байгуулагдсан улс төрийн дөрвөн хүчин хамтран зохион байгуулсан.
  - Ганц МАХН-тай байсан Монгол улсад 1989 оны 12 сараас 1991 оны 3 сард МоАХ, АСХ, ШДХ зэрэг улс төр, олон нийтийн шинэ байгууллага болон 4 нам үүсэн байгуулагджээ.

юм. Улс төрийн өлсгөлөнг дэмжсэн цуглаан, жагсаал орон даяар хүчтэй өрнөж байлаа. 3 сарын 9-нд нам төрийн удирдлага, шинэ холбоод, өлсгөлөн зарлагчдын төлөөлөл оролцсон “Дугуй ширээ”-ний яриа хэлэлцээ болж талууд зөвшилцөлд хүрчээ. Үүнд:

- Эрх баригчдын зүгээс УТТ огцрох асуудлыг удахгүй болох МАХН-ын ТХ-ын бүгд хуралд оруулж шийдвэрлэх;
- Үндсэн хуульд өөрчлөлт оруулж нэг намд онцгой эрх олгосон заалтыг хасах, намуудын тухай хууль батлах;
- Нөгөө талаас улс төрийн өлсгөлөнгөө зогсоохоор зөвшилцөж хамтарсан мэдэгдэл гаргав.

Эрх баригч МАХН-ын ТХ-ны УТТ бүрэн бүрэлдэхүүнээрээ огцорсон нь төр, засгийн газрын удирдлага солигдоход хүргэжээ. АИХ-ын чуулганаар эрх баригч намын удирдлагыг төрийн удирдлагаас салгаж БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчдийн даргаар П.Очирбатыг сонгон баталж, БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн дарга буюу Ерөнхий сайдаар Ш.Гунгаадоржийг томиллоо. Төр засгийн газар зөвшилцсөн асуудлуудаа хэрэгжүүлэхдээ удаан хандаж байсан



тул 4 сарын 27-нд засгийн газрын ордны дэргэд олон арван мянган хүн оролцсон эсэргүүцлийн цуглаан зохион байгуулав. Мөн энэ өдөр МоАН, МоАХ-ны гишүүдийг баривчилж хорьсныг эсэргүүцсэн улс төрийн өлсгөлөн Хөвсгөл аймагт эхэлж орон даяар тэднийг дэмжсэн эсэргүүцлийн хөдөлгөөн өрнөжээ. Улс төрийн нөхцөл байдал дахин хурцадсан тул 1990 оны 5 сарын 4-нд намууд яриа хэлэлцээр хийж зөвшилцөлд хүрснээр баривчилсан хүмүүсийг суллаж, МоАХ, МоАН-ын өлсгөлөн зарласан гишүүд тэмцлээ зогсоов.

Ардчилсан хувьсгал монголчуудад үг хэлэх, хэвлэн нийтлэх, эвлэлдэн нэгдэх, шүтэн бишрэх, өөрийн гэсэн өмчтэй байх, амьдран суугаа газраа чөлөөтэй сонгох, гадаадад зорчих, хүссэн мэргэжлээрээ хүссэн улс орондоо суралцах зэрэг хүний наад захын эрх, эрх чөлөөгөө эдлэх боломж олгосон билээ. Ардчилсан хувьсгалын хамгийн гол ололт, үнэ цэн нь Монгол сүүлийн 300 шахам жил гадаад улсын хараат байдалд байснаас гарч, улс төрийн тусгаар тогтнолоо жинхэнэ утгаар нь олж, хувь заяагаа өөрсдөө шийдэх болсон явдал юм.



### ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын өрнөлийг дүрсэлнэ үү. (Зургаар, он тооллын шугамаар, бичгээр, бусад хэлбэрээр)

Цуглаан, жагсаал: он, сар	Оролцогчийн тоо (ойролцоогоор)
1989.12 сарын 10	300
1989.12 сарын 17	2000
1990.1 сарын 14	10000
1990.1 сарын 21	20000
1990.2 сарын 11	30000
1990.3 сарын 4	100000

2. Өгөгдлөөр график байгуулж, дүгнэлт бичнэ үү.

3. Энэ хувьсгалын онцлох үйл явдлуудын жагсаалтыг гаргаж, юуны учир онцолсноо тайлбарлаарай.

Ардчилсан хувьсгалын онцлох үйл явдал	Яагаад?

4. Монголчууд ардчилсан хувьсгал хийхдээ ямар арга, хэлбэрүүдийг ашигласан бэ? Тэдгээрийг жагсаана уу.

5. Жагсаасан арга, хэлбэрүүдээ үндсэн, гол, хурц гэх зэрэг үзүүлэлтийг ашиглан ангилаад, санал бодлоо солилцоорой.

Зураг 4.13. Улс төрийн өлсгөлөн. БНМАУ-ын Сайд нарын зөвлөлийн орлогч дарга Д.Бямбасүрэн талбай дээр ирж улстөрийн өлсгөлөн зарлагчдын төлөөлөл МоАХ-ны ЕЗЗ-ийн гишүүн Э.Бат-Үүл болон МоАХ-ны Тэргүүлэгч гишүүн Ц.Элбэгдорж хоёртой уулзсанаар яриа хэлэлцээний эхлэлийг тавьсан юм.





Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Цуглаан, жагсаал
- Зөвшилцөл
- Чөлөөт ардчилсан сонгууль
- Улс төрийн өлсгөлөн
- Чөлөөт хэвлэл

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
<p>1. Монголын ардчилсан хувьсгал хэрхэн өрнөснийг дүрслэн гаргаарай.</p> <ul style="list-style-type: none"> <li>• Арга замууд</li> <li>• Удирдагчид, оролцогчид</li> <li>• Гол, гол үйл явдлууд</li> <li>• Он цаг, хугацаа</li> <li>• Хүмүүсийн санаа сэтгэл</li> </ul>	<p>2. Ардчилсан хувьсгалд монголын өргөн олон нийт оролцсоны учир, зорилго юу бол?</p> <p>3. Монголын ардчилсан хувьсгалыг дэлхийн улс орнууд хэрхэн хүлээж авсан бэ?</p>	<p>4. Монголын ардчилсан хувьсгал яагаад олон оронд туршлага болдог вэ?</p> <p>5. Ардчилсан хувьсгалын зүтгэлтнүүд, энэ түүхийн гэрчүүд таныг тойрон амьдарч байна. Та түүхч болоод тэдгээр хүмүүсийг сурвалжилж, тухайн үеийн түүхийг тэмдэглэн үлдээнэ үү.</p>

**ТОЛЬ**

- АИХ Ардын Их хурал (Улсын эрх барих дээд байгууллага)
- УТТ Улс төрийн товчоо (Монгол Ардын Хувьсгалт Намын Төв хорооны удирдах дээд бүтэц)
- БНМАУ Бүгд Найрамдах Монгол Ард улс (1924-1992 онд Монгол улсыг ийнхүү нэрлэж байсан)
- НҮБ Нэгдсэн үндэстний байгууллага (Олон улсын байгууллага)
- МоАН Монголын ардчилсан нам
- МСДН Монголын социал демократ нам
- МҮДН Монголын үндэсний дэвшлийн нам
- МоАХ Монголын Ардчилсан холбоо



Зураг 4.14. МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн зарим гишүүд анхдугаар их хурлын дараа

## 4

АРДЧИЛСАН СОНГУУЛЬ,  
ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬСЭДЭВ ЧУХАЛ  
БОЛОХ НЬ

Чөлөөт ардчилсан сонгууль бол ардчиллын үнэт зүйлсийн нэг мөн.

## ГОЛ САНАА

Ардчилсан хувьсгалын үр дүнд монголчууд түүхэндээ анх удаа өөрсдөө төр засгаа сонгон байгуулсан.

## ТҮЛХҮҮР ҮГ

- Сонгууль
- Үндсэн хууль
- Улсын бага хурал
- Улсын их хурал



## АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ

1. Нийгмийн ухааны хичээлтэй холбон хуулийн тухай ярилцаарай. Ямар хуулийг үндсэн хууль гэдэг вэ?, түүний ач холбогдол юу вэ?
2. Монгол улсын Үндсэн хуулиудын талаар үзэж судалснаа сэргээн ярилцаарай.



Зураг 4.15. Улсын бага хурлын гишүүд



Ардчилсан хувьсгалын улс төрийн нэг томоохон зорилт нь 1990 оны эхний хагаст багтаан АИХ-ын сонгуулийг явуулах шаардлага байсан билээ. Улс төрийн тайван тэмцэл, улс төрийн намуудын яриа хэлэлцээр, зөвшилцлийн үр дүнд 1990 оны 5 сард АИХ-ын чуулган Үндсэн хуульд дахин нэмэлт өөрчлөлт оруулж нэр дэвшигчдэд насны хязгаар тавьсан заалтыг хасаж, “Улс төрийн намуудын тухай хууль” болон “Үндсэн хуулийн нэмэлтийн тухай хууль” баталснаар олон намын оролцоотой сонгууль явуулах эрх зүйн орчин бүрджээ.



Зураг 4.16. БНМАУ-ын анхны ерөнхийлөгч Пунсалмаагийн Очирбат

Уг нэмэлтийн тухай хуульд шинэ Үндсэн хууль батлах хүртэл БНМАУ-ын төрийн эрх барих байгууллагын бүтэц нь төрийн эрх барих төлөөлөгчдийн дээд байгууллага АИХ; тусгаар тогтнол, Монголын ард түмний эв нэгдлийн илэрхийлэл Ерөнхийлөгч; хууль тогтоох, хянан шалгах эрх бүхий байнгын ажиллагаатай төрийн эрх барих дээд байгууллага Улсын Бага Хурал гэсэн бүтэцтэй байхаар болов. УБХ нь олон намын төлөөлөлтэй, байнгын ажиллагаатай парламентын хэлбэрээр ажиллаж шинэ Үндсэн хуулийн төсөл

боловсруулж АИХ-д хэлэлцүүлэх үүрэг хүлээсэн байна.

Анхны чөлөөт ардчилсан сонгууль 1990 оны 7 сарын 22-29 нд хоёр үе шаттайгаар явагдаж, 430 суудлын 343 нь МАХН-д оногджээ. Намуудын нэрээр давхар санал хураахад нийт сонгогчдын 61,74 хувь нь МАХН-ыг дэмжсэн дүн гарсны дагуу Улсын бага хурлыг 50 суудалтайгаар байгуулж МАХН 31, МоАН 13, МҮДН, МСДН-д тус бүр 3 суудал оногджээ.

БНМАУ-ын АИХ-ын чуулган 1990 оны 9 сарын 3-9 нд хуралдаж БНМАУ-ын Ерөнхийлөгчөөр П.Очирбатыг сонгосноор Монгол улс түүхэндээ анх удаа Ерөнхийлөгчтэй болсон юм. Дэд Ерөнхийлөгчөөр МСДН-ын гишүүн Р.Гончигдоржийг сонгожээ. Чуулганаас БНМАУ-ын Ерөнхий сайдаар Д.Бямбасүрэнг батлаж, улс төрийн намууд дахин зөвшилцсөний үр дүнд МҮДН-аас Д.Ганболдыг тэргүүн шадар сайдаар, МоАН-аас Д.Дорлигжавыг шадар сайдаар тус тус томилсон байна.

Д.Бямбасүрэнгийн засгийн газар улс орноо зах зээлийн эдийн засагт шилжүүлэх анхны алхмуудыг авч хэрэгжүүллээ. УБХ-аас баталсан “Өмч хувьчлалын тухай” хуулийн дагуу цэнхэр тасалбар болон ягаан тасалбараар улсын өмчийг хувьчилж, нэгдлийн малыг малчдад буцаан олгов. Түүнчлэн иргэдийн гадаадад чөлөөтэй зорчих эрхийг нээж өгсөн байна.

1990 оны 10 сард УБХ-ын тогтоолоор шинэ Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг хуульч Б.Чимидээр ахлуулан байгуулжээ. БНМАУ-ын АИХ чуулган 1991 оны 11 сарын 11-нээс эхлэн уг ажлын хэсгийн боловсруулсан төслийг 76 хоног хэлэлцсэний эцэст 1992 оны 1 сарын 13-нд Монгол Улсын Үндсэн хуулийг

баталлаа. Монголчууд 1924, 1940, 1960 оны Үндсэн хуулиудаа гаднын улсын оролцоо, нэг үзэл суртлын нөлөөн дор боловсруулан баталж байсан бол 1992 онд өөрсдөө боловсруулсан Үндсэн хуулиа хэлэлцэж баталсан юм.

Шинэ Үндсэн хууль эн тэргүүнд улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж, хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх, эх орондоо хүмүүнлэг, иргэний, ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилгоо болгон дэвшүүлсэн юм.

Шинэ Үндсэн хуулиар улсынхаа нэрийг Монгол Улс хэмээн өөрчилж, төрийн сүлдээ шинэчилж, ардчилал, шударга ёс, эрх чөлөө, тэгш эрх, үндэсний эв нэгдэл, хууль дээдлэх ёсыг эрхэмлэн дээдэлсэн парламентын бүгд найрамдах улс болсноо зарлалаа.

Монгол Улсын Үндсэн хууль НҮБ-ын Ерөнхий Ассамблейн баталсан “Хүний эрхийн түгээмэл тунхаглалд” тусгасан хүний үндсэн эрх, эрх чөлөөг Монгол улсын иргэн бүр эдлэх эрхтэйг тунхаглалаа. Түүнчлэн төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хүлээсэн байна.

Үндсэн хуулиар төрийн эрх мэдлийг тодорхой зааглан тодорхойлов. Төрийн эрх барих дээд байгууллага нь Улсын Их Хурал бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг хадгална, төрийн гүйцэтгэх дээд байгууллага нь Засгийн газар, харин шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ гэж зааж өгөв.

Ийнхүү Ардчилсан хувьсгалын улс төрийн шаардлагууд Үндсэн хуульд бүрэн тусгалаа олсноор ардчилсан хувьсгалын зорилго биелжээ. Монгол Улс ардчилсан нийгэм байгуулах, зах зээлийн эдийн засагт шилжих хууль эрх зүйн орчин бүрдсэн байна.



Зураг 4.17. Монгол улсын Үндсэн хууль



Зураг 4.18. Улаанбаатар. Чингисийн талбай

АРДЧИЛСАН СОНГУУЛЬ, ШИНЭ ҮНДСЭН ХУУЛЬ

ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Улсын бага хурал
- Улсын их хурал
- Сонгууль
- Үндсэн хууль

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй
1. Монгол улсад яагаад шинэ Үндсэн хууль хэрэгтэй болов? 2. Шинэ Үндсэн хууль баталснаар Монгол улсын улс төр, эдийн засгийн тогтолцоонд ямар өөрчлөлт гарсан бэ?	3. Монголын социализмын үеийн сонгууль, ардчилсан сонгууль хоёр ямар ялгаатай вэ?	4. Монгол улсын дөрвөн Үндсэн хуулийг харьцуулан судлаарай.



5

МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Ардчилал нь эдийн засгийн эрх чөлөө олгож, иргэн бүр хувийн өмчтэй болсноор монголчуудын амьдралын чанарт өөрчлөлт гарсан юм.

ГОЛ САНАА

Монголчуудын сонгосон зах зээлийн эдийн засаг нь хүн бүрт өмч эзэмших, үйлдвэрлэгч, бүтээгч байх боломж олгосон.

ТҮЛХҮҮР ҮГ


- Өмч хувьчлал
- Үнэ чөлөөлөлт
- Банк, санхүү



АСУУГААРАЙ, ТААМАГЛААРАЙ



Бүдүүвч 4.1 Малын тоо толгойн өсөлт (мянган толгой)



Бүдүүвч 4.2 Өмч хувьчлалын он цагийн шугам

1. Тухайн онуудад малын тоо хэрхэн өссөнийг тооцоолоорой.
2. Энэ өсөлтийг Монголын түүхийн тухайн цаг үеийн гол үйл явдлуудтай холбосон асуулт, таамаглал дэвшүүлээрэй.
3. Гаргасан асуултад хариулах болон таамаглалаа батлах, няцаахын тулд та бүхэнд ямар мэдээлэл, баримт хэрэгтэйг ярилцаарай.

Ардчилсан хувьсгалын нэг чухал үр дүн бол зах зээлийн эдийн засагт шилжсэн явдал мөн. Үүний тулд эн тэргүүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ нь өмч хувьчлал юм. Өмч хувьчлал бол социалист өмч нэрийн дор улс дангаараа өмчилж байсан баялгийг иргэдэд хувийн өмч болгон шилжүүлсэн түүхэн үйл явдал юм. Өмч хувьчлалын үр дүнд Монгол улсын бүх иргэн өөрийн гэсэн өмчтэй болсны зэрэгцээ хувийн үйлдвэрлэл, аж ахуйн нэгж хөгжих боломж нээгдэв. Энэ нь Монгол улсад өмчийн олон хэлбэрт тулгуурласан эдийн засаг хөгжих үндэс суурь болжээ.



Хувьчлалын хэлбэр	Юуг, хэрхэн хувьчилсан	Үр дүн
Бага хувьчлал: 3000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий ягаан тасалбар	Хөдөөд малыг, хотод үйлдвэрлэл үйлчилгээний жижиг нэгжүүдийг	<ul style="list-style-type: none"> <li>• 5 тэрбум төгрөгийн үнэ бүхий 1593 дэлгүүр, хоолны газар, ахуй үйлчилгээний цэг, салбарыг хувьчилж, 3300 гаруй хувийн хэвшлийн аж ахуйн нэгж шинээр үүссэн.</li> <li>• Нийт малын 90 гаруй хувь нь хувийн өмч болсон.</li> </ul>
Их хувьчлал: 7000 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий цэнхэр тасалбар	Үйлдвэр аж ахуйн газруудын хувьцааг худалдан авах	<ul style="list-style-type: none"> <li>• 17,4 тэрбум төгрөгийн үнэ бүхий хөрөнгө хувьчлагдан 1,1 сая гаруй иргэд хувьцаа эзэмшигч болсон.</li> <li>• 466 хувьцаат компани, 1297 бүрэн бус хариуцлагатай компани, 1907 хоршоо, 850 хувиараа эрхлэх аж ахуй бий болжээ.</li> </ul>

Зах зээлийн эдийн засагт шилжих, өмч хувьчлах нь үнэ чөлөөлөх, банк, санхүүгийн тогтолцоог шинэчлэх, нээлттэй, харилцан ашигтай гадаад харилцааг хөгжүүлэх зэрэг хоорондоо харилцан хамааралтай өөрчлөлтүүдийг шаардаж байв. Бүх бараа, үйлчилгээний үнийг улсаас хатуу тогтоодог байсныг халж, үнийг чөлөөлж, зах зээлийн эдийн засгийн хуульд нийцүүлсэн нь чухал шийдвэр байв. 1991 онд гарсан Засгийн газрын 20-р тогтоолоор төрийн мөнгөн орлогыг 2 дахин нэмэгдүүлж, бүх төрлийн барааны жижиглэн худалдах үнэ, үйлчилгээний тарифыг 2 дахин өсгөсөн нь үнэ чөлөөлөх анхны томоохон алхам юм.



Бүдүүвч 4.3 Үнэ чөлөөлсөн он цагийн шугам



Зураг 4.19. Зарим банкны таних тэмдэг

### ТОДРУУЛГА

1924 онд Монгол Зөвлөлтийн хувь нийлүүлсэн хөрөнгөөр Монгол банк байгуулагдажээ. Монгол банк анх нээгдэхдээ 260000 янчааны хөрөнгөтэй, 22 орон тоотой, үүний дотор Зөвлөлтийн мэргэжилтэн 18, монгол ажилчин 4 байжээ.

Зах зээлийн эдийн засгийн зорилтуудыг социализмын үеийн улсын банкаар шийдвэрлэх боломжгүй болов. Иймд УБХ-аас 1991 онд БНМАУ-ын Банкны тухай хууль гаргаснаар, хувийн, арилжааны банк байгуулах боломжтой боллоо. Ингэснээр үндэсний төв банк болон арилжааны банк бүхий банкны тогтолцоо бүрэлдэх суурь тавигдав. Тэргүүний техник, технологи нэвтрүүлэх, бүтэц, зарим чухал үйлдвэрлэлийг хөгжүүлэхийн тулд эдийн засгийн нээлттэй бодлого явуулав. Гадаадын хөрөнгө оруулалтын хуулийг 1990, 1993 онуудад гаргасан нь улс орны эдийн засагт ихээхэн ач холбогдолтой болсон юм.



Зураг 4.20. Картын барааны үе (1992-1993 он)

1990 оноос ЗХУ-ын зээл тусламж зогссон тул хандивлагч орнууд, ОУВС, Дэлхийн банк, Азийн хөгжлийн банкны зээл тусламжийг өргөн ашиглах болжээ. Эхний жилүүдэд Хятад, ЗХУ-ын хөрөнгө оруулалт зонхилж байсан бол цаашлаад АНУ, Япон, ХБНГУ, БНСУ, Канад зэрэг техник, технологийн өндөр хөгжилтэй орнууд хөрөнгө оруулдаг болов.

Монгол Улс 1997 онд 153 гишүүн оронтой Дэлхийн Худалдааны Байгууллагад гишүүнээр элслээ. Эдүгээ Монгол Улс дэлхийн 150 орчим улстай худалдааны харилцаа хөгжүүлж, 60 орчим улсад бараа, бүтээгдэхүүн экспортлож, 120 гаруй улсаас бараа, бүтээгдэхүүн импортолж байна. Ардчилсан хувьсгалын үр дүнд зах зээлийн эдийн засагт шилжих үйл явц шулуун дардан байгаагүй. Монголчуудын өмнө хувийн салбарыг аваад явах хөрөнгө, санхүүгийн хуримтлал хомс, туршлага дутмаг зэргээс гадна өмч хөрөнгө эзэнгүйдэх, ажилгүйдэл, ядуурал бий болох зэрэг цөөнгүй сорилт, бэрхшээл тулгарч байлаа. Эдгээрийн нэг нь картын бараанд шилжсэн үе юм.



## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Дараах үг, ойлголтын утга, агуулгыг тайлбарлан ярилцаарай. Үүнд: Зах зээлийн эдийн засаг, өмч хувьчлал, хөрөнгө оруулалтын эрхийн бичиг, арилжааны банк, хандивлагчид ...
2. Хүснэгтийн дагуу ажиллаж өмч хувьчлалын үр дүнг тодорхойлоорой.

Хэзээ (оноор)	Батлагдсан хууль, гаргасан шийдвэр	Авсан арга хэмжээ	Үр дүн нь юу болов?
1991	Өмч хувьчлалын тухай хууль Банкны тухай хууль		
1993	Валютын ханш чөлөөлөх шийдвэр		
1994	Үнэт цаасны хууль		
1996	Орон сууц хувьчлалын тухай хууль		
2002	Гэр бүлд газар өмчлүүлэх тухай хууль		
2008	Иргэнд газар өмчлүүлэх тухай хууль		

3. Монголын түүхэн дэх “Картын барааны он жилүүд” агуулгын хүрээнд:
  - а) Яагаад картаар хүнс олгох болсон бэ?
  - б) Энэ үед хүмүүс хэрхэн амьдарч байсан бэ?

в. Энэ үеийн бэрхшээлийг хэрхэн даван туулсан зэргийг илрүүлэх нэмэлт мэдээлэл цуглуулж, танилцуулаарай.

4. Ялгаатай үзэл бодолд өөрийн үнэлэлтийг өгнө үү.

Ялгаатай үзэл бодол	Санал			Учир нь
	Нийлж байна	Нийлэхгүй байна	Эргэлзэж байна	
Өмч хувьчлал нь хүмүүсийг хувийн өмчтэй болгосон.				
Өмч хувьчлал нь хүмүүст чинээлэг амьдрах боломж олгосон.				
Өмч хувьчлал нь ядуурал, ажилгүйдэлд хүргэсэн.				

5. Түүхэн үйл явдалд хүмүүс яагаад өөр, өөр үнэлэлт дүгнэлт өгдөг тухай эргэцүүлэн ярилцаарай.

Эдийн засгийн өөрчлөлтийн эхний үр дүнг дараах зарим баримтаас харж болно.

Мал хувьчилсны үр дүнд монголын мал сүргийн тоо толгой өссөн. Жишээ нь, 1941 онд бүх мал 27,5 сая болж өссөн нь 1995 он хүртэлх бүтэн 54 жилийн туршид огт давтагдаагүй бөгөөд 1995 онд 28,5 сая хүрсэн мал сүрэг он дараалан өссөөр 1997 онд түүхэндээ анх удаа 51 сая мал тоолуулжээ. 2001-2002 онд зуд болж мал сүрэг зохих хэмжээгээр хорогдсон ч эдүгээ 52 сая малтай болжээ.

1989 онд үндэсний орлогын 90 хувийг улсын үйлдвэрийн газрууд гаргаж байсан бол 2015 оны байдлаар ДНБ -ний 80 гаруй хувийг хувийн хэвшлийнхэн үйлдвэрлэх болжээ.



Бүдүүвч 4.4 Малын тоо (сая толгой), Нэг хүнд ногдох ДНБ (Дотоодын нийт бүтээгдэхүүн)

## МОНГОЛУСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ӨӨРЧЛӨЛТ

## ҮНЭЛЭЭРЭЙ

Үг бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Өмч хувьчлал
- Үнэ чөлөөлөлт
- Банк санхүү

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй							
<p>1. Эдийн засгийн өөрчлөлтүүд бидэнд юу авчрав? Хүснэгтийн дагуу ажиллаарай.</p> <table border="1"> <tr> <td rowspan="3">Эдийн засгийн өөрчлөлтүүд</td> <td>Банкны тогтолцоо</td> <td></td> </tr> <tr> <td>Үнэ чөлөөлөлт</td> <td></td> </tr> <tr> <td>Өмч хувьчлал</td> <td></td> </tr> </table> <p>2. Зах зээлийн эдийн засагт шилжихэд тулгарч байсан бэрхшээл сорилтын талаар ярилцаарай.</p>	Эдийн засгийн өөрчлөлтүүд	Банкны тогтолцоо		Үнэ чөлөөлөлт		Өмч хувьчлал		<p>3. Монголын түүхэнд өмчтэй холбоотой болсон үйл явдлуудыг харьцуулан судлаарай. Тухайлбал:</p> <ul style="list-style-type: none"> <li>• 1929 он: хөрөнгө хураасан.</li> <li>• 1959 он: нэгдэлжих хөдөлгөөн, малыг нийгэмчилсэн.</li> <li>• 1991 он: өмч хувьчилсан гэх мэт.</li> </ul> <p>4. Зах зээлийн эдийн засагт шилжсэнээр хувь хүмүүсийн амьдралд гарсан өөрчлөлтийг баримтаар нотолно уу.</p>	<p>5. 20-25 жилийн түүхтэй хувийн байгууллагууд (компани, ААН)-ын түүхийг судалж танилцуулаарай.</p> <p>6. Өмч хувьчлалын цэнхэр, ягаан тасалбарыг танай гэр бүлийнхэн хэрхэн зарцуулсныг аав, ээжээсээ асууж ярилцаарай.</p>
Эдийн засгийн өөрчлөлтүүд		Банкны тогтолцоо							
		Үнэ чөлөөлөлт							
	Өмч хувьчлал								

6

МОНГОЛЧУУДЫН ОЮУН САНАА, НИЙГМИЙН АМЬДРАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

Ардчилсан нийгмийг сонгосноор монголчуудын оюун санаа, нийгмийн амьдралд асар том дэвшил гарсан

ГОЛ САНАА

Монголчуудын оюун санаа, нийгэм, соёлын амьдралын өөрчлөлт нь хүн бүр эрхээ эдэлж, чөлөөтэй сэтгэх боломжтой болсонд оршино.

ТҮЛХҮҮР ҮГ

- Олон ургальч үзэл
- Хэвлэл мэдээллийн эрх чөлөө
- Шүтэх бишрэх эрх чөлөө

АСУУГААРЙ, ТААМАГЛААРЙ

1. Зургийн агуулгыг ярилцана уу.
2. Ардчилсан хувьсгалын үр дүнд монголчуудын оюун санааны амьдрал хэрхэн өөрчлөгдсөн талаар асуулт гаргаж, таамаглал дэвшүүлээрэй.
3. Гаргасан таамаглалаа батлах, няцаахын тулд та бүхэнд ямар мэдээлэл, баримт хэрэгтэйг ярилцаарай.



Зураг 4.21 Зарим телевизүүдийн таних тэмдэг



Бүдүүвч 4.5 Түүх, соёлоо сэргээн бахархах талаар авсан арга хэмжээ - он цагийн шугам

Социализмын үед манай улсад соёл, урлагийн бүтээл, хэвлэл мэдээлэлд хатуу хяналт цензур тогтоож байлаа. Тухайн үед зөвхөн марксист-ленинист үзэл сурталд нийцсэн социалист реализм хэмээх бодит амьдралтай нийцдэггүй урлагийн хэлбэрийг хүлээн зөвшөөрдөг байв. Энэхүү хяналт цензурыг “Хэвлэл, утга зохиолыг хянах газар” нэртэй төрийн байгууллага хэрэгжүүлж чөлөөт сэтгэлгээний

илрэл бүрийг эхний шатанд нь илрүүлэн хориглодог, зохиолч бүтээлчдийг нь шийтгэдэг байжээ. Ардчилсан хувьсгалын үр дүнд чөлөөт сэтгэлгээ, оюун санааны эрх чөлөө, олон ургальч үзэл бодит байдал болж соёл уламжлал, үндэсний бахархал жинхэнэ утгаараа сэргэн хөгжиж байна.

Түүхийн үнэнийг сэргээх, үндэсний соёлоо хөгжүүлэх, үндэсний бахархлаа сэргээх чиглэлээр 1990 оноос эхлэн олон арга хэмжээ авч хэрэгжүүлжээ. 2011 оны байдлаар төрийн болон хувийн өмчийн соёл, урлагийн 821 байгууллага Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байна.

Иргэдийнхээ сүсэглэн бишрэх эрхийг хязгаарлаж, үндэсний соёл уламжлалаа хадгалан хөгжүүлэх гэсэн оролдлогыг нь социализмын үеэд хаан боогдуулдаг байв. Үүний жишээ нь улс даяараа ганцхан сүм хийдтэй, ард түмнийхээ уламжлалт цагаан сарын баярыг нийтээрээ тэмдэглэхийг хориглож зөвхөн хөдөө орон нутагт малчдын баяр маягаар тэмдэглэхийг зөвшөөрдөг байсан юм.

Иргэдийн шашин шүтэх, эс шүтэх эрхийг 1992 оны Үндсэн хууль болон УИХ-аас 1993 онд баталсан Төр, сүм хийдийн харилцааны тухай хуулиар баталгаажуулав. Өнөөг хүртэл бурхны шашны 300 гаруй сүм хийдийг сэргээжээ. 1924 онд VIII Богд хаан Жавзандамба таалал төгссөнөөс хойш Бурхны шашин албан ёсны тэргүүнгүй байлаа. 2010 онд түүний хойд дүр IX Богд гэгээнтэн Монгол улсын иргэн болсон нь сүсэгтнүүдийн хувьд том үйл явдал болж монголчууд 90 гаруй жилийн дараа Бурхны шашны тэргүүнтэй болсон юм. Улмаар X Богд гэгээнээ Монголоос тодруулах боломж бүрдэж байна.

1990 оноос өмнө 1 телевиз, 1 радио, өдөр тутмын сонин 1 байсан нь эрх барьж буй нам, төр, засгийн газрын мэдэлд байв. Чөлөөт хэвлэл өнгөрсөн

хугацаанд эрчимтэй хөгжлөө. 2014 оны байдлаар 411 хэвлэл мэдээллийн хэрэгсэл үйл ажиллагаа явуулж, олон ургальч үзэл бодлын индэр болж байна. Үүний 111 нь сонин, 90 нь сэтгүүл, 72 нь радио, 138 нь телевиз байна. Эдгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээс гадна мэдээллийн 92 сайт үйл ажиллагаа эрхэлж байна.

Монгол улсын оршин тогтнох, хөгжин дэвших эх сурвалжийн нэг нь монгол хүний тасралтгүй хөгжил, оюун ухааныг ч а д а в х ж у л а г ч боловсрол юм. 1992 оноос өмнө 7 их, дээд сургуультай 16 мянган оюутантай байсан бол 2015 оны байдлаар төрийн болон хувийн өмчийн 101 их, дээд сургууль, гадаадын их сургуулийн салбар 5 сургуульд 178 мянган оюутан суралцаж байна.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн зарлигийн дагуу дэлхийн шилдэг 100 их, дээд сургуульд бакалаврын сургалтад оюутан суралцуулах хөтөлбөрийг 2014 оноос хэрэгжүүлж байна. Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр өндөр хөгжилтэй орны их дээд сургуулийн магистр, докторт суралцуулах арга хэмжээг 1997 оноос хэрэгжүүлж байгаа бөгөөд өнгөрсөн хугацаанд 1600 гаруй хүн энэхүү зээлд хамрагджээ.

Дунд сургуулийн 10 жилийн сургалтыг дэлхийн жишигт ойртуулан 12 жилийн сургалттай болголоо.

Боловсролын салбарыг иргэдийн





**ТОДРУУЛГА**

*Дараах цахим хуудаснаас тоо баримт, мэдээллийг дэлгэрүүлж үзээрэй.*

*www.mecs.gov.mn  
Боловсролын яам.*

оюуны хэрэгцээг хангах, улс оронд хэрэгцээтэй мэргэжилтэн бэлтгэх, олон улсын боловсролын жишигт нийцүүлэн хөгжүүлэх зорилгоор шинэчлэх ажил үргэлжилж байна. Нийгмийн оюун санааны өөрчлөлтийн хүрээнд шинжлэх ухаан, технологийн салбар онцгой байр эзэлж байна. Шинжлэх ухааныг хөгжүүлэх ажлын чиглэл болж олон чухал баримт бичиг батлагдав.

Зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжиж байгаатай холбогдон эрүүл мэндийн салбарт томоохон өөрчлөлтүүд гарчээ. Эрүүл мэндийн үйлчилгээг дан ганц төр хариуцдаг тогтолцоог өөрчилж хувийн эмнэлгүүд байгуулагдав. Иргэдийн эрүүл мэндийн даатгалын тогтолцоо шинээр бий болж, хүүхэд, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн эмзэг давхаргынхны даатгалын хураамжийг төр хариуцаж байна.

Хүн амын тоо 1918 онд 600 мянга, 1962 онд 1 сая, 1988 онд 2 сая, 2015 онд 3 саяд хүрэв. Монгол хүний дундаж наслалт сүүлийн 25 жилд долоон жилээр нэмэгджээ. Одоо монгол эмэгтэйн дундаж наслалт 75, эрэгтэйх 66 болжээ. Төрөөс эрүүл мэндийн салбарт гаргадаг төсвийн хэмжээ 1992 онд 10 орчим сая ам.доллар байсан бол 2011 оноос энэ тоо 500 сая долларт хүрчээ.

Спортын талбарт манай тамирчид өмнөх амжилтуудаа ахиулж түүхэндээ олимпийн анхны алтан медалиа 2008 оны Бээжингийн олимпийн наадмаар авчээ. Тэгэхдээ бүр гурван алтан медаль авснаас жудо бөхийн төрөлд Н.Түвшинбаяр, боксын төрөлд Э.Бадар-Ууган, параолимпийн байт сурын харвааны төрөлд Д.Баатаржав алтан медалийн эзэн болсон юм.



*Зураг 4.22. Олимпийн аваргууд: Н.Түвшинбаяр, Э.Бадар-Ууган, Д.Баатаржав*


1990-ээд оноос улсын өмчид тулгуурласан социалист тогтолцоо задран унаж, ардчилал, зах зээлийн эдийн засагт шилжснээр нийгмийн бүтцэд томоохон өөрчлөлт гарлаа. Хувийн өмчтний давхарга цоо шинээр үүсэн бүрэлдэж хүрээгээ тэлсээр байна. Тэд өнөөдөр ДНБ-ний 80 шахам хувийг үйлдвэрлэж байна. Нийгэмд орлого, баялгаараа ялгаатай давхаргууд бий болсон тул төрөөс орлого багатай эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх халамжийн үйлчилгээг өргөжүүлж байна.



ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1990	1991	1996	2002	2006
“Монголын нууц товчоо” зохиогдсоны 750 жилийн ой	Монгол бичгээ сэргээж хос бичигтэн болгох ажил өрнөсөн.	Төр засаг, хэлмэгдэгсдийн үр ач нараас уучлал гуйсан.	Чингис хааны мэндэлсний 840 жилийн ой	Их монгол улсаа тунхагласны 800 жилийн ой
Хэдэн жилийн өмнө вэ? Хэддүгээр зуун бэ?	Монгол бичгийг хэзээ, хэрхэн авсан бэ?	Монголын түүхэнд хэзээ, яагаад хэлмэгдүүлэлт болж байв?	Чингис гэж хэн бэ? Тэр Монголын болон дэлхийн түүхэнд юу хийж үлдээсэн бэ?	Яагаад бид Их Монгол улсын ойг тэмдэглэх учиртай вэ?
“Монголын нууц товчоо” яагаад түүхийн эх сурвалж болдог вэ?	Хэзээ, яагаад, ямар бичгээр сольсон бэ?	Хэлмэгдүүлэлт бидэнд ямар сургамж юу үлдээв?	Түүний төрсөн оныг тооцоолон олоорой. Зуунд шилжүүлээрэй.	Их Монгол улс байгуулагдсан оныг тооцоолон олоорой. Зуунд шилжүүлээрэй.

1. Юу, хэзээ болсон тухай сэргээгээрэй, тооцоолоорой.
2. Зургийг уншиж, дараах гурван ажлыг хийнэ үү.
  - а. Тухайн онуудад манай улсын бүх шатны сургуулийн тоо хэрхэн нэмэгдсэнийг тооцоолоорой.
  - б. Бүх шатны сургуулийн тоо өсөхөд нөлөөлсөн хүчин зүйлсийн талаар таамаглал дэвшүүлэн ярилцаарай.
  - в. Гаргасан таамаглалаа батлах, няцаахын тулд та бүхэнд ямар мэдээлэл, баримт хэрэгтэйг ярилцаарай.
3. Ялгаатай үзэл бодлуудтай санал нийлэх эсэхээ шийднэ үү. Хүмүүс яагаад өөр үзэл санаатай байдаг тухай эргэцүүлэн ярилцаарай.



Бүдүүвч 4.9 Бүх шатны сургуулиуд

Ялгаатай үзэл бодлууд	Санал			Учир нь
	нийлж байна	нийлэхгүй байна	эргэлзэж байна	
Боловсролыг үнэ төлбөртэй болгох шаардлагатай. Учир нь хүмүүс үнэгүй зүйлд хайр гамгүй ханддаг.				
Нэг улсад олон шашин байх нь үндэсний эв нэгдэлд сөрөг нөлөөлтэй.				
Хүн бүр шашин шүтэх эрхтэй. Хүний шүтэн бишрэх эрхийг боогдуулж болохгүй.				
Хүмүүс эрүүл мэндээ өөрөө хариуцдаг байх нь зөв.				

4. Тухайн үеийн дурсамж та бүхэнд юу хэлж байна вэ? Номын зохиогч ямар үгсийг, яагаад хашилтад хийсэн бол?

“... Чөлөөтэй бодож сэтгэхийн тухайд ёстой саналтгүй. Хүн бүр “нам засаг юу гэж бодно” яг тэгж боддог, сэтгэдэг байх ёстой. Энэ бол бидэнд нам засгаас “заяасан” цорын ганц бодох сэтгэх эрх юм. Тунхаглалд дурдсан “ийм ийм эрхтэй юм байна” гэж яриад, эрхээ эдэлье гээд явбал ажилгүй болох магадлал маш өндөр”

С.Амарсанаа “Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд”, 2011 он

5. Асуултад хариулна уу.

- а. Монголчууд бидний үеийн үед бахархах, үр хойчдоо үлдээх үнэ цэнтэй зүйл юу вэ? Яагаад?
- б. Хүн бүр өөр өөр санаа бодолтой байдаг. Гэвч монголчуудын эрхэмлэх ямар зүйлийн талаар бүгд нэг санаа бодолтой байх ёстой гэж Та үздэг вэ? Яагаад?

### МОНГОЛЧУУДЫН ОЮУН САНАА, НИЙГМИЙН АМЬДРАЛД ГАРСАН ӨӨРЧЛӨЛТ

#### ҮНЭЛЭЭРЭЙ

Үе бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Олон ургальч үзэл
- Хэвлэл, мэдээллийн эрх чөлөө
- Шүтэх бишрэлийн эрх чөлөө

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай.			Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй.
1. Хүснэгтийн дагуу салбар тус бүрт гарсан өөрчлөлтийн гол үр дүнг тодорхойлоорой.			3. Нийгмийн бүтцэд гарсан өөрчлөлтөд юу нөлөөлөв? 4. Социализмын үеийн сурагчид пионерийн байгууллагын гишүүнээр элсэхдээ дараах тангараг өргөдөг байжээ. Үүнд: 5. “... овогтой ... би Д.Сүхбаатарын нэрэмжит МПБ-ын эгнээнд багтан орж, МАХН-ын үйл хэрэгт үнэнч байж, социализмын бүрэн төгс ялалтын төлөө мятрашгүй тэмцэж, БНМАУ-ын пионерийн чин эрмэлзлийг ямагт биелүүлэхээ өөрийн нөхдийн өмнө баясгалантайгаар тангараглаж байна!” 6. Та нар сайн дураараа эвлэлдэн нэгдсэн байгууллагадаа тангараг өргөвөл ямар тангараг өргөх вэ? Та бүхний өргөх тангараг өмнөх үеийн хүүхдүүдийн өргөж байсан тангарагаас ямар ялгаатай байх бол ...?	7. Монголчуудын оюун санаа, сэтгэлгээнд гарсан өөрчлөлтийг тодруулан судлаарай. Тухайлбал, • Түүх, соёлоо хүндэтгэн дээдлэх, сэргээх • Шүтэх бишрэх эрх чөлөөг хүндэтгэх • Хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хангах • Эвлэлдэн нэгдэх, үзэл бодлоо илэрхийлэх
Салбар	Өөрчлөлт	Үр дүн		
Соёл				
Боловсрол				
Эрүүл мэнд				
Шинжлэх ухаан				
Нийгэм				
2. Өөрчлөлтийн явцад учирсан сөрөг талуудыг ярилцаарай.				

7

МОНГОЛ УЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

СЭДЭВ ЧУХАЛ БОЛОХ НЬ

- Ардчилсан хувьсгал ялснаар Монгол дэлхийд нээлттэй орон болж, дэлхийн аль ч улстай харилцах боломж нээгдэв.
- Монгол хүн гадаадад чөлөөтэй зорчих, эх орондоо эргэн ирэх эрхтэй.

ГОЛ САНАА

- Олон тулгуурт гадаад бодлого
- Гуравдагч хөршийн бодлого

ТҮЛХҮҮР ҮГ

- Гадаад харилцаа
- Гуравдагч хөрш
- Гуравдагч хөршийн бодлого


ТОДРУУЛГА

Дараах цахим хуудаснаас тоо баримт, мэдээллийг дэлгэрүүлж үзээрэй.  
www.mfa.gov.mn Гадаад хэргийн яам.



УНШААРАЙ, ОЙЛГООРОЙ

1. Монголчууд ямар, ямар улс уруу зорчдог вэ?. Тухайн улсуудаас газар зүйн зурагт заагаарай.



2. Социализмын үеийн Монгол улсын гадаад харилцааны тухай мэдлэг, мэдээллээ хуваалцана уу.
3. Гадаад улс оронд сурч, ажиллаж буй монгол хүмүүсийн тухай мэдээллээ хуваалцана уу.
4. Гадаад улс орноор аялах, тэнд суралцах тухайд та бүхэн ямар бодол, мөрөөдөл, төлөвлөгөөтэй байдаг вэ? Хуваалцана уу.

5. Ардчилсан хувьсгалын үр дүнд манай улсын гадаад харилцаанд ямар өөрчлөлт орсон гэж та нар бодож байна вэ?

1991 он



Японы ерөнхий сайд Тошику Кайфу гэргийн хамт айлчлав.

2002 он



НҮБ-ын Ерөнхий нарийн бичгийн дарга К.Аннан айлчлав.

2012 он



ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин айлчлав хийв.

2014 он



ОХУ-ын ерөнхийлөгч В.Путин 2 дахь удаагаа айлчлав.

1994 он

Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал анх удаа батлагдав.

2006 он



АНУ-ын ерөнхийлөгч Жорж Буш айлчлав.

2014 он



БНХАУ-ын дарга Ши Жиньпин айлчлав.

Бүдүүвч 4.10 Гадаад харилцааны онцлох үйл явдлын он цагийн шугам



Зураг 4.23.  
Монгол улсын нэр хүнд олон улсын тавцан дээр жил ирэх тусам өсч байна. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж НҮБ-ын индэр дээрээс үг хэлж байна.

## УРЬД

1912 онд Богдын Засгийн газраас дэлхийн 9 гүрэнд хандан нот илгээж байв.



Зураг 4.24. Монгол улсын Гадаад паспорт

Монгол улс өөрийн гэсэн гадаад бодлогын үзэл баримтлалтай болж, түүнийг УИХ-аар батлуулан мөрдөж байна. Уг үзэл баримтлалд:

- ОХУ, БНХАУ-тай найрсаг харилцаатай байх нь Монгол Улсын гадаад харилцааны бодлогын эн тэргүүний зорилт мөн. Эдгээр улстай бүхэлдээ тэнцвэртэй харилцаж, сайн хөршийн ёсоор өргөн хүрээтэй хамтын ажиллагаа хөгжүүлэх;
- АНУ, Япон, Европын холбоо, Энэтхэг, БНСУ, Турк зэрэг өрнө, дорнын улс, холбоотой “гуравдагч хөрш”-ийн бодлогын хүрээнд түншлэлийн харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхээр заасан байна.

Гуравдагч хөршийн бодлого гэдэг нь:

- Хоёр их хөршийн зэрэгцээ дэлхийн болон бүс нутгийн нөлөө бүхий орнуудтай харилцаа, хамтын ажиллагаа хөгжүүлэх, аль нэг улсаас хэт хамааралтай буюу хараат байдалд орохоос сэрэмжлэх,
- Гадаад түншүүдийн Монгол улс дахь ашиг сонирхол, оролцоог тэнцвэржүүлэх,
- Монгол Улсын аюулгүй байдлыг бэхжүүлэх, Монгол Улсын тогтвортой хөгжлийг хангахад оршино.

Монгол Улсын гадаад бодлогын үндсэн зорилго нь Улс орон, ард түмнийхээ язгуур эрх ашгийг улс төр, дипломатын аргаар хамгаалах явдал юм.

Ардчилсан хувьсгалын дараа гадаад харилцаанд гарсан өөрчлөлт нь зөвхөн төр улсын хэмжээнд төдийгүй Монгол хүн, монгол айл өрх бүрт ч илт мэдэгдэж үр ашгаа өгсөн юм. Монголчууд өнөөдөр дуртай улсдаа ажиллаж, амьдрах, аялах, зугаалах, сурч боловсрох болжээ. 1989 онд гадаадад зорчсон монгол иргэдийн тоо оюутнуудаа оруулаад 47,8 мянга байсан бол зөвхөн 2014 онд гэхэд л 1 сая 677,5 мянган хүн гадаадад зорчжээ.

Монгол улсын өнөөгийн гадаад бодлогын зарчим нь орчин үеийн харилцан хамааралтай, соёлт ертөнцөд, эрх тэгш, харилцан ашигтай, найрсагаар хамтран ажиллах явдал юм. 1990 оноос хойш Монгол улс үндэсний эрх ашгаа урьтал болгон нээлттэй олон тулгуурт гадаад бодлого явуулах болов. Юуны өмнө, хоёр их хөрш ОХУ, БНХАУ-тай, улмаар АНУ, ХБНГУ, Япон, Өмнөд Солонгос зэрэг өрнө, дорны улс орнуудтай найрсаг харилцаагаа хөгжүүлж байна.

## ТОДРУУЛГА

Хоёр айлчлалын огтлолцсон цэг (2006.03.21) Монголд өчигдөр хоёр томоохон айлчлал болов. Нэг нь манай хойд хөрш ОХУ-ын гадаад хэргийн сайд Сергей Лавровын албан ёсны айлчлал бол нөгөөх нь АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга асан Жеймс Бейкерийн албан бус айлчлал юм. Хэвлэлүүдийн мэдээллээс үзвэл нэг өдөр тохиосон эл хоёр айлчлал нэг цэгт огтлолцсон нь анхаарал татаж байна. Тэр цэг нь мэдээж сүүлийн үед анхаарлын төвд буй гадаадын хөрөнгө оруулалт, тэр дундаа уул уурхайн салбарт холбогдох асуудал байжээ.





## ШИНЖЛЭЭРЭЙ, ДҮГНЭЭРЭЙ

1. Монгол улсын гадаад харилцаанд ямар өөрчлөлт гарсныг ярилцана уу.
2. “Гуравдагч хөрш” орнуудын Монгол улсын эдийн засаг, нийгэм, соёлын салбарт оруулж буй хувь нэмрийг дараах хүснэгтээр үзүүлээрэй.
3. Хоёр хөрш оронтойгоо найрсаг харилцаатай байх нь Монгол улс, монгол хүмүүст ямар ач холбогдолтой вэ?
4. Олон улсын дээд хэмжээний болон бусад уулзалтуудаас Таны бодлоор ямар дүгнэлт хийж болох вэ?

Улс орнууд	Хамтран ажиллаж буй чиглэл	Хамтран ажилласан түүх
АНУ		
Япон		
БНСолонгос улс		
Энэтхэг		
Турк		

## МОНГОЛУЛСЫН ГАДААД БОДЛОГЫН ӨӨРЧЛӨЛТ

## ҮНЭЛЭЭРЭЙ

Үе тус бүрийг 2-3 өгүүлбэрээр тайлбарлан бичээрэй.

- Гадаад харилцаа
- Гуравдагч хөрш
- Гуравдагч хөршийн бодлого

Мэдээлэл болон тэмдэглэлээ ашиглаарай	Гол санаагаа ойлгов уу?	Бүтээлчээр сэтгээрэй									
<p>1. Ардчилсан хувьсгал гадаад бодлогыг хэрхэн өөрчилсөн бэ? Хүснэгтийн дагуу ажиллаарай.</p> <table border="1"> <thead> <tr> <th colspan="3">Гадаад харилцааны өөрчлөлтүүд</th> </tr> <tr> <th>Гадаад бодлогын хүрээнд</th> <th>Хөрш орнуудтай харилцах хүрээнд</th> <th>Бусад улс орнуудтай харилцах хүрээнд</th> </tr> </thead> <tbody> <tr> <td></td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> <p>2. Монгол улсын гадаад бодлогын зарчмуудын талаар санал бодлоо хуваалцаарай.</p>	Гадаад харилцааны өөрчлөлтүүд			Гадаад бодлогын хүрээнд	Хөрш орнуудтай харилцах хүрээнд	Бусад улс орнуудтай харилцах хүрээнд				<p>3. Түүхэн уулзалтуудын ач холбогдол юунд орших вэ?</p> <p>4. “Монгол улс дэлхийд нээлттэй, дэлхий дахин Монголд нээлттэй болжээ” гэдгийг баримтаар нотлоорой.</p>	<p>5. Дараах хүрээнд мэдээлэл цуглуулж, солилцоорой. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>• Өөрийн амьдарч буй орон нутгийн гадаад харилцааны талаар (шууд харилцдаг хот, хилийн боомт гэх мэт)</li> <li>• Гадаад улсад ажиллаж, амьдарч, сурч буй хүмүүсийн амьдралын талаар гэх мэт.</li> </ul>
Гадаад харилцааны өөрчлөлтүүд											
Гадаад бодлогын хүрээнд	Хөрш орнуудтай харилцах хүрээнд	Бусад улс орнуудтай харилцах хүрээнд									

## БҮЛГИЙН ДҮГНЭЛТ

Хүүхдүүдээ, та бүхэн энэхүү Ардчилсан Монгол улс ба өнөөгийн дэлхий дахин (1990 оноос өнөө үе) бүлэг сэдвийг судалж дууслаа. Энэ бол та бүхний амьдарч буй, өнөөгийн нийгмийн түүх тул танил, сонирхолтой байсан гэдэгт итгэж байна.

1. Он цагийн шугамыг гүйцээнэ үү.



2. Энэхүү бүлэгт гарсан хүмүүсийн нэрсийг жагсаан бичиж, хүмүүсийн нэрсээс Монгол Улсын болон дэлхийн түүхэнд хувь нэмэр оруулсан 3-5 нэрийг сонгож, яагаад ийнхүү үзэж буйгаа тайлбарлаарай. Дараах хүснэгтийн загварыг ашиглаарай.

№	Хүмүүсийн нэрс	Оруулсан хувь нэмэр		Тайлбар
		монголын түүхэнд	дэлхийн түүхэнд	

3. Эх сурвалжийг уншиж, дараах даалгаврыг гүйцэтгээрэй.

- а) Монголын Ардчилсан Холбооны зорилго, үйл ажиллагааны талаар

1989-12-09. Улс төрийн клуб, бүлгэмүүд нэгдэж цоо шинэ улс төр-олон нийтийн байгууллага болох Монголын ардчилсан Холбоог байгуулж тайван замаар ардчилсан хувьсгал хийх стратеги зорилгоо тодорхойлов. МоАХ-ны Ерөнхий зохицуулах зөвлөлийн гишүүнээр С.Амарсанаа, Э.Бат-Үүл, Б.Билэгт, Д.Баасан, С.Зориг, Л.Нямсүрэн, Д.Нинж, Д.Сосорбарам, Д.Сүхбаатар, Ц.Элбэгдорж, В.Энхболд, Б.Энхтүвшин, Д.Энхбаатар, Г.Бошигт,

Ч.Энхээ нарыг сонгожээ.

1989-12-10. МоАХ анхны цуглаанаа хийж БНМАУ-ын АИХ-ын Тэргүүлэгчид, эрх баригч МАХН-ын Төв хороонд гаргасан өргөх бичигтээ олон намын систем тогтоох, хүний эрхийг дээдлэх, бүх нийтийн сонгуулийг хугацаанаас нь өмнө 1990 оны эхний хагаст багтаан явуулах зэрэг 13 зүйлийн шаардлага тавьснаар Монголд ардчилсан хувьсгал эхэлснийг зарлан тунхаглав.

ярилцахад бэлтгэж, гол санааг илэрхийлсэн товч бичиглэл хийгээрэй.

- б) Монгол улсын ардчилсан хувьсгалын үйл хэрэгт янз бүрийн анги, давхаргын төлөөлөгчид оролцож байсныг нотлон жишээ баримтаар гаргаарай.

4. Ардчилсан өөрчлөлтийн үр дүнг дараах хүснэгтээр илэрхийлээрэй.

№	Нийгмийн амьдралын салбар	Өөрчлөлт, үр дүн
1	Улс төр	
2	Эдийн засаг	
3		

5. Энэхүү бүлгээр үзсэн сэдвүүдээ жагсаан бичиж, ямар үйл ажиллагаа бие дааж болон багаараа хамтран хийснээ нөхөж бичээрэй.

№	Сэдэв	Мэдсэн	Сурсан	Бодсон
1	Социалист систем задран унасан нь			
2	Ардчилсан хувьсгалын эхлэл			

6. Дараах бүлэглэсэн түлхүүр үгсийг ашиглан 3- 5 өгүүлбэр зохиогоорой.

- Өөрчлөн байгуулалт, социализмын мөхөл, Берлиний хана
- Ардчилал, хүний эрх, эрх чөлөө, Хүний эрхийн түгээмэл тунхаглал
- Цуглаан, жагсаал, улс төрийн өлсгөлөн, зөвшилцөл
- Олон ургальч үзэл, хэвлэлийн эрх чөлөө, шүтэх, бишрэх эрх чөлөө
- Өмч хувьчлөл, үнэ чөлөөлөлт, банк санхүү
- Гадаад харилцааны бодлого, гуравдагч хөрш,

7. Бүлгийг судлахад ашигласан эх сурвалжуудаа жагсаан бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

а) Эх сурвалжийг ашиглан түүхийн тодорхой асуудлыг судлахын тулд шинжлэн судлах үйл ажиллагааны ямар дараалал баримтлан юу хийснээ тэмдэглэнэ үү.

Үйл ажиллагааны дараалал	Юу хийсэн?	Ямар үр дүнд хүрсэн?

б) Эх сурвалжийг ашиглан түүхийн тодорхой асуудлыг судлахын тулд шинжлэн судлах үйл ажиллагааны ямар дараалал баримтлан юу хийснээ тэмдэглэнэ үү.

Эх сурвалжууд	Гарал	Төрөл	Хэрхэн ашигласан?

8. Бүлэгт гарсан улсууд болон газар орны нэрийг бичээд дараах даалгаврыг гүйцэтгэнэ үү.

- а) Жагсаасан газар нутгаа монголын болон дэлхийн газрын зурагт заагаарай.
- б) Газрын зурагт зааж чадаж буй эсэхээ дараах хүснэгтийн дагуу тэмдэглэж, өөрийгөө үнэлээрэй.

№	Улс, газар нутаг	Хөндлөнгийн үнэлгээ			Найз нөхдөдөө өгөх зөвлөлгөө
		шууд зааж чадсан	нэмэлт мэдээлэл уншиж байж заасан	зааж чадахгүй байсан	

9. Дараах сэдвүүдээс сонгож хэлэлцүүлэг зохион байгуулна уу.

- Монгол улс- ардчилал
- Хүний эрх, эрх чөлөө
- Ардчилсан сонгууль

**Баримт бичгийн эмхтгэл:**

1. Ардын засгийн газраас 1921-1924 онуудад авсан хувьсгалт арга хэмжээнүүд. Эмхтгэсэн Ц.Насанбалжир. УБ., 1954
2. Архив Внешней политики Российской империи ф.Китаский стол 143, Опись 491, д.644,
3. Архив Внешней политики Российской империи ф.Китайский стол 143, Опись 491, д.566, с.10
4. БНМАУ, Зөвлөлт улсын эх орны дайны үед. Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэсэн Н.Сэр-Оджав. УБ., 1954
5. БНМАУ-ын эдийн засгаас гадаадын капиталыг шахан зайлуулсан нь. Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэсэн С.Ичинноров. УБ., 1967
6. БНМАУ хөрөнгөтний биш хөгжлийн төлөө тэмцэлд. Баримт бичгүүд. 1925-1940 он. эмхтгэсэн Ц Насанбалжир. УБ., 1956. 79-83 т
7. БНМАУ-ын гадаад харилцааны баримт бичнүүдийн эмхтгэл. I,II боть. Эмхтгэсэн Д.Нямаа нар. УБ., 1964
8. Монголын түүхийн эх сурвалж, 1911-1921 он, УБ., 2003, 125 дахь тал
9. “Монголын ард түмний 1911 оны Үндэсний эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцэл” баримт бичгийн эмхтгэл (1900-1911 он), УБ., 1982
10. МАХН-ын түүхэнд холбогдох баримт бичгүүд. 1924-1940 он. Нэгдүгээр дэвтэр. Улаанбаатар. 1966.
11. МАХН-ын холбогдол бүхий зүйлүүд, УБ., 1928 он.
12. Монголын тухай БХК/Б-Н-ын баримт бичигт 1920-1952. Баримт бичгийн эмхтгэл I-III боть 1920-1932. Эмхэтгэгчид С.Дамдинсүрэн, А.С.Железняков ба бусад УБ. 2002-2005.
13. Монгол ба Коминтерн, Баримт бичгийн эмхтгэл, УБ., 1999
14. Монгол Улсын Үндсэн хууль., 1924., дөрөвдүгээр бүлгийн Гучин тавдугаар зүйл
15. Монгол Улсын Үндсэн хууль., 1992., Нэгдүгээр бүлэг. 9.1
16. Монголын автономит үеийн сургууль (1911-1920). Баримт бичгийн эмхтгэл (Эмхтгэсэн С.Жигмэдсүрэн, Б.Балжиргармаа). УБ., 1966
17. Орос Хятадын гэрээ хэлэлцээрүүдийн эмхтгэл. Нэгдүгээр хэсэг. 1689-1949 он. Эмхтгэсэн М.Батчимэг УБ 2001 т-149
18. Российский государственный архив социально-политической истории
19. Улсын дээд, доод хурал. Баримт бичгийн эмхтгэл. Эмхтгэсэн Ж.Гэрэлбадрах нар, УБ., 2009
20. Үндэсний төв архив х.1, д.1, х.н.25
21. Эдийн засгийн үндсэн бодлого., 1923.

**Ном, судалгааны бүтээлүүд:**

1. Амарсанаа.С., “Ардчилсан хувьсгалын тэргүүн эгнээнд”, УБ., 2013.
2. Баабар., “Нүүдэл суудал, XX зууны Монгол”, УБ., 2000
3. Баабар., “Монгол, Монголчууд, Монгол орон түүхийн альманах”, УБ., 2013
4. Батсайхан.О., “Монголын сүүлчийн эзэн хаан VIII Богд Жавзандамба хутагт: амьдрал ба домог”, УБ., 2014
5. Батсайхан.О., “Монголын тусгаар тогтнол ба Хятад, Орос, Монгол гурван улсын 1915 оны Хиагтын гэрээ”, УБ., 2007
6. Батсайхан.О., “Монгол үндэстэн бүрэн эрхт улс болох замд 1911-1946”, УБ., 2007
7. БНМАУ-ын түүх. Гутгаар боть. УБ., 1968
8. БНМАУ-ын түүх. УБ., 1984
9. БНМАУ-ын баатрууд. УБ., 1972
10. Богд хааны амьдралын он дарааллын товчоон., Эрхлэн нийтлэгч Шарнууд Дугарсүрэн., УБ., 2000, 62 т
11. Дэлхийн II дайн: Түүхэн сургамж орчин үе (Эрдэм шинжилгээний хурлын эмхтгэл) УБ., 2005
12. Дэлхий дахины түүх. Боть II. УБ., 2003
13. Лхамсүрэн.Б., “Монголын гадаад орчин төрийн тусгаар тогтнол”, УБ., 1995.т.110
14. Лонжид.З., “Богд гэгээнтэн Орос улсаас хэдэн удаа тусламж хүссэн бэ?” МУИС. НШУС. Эрдэм шинжилгээний бичиг, Түүх-6, УБ., 2007, 70 дахь тал
15. Лонжид.З., “Түүх сөхөхүй”, УБ., 2012.
16. Монголд ардчилал эхэлсэн түүх., УБ., 2015 он
17. Монголын эх түүх. 7 боть цуврал., Эрхлэн хэвлүүлсэн З.Лонжид, О.Батсайхан., УБ., 2014
18. Кузьмин С.Л., “Барон Унгерний түүх”, УБ., 2013
19. Кузьмин.С.Л., Ж.Оюунчимэг “Социализмын эсрэг 1932 оны Монгол дахь бослого”, УБ., 2014.
20. Монголчууд XX зууны эхэнд. Зурагт түүх. Ерөнхий редактор О.Батсайхан. Монсудар. УБ., 2011
21. Монголын Үндэсний хувьсгалын нэвтэрхий толь. Эрхлэн хэвлүүлсэн Ж.Урангуа, Б.Пунсалдулам, С.Чулуун. УБ., 2011
22. Монгол Улсын түүх (түүх, онол арга зүйн асуудалд) УБ., 2001
23. Монгол Улсын түүх Тавдугаар боть. УБ., 2003
24. Монгол цэргийн товчоон (1911-1990-ээд он). Дэд дэвтэр. УБ., 1996
25. Монголын ард түмэн: Бүхнийг фронтод, бүгдийг ялалтын төлөө. Альбом. УБ., 2015
26. Плиев.И.А., Квантуны арми сөнөсөн нь. УБ., 1970
27. Сандаг.Ш., “Монголын улс төрийн гадаад харилцаа 1850 –1919”, Тэргүүн дэвтэр., УБ., 1971
28. Хорьдугаар зууны Монгол цэргийн урлагийн түүх. УБ., 2009
29. Цэвээн.Ж., “Улсын эрх”, 1915
30. Цэнддоо.Б., Цацралт.С., 100 жил, 100 үйл явдал. Баримтат зурагт ном. УБ., 2014
31. “XX зууны монгол”, Ред. М.Санждорж, УБ., 1993
32. 1945 оны чөлөөлөх дайны баатрууд. УБ., 2010